УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга *1*

Хуралдааны товч тэмдэглэл: *2-84*

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: *89-249*

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг чөлөөлөх тухай асуудал *89-100*

2.Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал *100-111 239-233*

3.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг****/* *111-121*

4.Улсын Их Хурлын асуулгын цаг *156-230*

5.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх****/* *121-156 249*

6.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл */Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг/*** *249-244*

7.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***эцсийн хэлэлцүүлэг*** *244 249*

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 28-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 66 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 34 минутад Төрийн ордны "Их хуралдай" танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баттулга, П.Батчимэг, Ж.Баясгалан, Х.Булгантуяа, Д.Бум-Очир, А.Ганбаатар, Г.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Ганбат, Д.Ганмаа, Х.Ганхуяг, М.Ганхүлэг, П.Мөнхтулга, Б.Найдалаа, Ч.Номин, У.Отгонбаяр, Г.Очирбат, Ц.Туваан, Б.Түвшин, Г.Хосбаяр, Б.Хэрлэн, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Л.Энхнасан;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Д.Амарбаясгалан, М.Нарантуяа-Нара;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Л.Гантөмөр, З.Мэндсайхан, П.Сайнзориг, М.Сарнай, Б.Тулга;

Тасалсан: Ж.Батсуурь, Д.Жаргалсайхан, Л.Оюун-Эрдэнэ;

Хоцорсон: Б.Батбаатар-1 цаг 26 минут, Б.Батцэцэг-1 цаг 47 минут, Б.Бейсен-41 минут, Э.Болормаа-29 минут, Г.Дамдинням-25 минут, Б.Пунсалмаа-44 минут, О.Саранчулуун-12 минут, А.Ундраа-48 минут, Ч.Ундрам-08 минут, Б.Энхбаяр-29 минут, Р.Эрдэнэбүрэн-3 цаг 28 минут.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Л.Өлзийсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Н.Номтойбаяр, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Л.Өлзийсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ө.Шижир, Х.Тэмүүжин, А.Ариунзаяа нар үг хэлэв.

Н.Учрал: Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Лувсандоржийн Өлзийсайханыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 29
Бүгд: 81
64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын *эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:15/*

Уг асуудлыг 11 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаан 11 цаг 15 минутаас 11 цаг 45 минутад түр завсарлав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Л.Өлзийсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Л.Мөнхбаясгалан, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин 3 хоногийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дарга Н.Учрал 2 цагийн завсарлага өгөв./12:26/

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд танхимыг орхиж гарав./12:28/

Гурав.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Эрдэнэ, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлувсан нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын зөвлөх Б.Нандингэрэл, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Л.Батмөнх, референт Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, А.Ариунзаяа, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 04 минут үргэлжилж, 13 цаг 08 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 12 минутад эхлэв.

Дөрөв.Улсын Их Хурлын асуулгын цаг

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Тусгайлан бэлтгэсэн индрээс Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар нар цуварсан асуулт, хариултаар мэтгэлцэв.

Мөн тусгайлан бэлтгэсэн индрээс Ерөнхий сайдад тавих асуултаа асуулга болохоос 7 хонгийн өмнө бичгээр ирүүлсэн гишүүд болох Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Ө.Шижир, Ц.Баатархүү, Да.Цогтбаатар, С.Цэнгүүн, Ж.Баярмаа, Д.Батбаяр, Улсын Их Хурал дахь олонхын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Г.Лувсанжамц, О.Саранчулуун, Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлыг 16 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн анхны хэлэлцүүлэг явуулах асуудал санал хураалтаар үргэлжлэв.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Н.Учрал: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Пүрэвдорж, Р.Сэддорж, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Ж.Галбадрах,

Д.Ганмаа, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, М.Мандхай, Б.Мөнхсоёл, Ц.Мөнхтуяа, З.Мэндсайхан, Ч.Номин, Н.Номтойбаяр, П.Сайнзориг, О.Саранчулуун, Б.Уянга, Г.Уянгахишиг, Б.Хэрлэн, С.Цэнгүүн, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дахь заалтын “төлөвлөгөөнд болон” гэснийг “төлөвлөгөөний төсөлд,” гэж, “төсөвт” гэснийг “төсвийн төсөлд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 42
Бүгд: 87
51.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “үнэлгээний үзүүлэлт” гэсний дараа “, зорилтот түвшин” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 38
Бүгд: 87
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" батлагдахтай холбогдуулан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах аргачлалыг хуулиар тогтоох, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулах, төлөвлөх, батлах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах цаглавар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхтэй холбоотой хуулиудын уялдааг хангаж, шаардлагатай хуулийн төслийг боловсруулан 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газарт даалгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 40
Бүгд: 87
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын “Өмнөтгөл” хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /цаашид “Үндсэн чиглэл” гэх/-д үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчдын болон тэдгээрийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийн түвшинд тулгамдаж байгаа асуудлыг тогтоож, уг асуудлуудыг шийдвэрлэх арга зам, шийдвэрлэснээр бий болох үр дүн, хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон болно. Шалгуур үзүүлэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулсан бөгөөд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тус үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь нарийвчлан заасан.

Үндсэн чиглэл нь Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн төсөв, цаашлаад байгууллагын стратеги болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг баримт бичгийн суурь болно. Үндсэн чиглэлд тодорхойлсон үр дүнг бодлого, төлөвлөлтийн эдгээр баримт бичигт тусгаж, зорилтот үр дүнг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Үндсэн чиглэл нь “Шинэ итгэл – Эрс шинэтгэл”-д зорьсон “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Төрийн бүтээмж, засаглал”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд үндэсний 10 үр дүнд хүрэхээр төлөвлөв.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 38
Бүгд: 87
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2 дахь заалтыг “Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдааг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ.” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 37
Бүгд: 87
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Боловсролын чанар болон хүртээмжийн ялгааг арилгаж, эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлийн хүрээг тогтоож, хүн-төвтэй, хүртээмжтэй, чанартай, санхүүгийн эрсдэлгүй тусламж, үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэж, дундаж наслалтыг 2 насаар нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцсэн хүний нөөцийг бэлтгэн, хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.85 оноонд хүргэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 37
Бүгд: 87
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт “эв нэгдлийг” гэснийг “эв нэгдэл” гэж өөрчилж, “, эх оронч үзлийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 36
Бүгд: 87
58.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь заалтын “байдлыг бэхжүүлж” гэснийг “байдлыг дэмжиж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 38
Бүгд: 87
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын 5 дахь заалтын гарчгийн “Засаглал, дижитал шилжилт” гэснийг “Төрийн бүтээмж, засаглал” гэж, 2 дугаар хавсралтын бүлгийн гарчгийн “ЗӨВ ЗАСАГЛАЛ, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ” гэснийг “ТӨРИЙН БҮТЭЭМЖ, ЗАСАГЛАЛ” гэж; төслийн 3 дугаар хавсралтын “ЗАСАГЛАЛ, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ” гэснийг “ТӨРИЙН БҮТЭЭМЖ, ЗАСАГЛАЛ” гэж; төслийн 4 дүгээр хавсралтын 4.1, 4.2 дахь хүснэгтийн “БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ” гэснийг “БҮСИЙН ХӨГЖИЛ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 37
Бүгд: 87
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 2.1.2.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “2.1.2.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.6.7” гэж, “Салбар” баганад “72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” гэж, “Үр дүн” баганад “Ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох” гэж, “Арга зам” баганад “Анхдагч хуулийн төсөл шинээр боловсруулах, батлуулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “2.1.2.4” гэж, “Салбар” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Үр дүн” баганад “Ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ахмад настны (55-70 хүртэлх хөдөлмөр эрхлэлтийн түвшин)” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 38.4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 39.0, 2027: 39.6, 2028: 40.2, 2029: 40.8, 2030: 41.4” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 48
Бүгд: 87
44.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 1.1.3.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “1.1.3.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “Ажлын Хэсэг-2.1.34” гэж, “Салбар” баганад “71804 Мэргэжлийн боловсрол” гэж, “Үр дүн” баганад “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” гэж, “Арга зам” баганад “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “1.1.3.4” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно” гэж, “ТХЗ уялдаа” баганад “4.с.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Индекс” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 2 тэр бум, 2 сая 332.4 мянга гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 2025 оны түвшнээс дээгүүр, 2027: 2026 оны түвшнээс дээгүүр, 2028: 2027 оны түвшнээс дээгүүр, 2029: 2028 оны түвшнээс дээгүүр, 2030: 2029 оны түвшнээс дээгүүр” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 47
Бүгд: 87
46.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёлын гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 4.1.2.3 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.1.2.3” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “Алсын хараа-2.7” гэж, “Салбар” баганад “72212 Гэр бүлийн хөгжил, хамгаалал” гэж, “Үр дүн” баганад “Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.” гэж, “Арга зам” баганад “Угийн бичгээ хөтлөх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.1.2.3” гэж, “Салбар” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Үр дүн” баганад “Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Угийн бичгээ хөтөлдөг гэр бүл” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Тооцох+3%, 2027: Тооцох+5%, 2028: Тооцох+8%, 2029: Тооцох+10%, 2030: Тооцох+15%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам”,

“Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 54
Бүгд: 87
37.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

13.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 35 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “35” гэж, “Төсөл арга хэмжээний нэр” баганад “Боловсролын салбарын багш ажилтныг орон сууцжуулах төсөл” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 60
Бүгд: 87
31.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 37 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “37” гэж, “Төсөл арга хэмжээний нэр” баганад “Боловсролын сургалтын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн үйлдвэр” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 55
Бүгд: 87
36.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

14.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 36 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “36” гэж, “Төсөл арга хэмжээний нэр” баганад “Багшийн хөгжлийн үндэсний төвийн барилга /Улаанбаатар хот/” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 58
Бүгд: 87
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 38 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “38” гэж, “Төсөл арга хэмжээний нэр” баганад “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнсний үйлдвэр” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж гэсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 58
Бүгд: 87
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Н.Учрал: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1.в дэх заалтыг үндэслэн төслийн 4 дүгээр хавсралтын 4.3 дахь хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”, 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг тус тус хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 83
Бүгд: 86
3.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналын 2-28 дугаар саналуудтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлж, уг саналуудыг татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

Н.Учрал: 29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Хувь хүний хөгжлийг дэмжих” гэснийг “Багшийн чанар, хангалтыг сайжруулж, сургалтын хөтөлбөрийг шинэчилж, хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан орчинд суралцах тэгш боломжоор хангах” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 81
Бүгд: 86
5.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, 1.1.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, 2.1.2.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 2.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Сангийн яам” гэж тус тус нэмэх, 4.1 дэх дэд заалтын “Үндсэн хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам” гэснийг “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэснийг “Эдийн засаг, хөгжлийн яам, Боловсролын яам” гэж өөрчлөх, 4.1.3.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам” гэж, 4.1.4.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 4.2.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 4.4.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Зам, тээврийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 4.4.1.4 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 4.4.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж, 4.4.3.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 4.4.3.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 4.2.3.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам” гэж, 4.2.5.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 4.2.5.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж тус тус нэмэх, 4.1.1.2 дахь дэд заалтын “Бодлогын Үндэслэл” баганад “АХ-2.2” гэснийг “АХ-2.2.16” гэж өөрчлөх, “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 5.4.2.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж, 5.7.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)” гэж, 6.2.2.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 6.3.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам” гэж, 7.2.4.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 7.8.1.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж, 8.1.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Хот байгуулалт,

барилга, орон сууцжуулалтын яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Эрчим хүчний яам” гэж, 8.1.2.5 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, 8.1.2.7 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж, 9.1.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 9.1.6.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Шадар сайдын Ажлын алба (Гадаадын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа эрхэлсэн)” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 85
Бүгд: 86
1.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Эцэг, эхийн оролцоог дэмжих” гэснийг “Монгол хүн болох, монгол ёс заншил, түүх соёлоос суралцахад эцэг, эхийн оролцоог дэмжих” гэж өөрчилж, төслийн 3 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтад дараах шалгуур үзүүлэлт нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 3 дахь мөрөнд “Багш мэргэжлээр төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллах хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+5%, 2027: Т+10%, 2028: Т+15%, 2029: Т+20%, 2030: Т+30%” гэж, “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж,

- “Шалгуур үзүүлэлт” баганын 4 дэх мөрөнд “Багшийн ажиллах орчны стандартын шаардлагыг хангасан сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин: 2024, Түвшин: Тооцох, 2026: Т+5%, 2027: Т+10%, 2028: Т+15%, 2029: Т+20%, 2030: Т+30%” гэж, “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 85
Бүгд: 86
1.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын яам” гэж, 2.1.2.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 85

Бүгд: 86
1.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтын 1, 2 дахь “Шалгуур үзүүлэлт” мөрийг хасаж дараах байдлаар өөрчлөх:

“Шалгуур үзүүлэлт” баганын 1 дэх мөрийг “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн бүлэг дүүргэлтийг 35-аас доош байх бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /Нийслэл/” гэж өөрчлөн найруулж, “Суурь түвшин” баганад “Түвшин: “76.5” гэснийг “39.7” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: “78” гэснийг “43.8” гэж, “2027: 80” гэснийг “48.8” гэж, 2028: “82” гэснийг “56.8” гэж, 2029: “84” гэснийг “61.8” гэж, 2030: “88” гэснийг “70” гэж,

“Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /аймаг/” гэснийг “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн бүлэг дүүргэлтийг 35-аас доош байх бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /орон нутаг/” гэж, “Суурь түвшин” баганад “Түвшин: “97” гэснийг “82.2” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 98” гэснийг “84.7” гэж, “2027: 98.5” гэснийг “87.7” гэж, “2028: 99” гэснийг “92.7” гэж, “2029 он: 99.5” гэснийг “99.7” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 84
Бүгд: 86
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад дараах 5 мөр нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 3 дахь мөрөнд “Багш мэргэжлээр төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллах хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+5%, 2027: Т+10%, 2028: Т+15%, 2029: Т+20%, 2030: Т+30%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 4 дэх мөрөнд “Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 78.6” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 80, 2027: 81.5, 2028: 83, 2029: 84.5, 2030: 86” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 5 дахь мөрөнд “Төрөлжсөн ахлах сургуулийн тоо” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 6, 2027: 12, 2028: 15, 2029: 18, 2030: 21” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж:

Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 6 дахь мөрөнд “Элсэлтийн ерөнхий шалгалтын өндөр оноотой төгсөгчдийн багш мэргэжил сонгох хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: -, 2027: Т+1%, 2028: Т+1%, 2029: Т+2%, 2030: Т+2%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 7 дахь мөрөнд “Багшийн ажиллах орчны стандартын шаардлагыг хангасан ерөнхий боловсролын сургуулийн хувь гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+5%, 2027: Т+10%, 2028: Т+15%, 2029: Т+20%, 2030: Т+30%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 87
Бүгд: 87
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.3.1 дэх дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “КООСЭН хөтөлбөр хэрэгжүүлж буй политехник коллеж” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 3” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 4, 2027: - , 2028: 6, 2029: - , 2030: 7” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 1.1.3.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “1.1.3.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.1.34” гэж, “Салбар” баганад “71804 Мэргэжлийн боловсрол” гэж, “Үр дүн” баганад “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна.” гэж, “Арга зам” баганад “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас доошгүй тогтоож, ажиллах орчин, нийгмийн баталгааг сайжруулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр,

нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “1.1.3.4” гэж, “Салбар” баганад “71804 Мэргэжлийн боловсрол” гэж, “Үр дүн” баганад “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Багшийн үндсэн цалингийн улсын дундаж нэрлэсэн цалинтай харьцах харьцаа” гэж, “ТХЗ уялдаа” баганад “4.с.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Индекс” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 2.332.4 мян.төг” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 2,800,000 төгрөгөөс доошгүй (түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ), 2027: 2026 оны түвшнээс дээгүүр, 2028: 2027 оны түвшнээс дээгүүр, 2029: 2028 оны түвшнээс дээгүүр, 2030: 2029 оны түвшнээс дээгүүр” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.2 дахь заалтын “Үр дүн” баганад “Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.” гэснийг “Халдварт бус өвчлөлийг бууруулна.” гэж, “Арга зам” баганад “Хүн амын нийгэм, сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол, хандлагыг дээшлүүлэх” гэснийг “Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж өөрчилж, “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж нэмэх; 3 дугаар хавсралтын 1.2 дахь заалтын “Үр дүн” баганад “Халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.” гэснийг “Халдварт бус өвчлөлийг бууруулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хорт хавдраар нас барсан хүний тоо (100,000 хүнд ногдох)” гэж, “Хэмжих нэгж” баганад “Просантимиль” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганыг “Салбарын статистик” гэж өөрчлөн найруулж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Халдварт өвчний тохиолдлын тоо (10,000 хүнд ногдох), Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100,000 хүнд ногдох тухайн жилд сүрьеэгээр өвчилсөн хүний тоо)” гэсэн мөрийг тус тус хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1 дэх дэд заалтын “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.2” гэснийг “АХ-2.2.11” гэж, “Үр дүн” баганад “Эрүүл амьдралын дадал хэвшилтэй иргэдийг нэмэгдүүлнэ.” гэснийг “Эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” гэснийг “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын эрүүл мэндийн хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулах, санхүүжилт, хүртээмж, чанарыг сайжруулах” гэж өөрчлөх, “Хамтран хариуцагч” баганад “Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын

яам” гэснийг хасах; 3 дугаар хавсралтын 1.2.1 дэх дэд заалтын “Үр дүн” баганад “Эрүүл амьдралын дадал хэвшилтэй иргэдийг нэмэгдүүлнэ.” гэснийг “Эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.” гэж өөрчилж, “Шалгуур үзүүлэлт” баганыг “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт” гэж, “ТХЗ уялдаа” баганыг “3.8.1” гэж, “Хэмжих нэгж” баганыг “Хувь” гэж, “Суурь түвшин” баганыг “Он: 2024, Түвшин: 65” гэж, “Зорилтот түвшин” баганыг “2026: -, 2027: - , 2028: 67, 2029: -, 2030: -“ гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганыг “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, Үндэсний статистикийн хороо” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганыг “Салбарын статистик” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганыг “2 жил тутам” гэж тус тус өөрчлөн найруулах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.1 дэх дэд заалтын “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.2.22” гэснийг “АХ-2.2.3” гэж, “Үр дүн” баганад “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлнэ.” гэснийг “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” гэснийг “Хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулах” гэж тус тус өөрчилж, “Хамтран хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам, Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж нэмэх; 3 дугаар хавсралтын 1.2.1.1 дэх дэд заалтын “Үр дүн” баганад “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлнэ.” гэснийг “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганын 1, 2, 3 дахь мөрний “хамрагдалтын хувь” гэснийг “хамрагдалт” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганын 1, 2, 3 дахь мөрний “Эрүүл мэндийн яам” гэснийг “Эрүүл мэндийн статистик, эрүүл мэндийн хөгжлийн төв”, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганын 1, 2, 3 дахь мөрний “Захиргааны статистик” гэснийг “Салбарын статистик” гэж тус тус өөрчилж, дараах 4 шалгуур үзүүлэлт нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 4 дэх мөрөнд “Тамхины хэрэглээ - өдөр бүр тамхи татдаг хүмүүсийн эзлэх хувь (15-аас дээш насны хүн амын дунд)” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.а.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 22” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 21, 2027: 20, 2028: 19, 2029: 18, 2030: 17” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Мэдээлэл цуглуулах арга зүй: Түүвэр судалгаа, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам” гэж,

- “Шалгуур үзүүлэлт” баганын 5 дахь мөрөнд “Архины хэрэглээ – борлуулалтын мэдээлэлд үндэслэн нэг хүнд ногдох хэмжээ (15-аас дээш насны хүн амын дунд)” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.5.2.” гэж, “Хэмжих нэгж” баганад “Литр” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 7.9” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 7.5, 2027: 7.2, 2028: 6.8, 2029: 6.4, 2030: 6.1” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: “Нийгмийн эрүүл мэндийн

үндэсний төв, Мэдээлэл цуглуулах арга зүй: Түүвэр судалгаа, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам” гэж,

- “Шалгуур үзүүлэлт” баганын 6 дахь мөрөнд “Таргалалт – Биеийн жингийн индекс (BMI) ≥30 дээш хүн амын эзлэх хувь (15-аас дээш насны хүн амын дунд)” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.4.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 18.5” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 17.6, 2027: 16.7, 2028: 16.0, 2029: 15.1, 2030: 14.0” гэж “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Мэдээлэл цуглуулах арга зүй: Түүвэр судалгаа, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам” гэж,

- “Шалгуур үзүүлэлт” баганын 7 дахь мөрөнд “Орчны агаарын бохирдол – орчны тоосонцор, ялангуяа PM 2.5 (100,000 хүнд ногдох)-ын улмаас үүдэлтэй нас баралт” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.9.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 132” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: “Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Мэдээлэл цуглуулах арга зүй: Түүвэр судалгаа, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ хуралдааныг 17 цаг 09 минутаас 20 цаг 10 минутад даргалав.

Ж.Бат-Эрдэнэ: 40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.2 дахь дэд заалтын “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.2.24” гэснийг “АХ-2.2.14” гэж, “Үр дүн” баганад “Эмийн чанарыг сайжруулна.” гэснийг “Анхан шатны тусламж, үйлчилгээг бэхжүүлж, халдварт бус өвчний хяналтыг сайжруулна” гэж, “Арга зам” баганад “Эмийн хяналтыг сайжруулах” гэснийг “Анхан шатны тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлэх” гэж; 3 дугаар хавсралтын 1.2.1.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Эмийн чанарыг сайжруулна.” гэснийг “Анхан шатны тусламж, үйлчилгээг бэхжүүлж, халдварт бус өвчний хяналтыг сайжруулна” гэж өөрчилж, “Шалгуур үзүүлэлт” мөрийг бүхэлд нь хасаж, дараах 4 шалгуур үзүүлэлт нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 1 дэх мөрөнд “Анхан шатны тусламж үйлчилгээ хүртсэн хүн ам” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.b.2” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024” гэж, “Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+1%, 2027: Т+2%, 2028: Т+2%, 2029: Т+3%, 2030: Т+3%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн яам” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулж буй нийт зардалд анхан шатны тусламж, үйлчилгээнд зарцуулж буй зардал” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.b.2” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+2%, 2027: Т+3%, 2028: Т+4%, 2029: Т+5%, 2030: Т+6%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 3 дахь мөрөнд “Алслагдмал бүс нутгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хангамж” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.b.2” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он:2024” гэж, “Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад 2026: Т+1%, 2027: Т+2%, 2028: Т+3%, 2029: Т+4%, 2030: Т+5%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн статистик, эрүүл мэндийн хөгжлийн төв” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 4 дэх мөрөнд “Анхан шатны тусламж, үйлчилгээг “хүртээмжгүй”, “бэрхшээлтэй” гэж үнэлсэн хүн ам” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.b.2” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024” гэж, “Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: -, 2027: Т-10%, 2028: -, 2029: Т-15%, 2030: -“ гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн статистик, эрүүл мэндийн хөгжлийн төв” гэж, ”Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Түүвэр судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “2 жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 1.2.1.3 дахь дэд заалтын “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.2.23” гэснийг “АХ-2.2.12” гэж, “Үр дүн” баганад “Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг өргөжүүлнэ.” гэснийг “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ” гэж, “Арга зам” баганад “Үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх” гэснийг “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг хүн-төвтэй, нэгдмэл загварт шилжүүлж, чанар, үр дүнг сайжруулах” гэж өөрчилж, 3 дугаар хавсралтын 1.2.1.3 дахь дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад дараах 7 мөр нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Артерийн даралт ихсэх өвчний хяналтад орж тогтворжсон иргэдийн тоо /нийт артерийн даралт ихсэх өвчтэй иргэдэд эзлэх хувиар/” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.4.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024” гэж, “Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+4%, 2027: Т+8%, 2028:Т+12%, 2029: Т+16%, 2030: Т+20%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн статистик, эрүүл мэндийн хөгжлийн төв” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Түүвэр

судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, ”Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 3 дахь мөрөнд “Амбулаториор эмчлэх боломжтой, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй тохиолдол” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.8.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024” гэж, “Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+3%, 2027: Т+5%, 2028: Т+8%, 2029: Т+10%, 2030: Т+15%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын статистик” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 4 дэх мөрөнд “Артерийн даралтын улмаас эмнэлэгт хэвтэх (18 ба түүнээс дээш насны 100,000 хүн амд ногдох цусны даралт ихсэх өвчний үндсэн оношгой эмнэлэгт хэвтсэн тохиолдлын тоо)” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.4.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024” гэж, “Түвшин: 1928” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 1830, 2027: 1720, 2028: 1610, 2029: 1500, 2030: 1400” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн статистик, эрүүл мэндийн хөгжлийн төв” гэж,” Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Түүвэр судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, ”Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 5 дахь мөрөнд “Тодорхойгүй, уушигны хатгалгааны улмаас эмнэлэгт хэвтэх (18 ба түүнээс дээш насны 100,000 хүн амд ногдох нянгийн гаралтай уушигны хатгалгааны үндсэн оношгоор эмнэлэгт хэвтсэн тохиолдлын тоо)” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.4.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024” гэж, “Түвшин: 382.7” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 365, 2027: 340,5, 2028: 320, 2029: 300, 2030: 280“ гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын статистик” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, ”Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 6 дахь мөрөнд “Тодорхойгүй, уушигны хатгалгааны улмаас эмнэлэгт хэвтэх (18 ба түүнээс дээш насны 100,000 хүн амд ногдох нянгийн гаралтай уушгины хатгалгааны үндсэн оношгоор эмнэлэгт хэвтсэн тохиолдол)” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.4.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т-3%, 2027: Т-5%, 2028: Т-8%, 2029: Т-10%, 2030: Т-15%”, гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын статистик” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, ”Хариуцах байгууллага” баганад “Эрүүл мэндийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 7 дахь мөрөнд “Хорт хавдраар оношлогдож, эмчлэгдсэнээс хойш 5-аас дээш жил амьдарсан иргэдийн тоо /нийт хорт хавдрын хяналтад буй иргэдэд эзлэх хувиар/” гэж, “ТХЗ уялдаа” баганад “3.4.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин:

79.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 4.4.1.5 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Импортыг орлох барилгын материалын үйлдвэрийг нэмэгдүүлнэ” гэснийг “Олон улсын стандартад нийцсэн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх; Төслийн 3 дугаар хавсралтын 4.4.1.5 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Импортыг орлох барилгын материалын үйлдвэрийг нэмэгдүүлнэ” гэснийг “Олон улсын стандартад нийцсэн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

80.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 4.4.3.3 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.4.3.3.” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-7.3” гэж, “Салбар” баганад “70708 Гамшгаас урьдчилан сэргийлэх тэмцэх” гэж, “Үр дүн” баганад “Онцгой байдал, шуудан тээвэр, байгаль орчин болон бусад чиглэлд хүнгүй техник хэрэгслийг зохион бүтээх, ашиглалтыг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Шинэ технологи нэвтрүүлж, дотоодын үйлдвэрлэлийг төрийн худалдан авалт, татварын болон татварын бус аргаар дэмжих” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Цахим, хөгжил, харилцаа, холбооны яам, Байгаль орчин, уур амьсгалын, өөрчлөлтийн яам, Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн)” гэж; Төслийн 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.4.3.3.” гэж, “Салбар” баганад “70708 Гамшгаас урьдчилан сэргийлэх тэмцэх” гэж, “Үр дүн” баганад “Онцгой байдал, шуудан тээвэр, байгаль орчин болон бусад чиглэлд хүнгүй техник хэрэгслийг зохион бүтээх, ашиглалтыг нэмэгдүүлнэ” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хүнгүй техник хэрэгслийн тоо” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+10%, 2027: Т+20%, 2028: Т+30%, 2029: Т+40%, 2030: Т+50%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Онцгой байдлын ерөнхий газар” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын статистик” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

81.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 4.4.1.7 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.4.1.7” гэж, “Бодлогын үндэслэл баганад “АХ-3.2” гэж, “Хөтөлбөрийн нэр” баганад “71509 Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага” гэж, “Үр дүн” баганад “Дуу чимээний бохирдлыг бууруулна” гэж, “Арга зам” баганад “Барилга, бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээг дуу чимээний стандартад нийцүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Зам, тээврийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эрчим хүчний яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.4.1.7” гэж, “Хөтөлбөрийн нэр” баганад “71509 Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага” гэж, “Үр дүн” баганад “Дуу чимээний бохирдлыг бууруулна” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Дуу чимээний бохирдлын түвшин” гэж, “Хэмжих нэгж” баганад “децибел” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т-5%, 2027: Т-10%, 2028: Т-15%, 2029: Т-20%, 2030: Т-40%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Засгийн газар дахь хяналт хэрэгжүүлэх газар” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Чанарын судалгаа, хяналт шалгалтын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад

“Хоёр жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

82.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 4.2.4.5 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.2.4.5” гэж, “Бодлогын үндэслэл баганад “АХ-2.3.2” гэж, “Хөтөлбөрийн нэр” баганад “72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал” гэж, “Үр дүн” баганад “Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийг нийгэмшүүлж, хохирсон хүүхдэд хамгааллын үйлчилгээг шуурхай, оновчтой, хүртээмжтэй үзүүлнэ” гэж, “Арга зам” баганад “Хүүхдийн хамгааллын болон хөгжлийн үйлчилгээнд хамруулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж; Төслийн 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.2.4.5” гэж, “Хөтөлбөрийн нэр” баганад “72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал” гэж, “Үр дүн” баганад “Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүүхдийг нийгэмшүүлж, гэмт хэрэг, зөрчилд давтан холбогдохоос урьдчилан сэргийлнэ.” гэж нэмж, дараах 2 шалгуур үзүүлэлт нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 1 дэх мөрөнд “Гэмт хэрэг, зөрчилд давтан холбогдсон хүүхдийн эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т-5%, 2027:Т-10%, 2028:Т-15%, 2029:Т-20%, 2030:Т-40%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Цагдаагийн ерөнхий газар” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Бүртгэл, тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Хохирогч хүүхдийн хамгааллын үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+5%, 2027: Т+10%, 2028: Т+15%, 2029: Т+20%, 2030: Т+30%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Түүвэр судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 87
Бүгд: 87
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

83.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 4.2.5.5 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.2.5.5” гэж, “Бодлогын үндэслэл баганад “АХ-7.3” гэж, “Хөтөлбөрийн нэр” баганад “70704 Цагдаа” гэж, “Үр дүн” баганад “Цахим орчинд хүний эрхийг хамгаална.” гэж, “Арга зам” баганад “Цахим орчны мэдлэгийг нэмэгдүүлэх технологийн хамгаалалтын арга хэрэгслийг сайжруулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж; 3 дугаар хавсралтын “дугаар” баганад “4.2.5.5” гэж, “Хөтөлбөрийн нэр” баганад “70704 Цагдаа” гэж, “Үр дүн” баганад “Цахим орчинд хүний эрхийг хамгаална” гэж нэмж, дараах 2 шалгуур үзүүлэлт нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 1 дэх мөрөнд “Цахим гэмт хэрэгт өртсөн бодит тохиолдол” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т-5%, 2027: Т-10%, 2028: Т-15%, 2029: Т-20%, 2030: Т-40%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Цагдаагийн ерөнхий газар” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Тоон болон чанарын судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж;

- “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Цахим орчинд эрх нь зөрчигдсөн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах болон шийдвэрлэх хугацаа” гэж, “Хэмжих нэгж” баганад “Цаг” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т-5%, 2027: Т-10%, 2028: Т-15%, 2029: Т-20%, 2030: Т-40%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Судалгааны байгууллага, иргэний нийгмийн байгууллага” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Чанарын судалгаа, асуумж судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

84.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 4.4.3 дахь заалтын “Үр дүн” баганад “Гамшгийн улмаас учирсан хохирлыг бууруулна.” гэснийг “Байгалийн гамшиг болон ослын улмаас учирсан хохирлыг бууруулна.” гэж өөрчлөх, “Шалгуур үзүүлэлт” баганад “100,000 хүнд ногдох гамшгийн улмаас амь насаа алдсан, сураггүй болсон, гамшигт шууд нэрвэгдсэн хүний тоо” гэснийг “100,000 хүнд ногдох гамшиг, аюулт үзэгдэл, ослын ийн улмаас амь насаа алдсан, сураггүй болсон, гамшигт шууд нэрвэгдсэн хүний тоо” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 171.7 гэснийг 192.4 гэж, 2027: 161.9 гэснийг 191.6 гэж, 2028: 146.2 гэснийг 190.2 гэж, 2029: 132 гэснийг 190 гэж, 2030: 119.2 гэснийг 189.2” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87

1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

85.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 4 дэх заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад “Сайн сайхан байдал” гэснийг “Үндэсний сайн сайхан байдал” гэж өөрчилж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Үндэсний статистикийн хороо” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

86.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 5.1 дэх дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад 2 дахь мөрөнд “Нефтийн бүтээгдэхүүний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 0” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 0, 2027: 0, 2028: 0, 2029: 20, 2030: 38” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Үндэсний тооцоо, Үндэсний статистикийн хороо”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

87.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.1.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.” гэснийг “Хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, экспортын хэмжээг нэмэгдүүлж, төрийн худалдан авалтаар дэмжинэ.” гэж; 3 дугаар хавсралтын 5.1.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.” гэснийг “Хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, экспортын хэмжээг нэмэгдүүлж, төрийн худалдан авалтаар дэмжинэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

88.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.1.2.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Менежментийг сайжруулах” гэснийг "Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх цагаан алт хөтөлбөрийг хэрэгжүүлэх" гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

89.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.2 дахь заалтын “Арга зам” баганад “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах” гэсний дараа “, геологи, эрэл хайгуулын чиглэлээр төрөөс хийгдэх ажлыг нэмэгдүүлэх” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

90.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.3 дахь заалтын “Арга зам” баганад “Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах” гэснийг “Анхан шатанд малын гаралтай түүхий эдийг хүлээн авах, чанараар үнэлэх тогтолцоог бүрдүүлэх” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

91.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.3.1.3 дахь дэд заалтын “Арга зам” баганад "Дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх гэсний дараа ". Атрын аяныг хэрэгжүүлэх" гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

92.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.5.1 дэх дэд заалтын “Үр дүн” баганад “Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.” гэсний дараа “Бага хүүтэй зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж; 3 дугаар хавсралтын 5.5.1 дэх дэд заалтын Үр дүн” баганад “Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.” гэсний дараа “Бага хүүтэй зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Санхүүгийн зохицуулах хороо гэсний өмнө “Монголбанк,” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Санхүүгийн зохицуулах хороо гэсний өмнө “Монголбанк,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

93.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.5.1.2 дахь дэд заалтын “Арга зам" баганад "Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх” гэсний дараа “, хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх" гэж; 3 дугаар хавсралтын 5.5.1.2 дахь дэд заалтын “Мэдээллийн эх сурвалж” баганад “Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага” гэсний дараа “, Санхүүгийн зохицуулах хороо” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

94.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 5.5.1.4 дэх дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “5.5.1.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.3.2” гэж, “Салбар” баганад “Санхүүгийн зохицуулах хороо” гэж, “Үр дүн” баганад “Давхар даатгалын хураамж хэлбэрээр гадагш гарч буй валютын урсгал буурна.” гэж, “Арга зам” баганад “Дотоодын аж ахуйн нэгжийг дэмжиж, хамтын ажиллагааг сайжруулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Санхүүгийн зохицуулах хороо” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “5.5.1.4” гэж, “Салбар” баганад “Санхүүгийн зохицуулах хороо” гэж, “Үр дүн” баганад “Давхар даатгалын хураамж хэлбэрээр гадагш гарч буй валютын урсгал буурна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Гадагш шилжүүлж буй давхар даатгалын хураамжийн нийт хураамжид эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 31.4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 30, 2027: 28, 2028: 25, 2029: 23, 2030: 20” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Санхүүгийн зохицуулах хороо” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

95.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.6.1.1 дэх заалтын “Арга зам” баганад Гадаадын хөрөнгө оруулалтыг татах” гэсний дараа “тархмал эх үүсвэрийг нэмэгдүүлэх” гэж, 5.6.1.3 дахь заалтын “Арга зам” баганад “Дэд бүтэц, техникийн шинэчлэл хийх” гэсний дараа “, тархмал эх үүсвэрийг нэмэгдүүлэх” гэж нэмж, 7.3.6.1 дэх заалтын “Арга зам” баганыг “Нэгдсэн төлөвлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх” гэж өөрчилж, “Хамтран хариуцагч” баганад “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмж, 7.3.3.3 дахь заалтын “Арга зам” баганад “Үнэлгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх” гэснийг “Үр дүнд суурилсан үнэлгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх” гэж, 7.3.5.1 дэх заалтын “Арга зам” баганад “Хариуцлагыг нэмэгдүүлэх” гэснийг “Хөрөнгийн өгөөжийг инфляцаас

өндөр түвшинд хүргэх” гэж, 7.6.1.1 дэх заалтын “Арга зам” баганад “Гадаад улсын виз авах нөхцөлийг хөнгөвчлөх” гэснийг “Энгийн паспортоор визгүй зорчдог улсын тоог нэмэгдүүлэх” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

96.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 5.7.1.1 дэх дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замаар хилийн боомттой холбогдсон аймаг” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 6”, “Зорилтот түвшин” баганад “2026: 7, 2027: 8, 2028: 9, 2029: 10, 2030: 13” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Зам, тээврийн яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Захиргааны статистик, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Зам, тээврийн яам” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

97.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.2 дахь хэсгийн “Үр дүн” баганад “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн шинэчилнэ.” гэснийг “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн шинэчилж, бүсийн төв, нийслэл хоорондын зорчих хугацааг бууруулна.” гэж өөрчилж, “Хамтран хариуцагч” баганад “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)” гэж нэмэх; 3 дугаар хавсралтын 5.7.1.2 дахь хэсгийн “Үр дүн” баганад “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн шинэчилнэ.” гэснийг “Олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөн шинэчилж, бүсийн төв, нийслэл хоорондын зорчих хугацааг бууруулна.” гэж өөрчилж, “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Бүсийн төв, нийслэл хоорондын зорчих хугацааны бууралт” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т-5%, 2027: Т-10%, 2028: Т-15%, 2029: Т-20%, 2030: Т-25%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Зам, тээврийн яам” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Захиргааны статистик” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам”, “Хариуцах байгууллага” баганад “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

98.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 5.7.1.3 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.” гэснийг “Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлж, зорчих хугацааг бууруулна.” гэж өөрчилж, “Арга зам” баганад “Төмөр замын дэд бүтцийг өргөтгөх, сүлжээний бэлэн байдлыг хангах” гэсний дараа “цахилгаанжуулах” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)” гэж тус тус нэмэх, 3 дугаар хавсралтын 5.7.1.3 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ.” гэснийг “Төмөр замын сүлжээний уртыг нэмэгдүүлж, зорчих хугацааг бууруулна.” гэж өөрчилж, “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Босоо тэнхлэгийн төмөр замаар зорчих хугацааны бууралт” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин:Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т-5%, 2027: Т-10%, 2028: Т-15%, 2029: Т-20%, 2030: Т-25%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Зам, тээврийн яам” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Захиргааны статистик” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам”, “Хариуцах байгууллага” баганад “Зам, тээврийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

99.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.1.1.1 дэх заалтын “Арга зам” баганад “Уламжлалт мэдлэг, технологид суурилсан олон талын оролцоотой хамгаалалтын механизмыг хэрэгжүүлэх” гэснийг “Олон талын оролцоотой байгаль хамгаалалтын механизмыг эдийн засгийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

100.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.2.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Бохирдол багатай цэвэр технологи нэвтрүүлэх” гэснийг “70 хувиас дээш эрчим хүчний хэмнэлттэй болгон дулаалсан сууцны тоог нэмэгдүүлж, эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлэх” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

101.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.2.1.3 дахь хэсэгт “Арга зам” баганад “Хөрсний бохирдлын судалгаа, хяналт шинжилгээг сайжруулах” гэснийг “Бие даасан болон нэгдсэн цэвэрлэх байгууламжийн дэд

бүтцийг хүн амын нягтралд нийцүүлэн нэмэгдүүлэх” гэж өөрчлөх, “Хамтран хариуцагч” баганад “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

102.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.2.1.4 дэх заалтын “Арга зам” баганад “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгалтыг дэмжих” гэснийг “Үнэлгээжүүлэлтэд суурилсан боловсруулалтын түвшинг дээшлүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

103.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.2.2.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Үр ашигтай, ухаалаг технологи нэвтрүүлэх” гэсний дараа “, тархмал эх үүсвэрийг нэмэгдүүлэх” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

104.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.2.3.1 дэх хэсэгт “Арга зам” баганад “Гэр хорооллын сууц болон угсармал орон сууцыг ногоон барилгын шаардлагад нийцүүлэх” гэснийг “Гэр хорооллын сууц болон угсармал орон сууцыг ногоон барилгын шаардлагад нийцүүлэх, шинээр баригдах бүх төрлийн барилгыг эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй барих стандартад шилжүүлэх” гэж өөрчлөх, “Хамтран хариуцагч” баганад “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж; 3 дугаар хавсралтын 6.2.3.1 дэх дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “70 хувиас дээш эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын шалгуур хангасан сууцны нийт сууцанд эзлэх хувь” гэж “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 10” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 17, 2027: 30, 2028: 47, 2029: 63, 2030: 80” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Хот байгуулалтын кадастрын цахим системийн мэдээллийн сан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганын 3 дахь мөрөнд “Үл хөдлөхийн гэрчилгээ шинээр авч буй барилгад Ногоон барилгын шалгуур хангасан барилгын эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2025, Түвшин: 1” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 10, 2027: 20, 2028: 30, 2029: 40, 2030: 50” гэж, “Мэдээллийн

үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Хот байгуулалтын кадастрын цахим системийн мэдээллийн сан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

105.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтын 6.2.4.1 дэх дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

106.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.2 дахь дэд заалтын “Арга зам" баганад "Ногоон эдийн засгийг дэмжих” гэсний дараа “, үнийн болон татварын бодлого хэрэгжүүлэх” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

107.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар хавсралтын 6.2.4.2 дахь дэд заалтын шалгуур үзүүлэлтийн “Зорилтот түвшин” баганад “2026: “2” гэснийг “0” гэж, 2027: “4” гэснийг “0” гэж, 2028: “7” гэснийг “0” гэж, 2029: “8” гэснийг “0” гэж, 2030: “9” гэснийг “1” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

108.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.3 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Байгалийн нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг сайжруулна.” гэснийг “Байгалийн нөөцийг судалж, хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг сайжруулна.” гэж; 3 дугаар хавсралтын 6.3 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Байгалийн нөөцийн хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг сайжруулна.” гэснийг “Байгалийн нөөцийг судалж, хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалтыг сайжруулна” гэж

тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

109.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.3.1.5 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөрсийг хамгаалж, нөхөн сэргээнэ.” гэснийг “Хөрс болон доройтсон бэлчээрийг хамгаалж, нөхөн сэргээлтийг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх,” гэснийг “Бүс нутгийн онцлогт тохирсон бэлчээрийн олон наст ургамал тариалах, органик бордоогоор бордох, хөрсний үржил шим, бүтээмжийг нэмэгдүүлэх” гэж өөрчлөх; 3 дугаар хавсралтын 6.3.1.5 дахь заалтын “Үр дүн” баганад “Хөрсийг хамгаалж, нөхөн сэргээнэ.” гэснийг “Хөрс болон доройтсон бэлчээрийг хамгаалж, нөхөн сэргээлтийг нэмэгдүүлнэ.” гэж өөрчилж, “Шалгуур үзүүлэлт” баганын 4 дэх мөрөнд “Жилд дунджаар сайжруулж, нөхөн сэргээсэн талбайн хэмжээ” гэж, “Хэмжих нэгж” баганад “Сая.га” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 3.1” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 3, 2027: 3, 2028: 3, 2029: 3, 2030: 3” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Газрын нэгдмэл сангийн тайлан, Үндэсний статистикийн хороо” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын статистик” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмж, тус нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан төслийн 2, 3 дугаар хавсралтын 6.3.2.2 дахь дэд заалтыг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

110.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 6.3.2.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Малчдын зохистой хэмжээнд тэжээл бэлтгэж хадгалах дадал хэвшлийг сайжруулах” гэснийг “Бэлчээр, тэжээлийн нэг болон олон наст ургамлын үр, үйлдвэрлэлийг дотоодоосоо хангаж үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн тэжээлийн нэр төрөл, чанарыг сайжруулах, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

111.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.1.1 дах дэд заалтын “Үр дүн” баганад “Авлигыг тэвчих соёл, хандлагыг нэмэгдүүлнэ.” гэснийг “Авлигыг үл тэвчих соёл хандлагыг бүрдүүлнэ.” гэж; 3 дугаар хавсралтын 7.1.1 дэх дэд заалтын “Үр дүн” баганад “Авлигын тэвчих соёл, хандлагыг нэмэгдүүлнэ.”

гэснийг “Авлигыг үл тэвчих соёл, хандлагыг бүрдүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

112.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.2.1.3 дахь заалтын “Арга зам” баганад “Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэлийг тодорхойлох” гэсний өмнө “Хөдөлмөрийн ур чадварыг дээшлүүлэх,” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

113.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.2.1.10 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын “Дугаар” баганад 7.2.1.10 гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-7.4” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн” баганад “Иргэний орон зайг хамгаалж, иргэний нийгмийн байгууллагын чөлөөтэй ажиллах боломжийг сайжруулна.” гэж, “Арга зам” баганад “Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж; 3 дугаар хавсралтын дугаар баганад “7.2.1.10” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн” баганад “Иргэний орон зайг хамгаалж, иргэний нийгмийн байгууллагын чөлөөтэй ажиллах боломжийг сайжруулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажилласан төрийн байгууллагын тоо” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: - , 2027: -, 2028: Т+20%, 2029: -, 2030: Т+40%” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Иргэний нийгмийн байгууллага” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Тоон болон чанарын судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

114.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.2.1.11 дэх дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.2.1.11” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-7.4” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн” баганад “Хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулна.” гэж, “Арга зам”

баганад “Сэтгүүлчдэд хүний эрхийн боловсрол олгох” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.2.1.11” гэж, “Хөтөлбөрийн нэр” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн” баганад “Хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекс” гэж, “Хэмжих нэгж” баганад “Эрэмбэ” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 102” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 100 , 2027: 98, 2028: 96, 2029: 94, 2030: 92” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллага” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

115.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Ур чадварт суурилсан томилгоог төлөвшүүлэх” гэснийг “Төрийн албан хаагчдын ур чадварыг хөгжүүлж, ур чадварт суурилсан томилгоог төлөвшүүлэх” гэж, 3 дугаар хавсралтын 7.3.1 дэх дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад “Төрийн албаны сул орон тооны нөхөн бүрдүүлэлт” гэснийг “Албан тушаалын шаардлагад нийцсэн мэргэжлээр ажиллаж буй төрийн албан хаагчдын эзлэх хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Түвшин: 47” гэснийг “Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад 2026: “50” гэснийг “Т+10%” гэж, “2027: “55” гэснийг “Т+15%” гэж, 2028: “60” гэснийг “Т+20%”, “2029: “65” гэснийг “Т+25%”, 2030: “70” гэснийг “Т+30%” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 86
Бүгд: 87
1.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

116.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.2.1 дэх дэд заалтын “Үр дүн” баганад “Төрийн албаны сургалтын чанарыг дээшлүүлнэ” гэснийг “Төрийн албаны сургалт хөгжлийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж; 3 дугаар хавсралтын 7.3.2.1 дэх заалтын “Үр дүн” баганад “Төрийн албаны сургалтын чанарыг дээшлүүлнэ” гэснийг “Төрийн албаны сургалт хөгжлийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

117.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.2.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөгжлийн бодлого болон байгууллагын гүйцэтгэлийн нийцтэй байдлыг сайжруулна.” гэснийг “Хөгжлийн бодлого болон байгууллагын

гүйцэтгэлийн уялдаа холбоог сайжруулна.” гэж “Арга зам” баганад “Гүйцэтгэлийн менежментийн чадавхыг бэхжүүлэх” гэснийг “Гүйцэтгэлийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх” гэж; 3 дугаар хавсралтын 7.3.2.2 дахь заалтын “Үр дүн” баганад “Хөгжлийн бодлого болон байгууллагын гүйцэтгэлийн нийцтэй байдлыг сайжруулна.” гэснийг “Хөгжлийн бодлого болон байгууллагын гүйцэтгэлийн уялдаа холбоог сайжруулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний зөрүү” гэснийг “Төрийн байгууллагуудын чиг үүргийн давхардлын бууралтын хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Оноо” гэснийг “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “2023” гэснийг “2024” гэж, “Түвшин” баганад “1.8” гэснийг “Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 2, 2027: 2, 2028: 2, 2029: 2, 2030: 2” гэснийг “2026: Т-10%, 2027: Т-15%, 2028: Т-20%, 2029: Т-20%, 2030: Т-25%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Тухайн жилийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний үр дүнгээр тооцно. Зөрүүг (-2 - +2) интервалын хооронд хадгална.” гэснийг “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

118.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Чадахуйн зарчимд суурилсан оновчтой чиг үүрэг, бүтэц бүхий цомхон, чадварлаг төрийн албыг бэхжүүлнэ.” гэснийг “Төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.” гэж, “Арга зам” баганад “Төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг, орон тоог оновчтой тогтоох” гэснийг “Төрийн албанд дахин инженерчлэлийг хэрэгжүүлж, чиг үүргийн давхардлыг арилгах” гэж; 3 дугаар хавсралтын 7.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Чадахуйн зарчимд суурилсан оновчтой чиг үүрэг, бүтэц бүхий цомхон, чадварлаг төрийн албыг бэхжүүлнэ.” гэснийг “Төрийн албаны чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

119.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.3.2.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.3.2.4” гэж, Бодлогын үндэслэл” баганад “АХ-5.4.1, 5.4.12” гэж, “Салбар” баганад “70103 Гүйцэтгэх засаглалын удирдлага” гэж, “Үр дүн” баганад “Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчдын сурч, хөгжих боломжийг нэмэгдүүлж, оролцоог дээшлүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Чадавхжуулах сургалтад хамруулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад

“7.3.2.4” гэж, “Салбар” баганад “70103 Гүйцэтгэх засаглалын удирдлага” гэж, “Үр дүн” баганад “Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчдын сурч, хөгжих боломжийг нэмэгдүүлж, оролцоог дээшлүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчдад зориулсан төрийн албаны сургалтын уян хатан зохицуулалтын хүрээнд сургалтад хамрагдсан төрийн албан хаагч” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2025, Түвшин: “-” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 30, 2027: 50, 2028: 70, 2029: 90, 2030: 100” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Сургалтын үр дүн, тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

120.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.3.2.5 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.3.2.5” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-5.4.1, 5.4.12” гэж, “Салбар” баганад “70103 Гүйцэтгэх засаглалын удирдлага” гэж, “Үр дүн” баганад “Төрийн албанд хүний эрхийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Төрийн албан хаагчдыг хүний эрхийн сургалтад хамруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.3.2.5” гэж, “Салбар” баганад “70103 Гүйцэтгэх засаглалын удирдлага” гэж, “Үр дүн” баганад “Төрийн албанд хүний эрхийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Шинээр боловсруулж, баталсан хүний эрхийн хичээлийн хөтөлбөрийн хүрээнд сургалтад хамрагдсан төрийн албан хаагчид” гэж, “ТХЗ уялдаа” баганад “5.5” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2025, Түвшин: “-” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 20, 2027: 40, 2028: 60, 2029: 80, 2030: 100” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Сургалтын үр дүн, тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Судалгаа” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

121.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.3.2.6 дахь дэд заалт нэмэх:

Төслийн 2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.3.2.6” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-5.5.” гэж, “Салбар” баганад “70103 Гүйцэтгэх засаглалын удирдлага” гэж, “Үр дүн” баганад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд

гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл явцыг хялбаршуулна.” гэж, “Арга зам” баганад “Шат дамжлагыг бууруулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.3.2.6” гэж, “Салбар” баганад “70103 Гүйцэтгэх засаглалын удирдлага” гэж, “Үр дүн” баганад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үйл явцыг хялбаршуулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Өргөдөл, гомдлыг нэг удаагийн шийдвэрлэлтээр шийдвэрлэсэн байдал” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Т+20%, 2027: Т+30%, 2028: Т+40%, 2029: Т+50%, 2030: Т+55%” гэж, “Мэдээллийн эх сурвалж: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Бүртгэл, тайлан”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

122.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.6 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Газар өмчлөлийг эрчимжүүлнэ.” гэснийг “Газрын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Газрын хэмжилт, зураглал, төлөвлөлт, бүртгэлийг сайжруулах” гэснийг “Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах” гэж, 3 дугаар хавсралтын 7.3.6 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Газар өмчлөлийг эрчимжүүлнэ.” гэснийг “Газрын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

123.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.1.1 дэх дэд заалтын “Үр дүн” баганад “Төрийн албан хаагчийн томилгооны зөрчлийг бууруулна.” гэснийг “Төрийн албанд мерит зарчмыг бүрэн хэвшүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “чадамжид суурилсан сонгон шалгаруулалтыг бий болгох” гэснийг “төрийн албаны хүний нөөцийн удирдлагын тогтолцоог шинэчлэх” гэж; 3 дугаар хавсралтын 7.3.1.1 дэх дэд заалтын “Үр дүн” баганад “Төрийн албан хаагчийн томилгооны зөрчлийг бууруулна.” гэснийг “Төрийн албанд мерит зарчмыг бүрэн хэвшүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Төрийн албан хаагчийн томилгооны зөрчлийн бууралт” гэснийг “Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажил, албан тушаалаас чөлөөлсөн болон томилсон зөрчлийн бууралт” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

124.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.1.2 дах дэд заалтын “Үр дүн” баганад “төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.” гэснийг “Төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, төрийн албаны нэр хүндийг өсгөнө.” гэж, “Арга зам” баганад “Төрийн албан хаагчдын эдийн засаг, эрүүл мэнд, нэр хүнд, аюулгүй байдлын баталгааг хангах” гэснийг “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн нөхцөлийг дээшлүүлэх, цалин хөлс, нийгмийн баталгааг хангах” гэж; 3 дугаар хавсралтын 7.3.1.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.” гэснийг “Төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, төрийн албаны нэр хүндийг өсгөнө.” гэж тус тус өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

125.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.3.1 дэх заалтын “Арга зам” баганад “Цогц чанарын удирдлага нэвтрүүлэх” гэснийг “Чанарын цогц удирдлага нэвтрүүлэх” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

126.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.3.3.2 дахь заалтын “Арга зам” баганад “Бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийн нэгдсэн удирдлага бий болгох” гэснийг “Бодлого, төлөвлөлт, төсөвлөлт, хяналт үнэлгээний нэгдсэн удирдлага бий болгох” гэж, 3 дугаар хавсралтын 7.3.3.2 дахь заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийн уялдаа” гэснийг “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсөв, төсвийн гүйцэтгэлийн уялдаа” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

127.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.3.5.3 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.3.5.3” гэж, “Салбар” баганад “70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх” гэж, “Үр дүн” баганад “Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн оролцоог бууруулна.” гэж, “Арга зам” баганад “Эдийн засгийн аюулгүй байдлын нөлөөллийг тооцсоны үндсэн дээр төрийн оролцоог бууруулах боломжтой чиг үүрэг, үйлчилгээг хувийн хэвшлээр

гүйцэтгүүлэх, шилжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.3.5.3” гэж, “Салбар” баганад “70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх” гэж, “Үр дүн” баганад “Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн оролцоог бууруулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Чиг үүрэг, ажил үйлчилгээгээ хувийн хэвшилд шилжүүлсэн аж ахуйн нэгжийн тоо” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2025, Түвшин: 0” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 10, 2027:20, 2029: 30, 2028: 40 2030: 50” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: салбарын тайлан”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

128.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.5.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Сонгуульд оролцож буй иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх” гэснийг “Сонгуульд оролцож буй иргэдийн идэвх оролцоо, хяналтыг сайжруулах” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

129.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.6.1.2 дахь заалтын “Арга зам” баганад “Үйлчилгээг хялбарчлах” гэснийг “Хилийн чанад дахь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх зөрчигдсөн тохиолдолд хариуцсан байгууллагатай 72 цагийн дотор холбогдох” гэж өөрчлөх; 3 дугаар хавсралтын 7.6.1.2 дахь заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлт шийдвэрлэлтийн хувь” гэснийг “Хилийн чанад дахь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх зөрчигдсөн тохиолдолд хариуцсан байгууллагатай 72 цагийн дотор холбогдох” гэж, “Суурь түвшин” баганад “Түвшин: 95.17” гэснийг “Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 96” гэснийг “2026: Т+5%” гэж, “2027: 96” гэснийг “2027: Т+10%” гэж, “2028: 96” гэснийг “2028: Т+15%”, “2029: 97” гэснийг “2029: Т+20%” гэж, “2030: 98” гэснийг “2030: Т+25%” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 85
Бүгд: 87
2.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

130.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын 7.6.1.3 дахь заалтын “Арга зам” баганад “Дээд, өндөр түвшний айлчлалын давтамжийг хадгалах” гэснийг “Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын үнийн дүнд эзлэх хувь” гэж өөрчилж, “Үндсэн хариуцагч” баганад “, Эдийн засаг, хөгжлийн яам” гэж нэмэх; 3 дугаар хавсралтын 7.6.1.3 дахь заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад “Засгийн газар хооронд байгуулсан гэрээ хэлэлцээр” гэснийг “Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын үнийн дүнд эзлэх хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Түвшин: 15” гэснийг “Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “Он: 2026, Түвшин: 15” гэснийг “Он: 2026: Т+5%” гэж, “2027: 15” гэснийг “2027: Т+10%” гэж, “2028: 15” гэснийг “2028: Т+15%”, “2029: 19” гэснийг “2029: Т+20%” гэж, “2030: 20” гэснийг “2030: Т+25%” гэж тус тус өөрчилж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “, Эдийн засаг, хөгжлийн яам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж тус тус нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87
3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

131.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.6.1.4, 7.6.1.5 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2.44, 4.2.47, 4.5.8” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Баталгаат шуудан, цахим систем ашиглах, санал авах байрны тоог нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж; мөн хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.5” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-7.3 гэж, “Үр дүн” баганад “Онцгой байдал, шуудан тээвэр, байгаль орчин болон бусад чиглэлд хүнгүй техник хэрэгслийг зохион бүтээх, ашиглалтыг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Шинэ технологи нэвтрүүлж, дотоодын үйлдвэрлэлийг төрийн худалдан авалт, татварын болон татварын бус аргаар дэмжих” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам, Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил,онцгой байдлын асуудал эрхэлсэн)” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Цахим хөгжил, харилцаа, холбооны яам, Байгаль орчин, уур амьсгалын, өөрчлөлтийн яам, Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж, “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн сонгуульд оролцсон хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 7.1” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: -, 2027: 10, 2028: 15, 2029: -, 2030: -” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад

“Сонгуулийн ерөнхий хороо” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлж, хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

132.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.7.2 дахь дэд заалт нэмэх:

дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 50 дахь мөр тус тус нэмэх:

- 4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “50” гэж, “Бүс, аймаг” баганад “Говийн бүс: Өмнөговь” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, “Үр дүн” баганад “5.1.1” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2029” гэж, “Төсөвт өртөг /сая.төг/” баганад “75,645.7” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад “-“ гэж, “2026-2030” баганад “-” гэж, “2026” баганад “5,000.0” гэж, “2027” баганад “40,018.4” гэж, “2028” баганад “26,845.0” гэж, “2029” баганад “3,782.3” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Шууд хөрөнгө оруулалт” гэж, “Хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж;

- 4.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийн “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “50” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2029” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Барилга угсралтын ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь“ гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, “2026” баганад “7” гэж, “2027” баганад “53” гэж, “2028” баганад “95” гэж, “2029” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 42
Бүгд: 84
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 40
Бүгд: 84
52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Н.Учрал: 191.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 50 дахь мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 50 дахь мөр тус тус нэмэх:

- 4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “50” гэж, “Бүс, аймаг” баганад “Говийн бүс: Өмнөговь” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган

авах туршилтын үйлдвэр” гэж, “Үр дүн” баганад “5.1.1” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2029” гэж, “Төсөвт өртөг /сая.төг/” баганад “75,645.7” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад “-“ гэж, “2026-2030” баганад “-” гэж, “2026” баганад “5,000.0” гэж, “2027” баганад “40,018.4” гэж, “2028” баганад “26,845.0” гэж, “2029” баганад “3,782.3” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Шууд хөрөнгө оруулалт” гэж, “Хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж;

- 4.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийн “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “50” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2029” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Барилга угсралтын ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь“ гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, “2026” баганад “7” гэж, “2027” баганад “53” гэж, “2028” баганад “95” гэж, “2029” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 41
Бүгд: 84
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

192.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 84 дэх мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 84 дэх мөр тус тус нэмэх:

- 4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ” хэсгийн “Дугаар” баганад “84” гэж, “Бүс, аймаг” баганад “Баруун бүс, Увс” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн 164.5км хатуу хучилттай авто зам” гэж, “Үр дүн” баганад “5.7.1.1” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Төсөвт өртөг /сая.төг/” баганад “343,642.7” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад “-” гэж, “2026-2030” баганад “343,642.7” гэж, “2026” баганад “10,000.0” гэж, “2027” баганад “110,000.0” гэж, “2028” баганад “110,000.0” гэж, “2029” баганад “70,000.0” гэж, “2030” баганад “43,642.7” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Улсын төсөв” гэж, “Хариуцагч” баганад “Зам, тээврийн яам” гэж;

- 4.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийн “БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ” хэсгийн “Дугаар” баганад “84” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн 164.5 км хатуу хучилттай авто зам” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь“ гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, “2026” баганад “2.9” гэж, “2027” баганад “35.9” гэж, “2028” баганад “67.9” гэж, “2029” баганад “88.3” гэж, “2030” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Зам, тээврийн

яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 39
Бүгд: 84
53.6 хувийн саналаар дэмжигдлээ.

193.Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 88 дахь мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 88 дахь мөр тус тус нэмэх:

- 4.1 дэх хэсгийн жагсаалтын “ЗАСАГЛАЛ” хэсгийн “Дугаар” баганад “88” гэж, “Бүс, аймаг” баганад “Улсын хэмжээнд” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Ухаалаг засаг 2 төсөл” гэж, “Үр дүн” баганад “7.3.7” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2022-2027” гэж, “Төсөвт өртөг /сая.төг” баганад “145,048.28” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад “13,910.82” гэж, “2026-2030” баганад “125,296.21” гэж, “2026” баганад “78,682.47” гэж, “2027” баганад “52,454.98” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Гадаад зээл” гэж, “Хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж;

- 4.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийн “ЗАСАГЛАЛ” хэсгийн “Дугаар” баганад “88” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Ухаалаг засаг 2 төсөл” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2022-2027” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Төслийн хэрэгжилтийн явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь“ гэж, “Суурь түвшин” баганад “44” гэж, “2026” баганад “70” гэж, “2027” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн үг хэлж, дээрх саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

194.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг, Р.Сэддорж нарын гаргасан, Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 51 дэх мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 51 дэх мөр тус тус нэмэх:

- 4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “51” гэж, “Бүс, аймаг” баганад “Улаанбаатар, төв” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл” гэж, “Үр дүн” баганад “5.6.1.1, 6.2.2.2” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Төсөвт өртөг /сая.төг/” баганад “3,560,000.0” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад “-” гэж, “2026-2030” баганад “3,560,000.0” гэж, “2026” баганад “0” гэж, “2027” баганад “356,000.0” гэж, “2028” баганад “1,424,000.0” гэж, “2029” баганад “1,424,000.0” гэж, “2030” баганад “356,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Гадаад зээл” гэж, “Хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж;

- 4.2 дахь хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “51” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь“ гэж, “Суурь түвшин” баганад “-” гэж, “2026” баганад “-” гэж, “2027” баганад “10” гэж, “2028” баганад “50” гэж, “2029” баганад “90” гэж, “2030” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 49
Бүгд: 84
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 21 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал санал хураалтаар үргэлжлэв.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх саналыг нууц санал хураалтаар явуулав.

Н.Учрал: Барсүрэнгийн Баасандоржийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 31
Бүгд: 80
61.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигчийг томилох саналыг нууц санал хураалтаар явуулав.

Н.Учрал: Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 31
Бүгд: 80
61.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын гишүүдээс “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын *эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /21:31/*

Улсын Их Хурлын гишүүдээс “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын *эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /21:32/*

Уг асуудлыг 21 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Тав.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /*Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх***/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын ахлах мэргэжилтэн Х.Цэрэнханд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Л.Батмөнх, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Бямбацогт нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт

явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /21:57/

Зургаа.Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл */Засгийн газар 2025.11.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, мөн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Т.Ганбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Д.Даваабаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Л.Батмөнх нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням хариулж, тайлбар хийв.

Н.Учрал: Байнгын хорооноос гаргасан Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 76
Бүгд: 81
6.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 22 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***эцсийн хэлэлцүүлэг****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Эрдэнэ, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлувсан нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Л.Батмөнх, Б.Нандингэрэл референт Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж танилцуулав.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Н.Учрал: 1.Төслийн 2 дугаар хавсралтын 2.1.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.” гэснийг “Хөдөлмөрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх” гэснийг “Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх хүрээнд хамтын гэрээ хэлэлцээрийн чанарыг сайжруулах, тоог нэмэгдүүлэх” гэж; 3 дугаар хавсралтын 2.1.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.” гэснийг “Хөдөлмөрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 37
Бүгд: 82
54.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.6.1.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2.44, 4.2.47, 4.5.8” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Баталгаат шуудан, цахим систем ашиглах, санал авах байрны тоог нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж, “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн сонгуульд оролцсон хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 7.1” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: -, 2027: 10, 2028: 15, 2029: -, 2030: -” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 35
Бүгд: 82
57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2026 онд “2025 оны түвшнээс дээгүүр” гэснийг “2,800,000 төгрөгөөс доошгүй (түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ.) гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 37
Бүгд: 82
54.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин үг хэлэв.

4.Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2026 онд “2025 оны түвшнээс дээгүүр” гэснийг “2,800,000 төгрөгөөс доошгүй (түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ.) гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 37
Бүгд: 82
54.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Н.Учрал: “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 36
Бүгд: 82
56.1 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Д.Рэгдэл нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 82 гишүүнээс 48 гишүүн дэмжиж, 58.5 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 23 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийг хэлэлцэх эсэх асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Н.Учрал: Байнгын хороодын саналаар “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 38
Бүгд: 82
53.7 хувийн саналаар Байнгын хороодын санал дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 23 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Бусад.*Улсын Их Хурлын дарга Н.Учрал өнөөдөр* төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Д.Амарбаясгаланд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Батбаяр нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ЕБС-ын 11^{б} ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын урилгаар Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн Мөнгөнморьт сумын сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид, Төв аймгийн Батсүмбэр сумын Мандал багийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ЕБС-ын багш, ажилчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын урилгаар Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын Ж.Золжаргалын урилгаар нийслэлийн ЕБС-ын 40 дүгээр сургуулийн 12^{а} ,12^{г} ангийн багш, сурагчид, уран бүтээлч А.Мөнхдалайгийн урилгаар Соёл урлаг, нийгмийн салбарын залуу уран бүтээлчдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн *хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны* хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн референт Б.Нарантуяа, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 11 цаг 11 минут үргэлжилж, 126 гишүүнээс 89 гишүүн хүрэлцэн ирж, 70.6 хувийн ирцтэйгээр 23 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон "Их хуралдай" танхим
10 цаг 34 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж мэндчилье. Гишүүдийн ирц 74 гишүүн ирсэн. Ирц 58.7 хувьтай байна. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ.

1 дүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

2 дугаарт, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

3 дугаарт, "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хуулийн хугацаатай өнөөдөр эцсийн хэлэлцүүлгийг явуулж дуусах ёстой.

4 дүгээрт, "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газар 11 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Өдөр 14 цагаас Улсын Их Хурлын асуулгын цаг.

Үргэлжлээд "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

7 дугаарт, Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцууллаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Хууль зүйн байнгын хороо хуралдаж дууссан. Хууль зүйн байнгын хорооныхныг урьж байна. Номинчимэг дарга хуралдаан даргалсан.

Өнөөдрөөс төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлнэ. Улсын Их Хурлын гишүүн Дашзэгвийн Амарбаясгалан 11 сарын 27-ны өдөр Говь-Алтай аймгийн Тайшир сумд Дашзэгвэ, Норжин нарын отгон хүү болон мэндэлжээ. Дашзэгвийн Амарбаясгалан танд төрсөн өдрийн мэндийг дэвшүүлж, аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Одоо Хууль зүйн байнгын хороо. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн. Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна. Индэрт урья.

Да.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 96 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын санал болгосны дагуу томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүн Лувсандоржийн Өлзийсайхан үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын даргад ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.1.1 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын дарга Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх саналын талаар танилцуулахдаа Үндсэн хуулийн цэцийн гишүүн Л.Өлзийсайхан нь 2019, 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцдаа Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагын хувиар манлайлан оролцож, Монгол Улсад Үндсэн хуулийн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлж хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан.

Түүнчлэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу парламентын болон холбогдох салбарын эрх зүйн орчныг шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монголд парламентын ардчиллыг бэхжүүлэх, ард түмний засаглах эрхийг хангах чиглэлээр мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж ирсэн.

Парламент судлал, парламентын дэгийн асуудлаар мэргэшсэн байдал зэргийг нь харгалзан Монгол Улсын Их Хуралд дэгийн асуудлаар зөвлөх, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах, хуульд заасан бусад ажлыг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалд томилох саналыг тавьсныг хүлээн авсан талаар танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Д.Пүрэвдаваа, Ц.Сандаг-Очир нар асуулт асууж, хариулт авч, үг хэлсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Лувсандоржийн Өлзийсайханыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Учрал: Цогтбаатар гишүүнд баярлалаа.

Мэндчилгээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Золжаргалын урилгаар НЕБ-ын 40 дүгээр сургуулийн 12[а] ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөх ангийн сурагч дүү нартаа сурлагын өндөр амжилт хүсье. Элсэлтийн шалгалтаа амжилттай өгөхийг хүсье. Сонсогдож байгаа биз дээ тэр дотор? Сурлагын өндөр амжилт хүсье. Баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Өнөөдөр таван жилийн үндсэн чиглэл хэлэлцэнэ.

Шижир гишүүнээр тасаллаа.

Хүсэлт гаргасан Лувсандоржийн Өлзийсайхан гишүүн орж ирж суусан байгаа шүү. Ингээд Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асууна.

С.Эрдэнэболд: Би асуухгүй үг хэлье. Лувсандоржийн Өлзийсайхан доктор, Монгол Улсын Гавьяат хуульч, хуулийн салбартаа чанагдсан, өндөр нэр хүндтэй тэр тусмаа энэ парламент ёсны тухай онолын болон практикийн асар өндөр туршлагатай ийм хүн байгаа. Дээрээс нь манай бас эмэгтэй хуульчдын дунд өөрийн гэсэн бас олон жилийн хөдөлмөрөөрөө бас эмэгтэй хуульчдын нэрийг өндөрт өргөсөн ийм хүн байгаа. Тэгэхээр хувь хүнийх нь хувьд маш их хүндэлж, дэмжиж явдаг.

Гэвч сая бас Байнгын хорооны хурал дээр хэлсэн саналаа дахиж хэлэхэд Монгол Улсын Цэцийн гишүүн 6 жилээр томилогддог. Тэгээд гуравны нэг хугацаанд нь явж байгаад энэ өөр албан тушаалд шилжинэ гэдэг бол зөвхөн энэ тохиолдолд биш ер нь энэ зохисгүй юм гэж үзэж байгаа. Зохисгүй юм гэж үзэж байгаа. Тэр тусмаа Үндсэн хуулийн тэр эрхэм дээд Үндсэн хуулийг хамгаалах, Үндсэн хуулийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд Үндсэн хуулиа бас ингэж дархлаажуулах ажил, албыг хашиж байгаа хүн ингээд тодорхой шалтгаануудын улмаас ажил үүргээ солино гэдэг бас сайн жишиг биш гэдгийг бас би протоколд тэмдэглэж хэлмээр байгаа юм.

2 жилийн өмнө Улсын Их Хурлын мандатаар сонгогддог 3 гишүүний 1 болж сонгогдсон. Тэгэхээр юм юу гэдэг юм сая Байнгын хорооны хурал дээр Их Хурлын дарга хэлж байна л даа. Өлзийсайхан дарга байж байж л энэ парламент Үндсэн хууль зөрчдөггүй хууль гарна гэсэн логиктой үг хэлж байна. Энэ бол зөв логик бас биш. Мэдээж энэ хүнийг шударга, Монгол төрийн төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж ирснийг би хүндэлж байгаа авч, нөгөө талдаа бид нар хүнээр төлөөлүүлж системийн хувьд, тогтолцооны хувьд, институтийн хувьд ийм буруу жишээг

тогтоож болохгүй гэсэн байр суурийг би албан ёсоор протоколд хэлж байгаа. Нэр дэвшигч мэдээж тэгээд олонхоороо санал дэмжигдээд ажлаа хийгээд явах байх. Цааш цаашдаа энэ Үндсэн хуулийн цэц гэдэг энэ том хэргэм, хариуцлага, үүргээс ямар нэгэн улс төрийн ба улс төрийн бус шалтгаанаар хугацаат албаа дуусахгүйгээр дундаас нь гараад байна гэдэг эргээд энэ Үндсэн хуульдаа сайн зүйл авчрахгүй гэдгийг онцлон хэлье.

Н.Учрал: Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Өглөөний мэнд. Ер нь бид нар сүүлийн үед дандаа ийм бүх томилгоонууд намаас улс төрийн байдлаас яваад байдаг байсан байдал маш их үргэлжилсэн. Одоо харин миний харж байгаагаар Өлзийсайхан хуульч амьдралдаа улс төрийн ажил хийж үзээгүй, улс төрийн томилгоогоор улс төрийн албан тушаал хашиж үзэж байгаагүй. Яг төрийн албаныхаа мерит зарчмаар яг эрхэлсэн ажилтнаасаа эхнээс нь хүртэл амжилт үзүүлж явж байсан ийм хуульч эмэгтэй томилогдож байгаад баяртай байна.

Ер нь яг ний нуугүй хэлэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын дарга гэдэг бол Улсын Их Хурлын даргын ажлын алба биш. Улсын Их Хурлын даргын ажлын алба биш гэдгийг би заавал танд цохож хэлмээр байгаа юм. Яагаад гэхээр энэ 126 гишүүнд Улсын Их Хурал, Байнгын хороод гэх мэт энэ олон чиг үүргүүдийг уялдуулж ажилладаг, зохион байгуулалтыг хийж ажилладаг ийм бүтэц. Тийм болохоор аль нэг талд битгий гараарай. Одоо энэ өнгөрсөн 2, 3, үлдэж байгаа жилүүдийн хугацаанд улс төрийн үйл явцууд өрнөх л байлгүй, ямар нэгэн үйл явц болох л байлгүй, сонгууль дөхөхөөр бүүр их ихсэх л байлгүй. Тийм үед ямар нэгэн байдлаар хэн нэгнийх нь талд орж, аль нэгнийх нь талд илт үйлчилж, аль нэгнийх нь талд зохион байгуулалтыг илт зохион байгуулж ингэж болохгүй шүү гэдгийг би танд захиж хэлэх гэсэн юм. Тэгээд танд ажлын амжилт хүсье.

Н.Учрал: Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Та бүхэндээ өглөөний мэндийг дэвшүүлье. Улсын Их Хурлын Тамгын дарга гэдэг бол Улсын Их Хурал гэдэг институтийн Тамгын дарга шүү. Улсын Их Хурлын даргын зөвлөх, Улсын Их Хурлын даргын хуулийн хэлтэс биш шүү гэдгийг онцолж хэлье. 126 гишүүнтэй Монгол Улсын хууль тогтоох байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, бодлого, хуулийн хэрэгжилтэд анхаарч ажиллах ёстой ийм хүн гэж ойлгож байгаа.

Улсын Их Хурлын даргад хандаж 1 зүйлийг хэлье. Сүүлийн үед энэ Монгол Улсын парламент хуулийн ажил, санаачилга, хөтөлбөр хэлэлцэхээс илүү албан тушаалын асуудлыг байнга хэлэлцдэг боллоо. Тэр дундаа энэ намрын чуулган бол албан тушаал хэлэлцдэг, огцруулдаг, чөлөөлдөг, томилдог чуулган болж хувирч байна. Өнөөдөр Монголчууд энэ Улсын Их Хурлаас маш олон зүйлийг хүлээж, иргэдийн амьдралд үнэхээр хэрэгтэй хууль гарчхаасай гэж бодож байна. Тийм зүйл харамсалтай нь гарахгүй байна.

3 дугаарт, Улсын Их Хурлын даргад 1 зүйлийг хандаж хэлмээр байна. Монгол Улсад одоо байгаа хуулиуд маань үнэхээр бодит амьдрал дээр нийцэж байна уу, хэрэгжиж байна уу, иргэдийн амьдралд хэрэг болж байна уу гэдэг дээр дүн шинжилгээ хийх хэрэгтэй байна. Шинэ хуулийг батлахаас гадна одоо байгаа

хуулиуд дээр үе шаттай дүн шинжилгээ хийх ийм ажлын хэсэг гаргаад d.parliament гэдэг цахим систем дээрээ ямар хуулийн заалт нь хэрэгжиж байна, хэрэгжихгүй байна, иргэдийн амьдралд саад болж байгаа юм бэ гэдэг тогтмол ийм санал, асуулгыг явуулъя гэдэг ийм ажил хэргийн саналыг дэвшүүлье.

Тэгээд нэр дэвшиж байгаа хүнд баяр хүргэе. Ардчилсан намын бүлэг улс төрийн намын бүлгийн хувьд энэ Улсын Их Хурлын Тамгын газрын даргын асуудал дээр бас бүлгээрээ ярилцах хэрэгтэй гэж бодож байна. Баярлалаа.

Н.Учрал: Баатархүү гишүүн маш зөв асуудлыг хөндөж байна. Тэгээд би бас хариулъя. Улсын Их Хурал бүтэн жилийн хугацаанд ямар ямар хуулийг батлан гаргав гээд дүгнэх хэрэгтэй. Ажлын хэсэг байгуулж анхааралтай ажигласнаараа тоогоо алдсан юм байна. Би өнөөдөр Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Засгийн газрын ажилтай зэрэгцэж төрийн албан хаагч нарыг тал талд дууддаг, ажлын хэсгийн хуралд суудаг боллоо шүү дээ энэ төрийн албан хаагч нар. Тэр гишүүн дуудсан, тэр ажлын хэсэг дуудсан, засаг дуудсан, эсвэл чуулган дээр. Яаман дээр байж байгаа хүн алга. Би өнөөдөр Их Хурлын даргын захирамжаар байгуулалцсан 58 ажлын хэсгийн захирамжийг цуцална. Одоо ер нь бүгдээрээ хийх ажлаа хийе. Юу хийхээ мэдэхээ болилоо гэхэд юу хийхгүйгээ ядаж мэддэг байя гэж би зорьж байгаа. Өнөөдрөөс би ажлын хэсгүүдийг цэгцэлж 7-10 ажлын хэсэг л байгуулна. Энэнээс цааш хэтрэхгүй. Засаг хуулиа оруулж ир гэж шахна. Оруулж ирэхгүй бол Их Хуралд хэлэлцэх асуудал Засгийн газраас өргөн мэдүүлээгүй бол байхгүй шүү. Тийм учраас засаг ажлаа хийх хэрэгтэй. Ийм л зарчмаа барья.

Тэгээд энэ томилгоогоо одоо ингээд хуулийн хугацаатай томилгоонуудаа хийгээд ажил төрөлдөө оръё. Тэгэхээр Баатархүү гишүүндээ хэлэхэд надад 1 сар өгчих. Би Засгийн газрын кабинетыг reel time-аар бүх их өгөгдөлд суурилсан мэдээлэл гаргуулдаг болгосон шиг Их Хурлын 126 гишүүнд энэ бүх мэдээ, мэдээллүүдийг дата болгоод reel time-аар хардаг болгоно. Энийг сарын хугацаанд би бэлдээд та бүхэнд хүргүүлнэ.

Хоёрт, Их Хурал Үндсэн хуулийг зөрчсөн ямар ч үйлдэл гаргаж болохгүй шүү дээ. Үндсэн хуулийн цэцэд байгаа гишүүд л зөвхөн Үндсэн хуулийг хамгаална гэж байхгүй. Их Хурал өөрөө Үндсэн хуулийн зөрчилтэй ямар ч хууль тогтоомж баталж болохгүй, дэгээ зөрчиж болохгүй, одоо туршлагажих цаг байхгүй. Одоо ингээд төрийн албан хаагчийг би ингээд авчраад Тамгын даргаар тавих шиг амархан юм надад алга.

Гэхдээ надад хүн сургаж авах, хүн туршлагажуулж авах цаг алга. Бид өнгөрсөн хугацаанд Үндсэн хуулийн зөрчилтэй шийдвэрүүд, дэг зөрчсөн үйлдлүүд удаа дараа гаргажээ. Үүндээ үнэлэлт, дүгнэлт хий. Тийм ч учраас 2019, 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт энэ дэд ажлын хэсгийг ахлаад тухайн үед Тамгын даргаар ажиллаж байсан яг таны хэлснээр улс төрийн нам, эвсэлд огт харьяалагдаж байгаагүй би Цэцийн гишүүн Өлзийсайхан даргыг та Тамгын даргаар ирж ажиллаач гэж Их Хурлын даргын хувиар хүссэн юм. Ингээд миний хүсэлтийг хүлээж аваад ирж байгаа энэ зориг, энэ итгэл үнэмшил, үнэхээр өөрийнхөө тэр парламентын ардчиллыг илүү бэхжүүлэх үзэл санааныхаа төлөө тэр хуулийн ноён оргил болсон албан тушаалаас татгалзаад ирж байгаад нь бид

хүндэтгэлтэй хүлээж аваад ажлаараа шахаад явах нь зөв байх гэж бодож байгаа юм. Их Хурлын Тамгын газрын дарга бол Их Хурлын даргын хуулийн зөвлөх биш.

Дээрээс нь Их Хурлын Тамгын дарга, манай энэ Байнгын хорооны ахлах зөвлөхүүдэд би та бүхэнд хандаж хэлье. Та нар улс төрч нарт үгүй гэж хэлж сур. Улс төрчид дураараа авирлавал наадах чинь хууль зөрчинө өө уучлаарай гэж хэлж сур, хаалгыг нь саваад гарч сур. Тэрнээс биш ингээд улс төрчдийн үгэнд ордог, улс төрчид дур дураараа юм ярьдаг эцсийн эцэст хэн хохирч байгаа юм? Төрийн албан хаагч нар л хохирч байна шүү дээ. Улс төрчдийн гар, хөл болсноороо гэдэг л ийм л Баатархүү гишүүнд хариулт хэлье.

Н.Учрал: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Ер нь хуульчдын мөрөөдөл, карьерынх нь оргил нь Үндсэн хуулийн шүүх л дээ. Үндсэн хуулийн шүүх гэхэд шүүгч хийнэ гэдэг бол хүн болгоны мөрөөдөөд байдаг ажил биш. Тэгээд өөрийнхөө хүсэлтээр чөлөөлөгдөж байгаа юм байна. Өөрөө хүсэлт гаргаж байгаа хүнийг чөлөөлөхгүй гэж хэлэх нь бүүр зохимжгүй зүйл. Тийм учраас бид бүгд ингээд ер нь чөлөөлөөд гаргасан нь зөв байх.

Гэхдээ дахиад 1 асуудал байна. 2019 оны 6 сарын 6-нд Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолоор томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүний хугацаа дуусаад одоо 6 дахь сар руугаа орох гэж байна. Өөрөөр хэлбэл хагас жил болох гэж байна. Бүрэн эрх нь дууссан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Үндсэн хуулийн цэцийг даргалаад шийдвэр гаргаад сууж байна. Энэ Үндсэн хуулийн манаачийн эргэлзээтэй байдлыг бид энэ байдлаар үргэлжлүүлээд явж болохгүй. Хууль номынхоо дагуу Улсын Их Хурлаас санал болгож томилогдсон Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрх дууссан учраас энэ асуудлаа бас нэн даруй түргэн шийдэх ёстой.

Ер нь Улсын Их Хурал өөрөө хурдтай ажиллахгүй байгаагаасаа шалтгаалаад олон нийтэд эргэлзээтэй хардалт төрүүлэхүйц албан тушаалын бүрэн эрхийн эргэлзээ үүсгээд байна. Үндсэн хуулийн цэцийн хугацаа дууссан албан тушаал нь хэзээ оруулж ирэх вэ? Нэн даруй энийгээ шийдэх хэрэгтэй байна. Өөрийнхөө хүсэлтийг өгсөн хүнийг бас нэн даруй шийдээд явуулчихъя. Өөр хэлэх юм алга.

Н.Учрал: Ойлголоо тэгээд хугацаа дууссан Цэцийн гишүүдийг хуулийн хугацаанд нь оруулж ирнэ. Тийм одоо дуусчихсан байгаа. Тийм оруулж ирнэ.

Мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар Эрдэнэболд, Далайн Батбаяр нарын урилгаар Төв аймгийн Архуст сумын ЗДТГ-ын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Тамгын газрын албан хаагчдадаа ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баярлалаа.

Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Өлзийсайхан даргад, Цэцийн гишүүнд бас баяр хүргэе. Яг өөрийнхөө хүсэл зорилгоор, карьерынхаа хүсэлтээр наашаа ирсэн гэхээсээ

илүүтэй Улсын Их Хурлын удирдлага, удирдлагын баг санал тавьж туслаач гэдэг л туршлагатай хүн байна туслаач гэдэг л ийм санал тавьсан болов уу гэж бодож байна. Миний хувьд 20-24 онд Статистикийн хорооны даргаар буюу Улсын Их Хурлын харьяа байгууллагыг удирдаж ажилласан. Энэ хугацаанд Өлзийсайхан даргатай бас Ерөнхий нарийн бичгийн дарга байхад нь бас гар нийлж сайхан ажилласан. Тэгээд миний хувьд юунд баяртай байна вэ гэхээр ямар ч байсан эмэгтэй дарга орж ирж байна. Жендерийн бас мэдрэмжтэй байна гэдэгт нэг ёсондоо бас талархал дэвшүүлмээр байна. Засгийн газар ч тэр, Улсын Их Хурал ч тэр, ер нь төрийн аливаа байгууллага бүгд л энэ Жендерийн хуулиа бас мөрддөг баймаар байна. Аливаа энэ томилогддог албан тушаалууд дээрээ жендерийн квотыг маш сайтар хангаж байж, төр өөрөө хуулиа биелүүлж байж сая бусдаас хууль биелүүлэхийг бас шаардана.

Саяхан болоод өнгөрсөн процесс дунд магадгүй Өлзийсайхан дарга ч ирж байгаа дээр бас онож байгаа байх. 95 дугаар тогтоолтой холбоотойгоор Улсын Их Хурлын 95 дугаар тогтоолыг хүчингүй болгох энэ процесс ердөөсөө хийгдээгүй гацаанд орсон байгаа. Даргын дэргэдэх зөвлөл дээр хэрхэн, яаж хүчингүй болгох вэ гэдэг дээр дарга нар маргалдаад ямар ч шийдвэр гаргаагүй байгаа одоо хүртэл Учрал даргаа. 95 дугаар тогтоолыг яах ёстой юм бэ гэдэг ийм том асуултын тэмдэг Цэцийн дүгнэлттэй холбоотой, 8 дугаар дүгнэлттэй холбоотой гарсан.

Тэгээд Үндсэн хуулийн 66.2, 66.4, 5 хоорондоо маргаантай байгаад байгаа юм. Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг уг нь авч хэлэлцэх ёстой. Цэцийн дүгнэлт нь өөрөө Улсын Их Хурал дүгнэлт гаргасан мөртөөсөө хэлэлцэхгүй гээд бас заачихсан. Тэгээд Үндсэн хуулиа дагах юм уу, Цэцийн шийдвэрийг дагах юм уу Улсын Их Хурлыг ийм эвгүй байдалд оруулсан дүгнэлт гаргачихсан байгаа.

Тэгэхээр үүнийг хэрхэх вэ гэдгийг магадгүй тус Цэцийн шийдвэрийг гаргахад гар бие оролцсон Өлзийсайхан гарц, гаргалгааг нь олж магадгүй юм гэж миний хувьд үзэж байна. Тэгээд үүнийг бас хамгийн эхний шийдвэрлэх асуудал. Өнөөдрийн Даргын дэргэдэх зөвлөл хуралдах энэ тал дээр бас яг дорвитой шийдвэр гаргах ёс ёстой шүү гэдгийг бас хэлье. Тэгээд Өлзийсайханд амжилт хүсье.

Н.Учрал: Ариунзаяа гишүүний бас санал гэж ойлголоо. Даргын зөвлөл дээр бас тодорхой асуудлуудыг ярина. Нямтайширын Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Сүүлийн үед Их Хурлаас их томилгоо хийж байна. Томилогдож байгаа хүн болгоныг танилцуулахдаа ийм ийм ийм газар ажиллаж байсан ийм ч арвин туршлагатай гэж ярьж байгаа нь нэг талдаа их буруу мэт санагддаг боллоо. Яагаад гэхээр хэчнээн ажиллаж байсан туршлага хуримтлуулсан хэдий ч яг тухайн салбартаа ямар ололт, амжилт, өөрчлөлтийг авчирч чадав гэдэг өнцгөөс ердөөсөө ярихгүй байгаад байна. Тэгээд одоо бид хэд ч гэсэн бас ичих хэрэгтэй байна л даа. Их Хуралд 4 сонгогдлоо, 3 сонгогдлоо, 5 сонгогдлоо гээд. Үхсэн тэгж олон сонгогдчихоод энэ улс орноо олигтой хөгжүүлээд аятайхан болгочихсон нь хаана байгаад байгаа юм. Томилогдож байгаа субъект болгонд ийм ч газруудад шат дараалаад дэвшиж ажиллалаа. Ийм ч туршлагатай гэж яриад байна. Ажиллаж байсан газар болгон дээрээ ямар өөрчлөлт, шинэчлэлт авчирсныг ердөөсөө ярьдаггүй. Зүгээр л ерөөсөө цаг хугацааны кроник л яриад, уншаад суугаад байдаг. Энэ ердөөсөө болохгүй. Тэгээд энэ Өлзийсайхантай

хамтарч ажиллаж нэг хэсэг явж байсан төдийлөн сайн үнэлэлт, дүгнэлт өгч чадаагүй.

1 асуулт байна. 12 сарын 14-ний Улсын Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар Учрал дарга энийгээ анхааралдаа аваарай. Даргын зөвлөлийн хурлаар юу гэж шийдсэн бэ гэхээр 10 сарын 22-ны Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 08 дугаар дүгнэлтийн 36 дугаар тал, 16 дугаар мөртөөс эхэлсэн асуудал нь тодорхой яривал энэ гаргаж байгаа Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэхгүй гээд шийдвэр гаргачихсан. Тэгээд энэ нь өөрөө Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан, Үндсэн хуулийн 66.2, 66.3-ыг ноцтой зөрчсөн байгаа тул Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд энэ асуудлаа албан ёсоор тайлбар өг өө гэж албан бичиг явуулахаар шийдвэр гаргасан байгаа. Өнөө өглөөний байдлаар энэ албан бичиг хараахан яваагүй байгаа юм байна. Энэ Өлзийсайхан дарга Тамгын газрын даргаар тэгээд олонхоороо хүч түрээд томилогдох байх. Энэ албан бичгийг өнөөдөр даруй явуулна. Гэтэл өөрөө Үндсэн хуулийн цэцийн гишүүн байхдаа Улсын Их Хурлын бүрэн эрхэд ноцтойгоор халдсан буюу 66.2, 3-д байгаа зүйл, заалтыг үл ойшоож, энэ шийдвэр гаргасантайгаа зөрчилдсөн ийм байдал үүсэж байгаа. Тэгэхээр энэ дээр ямар байр суурьтай байх юм? Энийг маш тодорхой хэлээдхээч. Тэр 08 дугаар дүгнэлт нь өөрийнх нь гарт байгаа байлгүй дээ? 36 дугаар тал 16 дугаар мөртөө уншаадах, тэгээд Үндсэн хуулийн 66.2, 66.3-ыг уншаадах. Энэ дээр тайлбар өгөөдөх дөө.

Н.Учрал: Ажлын хэсгээс Өлзийсайхан Цэцийн гишүүн.

Л.Өлзийсайхан: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд заасан байгаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх эрх бүхий байгууллага гэж заасан байгаа.

64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна гээд заасан байгаа. Тэгэхээр энэ 64 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан энэ заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болоод Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд дэлгэрүүлэн заасан байгаа. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц нийт 9 гишүүнээс бүрдэнэ. Тэр Цэцийн гаргасан 9 гишүүний шийдвэр бол өөрөө олонхын шийдвэр байдаг. Тийм учраас хувь гишүүн болоод шийдсэн шийдвэрийн талаар Үндсэн хуулийн цэцийн гишүүн ямар нэгэн байр суурийг илэрхийлэх эрхгүй. Хуулиар хориглосон байгаа. Харин Монгол Улсын Их Хуралд гаргасан шийдвэрээ уншиж танилцуулах эрх байгаа.

Н.Учрал: Номтойбаяр гишүүн.

Н.Номтойбаяр: Үгүй чи юу хариулаад байгаа юм бэ би асуултыг аягүй тодорхой асуулаа шүү дээ. 12 сарын 10-ны, 14-ний өдрийн 13 цагийн Улсын Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөлийн хуралдаанаар тухайн зөвлөлийн хуралдаанд Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар, Ардчилсан намын бүлгийн шийдвэрийг Тэмүүжин гишүүнд танилцуулж олон талаасаа бид нар ярилцаж байгаад энэ 08 дугаар Цэцийн дүгнэлт чинь Улсын Их Хурлын бүрэн эрхэд

халдчихаад байна. Тиймээс Цэц рүү энэ асуудлыг нь албан тоот явуулж, өөрийнх нь байр суурийг сонсъё гээд албан бичиг явуулахаар шийдвэрлэчихсэн. Одоо энэ шийдвэрийн биелэлтийг өөрөө хүлээх үүрэг хариуцлага одоо томилогдсоноороо хүлээх гээд байна шүү дээ. Тэгэхээр өөрийн чинь байр суурь энэ бичгийг явуулахгүй. Яагаад гэвэл энэ Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн тэд тэддүгээр заалтаар ийм ийм учир шалтгаан байгаа учраас энэ бичгийг бүүр явуулахгүй гэдэг хариулт өгөхөөр байна.

Н.Учрал: Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байгаа. Чөлөөлөгдөөгүй байгаа учраас Үндсэн хуулиар Цэцийн гишүүний хувиар хариулж байна л даа. 9 гишүүн олонхоороо шийдсэн асуудал дээр хувь хүн байр сууриа илэрхийлэхгүй гэдэг. Одоо бол яг Цэцийнхээ гишүүнээр ажиллаж байна шүү дээ. Тэгэхээр хууль зөрчих гээд байна. Тэгэхээр мэдээж чөлөөлөх асуудлыг ярих учраас дараа дараа тэгээд байр сууриа дараа тийм. Одоо бол хуулийн хүрээнд сая тэгж тайлбарлаж байна л даа Өлзийсайхан дарга.

Далайн Батбаяр гишүүн. Далайн Батбаяр гишүүн байхгүй байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Та бүгдийнхээ энэ өглөөний амгаланг эрье. би Өлзийсайханыг зүгээр их зовоохгүй. Тэгэхдээ ер нь та бүгдийн саяын гаргасан Үндсэн хуулийн бус шийдвэрт би үнэхээр дургүй байгаа. Тэгэхдээ би 2 зүйлийг бас тодруулъя гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт, лав өөрийг чинь шагнасангүй. Энэ төрийн өндөр албан тушаалаас ингээд бууж байхыг бодоход. Тэгэхээр чи Засгийн газрыг огцруулах тухай тогтоол дээр бас жоохон эсрэг байр суурь барьчихсан юм уу ямар тийм эргэлзээ төрүүлсэн үү. Тийм учраас шийтгэгдчихэв үү гэж нэгдүгээрт би зүгээр тэгж хардаад байгаа юм.

Хоёрдугаарт, би чамаас 1 зүйл тодруулъя. Үндсэн хуулийн 43.1 дэх заалтаар санал хураасангүй гэсэн байхгүй юу. Үгүй бид нар Байнгын хороон дээр Ерөнхий сайдыг огцруулъя л гэж санал хураасан. Ерөнхий сайдыг огцруулахыг дэмжээгүйг дэмжье л гэж хураасан. Яг уг саналаар нь л хураагаад байсан байхгүй юу 43.1-ээр нь. Мөн Үндсэн хуулийн 27.1 дээр Их Хурал чуулганы хэлбэрээр шийдвэрээ гаргана. Би Цэц дээр очоод хэлсэн шүү дээ. Энэ нь Байнгын хороо санал, дүгнэлтээ гаргана, нэгдсэн хуралдаанаар шийднэ гэсэн үг байхгүй юу. Мөн 28.2 дээр Байнгын хорооны эрхийг хуулиар тогтооно гэчихсэн Үндсэн хуулийн заалт шүү дээ. Ингээд Байнгын хорооны эрхийг Их Хурлын тухай хуулийн 22.3-аар тогтоочихсон. 22.3.8 дээр Байнгын хороо Их Хурлаас томилогдсон албан тушаалтан Ерөнхий сайдыг огцруулах асуудлаар санал, дүгнэлт гаргаж хэлэлцүүлнэ гээд ингээд Байнгын хорооны эрхэд заачихсан тийм ээ? Тэгээд Дэгийн тухай хуулийн 101.3 дээр Байнгын хорооны санал, саналыг гэж байгаа шүү. Дүгнэлтийг сонсож хэлэлцэж шийдвэрлэнэ гэж байгаа юм.

Тэгэхээр 43.3 яагаад 27.1, 28.2 гэсэн Үндсэн хуулийн 2 заалтаас давчхаж байгаа юм. Чи энийг яг юу гэж бодож байна вэ? 27.1 дээр чуулганы хэлбэрээр шийднэ гэж байна шүү дээ. Тэгээд 28.2 дээр Байнгын хорооны эрхийг хуулиар шийднэ гээд. Тэгээд Үндсэн хуулийн энэ заалтын дагуу Их Хурлын тухай хуулийн 22.3.8 дээр ингээд заагаад өгчихсөн байна огцруулахад. Тэгэхдээ саяын та нарын

хийсэн үйлдэл бол хэзээ нэг цагт сөхөгдөж магадгүй юм байгаа юм. Төр яаж ч эргээ билээ. 27, 28 онд юу ч болоо билээ. Тэгэхэд төрийн эрхийг хууль бусаар авсан гэдэг асуудал хөндөгдөх юм бол аймаар том ял шүү дээ. Айхтар том ял байхгүй юу. Тийм учраас та нар бас л болчимгүй л юм хийсэн. Их Хурлын дарга харин тэр Баясгаланг татъя гэж байгаа зөв шүү. Тэгээд яг хэлсэн амандаа байгаарай. Ингээд ажил аваад эхэлж байна. Ярьсан, хэлсэндээ байх юм бол бид нар дэмжээд л явна шүү дээ. Энэ асуудлыг бас Их Хурлын дарга шийдээрэй.

Н.Учрал: Лувсандоржийн Өлзийсайхан гишүүн.

Л.Өлзийсайхан: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр би сая бас Номтойбаяр гишүүний асуултад хариулахдаа хуулийн, Үндсэн хуулийн болоод холбогдох хуулийн заалтыг тайлбарласан байгаа. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын гишүүдэд бас иммунитет гэж байдаг. Тэгэхээр бас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд бас иммунитет гэж бас байдаг. Тэгэхээр нэгэнт гаргасан шийдвэрийн талаар Цэцийн бүх гишүүд тэгш эрхтэй байдаг учраас би тайлбар хэлэх хууль ёсны надад хориглосон ийм заалт үйлчилж байгаа. Тэгэхээр миний хувьд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллахдаа Үндсэн хуулийг дээдэлж, мөрдөж ажилласан. Тийм учраас бусад Цэцийн гишүүдийнхээ бас би бүрэн эрхийг хүндэтгэнэ. Хараат бус бие даасан байдалд нь халдах эрх надад байхгүй.

Н.Учрал: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Байр сууриа илэрхийлэхийг чинь ойлголоо. Тэгэхээр дараагийнх дээр Номтойбаярыг асуухаар чинь энэ дээр бас ямар байр суурьтай байсныг товчхон дурдчихад энэ чинь түүх болж үлдэнэ. Хожим магадгүй чи төрийн эсрэг гэмт хэрэгт орооцолдоод эхэлбэл энэ чинь чамайг аварч мэднэ. Тийм учраас энэ дээр хариулт өгчих хэрэгтэй. Би чамаас нэг юм асуугаад байгаа шүү дээ Үндсэн хуулийн 3 заалт яагаад нэг нь илүү, нөгөө 2 нь дутуу үйлчлээд байгаа юм бэ гээд. Тэр 27.1, 28.2, 43.1.

Н.Учрал: Лувсандоржийн Өлзийсайхан гишүүн 4 дүгээр микрофон.

Л.Өлзийсайхан: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Би яг энэ асуултад би хариулах юм бол би Цэцийн шийдвэрт, гаргасан шийдвэрт бас би яг субьектив тайлбар хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр та бас намайг ойлгоорой. Мэдээж би судлаач хүнийхээ хувьд тайлбарыг хэзээ нэгэн цагт бас хэлж болно. Тэгэхдээ яг одоо би парламентын өмнө Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн талаар би ямар нэгэн байдлаар гаргасан шийдвэр хууль хоорондын ямар хэмжээнд нэг хэмжээнээсээ дээр доор ч юм уу, яагаад үйлчилж байна, яагаад үйлчлэхгүй байгаа юм гэдэг асуултыг хэлэх нь өөрөө би Цэцийн гишүүний бүрэн эрх халдах гээд байгаад байгаа юм шүү. Үүн дээр та бүгд бас намайг ойлгоорой.

Н.Учрал: Даваасүрэн гишүүн тодруулъя.

Ц.Даваасүрэн:Үгүй үгүй би зүгээр чамайг томилогдох гэж байгаа хүний чинь хувьд яриад байгаа юм биш. Ер нь чи бас энэ хууль тогтоох дээд байгууллагын энэ том албан тушаалд ирж байгаа хүний чинь хувьд би хуулийн хувьд, чи энэ хуульч хүний хувьд энэ асуудлыг юу гэж үзэж байна вэ? Хувь хүнийхээ байр суурийг

илэрхийлээч л гэж байна шүү дээ. Цэцийн тухай шүүж ярь гээгүй шүү дээ. Энэ 3 заалт тэгш үйлчилдэггүй юм уу юу гэж бодож байна л гэж асуугаад байна шүү дээ.

Н.Учрал: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэе.

Их Хурлын дарга Лувсандоржийн Өлзийсайхан Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаач гэж хүсэлт илгээсний дагуу Цэцийн гишүүн Лувсандоржийн Өлзийсайхан өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ анх томилсон, өөрийг нь санал болгосон Их Хуралд илгээсэн. Тэгээд үүнтэй холбогдуулаад Цэцийн гишүүнийг чөлөөлөх асуудлыг хэлэлцэж байна. Үүний дараа Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж Өлзийсайхан даргыг Их Хурлын Тамгын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилох саналыг оруулж ирнэ. Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ Их Хурлын даргад гаргасан байгаа. Ингээд хурдан хугацаанд энэ Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг үүрэгт ажилд нь оруулаад бас ажил руугаа шуурхай орох шаардлага байна. Түүнийг манай Их Хурлын гишүүд бас ойлгож дэмжихийг би хүсэж байна. Ингээд санал хураалтыг явуулна

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Лувсандоржийн Өлзийсайханыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор. Санал хураалт.

52 гишүүн дэмжиж, 29 гишүүн татгалзсан байна. 64.2 хувийн саналаар Лувсандоржийн Өлзийсайханыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх санал дэмжигдлээ.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Лувсандоржийн Өлзийсайханыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай” Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тогтоол, “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай”

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 105 дугаар зүйлийн 100.1, 105.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Лувсандоржийн Өлзийсайханыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоол танилцууллаа.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Лувсандоржийн Өлзийсайхан гишүүн Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллахдаа хууль дээдлэх зарчмыг барьж, Үндсэн хуулиа дээдлэн сахиж, хариуцлагатай ажилласан. Ингээд Өлзийсайхан даргад цаашдынх нь ажилд өндөр амжилтыг хүсье.

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдана. Чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулъя. 15-20 минут завсарлуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо Сандаг-Очир дарга Төрийн байгуулалтын байнгын хороо “Чингис хаан” танхимд хуралдана. Түүний дараа Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох асуудлыг хэлэлцсэний дараа Засгийн газраас өргөн мэдүүлсэн таван жилийн үндсэн чиглэлийг хэлэлцэнэ. Гишүүд бас ирцдээ анхааръя. Түр завсарлуулъя.

11.15 цаг

Баасан гараг 28 Арваннэгдүгээр сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 11 цаг 45 минут

Н.Учрал: Чуулганы хуралдаан үргэлжилнэ. Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргалын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын Мандал багийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж дууссан байна. Хэлэлцэх асуудалдаа орно.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Ингээд та бүхэнд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47.2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хуралд томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Лувсандоржийн Өлзийсайханыг томилуулахаар санал болгож байна.

Лувсандоржийн Өлзийсайхан нь 1998 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. Магистр зэрэгтэй. 2021 онд

Парламентын хуралдааны дэг, эрх зүйн харьцуулсан шинжилгээ бүтээлээр Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. 2025 онд Швейцарын Холбооны Улсын Бернийн их сургуульд зочин судлаачаар ажилласан. Профессор цолтой, Монгол Улсын Гавьяат хуульч.

1998-2002 онд Монгол Улсын Багшийн их сургуульд багш, 2002-2016 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш, ахлах багш.

2007-2012 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн хууль тогтоомжийн хэлтэст зөвлөх, ахлах зөвлөх.

2012 онд Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх.

2013-2015 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн хүний нөөцийн газрын дарга.

2015-2017 онд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатын шүүхийн шүүгч.

2017-2018 онд Улсын Их Хурлын Тамгын газарт Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх.

2018-2019 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлага, зохицуулалтын газрын дарга.

2019 онд Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга.

2019-2023 онд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга.

2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдон ажилласан.

Лувсандоржийн Өлзийсайхан нь МУИС-ийн Хууль зүйн сургуульд 17 жил багшилж, Эрх зүйн онол, Үндсэн хуулийн эрх зүй, Парламент судлалын чиглэлээр 10 гаруй нэг сэдэвт бүтээл, ном, гарын авлага туурвиж, 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, судалгааны ажил бичиж эрдэмтэн, судлаачид болон олон нийтийн хүртээл болгосон байна.

Үндсэн хуулийн хяналт, шүүх эрх мэдлийн болон хууль тогтоох үйл ажиллагааны практикийг судлах чиглэлээр АНУ, ОХУ, ХБНГУ, Япон, Франц, Солонгос, Швейцарын Холбооны Улсад тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Лувсандоржийн Өлзийсайхан нь дэлхий дахины болон Монголын парламентын түүх, сорилт бэрхшээл, парламентат ёсны ирээдүйн хөгжлийн асуудлаар олон тооны судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвиж, үр дүнг нь Улсын Их Хурлын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн төрд бэлтгэгдсэн мэргэшсэн хуульч юм.

Лувсандоржийн Өлзийсайхан нь 2019, 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцад Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагын хувиар манлайлан оролцож, Монгол Улсад Үндсэн хуулийн эрх зүйн шинэтгэлийг эхлүүлж хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмрээ оруулсан.

Тодруулбал, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу парламентын эрх зүйн орчны болон бусад шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монголд парламентын ардчиллыг бэхжүүлэх, ард түмний засаглах эрхийг хангах чиглэлээр мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажиллаж ирсэн бөгөөд энэхүү мэдлэг, ур чадвар, туршлага нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амьдралд бодитой хэрэгжүүлэх, үр нөлөөг нь сайжруулах асуудлаар чухлаар тавигдаж байгаа энэ цаг үед онцгой ач холбогдолтой хэмээн Улсын Их Хурлын дарга үзэж байна.

Иймд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад тавигдах хууль зүйн өндөр мэргэшилтэй, төрийн албаны удирдах ажлын туршлагатай байх гэсэн үндсэн шаардлагыг хангаж байгаа, хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаанаас эхлэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салбарт болон Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиглэлээр 27 жил ажилласан туршлагатай Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалд томилох саналыг Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг хэлэлцэж дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урья.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн Улсын Их Хурлын даргаас Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Лувсандоржийн Өлзийсайханыг томилох саналыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын даргын уг саналыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж, байр суууриа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Лувсандоржийн Өлзийсайханыг томилж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Барсүрэнгийн Баасандоржийг чөлөөлөх тухай саналыг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилох, чөлөөлөх тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье..

Н.Учрал: Баярбаатар даргад баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Лувсандоржийн Өлзийсайхан хүрэлцэн ирсэн байна.

Эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Үг хэлэх.

Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Үүрийнтуяа гишүүнээр тасаллаа. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг хэлнэ. Асуулт асууна.

Х.Тэмүүжин: Парламентад ёс, парламентын засаглалын чиглэлээр судалгаа хийгээд мэргэшсэн Монгол Улсад байдаг цөөхөн хүмүүсийн нэг нь Өлзийсайхан л даа. Лүндээжанцан гишүүний парламентын тухай Улсын Их Хурлын тухай маш сайн бүтээлүүд байдаг. Түүнтэй эн зэрэгцэхүйц бас онолын хувьд Өлзийсайханы бичсэн бүтээл байдаг. Парламентыг өмгөөлнө, парламентч байна гэдэг нь Улсын Их Хуралд олон сонгогдохоосоо илүүтэйгээр парламентын бүрэн эрхийн хил хязгаарыг манаж чаддаг, парламентын дархлаа нь, сэтгэл санаа нь бас ингээд цочирдож зовдог, энэ хууль тогтоох эрх мэдлийг парламентаас гадуур хэн нэгэн дураараа, тэр дундаа огт сонгогддоггүй ардчиллын эх үүсвэртэй ямар ч хамааралгүй албан тушаалтнууд эдлээд байхаас сэрэмжилж босож ирдэг тийм мэдрэмж, сэтгэхүйтэй хүмүүсийн хийдэг ажил.

Ардын намын 3 хурлын дунд хамгийн том хохирсон институт сая Улсын Их Хурал байлаа. Улсын Их Хурлын бүрэн эрхийг хэдэн тийш нь салгаж шидээд Үндсэн хуульд байгаа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэхээр хуралдаж шийдвэр гаргадаг эрхийг нь хүртэл Үндсэн хуулийн цэц тийм эрх байхгүй шүү гээд алх цохиод гаргахад тэр тухай сэрхийж бодох хүн 126 дотор их цөөхөн байлаа. Засгийн газар нь Улсын Их Хурлын нэгдсэн чуулганыг хуралдуулахгүй энэ байшин дотор бойкот хийхэд Эрүүгийн хуульд байгаа гэмт хэрэг шүү дээ уул нь. Ийм үйлдлийг энэ юу болж байна гэж бодох задгай тархитай хүн бас алга байлаа. Бүгд л айсан, барьцаалагдсан шинжтэй байлаа.

Парламент Монгол Улсад байгаа юм уу, байхгүй юм уу гэдэг дээрээ хүртэл эрх хэмжээний зөрчил гарлаа. Ерөнхий нарийн бичгийн даргаа солих гэж байгаа юм байна. Улсын Их Хурлын даргыг томилогдоход Ардчилсан намын бүлэг нэг үг хэлсэн. Парламентын энэ дархлаа, амин сүнсийг парламентын спикер авч явдаг юм. Дэлхий нийтээр парламентын спикер дээр 2-хон зарчим барьж байна. Төв ч байна шүү. Яагаад гэвэл энэ парламент гэдэг чинь олон намын төлөөлөл, олон ургалч үзлийн илэрхийлэл, хоорондоо маргаж мэтгэлцэнэ, байр сууриа хамгаалахын тулд хатуу зогсох цаг бас гарна, улс орны нийтлэг ашиг сонирхлын төлөө ойлголцож, бас нэг шийдвэрийн ард хүчтэй нэгдэх бас шийдэл гарна. Ийм байхын тулд энэ парламентын толгой дээр хүчтэй лидер гэхээсээ илүүтэйгээр төв ч байр суурьтай, хоёрт нь намын улс төрөөс ангид байж чадах бие даасан хүн байдаг юм байна. Энэ ажлаа хийгээрэй гэж хүссэн.

Н.Учрал: Тэмүүжин гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Х.Тэмүүжин: Өлзийсайханыг дэмжиж байна. Хувь хүнийхээ хувьд мэдэж байна. Парламентыг мэргэшсэн хууль тогтоогчийн түвшинд ажиллуулахад

судалсан судалгаа, ажилласан ажлынхаа туршлагаар дэм тус болох байх. Парламентын спикерт хэлэх үг байна. Таны индэр дээрээс хэлсэн төвч байр сууриас хандах тухай улс төрийн намын, дотоод болон намын улс төрөөс ангид энэ парламентат ёсны төлөө зогсох тухай гал цогтой үг чинь бүдгэрээгүй байх шиг байна. Энэ үгийн дараа би, санал хураалтын дараа Ардчилсан намын бүлгийн дэд даргын хувьд үг авна шүү.

Н.Учрал: Тэмүүжин гишүүн бас асуулт асууж байна. Тэгээд би Их Хурлын даргаар томилогдоод хэлсэн үгэндээ эзэн болно. Олон намын үзэл баримтлал, итгэл үнэмшил, олон ургалч үзлийг бас үргэлж хүндэтгэнэ. Энэ ч утгаараа би Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар эрх баригч намын даргын хувиар манай намд ажиллаж байсан улс төрийн албан, ажил хашиж байсан хэн нэгнийг оруулж ирэхийг би хүсээгүй. Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга бол дэгийн зөвлөх байх ёстой. Надад болон бусад улс төрчдөд үгүй гэж хэлж чадах мэргэшсэн хуульч байх ёстой. Энэ ч утгаараа би Өлзийсайхан даргыг энэ саналыг тавиад надад үгүй гэж хэлдэг байгаарай, хууль зөрчвөл болохгүй гэдгийг үндэслэлтэйгээр нь тайлбарладаг байгаарай л гэж би хүссэн. Тэгээд энэ ч утгаараа бас ийм парламентат ёс, парламентын ардчиллын чиглэлээр мэргэшсэн хүн бас Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга болж байгаа учраас энэ 19, 23 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ажиллаж байсан, энэ дэд ажлын хэсгийг ахалж байсан хүн Тамгын Ерөнхий нарийн бичгийн дарга болж байгаа учраас цаашдаа бүгдээрээ 19 он, 23 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө амилуулахад хичээж зүтгэе.

Тийм ч учраас Тэмүүжин гишүүн бол 12 онд байх хууль зүйн салбарын сургагч багш бэлтгэх сургалтад би бас таны Эрх зүйн онолын хичээлд хэдэн өдөр суусан. Тэгээд миний тэр итгэл үнэмшил бол хэвээрээ. Тийм учраас парламент ёсоо бэхжүүлэх энэ үйлсэд улс төржихгүйгээр хандаасай хэмээн Өлзийсайхан даргыг би санал болгосон юм. Тийм учраас Ерөнхий нарийн бичгийн дарга бол Их Хурлын даргын хуулийн зөвлөх биш. Их Хурлын Тамгын газрын дарга. Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга бол 126 гишүүндээ үйлчилдэг, Их Хурлыг хууль зөрчихөөс хамгаалдаг, дэгийг сахиулдаг ийм л төрийн жинхэнэ албан хаагч байх ёстой гэж л зорьж байгаа юм. Тэгээд үүнийг бас дэмжиж өгөхийг хүсье.

Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Би асуулт асуухгүй. Үг хэлье гэж бодож байна. Өлзийсайхан даргыг ингээд томилогдох гэж байгаад дэмжиж байгаа. Та бол Монголын эмэгтэйчүүд дундаа, хуульчдын дундаа манлайлал үзүүлсэн энэ улсад маш ховорхон тохиолдох тийм сайн хуульч, дэг ёсыг мэддэг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан ийм хүн. Тийм учраас би талархалтай хандаж байгаа. Та Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс бууж энэ Улсын Их Хурлын Тамгын газрыг удирдах гэж байна. Гал тогоог удирдах гэж байна.

Тэгэхээр сая Монгол Улсын парламент хүнд юмыг туулсан. Монголын төр хүнд юмыг туулсан. Байнгын ажиллагаатай парламент бий болсон цагаас хойш 1 өдрийн дотор Засгийн газраа, Улсын Их Хурлын даргаа огцруулсан үйл явдал болсон. Энэ хэмжээгээрээ Монголын төр нэлээн бужигнаж тогтворгүй байдалд орсон. Одоо буцаад илаарьших гэж байна. Энд таны хичээл зүтгэл их байх. Та ийм

юм бодож тэр өндөр албан тушаалаа өөрийн хүсэлтээр өгөөд энд ирсэн байх гэж би итгэж, найдаж байгаа.

Засгийн газар нь Их Хурлаа бойкотолдог, дарамталдаг ийм байдал сая бий болсон. Энийг бүгдээрээ мэдэж байгаа. Энэ байдал дахиж бий болох ёсгүй. Улсын Их Хурлын дарга бас энийг хичээж ажиллах хэрэгтэй. Энэ саяын болсон үйл явдлыг илаарьшуулж, эв нэгдэлтэй байлгахын төлөө Улсын Их Хурлын дарга, Өлзийсайхан дарга та 2-ын хичээл зүтгэл их байгаа юм.

Одоо удахгүй 12 дугаар сарын 29 болно. Монгол улс Манжийн дарлалаас салж, үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж, тусгаар тогтнолоо зарласан түүхэн үйл явдал болно. VIII Богд Жавзандамбын хэлсэн ийм үг байгаа юм. Тусгаар тогтнохоос өөр оршин тогтнохуйн үндэс алга гэж. Тэгвэл өнөөдөр Монголын төрд ардчиллаас өөр тусгаар тогтнох, оршин тогтнохуйн үндэс байхгүй юм шүү. Тэгэхээр ардчилсан парламентын үйл ажиллагааг хамгаалж, аль нэг нам, улс төрийн хүчинд үйлчлэхгүй байгаарай. Өмнө нь таны өмнө ажиллаж байсан Баасандорж даргыг би хувьдаа сайн ажилласан гэж үнэлдэг. Та бол илүү сайн ажиллах ёстой. Бас хэцүү цаг үед энэ албанд томилогдож байгаа шүү. Ингээд танд амжилт хүсье.

Н.Учрал: Доржсүрэнгийн. Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Парламентын засаглалын чиглэлээр судалгаа бол судалгаа хийсэн, ном, бүтээл туурвил гаргая гэвэл гаргачихсан, олон жилийн ажлын дадлага туршлагатай ийм чадварлаг эмэгтэй Улсын Их Хурлын Тамгын газрын дарга, Ерөнхий нарийн бичгийн даргын энэ албан тушаалд нэр дэвшиж орж ирж байгаад миний хувьд талархалтайгаар хүлээж авч байгаа. Үндсэн хуулийн цэцийн гишүүн гэдэг энэ хариуцлагатай, нэр хүндтэй хуулийн оргил болсон энэ ажлаасаа өөрийн саналаар татгалзаж парламентын ардчиллыг бэхжүүлэхийн төлөө зориг гаргаж орж ирж байгаа Танд би бас талархлаа илэрхийлмээр байна.

Өнгөрсөн цаг хугацааны амаргүй үеийг гишүүд янз янзаар л тайлбарлаж байгаа. Манай парламентын туршлагатай бараг л шинэ гишүүдэд хичээл заахаар олон жил суучихсан ах нар маань хүртэл л ямар нөхцөл байдалд байснаа өнөөдөр ч ойлгож байгаа юм уу, үгүй юм уу гэмээр л зүйл заримдаа ярих юм. Парламентын ардчилал, парламентын засаглал бэхжүүлнэ ээ, тогтвортой байлгана аа, энэ ардчиллын үнэ цэнийг бэхжүүлнэ л гэж байгаа бол Улсын Их Хурлын гишүүний энэ парламентч хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхэд нь халдахгүй байх ёстойгоос л эхлэх ёстой. Үндсэн хуулийг сахин хамгаалсных нь төлөө аль нэгэн бойкотны үүрэг гүйцэтгэсэн нөхдүүдийн гар хөл юм шиг ярьж байгаад нь би бас их харамсаад байгаа юм. Тэгэхээр би 126 гишүүнтэй болсон энэ парламентын засаглалыг бэхжүүлэхэд энэ гишүүдээ бид Үндсэн хуулийн суурь зарчмуудыг, Үндсэн хуулийн үнэ цэнийг мэдрүүлдэг болгох энэ цаг хугацаанаас бараг энэ ардчиллын асуудал эхлэх болов уу гэж харж байна.

Их Хурлын гол үйл ажиллагааг зохицуулдаг дэгийн зөвлөх хийнэ та. Энэ дэгийн зөвлөх гэдэг бол Их Хурлын гишүүдийг, Их Хурлын удирдлагуудыг Үндсэн хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах, хууль тогтоомжоо мөрдөх энэ хязгаарыг та зөвлөж, хууль зөрчүүлэхгүй байх үндсэн үүргийг хүлээх ёстой.

Харамсалтай нь өнгөрсөн цаг хугацааны явцад бий болсон үр дүнгээр дэгийн зөвлөх дэгээ зөвлөж чадаагүйгээс өнөөдөр бидний хамгийн туршлагатай, хамгийн улс төрийн карьерын хувьд ирээдүйтэй байсан улс төрч эмэгтэй албан тушаал авахаасаа огцрох хэмжээнд хүрсэн гэж би хардаг.

Тийм учраас энэ дэгийг зөвлөж байгаа хууль, эрх зүйн талаас нь тайлбар гаргаж өгч байгаа нөхцөл байдал дээр хэн нэгэнд зориулж биш хуулийн талд ажиллаасай гэж би хүсэж байгаа. Энийг ч таныг би хийж чадна гэдэгт бүрэн итгэлтэй байгаа.

Дараагийн асуудал бол Байнгын хороодын зөвлөхүүд Их Хурлын Тамгын газрын Ажлын албыг бэхжүүлэх, чадавхжуулах чиглэлд бас танаас би илүү их үр дүнтэй ажлууд гарах байх гэж ингэж итгэж байна. Танд ажлын өндөр амжилт хүсье.

Н.Учрал: Үүрийнтуяа гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Золжаргалын урилгаар НЕБ-ын 40 дүгээр сургуулийн 12^{Г} ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нартаа сурлагын өндөр амжилт хүсье. Манай Золжаргал гишүүн их сайн ажиллаж байгаа шүү гэж ээж, аавдаа хэлээрэй гэж байгаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Дэгийн зөвлөх, Их Хурлын даргын биш, Их Хурал дахь олонхын бүлгийн зөвлөх биш, Улсын Их Хурлын дэгийн зөвлөх гэдэг албан тушаал дээр томилгоо хийх гэж байна. Үндсэн хууль дээр Улсын Их Хурал Улсын Их Хурлын гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр Байнгын хороо болон нэгдсэн чуулган хүчин төгөлдөр хуралддаг. Намын бүлэг Улсын Их Хурлын албан ёсны бүтэц. Та түрүүн хэлсэн Улсын Их Хурал мэтгэлцдэг, байр сууриа илэрхийлдэг, шийдвэрийг гаргахын тулд албан ёсны бүтцээрээ хуралддаг хуралдааны үндсэн чиг үүрэгтэй байгууллага. Улсын Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөл уул нь Улсын Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөл гэж байх ёсгүй. Улсын Их Хурлын зөвлөл буюу Улсын Их Хурлыг амжилттай хурлаа зохион байгуулахын тулд урьдчилан хэлэлцүүлэг хийдэг энэ бүтэц ажиллах ёстой. Улсын Их Хурлын даргын зөвлөл 7 хоногт 1 удаа хуралддаг. Хуралдаад ирэх 7 хоногийнхоо бизнес төлөвлөлтийг ярьдаг. Ямар хурал хийж, ямар бүтцээрээ ажиллаж, яаж шийдвэр гаргах вэ гэдэг талаараа хэлэлцдэг. Энэ хэлэлцэх үйл явцаараа бид тэрнийхээ гаргасан шийдвэрийн дагуу дэгээрээ хуралдаж байгаа. Сүүлийн үед энэ хуралдаанаар биш “viber” групп дээр шийдвэр гаргадаг болоод хувирчихлаа. Хуралдааны хэлэлцсэн асуудал дээр “viber” групп дээрээс л санал асуулга явуулж байгаад заримыг нь хасдаг, зарим нь нэмдэг болоод хувирчихлаа. Хэрвээ энэ чинь албан ёсны хурлын хэлбэр болоод эхлэх юм бол энэ 126 хүн суух хэрэггүй “viber” групп дээрээ хэлэлцүүлгээ хийгээд саналаа хураасан нь дээр шүү дээ. Энэ буруу жишиг чинь өнөөдөр энэ дэгийг эвдэж байна. Улсын Их Хурлын албан ёсны бүтэц бүлэг хуралдаагүй байна.

Яагаад гэвэл энэ Улсын Их Хурлын дэгийн зөвлөхтэй холбоотой асуудал бол 126 гишүүний гишүүнтэй холбоотой асуудал. Эрх барьж байгаа намын дарга, эс үгүй бол эрх барьж байгаа намын бүлэг шийдчихээрээ бүх юмыг шийдчихлээ гэж шууд ингэж оруулж ирж зохимжгүй.

Ардчилсан намын бүлэг энэ асуудлаар хуралдаагүй байна. Тийм учраас бид завсарлага авч байна. Албан ёсныхоо бүтцээр бид хуралдаж, энэ дэгийн зөвлөх та хэдийн сая сургамж авсан. Ажлаа хийгээгүйгээс болоод ийм болдог юм байна гээд танай нэг намын лидер албан тушаалаа өгсөн байж магадгүй. Ардчилсан нам бас энэ Тамгын газраас энэ хүмүүсээс үйлчилгээ авах эрхтэй. Тийм учраас бид дотроо бас асуудлаа ярих ёстой. 3 хоногийн завсарлага авч байна. Хүсэлт өгч байна.

Хувь хүн дээр гишүүд болгон өөр өөрийн байр сууриар хандаж байгаа. Бид нар хоорондоо ярилцах ёстой. Улсын Их Хурал дэгээрээ ажлаа хийх ёстой. Цаашид Даргын дэргэдэх зөвлөлийг “viber”-раар хуралдуулахаа болимоор байна. Албан ёсоороо хуралдаад албан ёсныхоо шийдвэрийг гаргаад тэр шийдвэрээрээ бүлгүүд нь хуралдаад, бүлгүүд нь бас ямар шийдвэр гаргах вэ гэдгээ ярилцаад Байнгын хороод нь хуралдаад энэ жишиг жаягаараа явахгүй бол энэ парламент чинь сүүлдээ даргын хавтсанд байдаг шийдвэр гаргагч гэдэг шиг болж хувирах нь.

Бид парламентат ёсыг, парламентын дархлааг, парламентын энэ хууль тогтоох эрх мэдлийг чанаржуулъя л гэж бодож байгаа бол жижиг юмнаас ч гэсэн эхлэх ёстой. Энэ жижиг зүйл юм шиг боловч бид хүний томилгоотой холбоотой, Улсын Их Хурлаас шийдвэр гаргах гэж байгаатай холбоотой асуудлаар ядаж цөөнхийнхөө бүлгийг, бүлэггүй байгаа энэ нам парламентын гишүүдээ энэ асуудлаар нэг өрөөнд ороод суугаад ярилцах боломжийг нь өгдөг байх хэрэгтэй.

Н.Учрал: Тэмүүжин гишүүн бүлгийн дэд даргын хувиар санал хэлж байгаа юм байна тээ? Их Хурлын Тамгын газрын дарга Ерөнхий нарийн бичгийн дарга Барсүрэнгийн Баасандорж өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ Их Хурлын даргад гаргасан. Тэргүүн дэд дарга Ариунхур өргөдлөө өгсөн байна. Би дуудаад өргөдлөө өг гэж шахаагүй шүү. Ариунхур дарга өргөдлөө өгсөн байна. Их Хурлын даргын хуулийн зөвлөхүүд бүгдээрээ чөлөөлөгдсөн ийм нөхцөл байдалтай байна. Ингээд би Их Хурлын даргын хувиар ингээд Ерөнхий нарийн бичгийн дарга Их хуралд санал болгох, хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд нэлээд бодож байж энэ 19, 23 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амьдрал дээр бас амилуулахад идэвхтэй ажиллаасай гэж би Өлзийсайхан даргаас санал болгосон юм.

2019, 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг нийгэм олон нийт зарим нь зөв байсан уу, буруу байсан уу, 126 гишүүн зөв байсан уу, буруу байсан уу, энэ пропорциональ тогтолцоо орж ирсэн зөв байсан уу гэдэг дээр нийгмийн мэтгэлцээн өрнөж байх шиг байна. Тэгээд миний хувьд өөрөө 126 гишүүнтэй болж, энэ пропорциональ тогтолцоо нэвтэрсэн нь зөв байсан гэдэг ийм итгэл үнэмшилтэй хүн.

Үүнийг илүү амьдрал дээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлт зөв байсан юм гэдгийг амилуулах буюу тухайн үед энэ дэд ажлын хэсгийг нь ахлан ажиллаж байсан Өлзийсайхан даргыг ийм цаг үед бас мэдлэг, ур чадвараа дайчилж ажиллаж туслаач л гэж би хүссэн юм. Тэрнээс энэний ард ямар нэгэн тийм улс төр

огт байхгүй. Ялангуяа манай Тэмүүжин гишүүн тэргүүтэй гишүүд энэ улс төрийн намын дарга Их Хурлын дарга байх дээр хатуу эсрэг ийм шүүмжлэлтэй байсан. Тийм ч учраас би Ерөнхий нарийн бичгийн даргаасаа авхуулаад ийм улс төржсөн томилгоо хийхийг хүсээгүй юм. Тэрнээс биш зүгээр ийм намдаа ажиллаж байсан хүмүүсийг Ерөнхий нарийн бичгийн даргаар оруулчхаж болно шүү дээ. Тэгж хүсээгүй. Тийм ч учраас яг таны хэлдгээр Дэгийн зөвлөх учраас та бүхэнтэй мөр зэрэгцэн ажиллаж байсан ийм хуульч хүнийг тавиад ажиллуулбал цаашдаа энэ Их Хурлын Тамгын газар хуулийн ямар нэгэн зөрчилгүй ажиллана л гэж хүссэн. Түүнийг бас та зөвөөр ойлгоорой гэж.

Тийм учраас би бүх Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг дээр Тамгын газрын дарга Ерөнхий нарийн бичгийн даргын томилгооны талаар нэг үг ч дурсаагүй Ардчилсан намын, Ардын намын бүлэг дээр. Ардын намын бүлэг дээр тэр Засгийн газрын гишүүдийг л ярьж байгаа. Тэрнээс биш энэ төрийн албыг энэ чинь өөрөө хууль зүйн өндөр мэргэжилтэй, төрийн захиргааны албан хаагчийг Их Хурал дахь Ардын намын бүлгээс улс төрийн шийдвэр гаргаагүй. Тэрийг Батжаргал дарга, бид нар огт гаргаагүй. Ингээд Их Хурлын даргын бүрэн эрхийн асуудал учраас танилцуулаад Их Хурлаар шийдэх нь зөв өө гэж л ийм л бодлого гаргаад явж байгаа.

Тийм учраас заавал энэ төрийн жинхэнэ албан хаагчийг Их Хуралд улс төрийн намууд бүлгээрээ авч хэлэлцээд байх нь өөрөө энэ хүн цаашдаа ажил хийхэд бэрхшээлтэй болно. Би харин та бүхний хэлсэн саналыг хүндэтгэж байна. Тамгын Ерөнхий нарийн бичгийн даргаар хэрвээ Өлзийсайхан дарга томилогдвол Их Хурлын даргын хуулийн ахлах зөвлөх биш Их Хурлын дэгийн зөвлөгөө илүү хариуцлагатай хийж, Их Хурлын 126 гишүүнийг хууль зөрчихөөс хамгаалж, хууль, эрх зүйн мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөө өгч ингэж ажиллахыг би хичээнгүйлэн хүсэж байгаа.

Тийм учраас 3 хоног, тэд хоног гэж завсарлага авах нь цаг хугацааны хувьд Их Хурлын даргын хувиар ажлаа явуулахад бэрхшээлтэй байна. Гэхдээ Ерөнхий дарга ч байхгүй, Тэргүүн дэд ч байхгүй, Ерөнхий дарга нь томилогдоогүй учраас хуулийн зөвлөхүүд ч авч чадахгүй ийм л нөхцөл байдалтай байгааг бас та ойлгохыг би хүсэж байна. Тэгээд Ардчилсан намын бүлгийн зүгээс завсарлага авах хүсэлт гаргасан тул Ардчилсан намын бүлэгт 2 цагийн завсарлага өглөө. 2 цагийн завсарлага.

Тэмүүжин гишүүн үг хэлье.

Х.Тэмүүжин: Бид бүгд бүгд ажлаа төлөвлөдөг. 7 хоногийн хуваарь тодорхой гарсны дараа Улсын Их Хурлын 126 гишүүн бүгд миний Байнгын хороо хэзээ хуралдах гэж байгаа, ажлын хэсэг хэзээ хуралдах гэж байгаа юм, нэгдсэн чуулга хэзээ хуралдах гэж байгаа юм, ямар асуудал яаж шийдэх гэж байгаа гэдгээрээ төлөвлөгөөгөө гаргадаг. Манай бүлгийн дарга энэ гэнэтийн асуудлыг чинь мэдээгүй байсан учраас гадагшаа томилолттой явчихсан. Манай бүлгийн гишүүд бас энд, тэнд томилолттой байна. Бид хууль, дүрмээрээ 1 дэх өдөр бүлгүүд хуралдах учраас манай бүлгийн 42 гишүүний талаас илүү хувь нь 1 дэх өдөр бүлгийн хурал хуралдана гэдэг төлөвлөгөөтэй байна.

Тэгэхээр та нэг юмыг сайн ойлгох хэрэгтэй байна. Засгийн газар яаралтай хуралтай үедээ сайдууд Ерөнхий сайдын өмнө бүгд бэлэн байдаг. Энэ бол кабинетын зарчим. 126 гишүүн энэ бол парламент 7 хоногоор, 14 хоног хоногоор төлөвлөсөн төлөвлөгөөгөөр явдаг. Энэ төрийн ноён нуруу шүү. Энэ төрийн ноён нурууг босоод суугаа газар хугалж болохгүй. 1 дэх өдөр манай бүлэг хуралдана. Бүлгээрээ бид ярилцана. Таны оруулж ирсэн нэр дэвшигчтэй холбоотой гомдол, санал манай бүлэг дээр алга байна.

Харин процесстой холбоотой асуудал чинь биднийг үл тоож байна. Улсын Их Хурлын бүтэц, яах вэ танай бүлгээр энэ намын даргаа оруулж ирж байгаа асуудал хэлэлцэхгүй байж болно гээд танай намынхан даргадаа эрх мэдлээ бэлэглэчихдэг учраас тийм хандлагатай байж болно.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг бол 42 гишүүнтэй. 42 хүн хоорондоо ярьж байж нэгдсэн шийдвэр гаргадаг. Улсын Их Хурал бол 126 гишүүнтэй. Үндсэн хууль дээр Улсын Их Хурал 126 гишүүнээс бүрдэнэ гэж байгаа. Гишүүн болгон адилхан саналтай, үгээ хэлдэг, саналаа илэрхийлдэг. Хэн нэгэн даргыг нь төлөөлөхгүй, өмнөөс нь шийдвэр гаргахгүй. Тийм учраас хуралдах боломж олгож өгөөч гэж хүсэж байгаа. Хурал маань 1 дэх өдөр болно. 1 дэх өдөр хуралдаад 2 дахь өдөр байна уу, 3 дахь өдөр байна уу шийдвэрээ гаргаж болно шүү дээ. Та бүхэн Засгийн газар хүсэлт гаргаад сайдаа солиод Улсын Их Хуралд сонсгоод өнгөрье гэхэд л Даргын зөвлөлийг хуралдуулахгүйгээр “viber”-аар санал аваад л шийдвэрээ гаргаад нэгдсэн чуулган хийчихдэг л юм байна лээ шүү дээ.

Гэтэл энэ бол Засгийн газрын сайдыг Улсын Их Хурал сонсох тухай биш цаашид 126 гишүүн бүрэн эрхээрээ ажиллахдаа дэгийн зөвлөгөө авах тухай албан тушаалтныг ярих гэж байгаа шүү дээ. Тийм учраас зүгээр хүсэж байгаа хүсэлт юу вэ гэхээр бид хурлаа хуралдаад, шийдвэрээ гаргаад, тэгээд ирэх 7 хоногтоо энэ асуудлаа шийдээд явж болно. Нээлттэй. Хуралдах эрхээ авах гэж бид сүүлдээ юу болох юм бэ? Гуйж мөргөж сөгдөх юм уу?

Н.Учрал: Өнөөдөр Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн чиглэл хэлэлцэнэ шүү. Ер нь өнөөдөр улсынхаа хөгжлийг ярих гэж байгаа.

Тэрний өмнө манай Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар биш андуурсан. Ундрам гишүүн мөн биз дээ. Ундрам гишүүний урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ЕБС-ийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, ажилчдадаа ажил, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье.

Тэмүүжин гишүүний би саналыг хүндэтгэж байна. Энэ “viber” дээр Даргын зөвлөл дээр гэнэт гэнэт асуудал ороод ингээд сурчихсан юм байна лээ. Ийм соёл тогтчихсон юм байна лээ. Энэ соёлоо одоо өөрчилцгөөе. Гэхдээ нэн яаралтай горимоор ч юм уу, эсвэл Даргын зөвлөлөөр шийдэх шаардлагатай асуудлууд цаг тухайд нь орж ирдэг. Энэ мөч болгоныг биеэр хуралдуулахаар зарлаж байна шүү харин гэдгээ би бас хэлчихье. Даргын зөвлөлийн хурал 2 цагийн дараа, цагийн дараа гээд ингээд зарлагдах нөхцөл байдлууд үүснэ. Ингээд харин хуралдааныхаа журам дээр магадгүй тодорхой гишүүд дотоодод томилолттой, гадаад томилолт энэ тэр байвал цахимаар бас оролцоод санал бодлоо хэлдэг байх журмаа

шинэчлээд ингээд биеэр хуралдаж асуудлыг шийддэг байх шинэ журмыг хэрэгжүүлж эхэлье.

Харин манай Даргын зөвлөлийн гишүүд тухайн цаг мөчид нь бас хуралдаа хүрэлцэн ирж байхыг дараа нь бас би бас шаардана. Тэгэхгүй бол нэн аюултай горимоор хууль оруулаад ирдэг, тэгээд хуулийн хугацаатай асуудлууд байдаг, тэгээд хэлэлцэх гэхээр бас ирц бүрддэггүй асуудлууд байдаг учраас энэ журмаа шинэчлээд ингээд асуудлаа шийдээд явна. Түүнд би таны саналыг хүлээж авч байна. Тэгээд маш хариуцлагатай Даргын зөвлөлийн хурлуудыг хийж хэвшинэ гэдгийг хэлье.

Улсын Их Хурлын энэ Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөөд томилох ёстой. Тэгээд Баасандорж даргыг чөлөөлөх саналтай ингээд явах ёстой. Би танд түрүүн завсарлагынхаа хугацааг, мэдээж хуулиараа угаасаа 5 хүртэлх хоногийн хугацаанд завсарлага өгнө. Хуралдаан даргалагч шийднэ гээд байгаа юм. Тэгээд энэ Улсын Их Хурлын даргын бүрэн эрх дээр нь Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Их хурал томилж, чөлөөлнө. Төрийн албаны хуульд заасан сонгон шалгаруулалт, журам Ерөнхий нарийн бичгийн даргыг томилоход хамаарахгүй гэж.

Тэгээд ер нь Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг улс төрийн намын бүлгүүд оруулж асуугаад тэгээд шийдвэр гаргаад байх нь цаашдаа Их Хурал бас энэ парламентын ардчилал бэхжээд, хөгжөөд явахад тийм ч сайн жишиг биш байх л гэж би бодож байгаа. Тийм учраас Ардын намын бүлэг дээр ч гэсэн энэ асуудлыг огт, үгүй энэ чинь төрийн жинхэнэ албан хаагчид тийм. Энэ чинь төрийн жинхэнэ албан хаагч шүү дээ. Таны бидэнд заасан хичээлээр л яриад байгаа шүү дээ би. Тийм, би ч таны Эрх зүйн онол, Төрийн онол 2-т суусан хүн, шавь байхгүй юу.

Тийм учраас Тэмүүжин багшийнхаа хичээлээр л төрийн жинхэнэ албан хаагч гэдэг утгаар тэрнээс улс төрийн албан хаагч мэдээж өөр асуудал байгаа. Засгийн газрын гишүүдийг бүх намууд бүлгүүдээ оруулж ирээд ёстой асууж тодруулах ажлуудыг сайн хийх ёстой. Танд, та бүхнийг бас би Тэмүүжин гишүүнд хүсэлт тавьж байна. Одоо ингээд Ерөнхий дарга нь, Тэргүүн дэд дарга нь тэгээд одоо бүх ажлууд нь явахгүй байдалтай байгаа байхгүй юу. Тэгэхдээ өмнө нь Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг бүлгээр оруулж ярьж байсан практик байхгүй юм байна лээ шүү. Ерөөсөө Ерөнхий нарийн бичгийн даргыг улс төрийн намын бүлгүүд хэлэлцэж байгаагүй юм байна лээ. 1 ч удаа. Ардын намын бүлэг ч хэлэлцэж байгаагүй юм байна лээ, Ардчилсан намын бүлэг ч хэлэлцэж байгаагүй юм байна лээ. Одоо тэр.

Ардын намын бүлэг энэ талаар ямар ч санал, дүгнэлт гаргаагүй, танилцуулга ч хийгээгүй. Хуралдуулах боломж олгоод би тэгээд 2 цагийн завсарлага хүлээгээд цохичихсон. Дээрээс нь Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга чөлөөлөгдөх хүсэлтээ өгөхөөр нь дараагийн хүнийг нь Их Хурлын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд оруулаад ирсэн. Тэгээд оруулаад ирсэн учраас энийг хэлэлцье л гэж хэлж байна шүү дээ. Үгүй үгүй Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан. Гаргасных нь дараа дараагийн хүнийг нь санал болгосон. Энэний чинь хугацаа байхгүй шүү дээ ийм асуудалд чинь. Тэр хүн ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргаж байна шүү дээ.

Тэргүүн дэд дарга нь бас өөрөө хүсэлтээ гаргаж байна шүү дээ. Тэгэхээр дараагийн хүнийг нь Их Хурлын даргаас санал болгоно биз дээ.

Тэгэхээр энэ чинь төрийн ажил тогтвортой байх үүднээсээ л та бүхэнтэй нээлттэй яриад л явж байгаа шүү дээ. Би таныг санал бодлоо хэл гэсэн. Төрийн байгуулалтын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороон дээр танилцуулсан. Тэгээд одоо бүгдээрээ ажлаа хийе л гэж байгаа шүү дээ. Би бол аль олон ургалч үзлийг чинь хүндэтгэнэ. Аль аль намын бүлэгтээ би энэ парламентын спикерийн хувиар тэгш боломжоор нь хангаад ингээд ажиллая л гээд би хэлж байгаа шүү дээ. Тэгэхээр ажлаа хийх нөхцөл бололцоогоор хангаач л гэж байгаа юм. Би 2 цагийн завсарлага өгсөн. Тэгэхээр 2 цагийн завсарлага Ардчилсан намын бүлэгт өглөө.

Үгүй үгүй Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга гэсэн албан тушаал дээр улс төрийн шийдвэр гаргаж болохгүй. Энэ.

Ардчилсан намын бүлгийнхэн сууж байгаарай одоохон. Ардчилсан намын бүлэгт 2 цагийн завсарлага өгсөн. Тухайлсан асуудлаар тэгээд дараагийн асуудал руу орно.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэн танилцуулах юм? Улсын Их Хурлын гишүүн Заяабал танилцуулна. Индэрт урья.

Б.Заяабал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасныг баримтлан 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 435 дугаар захирамжаар “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгээр ахлуулж, гишүүдэд Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, М.Мандухай, Б.Мөнхсоёл, Ц.Мөнхтуяа, З.Мэндсайхан, Ч.Номин, Н.Номтойбаяр, П.Сайнзориг, О.Саранчулуун, Р.Сэддорж, Б.Уянга, Г.Уянгахишиг, Б.Хэрлэн,

С.Цэнгүүн, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нарын гишүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажилласан.

Ажлын хэсэг төлбөрийн тэнцлийг алдагдлыг багасгах, урсгал дансны алдагдлыг цаашид үе шаттайгаар бууруулах бодлогын хүрээнд уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээгээр гадагшилж буй валютын урсгалыг багасгах чиглэлээр тогтоолын төслийн 1, 2, 3 дугаар хавсралттай холбогдуулан нийт 143 зарчмын зөрүүтэй санал, 4 найруулгын саналын томьёолол бэлтгэн Байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт танилцуулсан болно.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасныг баримтлан бусад Байнгын хороод тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, зарчмын зөрүүтэй саналуудаа олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж санал, дүгнэлтийн хамт Эдийн засгийн байнгын хороонд ирүүлснийг танилцуулж байна.

1.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт.

Тус Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мандхай, Мөнхбаясгалан нараас хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах, ган, чийгт тэсвэртэй үр, сортыг бий болгох, дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх зэрэг зарчмын зөрүүтэй 12 саналын томьёоллоор санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх эдгээр саналуудыг дэмжсэн байна.

2.Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт.

Тус Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир төслийн 2 дугаар хавсралтын бүсийн хөгжил, бодлогын чиглэлд улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх талаар зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн байна.

3.Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт.

Тус Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлтийг бууруулах, иргэдийн хор уршгийн талаарх мэдлэг, боловсрол нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр зарчмын зөрүүтэй 1 саналын томьёолол гаргаж, санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх мөн дэмжсэн байна.

4.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт.

Тус Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа, Пунсалмаа, Галбадрах, Мөнхсоёл, Мөнхсайхан, Батчимэг нараас багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах,

боловсролын салбарын санхүүжилтийг хүртээмжтэй, тогтвортой өсгөх нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийг тогтмолжуулах, эрүүл мэндийн салбарт зарцуулах зардлын ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлэх, ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих зэрэг зарчмын зөрүүтэй 17 саналын томьёолол гаргасан бөгөөд олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Өргөдлийн байнгын хороодын хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүдээс тогтоолын төсөлтэй холбоотой тусгайлсан зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсэгт заасныг баримтлан “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсыг 2026-30 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцууллаа.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэж ажилласан ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирсэн байна. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Жадамбын Энхбаяр, Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Сангийн сайд Болдын Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням, Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батын Батбаатар, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Чинбатын Ундрам Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Энхбаярын Батшугар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Жигжидсүрэнгийн Чинбүрэн Эрүүл

мэндийн сайд, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Батболдын Мөнхтөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Бизнесийн орчны бодлогын газрын дарга Лхагвасүрэнгийн Балчинлувсан. Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Батчулууны Мөнгөнсүх, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Батжаргалын Төгөлдөр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга Батхишигийн Мөнх-Эрдэнэ гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, тайлбар авна. Гишүүд Улсын Их Хурал дахь анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Тэмүүлэн, ажлын хэсгийн гишүүд, Засгийн газрын гишүүдээс асуулт асууж, хариулт авч болно. Асуулт асууж, тайлбар авах Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгье.

Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн. Ирцээрээ Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Таван жилийн төлөвлөгөөг харж байна. Зарчмын зөрүүтэй энэ олон саналууд орж ирж байна. Тэгээд энэ танай ажлын хэсэг ер нь яаж хуралдсан юм Байнгын хороо? Тэгээд дийлэнх Байнгын хорооноосоо дэмжигдэж орж ирсэн саналууд ерөөсөө уначихсан байх юм. Тухайлбал, миний Төрийн байгуулалтын байнгын дээр гаргасан ганцхан санал Байнгын хороон дээрээ дэмжигдсэн. Гэтэл Эдийн засгийн байнгын хороон дээр уначихсан байх юм. Энэ нь өөрөө Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн энэ зүйл, заалтыг эрчимжүүлэх асуудал. Яагаад гэхээр өнгөрсөн жил бид нар энэ хууль энэ 25 оны 6 сарын 1-нээс хэрэгжих байсан. Гэтэл Засгийн газар энэ чиглэлээр ямар ч ажил, арга хэмжээ хийгээгүй, хуулийн бэлтгэл хангаагүй гээд ингээд Засгийн газраас энэ хуулийг 1 жилээр хойшлуулж өгөөч гэдэг ингээд хавар бид нар хойшлуулсан. Тэгээд хэрэгжих хугацааг нь 26 оны 6 сарын 1 болгосон.

Гэтэл өнөөдөр хагас жил нь өнгөрчихлөө. Энэ хугацаанд юу хийсэн юм? Ерөөсөө энэ талаар ажил хийгдэхгүй байгаа. Тийм учраас хуулийн хэрэгжилтийг, биелэлтийг хангуулах үүднээс зориуд ийм заалт оруулсан юм энэ таван жилийн хөгжлийн. Тэгэхгүй бол энэ чинь хөгжлийн төлөвлөгөөнд орохгүй бол ирэх 5 жил энэ чинь энэ хуулийн заалт ерөөсөө хэрэгжихгүй ингээд худлаа хоосон цаасан дээр бичсэн хууль болоод байна л даа. Тэгээд энийг нь Эдийн засгийн байнгын хороо унагачихсан байх юм. Ямар учиртай юм бэ? Сонсох нь танай Эдийн засгийн байнгын хороо ирц хүрэхгүй шалтгаанаар баахан гишүүдийн гаргасан саналыг унагасан гэсэн ийм асуудал яригдаад байгаа. Ингэж асуудалд ингэж хандаж болохгүй шүү дээ. Ирэх 5 жилийнхээ төлөвлөгөөнд л оруулж авахгүй бол өөр бид нар хаанаа юугаа оруулж авах юм. Энэ дээр хариулт өгөөч.

Н.Учрал: Мэндчилгээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар нийслэл Улаанбаатар хотынхоо хоймор дүүрэг ЧД-ийн

иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. ЧД-ийнхэндээ аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай тойргийнхон байна. Баатархүү гишүүнийхээ халуун дотно мэндчилгээг дэвшүүлье.

Сандаг-Очир гишүүний асуултад Тэмүүлэн гишүүн хариулна. Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Би өнгөрсөн 7 хоногт Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийнхээ байр суурь, ажлын хэсгээс гаргасан санал болоод түүнтэй холбоотой асуудлаар хариултад хариулна. Өчигдөр Эдийн засгийн байнгын хорооны хурлыг Эдийн засгийн байнгын хорооны дарга өөрөө зохион байгуулсан. Тэгэхээр одоо Байнгын хорооны хурлаар хэлэлцэж байгаа асуудал нь хэлэлцэгдэж байгаа учраас орж ирж энэ асуултад, гишүүдийн асуултад хариулах ёстой гэж харж байна.

Өчигдөр би хуралд ажлын хэсгийн даргын хувиар, асуудлаа оруулсан хүний хувиар хөндлөнгөөс Эдийн засгийн байнгын хорооны хурлын явцыг ажиглахад үндсэндээ зохион байгуулалтаа хийж, хурлаа хийж үндсэндээ хуралдаж чадаагүй. Ажлын хэсэг 7 хоногийн хугацаанд 25 хүн бүхий л өөрсдийнхөө нөөц боломж, бололцоо, хүч чадал, мөн дээрээс нь энэ Эдийн засаг, хөгжлийн яам болоод бусад яамдын төлөөллүүдийг оролцуулаад бараг өдөр, шөнөгүй ингэж ажиллаад ингээд бид нар манай ажлын хэсгээс 130 гаран санал гарч ирсэн байгаа.

Эдийн засгийн хөгжлийн энэ үндсэн чиглэл бол өөрөө хөгжлийн бодлого байгаа. Энэ үзэл санаа, үзэл баримтлал байгаад байгаа. Энэ дээр бид нар бодлогын асуудлыг яг баримтлах ёстой, бодлогын асуудлыг ярих ёстой гэдэг байр суурийг манай ажлын хэсгийн гишүүд баримталж бид бүхний гаргасан энэ 135 санал бол зөвхөн ирэх таван жилийн хугацаанд Монгол Улсыг хөгжүүлэх бодлоготой холбоотой, энэ хөгжлийн стратегитай холбоотой асуудал байгаа. Бид бүхнээс ямар төсөвтэй холбоотой саналыг гаргаагүй.

Гэтэл Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад үндсэндээ энэ хөгжлийн бодлогын баримт бичгийг төсвийн 2 дахь хэлэлцүүлэг болгох шахуу ийм асуудлууд орж ирсэн. Эндээс үүдээд Эдийн засгийн байнгын хороон дээр үл ойлголцол гишүүдийн дунд үүссэн. Ингээд тодорхой зарим гишүүд бас хурлыг орхиж гарсан. Ажлын хэсэг хуулийн хугацаатай учраас 11 сарын 30-ндаа багтаж бид нар энэ үндсэн чиглэлээ батлах учраас өчигдөр ялт ч үгүй Эдийн засгийн байнгын хороо хуралдаад ажлын хэсгийн энэ саналууд бас ингээд дэмжигдээгүйгээр орж ирж байгаа юм.

Гэхдээ ямар ч бай ажлын хэсэг үндсэндээ бид бүхэн энэ 7 хоногийн хугацаанд энэ Монгол Улсыг хөгжүүлэх стратегитай холбоотой гол бодлогын асуудлуудыг гаргаж ирсэн. Энэ макро эдийн засгийн гол үндсэн зорилт, үзүүлэлтүүдийг бид бүхэн хэрхэн сайжруулах энэ асуудлуудыг тавьсан. 8 үндсэн чиглэл, 35 бодлогын зорилтын хүрээнд асуудлуудыг гаргаж ирсэн байгаа. Та бүхэн саналын томьёоллуудаас харах байх. Ажлын хэсгийн даргын хувиар мэдээж чуулган дээр хийсэн асуудлаа танилцуулах боломж өөрийнхөө суудал дээрээс байгаа.

Тэгэхээр бидний хувьд гол үндсэндээ анхаарах асуудал ирэх таван жилийн хугацаанд энэ төлбөрийн тэнцлийнхээ алдагдлыг яаж багасгах юм, урсгал дансныхаа алдагдлыг яаж үе шаттайгаар бууруулах юм гэдэг гол зорилтуудыг бас энэ дотроо хийж өгсөн байгаад байгаа. Эргээд эдийн засаг дахь энэ төрийн оролцоог бид нар ер нь яаж бууруулах юм бэ, ДНБ-д эзэлж байгаа төрийн зардлыг хэрхэн бууруулах юм бэ, ТӨК-удын асуудлыг хэрхэн багасгах юм бэ гэдэг асуудлыг энэ бас хуулийн ажлын хэсгээс оруулж байгаа саналууд дээр оруулж ирсэн. Бид бүхэн энэ хувийн хэвшлээ дэмжих, илүү чөлөөт зах зээлийг дэмжих энэ бодлогууд бас энэ эрчим хүчний салбар болоод бусад энэ бодлогын салбарын асуудлууд дээр оруулж ирсэн гэдгийг хэлэх байна. Бодлогын баримт бичиг дээр бас бодит бүхнийг анхаарч үзсэн бас нэг асуудал энэ ногоон эдийн засгийг дэмжих, хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр бид нар ер нь цаашид энэ өрхийнхөө хэрэглээг, хувийн секторынхоо хөрөнгө оруулалтыг, үйлдвэрлэх эрхийг нь дэмжих юм гэдэг энэ бодлогын суурь асуудлууд бас энд орж ирсэн гэдгийг бас хэлэх байгаа.

Хүний хөгжилтэй холбоотойгоор манай гишүүд боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр маш том бас бодлогын асуудлуудыг бас зорьсон. Тэр дотроо эрүүл мэндийн салбар дотроо энэ дундаж наслалтыг ирэх таван жилийн хугацаанд 2 насаар нэмэгдүүлэх буюу түүнтэй холбоотой зорилтуудыг бас энэ дотроо хийж, оруулж өгсөн хүний эрхийн мэдрэмжтэй бас төсөл болоход нь анхаарч ажилласан гэдгийг би бас товчхондоо мэдээлэл өгөх байна.

Н.Учрал: Баасанжаргал гишүүн асуулт асууя. Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Тэгээд юу гэж ойлгох юм бэ? Энэ чинь анхны хэлэлцүүлэг Эдийн засгийн байнгын хороо нь хуралдсан гэж ойлгох юм уу, хуралдаагүй гэж ойлгох юм уу? 130 хэдэн саналын чинь 16-хан санал нь дэмжигдээд 120 хэдэн санал нь ингээд эсрэгээрээ дэмжигдээгүй санал болоод явж байна шүү дээ. Энэ дотор чинь маш чухал чухал олон саналууд байна шүү дээ. Эрчим хүчний чиглэлээр, боловсрол, эрүүл мэнд, ногоон хөгжил, төрийн байгуулалтын шинэчлэлийн чиглэлээр гээд ингээд. Тэгээд энийг чинь л дэмжээгүй саналаа дэмжье гэдэг томьёоллоор санал хураалтаа явуулах уу? Би бол Эдийн засгийн байнгын хороо энэ таван жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр маш хариуцлагагүй хандсан байна шүү. Энэ олон гишүүдийн гаргасан саналд үндэслэл, тооцоо, судалгаатай саналуудад ийм хариуцлагагүй байдлаар хандаж, ирц хүрэхгүй гэдэг шалтгаанаар 130 саналаас 120 хэдийг нь унагачхаад орж ирж байна гэдэг бол энэ хариуцлагагүй хандсан байна гэж би хувьдаа бол…/минут дуусав.

Н.Учрал: Тэмүүлэн гишүүн хариулна.

Г.Тэмүүлэн: Хурлын ирц бүрдсэн. Тэгэхээр хурлын үйл ажиллагаа би хүчин төгөлдөр гэж харж байгаа. Гол нь оруулсан саналуудыг тодорхой эрх ашгийн сонирхлын үүднээс дэмжихгүй гээд зарим гишүүд гарсан байгаа. Энэ бол Эдийн засгийн байнгын хороон дээр. Би ажлын хэсгийн даргын хувьд хэдий бид нарт богинохон хугацаа олдсон ч гэсэн, хуулийн хугацаанд хавчигдсан гэсэн энэ 25 гишүүн бол өөрөө өөрсдийнхөө чиглэл чиглэлээр мэргэшсэн асуудлуудаараа энэ 134 саналыг оруулж ирсэн. Энийг Их Хурлын гишүүд маань та бүхэн маань бас дэмжээд энэ саналуудыг босгож өгөөрэй л гэдгийг би бас хичээнгүйлэн хүсэх байна.

Н.Учрал: Энэ бол Засгийн газраас өргөн мэдүүлсэн таван жилийн үндсэн чиглэл. Тэгэхээр миний хувьд энэ Эдийн засгийн сайдаар ажиллаж байхдаа бас яамныхаа төрийн албан хаагчидтайгаа хамтарч боловсруулсан учраас мэдээлэл сайн байгаа юм. Тэгээд манай Тэмүүлэн гишүүнтэй ажлын хэсэг бол олон өдөр, шөнө, оройгүй сайн ажилласан. Ингээд Их Хурлын ажлын хэсэг, ажлын хэсэг байгуулаад ажилладаг. Тэгээд Байнгын хороон дээрээ орж ирээд ингээд дэмжигдээгүй баахан саналтай. Энд ингээд зөв, бурууг шүүн тунгаа гээд чуулганд ороод ирэхээр энэ чинь тэгээд л дахиад л ирцээс хамаараад эргээд таван жилийн чиглэлээ уншсан чинь хэн ч уншаад ойлгогдохгүй юм болох вий дээ. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бас л тэгсэн шүү дээ. Санал нь унаж, боссоор байгаад сүүлдээ одоо уншихаар 1 хүн бичээгүй жилийн төлөвлөгөө болсон шүү дээ. Хаанаас баахан текст нийлүүлчихсэн юм бэ гэмээр. Энэ л алдаагаа л давтаад л байна л даа. Уг нь анх удаа л индикаторууд тавиад л тоогоор хэмжиж болохуйц байдлаар хийх гэж дэвшил гаргасан. Тэгээд бас л их ойлгомжгүй л байдалд л очиж байх шиг байна.

Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Х.Баасанжргал: Сан би өөрөө ажлын хэсгийн гишүүн. Ажлын хэсгийн гишүүний хувьд сая Сандаг-Очир гишүүний асууж байгаа 1 асуултад бас хариулах нь зөв байх гэж бодож байна. Яг энэ таван жилийн үндсэн чиглэлд хууль тогтоомжийг эрчимжүүлэх ч гэдэг юм уу, ийм томьёоллоор, ийм агуулгаар санал өөрөө тусгах боломжгүй буюу арга зүйн хувьд жаахан зөрүүтэй байдал байгаа гэдгийг бас ойлгоорой гэж хүсэх гээд байгаа юм.

Яагаад гэвэл хууль тогтоомжийг эрчимжүүлнэ гэдэг үр дүн тавьчихдаг. Тэгээд эрчимжүүлснээ яаж хэмжих вэ гэдэг асуудал гарч ирсэн. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамны мэргэжлийн хүмүүсийн зүгээс бас яг энэ индикатор, шалгуур үзүүлэлт дээр бас нэлээн анхаарч байгаа учраас зарим нэг гишүүдийн санал хасагдсан байх гэж бодож байна.

Хоёрдугаарт гэвэл ер нь бид нар энэ таван жилийн үндсэн чиглэлийн эхний 2, 3 дугаар хавсралтыг үндсэндээ манай ажлын хэсгийн гишүүд маш сайн ажилласан. Хамгийн хэцүү, хамгийн төвөгтэй хэсэг нь юу байсан бэ гэвэл Тэмүүлэн гишүүн ч гэсэн бас зарим нэг зүйлийг тодорхой хэлэх нь зөв байх. Энэ зарим гишүүдийн ашиг сонирхлыг хөндөөд байгаа буюу тэр 4 дүгээр хавсралтын 3, 4 дүгээр хэсэг ямар ч ТЭЗҮ нь байхгүй, зураг, төсөв нь байхгүй, хаанаас санхүүжих эх үүсвэр нь байхгүй баахан төслүүд орж ирсэн.

Дээрээс нь дахиад манай Их Хурлын гишүүд яг л төсөвт ханддаг шигээ бүгдээрээ тойрогтоо зам барих гээд л, бүгдээрээ тойрогтоо болсон, болоогүй барилга, байшин барих гээд л нөгөөдөх нь тооцоо, судалгаа нь байхгүй, ТЭЗҮ нь байхгүй, эх үүсвэр нь байхгүй ийм зүйлүүд орж ирсэн. Бүгдээрээ яг энэ дээр ингээд л таван жилийн энэ үндсэн чиглэлийг гол эвдэж байгаа юм дандаа ийм ашиг сонирхол шүү дээ. Ямар ч ийм төлөвлөгөөгүй явах сонирхолтой. Бүгдээрээ тойрогтоо очоод зам барьсан, байшин барьсан гэдэг гавьяа байгуулах гэдэг ерөөсөө л ийм ашиг сонирхолтой хөтлөгдөөд үндсэндээ энэ ажлын хэсгийн гол үндсэн ажлыг нураасан гэх юм уу, Байнгын хороон дээр энэ саналуудыг унагаасан гол шалтгаан бол ерөөсөө л тэр байсан. Тэрнээс биш яг мэргэжлийн

экспертүүдийн ажиллаж гаргаж байгаа санал дээр их айхтар тийм зарчмын зөрүүтэй зүйл байгаагүй. Зүгээр би хувьдаа хэд хэдэн зарчмын зөрүүтэй санал гаргаж оруулсан.

Тэгэхдээ санхүү, мөнгөтэй холбоогүй. Хүний эрхтэй холбоотой, цахим орчинд хүний эрхийг хамгаалах, иргэний нийгмийн байгууллагын орон зайг бэхжүүлэх, иргэд төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах юм бол 1 удаагийн эргэцээр буюу шийддэг байх тэр тоогоор нь илүү төрийн байгууллагын үйл ажиллагааг хэмждэг байх, үр дүнг нь хэмждэг байх ч гэдэг юм уу ийм хүний эрхтэй холбоотой асуудлуудыг энэ таван жилийн үндсэн чиглэлд оруулж ирсэн. Энэ ч утгаараа бас цаашид бас төрийн байгууллагууд ч гэсэн энэ хүний эрхийг хангаж байгаагаа хэрхэн, яаж хэмжих юм гэдэг бас өөр шинэ шалгуур үзүүлэлтүүд орж ирсэн. Энэ бас цаашид хэвшээд явах ёстой гэж хувьдаа харж байгаа. Бид нар аливаа…/минут дуусав./

Н.Учрал: Санал хэллээ. Ажлын хэсгийн гишүүний хувиар. Баасанжаргал гишүүн санал хэллээ. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэнгээр ахлуулсан Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж, Баасанжаргал, Бадамсүрэн, Батболд, Батсүмбэрэл, Галбадрах, Ганмаа, Золжаргал, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Мөнхтуяа, Мэндсайхан, Номин, Номтойбаяр, Сайнзориг, Саранчулуун, Уянга, Уянгахишиг, Хэрлэн, Цэнгүүн, Энхцэцэг, Эрдэнэбат 7 хоног ажилласан. Өдөр, шөнөгүй л ажиллаж байх шиг байсан. Тэгээд манай шинэ залуучууд өөрсдөө өөрсдийнхөө хүсэлтээр би энэ ажлын хэсэгт орж ажиллая, энэ хөгжлийн төлөвлөгөөг зөв болгоё, зөв хэмждэг байя, төсөв биш хөгжлийн үнэхээрийн жинхэнэ төлөвлөгөө байхад нь анхааръя гээд ажиллаад 135 зарчмын зөрүүтэй санал гаргаад ажиллахад ажлын хэсгийн 8-хан санал нь дэмжигдээд бусад нь уначихсан. Гишүүдийн 7 гишүүн бас санал гаргасан юм байна. Мэргэжлийн Байнгын хороон дээрээ дэмжигдээгүй ч саналууд байна. Үүнийг нь Эдийн засгийн байнгын хороо дэмжээд ингээд 16, 15-хан дэмжсэн саналтай, бусад саналууд нь бүгдээрээ унасан ийм л асуудлыг оруулж ирж байгаа нь энэ Эдийн засгийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүд хэрхэн яаж асуудалд хандаж байна вэ гэдэгт бас маш том асуултын тэмдэг тавихуйц ажил болчихлоо.

Бидэнд одоо ямар гарц байна вэ гэхлээр Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжихгүй байж ажлын хэсгийн оруулж ирсэн саналуудыг босгож ирэх буюу Учрал дарга уншиж тэгээд ирцдээ орсон хүмүүс гарч болж байна. Эсвэл ухамсарт үйлдлээр улаан кнопоо дарж болж байна. Ямар ч байсан энэ залуучуудын ажилласан ажлыг нэг ажил хэрэг болгохгүй л болохгүй нь.

Ер нь энэ төлөвлөгөөг төсөвтөө андуурч байна гэж Тэмүүлэн ажлын хэсгийн дарга сая хэллээ. Үнэн шүү дээ. 1 жилийн төлөвлөгөөг хүртэл төсөв мэт аашилдаг байхгүй юу. Тэгэхээр үндсэндээ 1 жилийн төлөвлөгөөг хүртэл баталдгаа больё гэдэг ийм саналыг би хэлээд байгаа юм. Дунд хугацааны төлөвлөгөөгөө гаргаад түүндээ нийцсэн жилийн төсөвлөлтөө хийгээд явбал илүү зохино. Тэгэхгүй бол 1 жилийн төлөвлөгөө гэж 26 оны төлөвлөгөөндөө огт нийцээгүй улсын төсвийг бид баталсан. Хоорондоо ямар ч нийцэлгүй.

Хэмнэлтийн тухай хуулийг бас энд дурдмаар байна. Алаг цоог үйлчилж байгаа. Хэмнэлтийн тухай хуулийг огт мөрдөөгүй, зөрчсөн төсөв баталсан. Тэгээд хуулийг анхан шатдаа аймаг, сум, орон нутагтаа их л хатуу шаардаад байдаг. Гэтэл гишүүд болоод Засгийн газар өөрсдөө энэ Хэмнэлтийн хуулиа огтоос мөрддөггүй. Ийм учраас энэ Хэмнэлтийн тухай хуулиа эргэн харж бүүр болохгүй цуцлаад тэгээд зөв голдиролд нь оруулаач гэдэг ийм асуудлыг хүсмээр байна. Хэлээд байгаа шүү дээ төр өөрөө гаргасан хуулиа мөрддөг байх чухал гэж. Тэгээд өөрсдөө мөрдөхгүй бол бусдаас яаж мөрдөхийг шаардах вэ дээ ийм л байна. Ухамсарт сонголтоор улаан кнопуудаа дарж байгаа шүү.

Н.Учрал: Соёл урлагийн салбарын залуу уран бүтээлчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ уран бүтээлийн өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе.

Ариунзаяа гишүүн санал хэлсэн үү? Ариунзаяа гишүүний санал маш чухал санал хэллээ шүү. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” гээд, би бас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн талаар дурдмаар байна. Төрийн хэмнэлтийн хууль үйлчилж байгаа гэж ойлгож байгаа. Гэхдээ үйлчлээгүй мэт байна. Зарим газруудад бүүр гаарч байна. Тухайлах юм бол ТӨК-уд. Өнөөдөр бид нар ТӨК-удыг төр биш олон нийт хянадаг болсон тогтолцоо дэлхий даяараа шилжчихээд байгаа. Гэтэл бид нар төр хянах гэж хичээсээр л байгаа юм. Одоо энэ үндсэн Засгийн газраас орж ирсэн “Таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” дотор ч гэсэн 7.3.5 дээр төрийн өмч болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж, үр ашигтай ажиллуулна гэдэг л ийм нэр томьёолол байгаад байгаа юм. Бид нар ялангуяа энэ таван жилийн үндсэн чиглэл батлах төлөвлөгөө дотроо экспертүүдийг давсан мэдэмхийрлийг хиймээргүй байгаа юм. Энэ чинь өөрөө холион бантан хутгаад байна л даа. Тойрогтой гэдгийг ойлгож байгаа. Би ч гэсэн тойргоос сонгогдсон гишүүн.

Гэхдээ бид нар таван жилийн хөгжлийн төлөвлөгөөгөө зөв батлаад зөв явж чадвал ядаж нэг юман дээр ч гэсэн үр дүн гаргаж чадвал энэ улс эх орны хөгжилд хэрэгтэй болчхоод байгаа юм. Ард иргэд бүгдээрээ л ярьж байна шүү дээ. Хөгжүүлнэ гэхээс илүүтэй хулгайтайгаа тэмцвэл наад хөгжлийн чинь чиг горим бараг зөв болох гээд байна шүү гэж. Би яагаад ТӨК-удтай холбоотой асуудлуудыг дурдаад байна гэхээр энэ зорилго үзүүлэлтийн тодорхой бус байдал өнөөдөр ТӨК-уд дээр бүүр замаа алдчихсан. Ямар ч ангилал байхгүй. Аль нь ашгийн төлөө юм, аль нь нийгмийн үйлчилгээний үзүүлэлт үзүүлэх компани юм. Тэгээд энэ авлигын шинж чанартай маш олон зүйлүүд ТӨК-уд дээр гаарчихсан. Засгийн газар дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хяналт шалгалтын ажлын хэсэг гараад тодорхой хэмжээний дүгнэлтүүд гарчихсан байх шиг байна. Би бас Бямбацогт сайдаас тэр тодорхой материалуудыг өгөөч гэж хүслээ.

Өнөөдөр ТӨК-уд хөгжинө гэж ярихаас илүүтэй ТӨК-удын хулгайтай тэмцэнэ гээд бараг таван жилийн төлөвлөгөө дотроо оруулчихвал нийцэх гээд байна шүү ний нуугүй хэлэхэд. Өнөөдөр ТӨК гэдэг бол хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашиг, сонирхлоо нийцүүлдэг ийм байгууллага болж хувирсан байна. Сонгуульд

үйлчилдэг, санхүүг нь бүрдүүлдэг байгууллага болж хувирсан байна. Алдагдалтай ажилласан компанийн захирлуудыг шагнаж урамшуулдаг болсон байна. Ийм байж болохгүй.

Тэгэхээр бид нар энэ таван жилийн төлөвлөгөө дээрээ маш зөв, зүйтэй саналыг экспертүүд ялангуяа ажилласан энэ ажлын хэсгийн дүгнэлтээр авч үзээсэй гэж Улсын Их Хурлын гишүүддээ уриалмаар байна. Баярлалаа.

Н.Учрал: Та санал хэлсэн үү?

Таван жилийн үндсэн чиглэл бол сонгуулийн циклийн үед биш 2021 онд Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн дагуу шинээр анх батлагдсан. Ингээд таван жилийн дараа дахиад Их Хурлаар хэлэлцэгдээд ирэх таван жилийн чиглэл батлах гэж байна. Энэ цаг мөчид энэ таван жилийн чиглэлд нийцүүлж улс төрийн намууд 2028 онд сонгуулийн мөрийн хөтөлбөрөө шат шатын сонгуульд дэвшүүлнэ. Тийм ч учраас Улсын Их Хуралд 5 нам, эвслийн төлөөлөл байгаа. 5, нам эвслийн төлөөллүүдийг энэ Их Хурлынхаа танхимд хүрэлцэн ирж таван жилийн үндсэн чиглэлдээ идэвхтэй хэлэлцүүлэгт оролцохыг уриалж байна. Ардчилсан намынхныг бас урьж байна. Таван жилийн үндсэн чиглэл бол бид өнгөрсөн хугацаанд маш их цаг гаргаж. Мэдлэг чадвараа дайчилж ажилласан.

Тэгээд манай Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам энэ таван жилийн үндсэн чиглэлийг шинэ Засгийн газар байгуулагдсан цаг үеэс авхуулаад маш их цаг гаргаж ажилласан маш их хичээсэн. Тэгэхээр би Эдийн засаг, хөгжлийн сайдаар бас ажиллаж байсандаа бахархаж явдаг. Ийм чадварлаг баг, хамт олныг богино хугацаанд удирдсан. Энэ хугацаанд манай энэ төрийн албан хаагч нар, газар, хэлтсийн дарга нар хичээж зүтгэж энэ таван жилийн чиглэлийг хэмжиж болохуйц, хүрч болохуйц байдлаар яг эд бодитой индикаторуудыг тавьж, тоон аргад суурилж боловсруулсан. Үүнийг манай Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ахалж өнөөдөр та бүхэнд танилцуулж байна шүү дээ. Энэ олон хүний хүч хөдөлмөр.

Тийм учраас таван жилийн чиглэл дээр Их Хурлын гишүүдийг цаг, заваа гаргаж, нийгэм олон нийтэд зөв мэдээлэл өгсөн ийм эрүүл хэлэлцүүлгийг өрнүүлэхийг хүсэж байна. Эндээс мэдээлэл авах ёстой иргэд. Асуултууд ч гэсэн иргэд, олон нийтэд зөв мэдээллийг төрүүлэхэд ирэх он жилүүдэд манай улс хэрхэн хөгжих юм бэ гэдэг энэ агуулгын дор бодлогын мэтгэлцээнийг парламент өнөөдөр өрнүүлэх ёстой. Тийм учраас Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Тэр Тамгын Ерөнхий даргыг өнөөдөр томилно уу, 1 дэхэд томилно уу тэр бол 88 дугаар асуудал шүү. Таван жилийн чиглэл хэлэлцэж байна. Сэдэв байвал улс төржих гээд байхаа хэдүүлээ больё. Ярилцаад, зөвшилцөөд, ойлголцоод явж болно. Гол нь одоо энэ олон хүний хүч хөдөлмөр, ШУА, 6 салбар, чуулган, ШУА-ийн Их чуулган бүгд энэ таван жилийн чиглэлийг баталсан. Өөрсдөө оролцсон. Тэгээд эрдэмтэн, судлаачид энэ парламентыг харж байна. Тийм учраас цаг, заваа гаргаж оролцохыг хүсэж байна.

Дорноговь аймгийн Сайншанд Замын-Үүд сумын ИТХ-ын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордны үйл ажиллагаатай танилцаж байна. Дорноговь аймгийнхандаа ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Одоо Байнгын хорооноос. Өнөөдөр сүүлийн өдөр шүү таван жилийн чиглэлийг батлах. Анхны хэлэлцүүлэг, санал хураалтууд явагдана. Дахиад Байнгын хороо хуралдаад эцсийн хэлэлцүүлэг батлагдах ёстой. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулсан. Өнөөдөр чуулган сунгаж хуралдана. 14 цагаас Ерөнхий сайдын мэдээлэл Их Хурлын гишүүний асуулгын цаг шүү дээ шинэ Дэгийн хуулиар. 14 цагаас асуулгын цагтай.

16 цагт таван жилийн үндсэн чиглэлээр санал хураалт эхэлнэ. Сая асуулт асууж, үг хэлсэн. Хуулийн хугацаатай учраас өнөөдөр заавал хэлэлцэж дуусгана. Тэгэхээр сая гишүүд асуулт асууж, тайлбараа авч дууслаа.

Үдээс өмнөх чуулган өндөрлөж байна. 14 цагаас чуулганы нэгдсэн хуралдаантай.

13.08 цаг.

Баасан гараг 28 Арваннэгдүгээр сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 12 минут

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААН

Н.Учрал: Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 28-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэллээ. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын асуулгын цаг эхэлж байна.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайдаас урьдчилан хүргүүлсэн асуултын дагуу асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын асуулгын цаг эхэллээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нарыг тусгайлан бэлтгэсэн индэрт урьж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.6-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан Монгол Улсын Ерөнхий сайдад урьдчилан хүргүүлсэн асуултыг тавина. Бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна. Асуулт асуух зөвшөөрөл өгч, мэтгэлцүүлэх дэгийн хуулийг баримтална. Асуулгын цагийг эхлүүлье.

Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Сайн байцгаана уу эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал асуулгын цагтай болсноос хойш 3 дахь удаагийн мэтгэлцээн эхэлж байна. Энэ удаад гишүүдэд Ерөнхий сайдаас асуух маш их зүйл байгаа. Учир нь намрын чуулган нээлтээ хийснээс хойш эрх баригч Монгол Ардын намынхан нам дотроо зодолдсон болохоос биш улс орны өмнө тулгамдсан асуудалд төдийлөн анхаарал хандуулсангүй. Энэ намар багш нар ажил хаялаа, эмч нар ажил хаялаа, хүүхдүүд цоожтой хаалганы цаана үлдлээ, бензин тасарлаа.

Харин одоо утааны улирал эхэлсэн, томуу өвчин дэгдсэн. Хүүхдүүд эмнэлгийн коридорт хэвтэцгээж байна. Улаанбаатарын утаа байдгаараа л байна. Хятадаас 1 сая тонн нүүрсийг сая орчим төгрөгөөр авч байгаа. Тэглээ гээд утаа буурахгүй л байна. Харин Монгол Ардын намын дарга нар нам доторх өрсөлдөөнд ялахын тулд бүхнээ зориуллаа. Улмаар Засгийн газрын бодлогын үндсэн хэрэгсэл болох улсын нэгдсэн төсвийг хүртэл улс төрийн наймааны хэрэгсэл болгов.

Эцэст нь Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар та Улсын Их Хурлын 71 гишүүний саналаар огцорсон атлаа Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр суудалдаа үлдсэн анхны Ерөнхий сайд гэгдэх өвөрмөц амжилтын эзэн боллоо. Мөн Монгол Ардын намын даргаар сонгогдсон Ням-Осорын Учрал та 5 намын төлөөлөл бүхий Улсын Их Хурлын индэр дээр гараад суучихлаа. Одоо та нөхөд минь сандал суудлаа хуваарилж дууссан бол үндсэн ажилдаа орцгоох уу гэж хичээнгүйлэн хүсье.

Тэгвэл улс оронд минь нөхцөл байдал ямар байна вэ? Улсын Их Хурлын чуулганы танхимд яригдаж буй улсын төсвийн хөрөнгө оруулалт, элдэв мега төслийн өртөг их наядаар хэмжигддэг болсон. Хамгийн багадаа л хэдэн тэрбум төгрөг гэж ярьдаг. Улаанбаатар хотын захирагч 1км авто замыг 70 тэрбум төгрөгөөр барина гэж ярьж байна. Сүүлдээ бүтээн байгуулалт нь битгий хэл эрх баригчдын хулгай их наяд…/минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

Б.Жаргалан: Их наядаар хулгайлаад байна гэж бодохоор эдийн засаг үнэхээр сайн байгаа ч юм шиг. Гэвч бодит байдал ямар байна вэ иргэдийн амьдрал ямар байна вэ? Тэгээд жаахан амьдралтай зүйл ярья гэж бодож байна. Өнөөдөр дэлгүүрт “атар” талх 2600 төгрөгөөр зарагдаж байгаа. Тэгвэл ердөө 4-хөн жилийн өмнө “атар” талхны үнэ 1300 төгрөг байжээ. 4 жилийн дотор талхны үнэ 2 дахин нэмэгдсэн байна. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ ийнхүү нэмэгдэж байгаа. Иргэдийн орлогын өсөлт, үнийн өсөлттэй гүйцэхээ байлаа. Тэгвэл Засгийн газраас богино хугацаанд айл өрхийн өдөр тутмын зардал, амьжиргааны өртөг санхүүгийн дарамтыг бууруулахын тулд ямар бодит арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар тодорхой шийдэлд нэрлэнэ үү гэж Ерөнхий сайд танаас эхний асуултаа асуух байна.

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Жаргалан гишүүний зөв өө. Засгийн газар хүнд нөхцөлд ажилласан. Одоо гадаад зах зээл дээр манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнэ бараг 2 дахин унаж, төсвийн орлого тасарч, дотооддоо улс төрийн тэмцэлтэй, парламент

улс төржилт, шатахуун, нефть, биднээс шалтгаалахгүй олон сорилтуудыг Засгийн газар давж амжилттай ажиллаж байгаа. Ийм учраас Засгийн газар энэ гадаад зах зээлийн хүндрэл төсөвт учирч байгаа хүндрэлийг даван туулахын тулд байгуулагдсан өдрөө ажилдаа шамдан орж ард түмнийхээ нуруун дээр энэ ачаа, дарамтыг үүрүүлэхгүйн тулд төсвийн тодотголыг хийсэн. Энэ бодитой ажил. Монгол Улсын түүхэнд анх удаа улсын төсвийн зардлыг 2.2 их наядаар танаж, үрэлгэн зардлуудыг танаснаараа та бүхний баталсан тэр хэт хөөсрүүлсэн төсвийг чинь зөв голдиролд нь оруулж чадсан.

Ингэснээрээ валютын ханш 4 мянган, долларын ханш 4 мянган төгрөг хүрэх тооцооллыг бид бууруулж, өнөөдөр долларын ханш 50, 60 төгрөгөөр буурчхаад байна. Одоо өнөөдөр 3559 төгрөг байгаа. Тэр үед 3600 гарчихсан байсан. Энэ шууд импортоос хамааралтай манай бүтээгдэхүүний инфляцыг хөөрөгдөөд энэ ард түмний амьдрал кармад шууд хүндээр тусах байсан. Төсвийн алдагдал 2.2 их наядаар энэ хөөргөж байгаа энэ зардал чинь өөрөө инфляцыг 14, 5 хувьд хүргэх байсан. Бид нар ерөөсөө улс төржөөгүй ард иргэдийнхээ энэ амьдралыг хамгаалахын тулд, ард түмнийхээ энэ халааснаас хулгайлаад байдаг тэр инфляцыг, үнийн өсөлтийг хязгаарлахын тулд энэ төрийн данхайсан бүтцийг танаж төсвийн зардлыг нэмсэн. Та бүхний хамтарсан Засгийн газрын данхайсан байсан төсвийг чинь бид танасан. Үүний тулд авлигатай тэмцэх ажлыг зохион байгуулсан. Энэ авлига, хулгайтай тэмцэх ажлын чинь үр дүнд өнөөдөр 300 гаруй хэрэг шүүхэд шийдвэрлээд шилжигдэж байна. Энэ бүхний чинь үр дүнд бас төсвийн үр ашиг, энэ дотоод үр ашгийг сайжруулсан. Манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүн нүүрсний үнэ…/минут дуусав./

Н.Учрал: Ерөнхий сайд минут өгье.

Г.Занданшатар: 2 жилийн өмнө та, 1 жилийн өмнө та бүхэн Засгийн газар байгуулж байхад 250 доллар байсан. Өнөөдөр 70 доллар болж уначхаад байгаа экспортын гол нэрийн бүтээгдэхүүн чинь. Ийм хүнд эдийн засгийн нөхцөл байдлуудыг давахын тулд бид ард иргэдийнхээ нуруун дээрээс ачааллыг авч, энэний үр дүнд 12, энэ сүүлийн 8, 9 дүгээр сард анх удаа төсвийн тэнцэл дараалан 70 сая доллар, 240 сая долларын ашигтай гарч, гадаад валютын ханш тогтворжиж, валютын нөөц бараг 6 тэрбум долларт хүрлээ түүхэндээ анх удаа Монголын. Энэний үр дүнд ханш чинь тогтворжиж буурч байна. Инфляц буурч байна. Энэний үр дүнд тасралтгүй буурч байсан иргэдийн энэ амьдралыг доройтуулж байсан үнийн өсөлт, орлогын дутагдал, хамгийн гол нь иргэдэд орлого хүрэлцэхгүй байсан. Үнийн өсөлт энэ 2-ыг хязгаарлаж бодит төсөлд анх удаа 4 хувьд хүрсэн. Энэ бүхэн бол яг иргэддээ чиглэсэн энэ бодлогуудын үр дүн. Энэ авлига хулгайтай тэмцэж байгаагийн энэ хамтарсан Засгийн газрын үед данхайсан, тэлчихсэн төсвийг…/минут дуусав./

Н.Учрал: Уучлаарай мэндчилгээ дэвшүүлчихье. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболдын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ЕБС-ийн $11^{б}$ ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Манай Далайн Батбаяр гишүүн хамт урьсан байна. Манай Сүхбаатарын Эрдэнэболд гишүүнийхээ халуун дотно мэндчилгээг өргөн дэвшүүлье. Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсье. Тэр урт шар дээлтэй сууж байгаа Эрдэнэболд

гишүүн шүү. Манай Эрдэнэболд гишүүн, Далайн Батбаяр гишүүн нар сайн ажиллаж байгааг ээж, аавдаа уламжлаарай.

Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Ерөнхий сайд гадаад шокийн талаар ярьж байна. Гадаад шоктой бол дэлхийн бүх улс орнууд адилхан нүүр тулж байгаа. Тэр утгаараа Ерөнхий сайд Засгийн газрын үйл ажиллагаа, энэ гадаад шокуудыг хэрхэн яаж амжилттайгаар даван туулах вэ, яаж зөв бодлого баримтлах вэ гэсэн тийм үндсэн даалгавартай байдаг.

Хоёрдугаарт нь та танай Засгийн газар гэж маш ихээр ярилаа. Танд сануулахад 2016 оноос хойш 10 дахь жилдээ Монгол Ардын нам үнэмлэхүй олонхоор энэ парламентад засаг бариад 10 дахь жилдээ очиж байна. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд ажилласан хамтарсан Засгийн газар Монгол Ардын намын Засгийн газар байсан. Тэрхүү хамтарсан Засгийн газарт Ардчилсан намын 8 сайд урилгаар оролцож тодорхой ажлуудын бас ард гарахыг зорьсон. Дор бүрнээ тодорхой бас амжилт ололтуудыг хийсэн байгаа гэж бодож байна.

Гэхдээ улс төрийн бодлогын манлайлал, санаачилга зөвхөн Монгол Ардын нам дээр сүүлийн 10 жилд явж байгаа шүү. Тэгээд тэрийг бас танд сануулахыг хүсэж байна. Тэгээд бид өнөөдөр амьжиргааны өртгийн талаар ярихыг зорьсон. Амьжиргааны өртөгт хамгийн гол нөлөөлж байгаа зүйлүүд сая би “атар” талхны үнийг ярилаа. Та Засгийн газрын тэргүүний хувьд импортлогч улс биш үйлдвэрлэгч улс орон болно. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ гэж маш ихээр ярьдаг. Тэгээд хөдөө аж ахуйн салбарын бас үйлдвэрлэлийг дэмжиж байгаа гэж танай Засгийн газар ярьдаг. Энэ салбарыг толгойлж байсан хүн маань Эдийн засгийн хөгжлийн сайдаар бас ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд хөдөө аж ахуйн салбарт Атрын аян, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Цагаан алт гээд маш олон ийм хөтөлбөрүүд хэрэгжсэн. Тэглээ гээд иргэдэд бодитой бас мэдэгдсэн зүйл хараахан алга байна. Энэ зүйл дээр бас 1 зүйлийг хэлэхэд энэ олон татаастай зээлүүд төсөв дээр явж байгаа. Татаастай зээлийн хэмжээ 2.3 их наяд төгрөг болсон байна. Энэ банк санхүүгийн салбарт бас давхар зах зээлийг үүсгээд байгаа ийм сөрөг нөлөөлөл бий болгож байна.

Б.Жаргалан: 1 минут нэмж өгье.

Б.Жаргалан: Жинхэнэ ЖДҮ-чин гэж бидний хэлдэг бор зүрхээрээ элдэв янзын улс төрийн хамааралгүй, бор зүрхээрээ ажиллаж байгаа жинхэнэ ЖДҮ-чид маань 3, 30 хувийн зээл арайхийж авч байхад тодорхой улс төрийн хамааралтай, дээрээс нь мэдээлэлд ойрхон, сонгуулийн санал өгч болзошгүй тийм хүмүүс 3 хувийн зээл аваад ингээд ажиллаж байна. Энэ бол банк, санхүүгийн салбарт ийм давхар зах зээл үүсгэж, ийм зах зээлийн хуваарилалт, нөөцийн хуваарилалтыг маш буруу тийшээ авч явж байна. Тэгэхээр та бас банкны салбарт ажиллаж байсан хүн. Энэ санхүүгийн салбар дээр байгаа зах зээлийн бус энэ өрсөлдөөнт бус орчинтой ер нь цаашид яаж тэмцье гэсэн бодолтой байна вэ? Бодитоор яаж үндэсний үйлдвэрлэлээ дэмжих вэ?

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Ер нь аливаа үйлдвэрлэлийг бүтээн байгуулалтыг нураахад 1-хэн жил, бүтээн байгуулахад тэрийг сэргээн босгоход бас их олон жил шаардагддаг юм байна. Ерөөсөө манай өмч хувьчлалын алдаатай бодлого, тэгээд залгуулаад Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ дотоодын зах зээлээ хамгаалаагүй гэдгээс шалтгаалаад манай дотоодын үйлдвэрлэл үндсэндээ дампуурч, 4382 аж ахуйн үйлдвэрийн газрууд үндсэндээ хувьчлал нэрийн доор алга болоод, тоног төхөөрөмж нь урагшаа, хойшоо ачигдаад ингээд үндсэндээ бид үйлдвэрлэгч улс биш болсон.

Таны нэр дурдаад байгаа Хүнсний хувьсгал, Цагаан алт зэрэг хөтөлбөрүүдийн үр дүнд өнөөдөр манай ноолуурын салбар гэхэд 247 сая долларын самнасан ноолуур нэмж, тэр хэмжээгээр эмэгтэй ажлын байр нэмэгдэж байгаа. 1 шат ахиж байгаа. Ахиад 1 шат бид утас үйлдвэрлэдэг тэгээд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох юм бол бид ухдаг шар алтнаас ургадаг цагаан алт, ноос, ноолууpаа дэлхийн валют болгож гаргах бололцоотой. Үүний тулд шинэ зах зээлийг нээж Евро Азийн эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээрт нэгдэхэд бид энэ 1 тэрбум доллар хүртэл зөвхөн ноолуур ургаад жил болгон төлжиж байдаг энэ баялгаа эргэлтэд оруулах бололцоотой. Одоо ноолуурын салбар сэргэж байна. Манай самнах хүчин чадал 100 хувьд хүрчихлээ дотоодын. Энэ 247 сая доллар гэдэг илүү үр дүн, өндөр өртөгтэй, 30-40 хувийн нэмүү өртөг шингэсэн ийм үйлдвэрлэл бий болж байгаа юм.

Хүнсний хувьсгал ч гэсэн тэр. Нийтдээ 56 шинэ үйлдвэр байгуулагдсан, байгуулагдсан байна. Одоо бид энэ үйлдвэрийн тоог 100 хувьд хүргэж, эхний ээлжид дотоодынхоо хүнсний хэрэгцээг өөрсдөө хангадаг болчихвол иргэдийн амьжиргаанд тустай. Амьжиргааны өртгийн, хэрэглээний сагсны багцад байдаг гол бүтээгдэхүүн бол хүнсний бүтээгдэхүүнүүд байдаг. Ийм учраас бид тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг жишээлбэл өндөг гэдэг юм уу, тахиа гэдэг юм уу энэ бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл нэмэгдээд 100 хувь импортын хамааралтай байсан бол эдийн засгаа дэмжих энэ бодлого бодитой хэрэгжиж байна.

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Бид бараг 30 гаран жилийн туршид ийм тусгайлсан төрөөс дэмжиж байгаа гэсэн нэрийдлээр тодорхой салбарыг онилоод тэгэнгүүтээ ЖДҮ сан ч гэдэг юм уу, саяын нэрлэдэг хөтөлбөрүүд ч гэдэг юм уу ийм тусдаа зах зээл бий болгоод тэр нь ингээд улс төрд ойрхон хүмүүст илүү давуу тал болж очсон байдлаар энэ үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж ирлээ. Ноос, ноолуурын салбарыг 30 жил дэмжсэн байдаг. Би танд бодлогын арай өөр шийдэл хэлээд байгаа юм. Тэр нь юу вэ гэхлээр ийм давхар зах зээл үүсгэж зарим аж ахуйн нэгжүүдэд илүү маш хямд зээлийг олгоод зарим аж ахуйн нэгжүүдэд маш өндөр зээлтэй ийм нөхцөлийг бүрмөсөн болиод ерөнхийдөө ийм нийтээр нь энэ санхүүгийн салбарынхаа хүүг буулгах ийм нөхцөлийг бүрдүүлэх нь зөв өө гэж хэлээд ийм тодорхой бодлогын шийдэл санал болгоод байгаа арга хэлбэр. Тэгэхээр энэ дээр та бас Засгийн газрын тэргүүний хувьд бас бодолцож үзмээр байна.

Энэ үнийн өсөлтөд нөлөөлж буй бас нэгэн хүчин зүйл бол суурь дэд бүтцийн үнэ өртөг юм. Тэгээд өнгөрсөн жил цахилгааны үнийг нэмэгдүүлэх шийдвэр гарсан нь инфляцад маш их нөлөө үзүүлж байгаа. Өнөөдөр инфляц 9.2 хувьтай байгаагийн 2 орчим хувь нь цахилгааны үнэ бүрдүүлж байна.

Тэгээд би танд хүний сэтгэгдлийг уншиж өгье. Энэ тог цахилгааны үнэ гэж улаан мөлжлөг боллоо. Стандартын тог цахилгаанаар хангаж чадахгүй байна. Ямар ч бэлтгэлгүй дун өвлийн хүйтнээр ухаалаг тоолуурт шилжүүллээ. 19 цагаас 23 цаг хүртэл цахилгаан халаалтаа салгаж байж хоол ундаа хийж байна гэж байна. Өрхийн орлого, зарлагын судалгааг харвал Монголын дундаж айл өрхийн цахилгааны зардал өмнөх оны мөн үеийнхээс 30 хувиар өссөн байна. Бид цагийн сайханд эрчим хүч экспортлогч улс болно гэж ярьж байсан шүү дээ. Тэгэхээр зөвхөн нүүрс гэлтгүй сэргээгдэх эрчим хүчний маш их арвин баялаг нөөцтэй манай улс ингэж тог цахилгаанаа хязгаарлах ийм түвшинд оччихоод байгаа нь үнэхээр эмгэнэлтэй санагдаж байна. Тэгэхээр эрчим хүчний эх үүсвэрээ эрс нэмэгдүүлж, импортын хамаарлаас гарах цаг болсон гэж харж байгаа.

Н.Учрал: Ерөнхий сайд. Нэмэлт 1 минут Батбаярын Жаргалан гишүүнд өгье.

Б.Жаргалан: Энэ дээр бас танд би тодорхой санал хэлэхийг хүсэж байна. Та бодлогын шийдэл ярья гэсэн энэ мэтгэлцээнээр. Цахилгаан станц барих тусгай зөвшөөрлийг бүрэн халж, ийм хувийн хэвшилд хүссэн станц барих тийм боломж, бололцоог нээх нь чухал гэж үзэж байна. Эрчим хүчний тухай хууль орж ирнэ гээд орж ирэхгүй байгаад байгаа. Энэ дээр танай Засгийн газар яг ямар бодит бодлого барьж байна вэ гэдгийг Ерөнхий сайдынх нь амнаас сонсмоор байна. Ингэж чадах юм бол бид Улаанбаатарын гэр хорооллыг цахилгаан халаагуурт шилжүүлэх замаар богино хугацаанд бас утаанаасаа бүрэн салах бүүр боломжтой гэж харж байна.

Тэгэхээр эрчим хүчнийхээ салбарын либералчлал гэж яриад байгаа зүйлийг энэ тусгай зөвшөөрлийг халахаас эхэлье. Улмаар цаашлаад цахилгааны үнийг биржээр тогтоодог эх үүсвэрүүд нь хоорондоо бирж дээр өрсөлддөг ийм тогтолцоо бүрдүүлэх боломж байна уу? Цаашлаад бид нар эрчим хүч экспортлогч улс болохыг та зорьж байна уу?

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Далайн Батбаярын урилгаар Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын ЗДТГ-ын албан хаагчид Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний ажилд өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Далайн Батбаяр гишүүнийхээ халуун дотно мэндийг дэвшүүлье. Сайн ажиллаж байгаа шүү манай Батбаяр гишүүн. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн бас хамт та бүхнийг урьсан шүү.

Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь Жаргалан гишүүнтэй санал нэг байна. Парламентын мэтгэлцээн шийдэл ярьдаг тэрийг нотолж няцаагчдын мэтгэлцээн Засгийн газар шийдлээ оруулж ирээд тэгээд тэрийгээ мэтгэлцдэг байх ийм зарчим руу яваандаа парламентын мэтгэлцээн чиглэх учиртай. Тийм ч дэг агуулгатай байсан.

1 дүгээрт, эрчим хүчний либералчлалыг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай. Тэгэхдээ энэ шат шатанд байгаа үр ашиггүй байдал, авлигал, хээл хахуулийг залруулахгүйгээр дээрээсээ эхэлж шууд нийлүүлэлтийн циклээсээ

либералчлал эхлэх нь бас оновчтой биш байгаа юм. Яагаад гэхээр яг уурхай шатад түүхий эд уурхай хямд нүүрс үйлдвэрлэхэд уурхай дээр байгаа тэр үр ашиггүй байдлыг халах ёстой. Тэгээд үйлдвэрлэлийн шатад, цахилгаан шатад өнөөдөр гэхэд тодорхой авлигал, хээл хахууль худалдан авалтын ажиллагааны проблемоос шалтгаалаад IV дүгээр цахилгаан станцын захирлыг халж байна. Тэнчээ бас асуудлууд. Энэ хий зардлууд нь үр ашиггүй зардлыг нэмэгдүүлээд байхаар эцсийн дүндээ цахилгааны үнэ өртөг иргэдийн нуруун дээр ирдэг учраас тусгай зөвшөөрлийг либералчиллаа гээд суурь үнэ өндөр байх юм бол энэ үр дүнтэй хэрэгжихгүй бас.

Дээр нь эрч сүлжээ нийлүүлэх эрчим хүчний гэрээ заавал байгуулагдах ёстой хэдэн центээр нийлүүлэх юм. Одоо өндөр болчхоод байгаа юм. Зах зээлийн хүүгийн зарчмын хувьд Улсын Их Хурлаас хууль батлагдаад ер нь улс төрийн өндөр албан тушаалтнууд, түүнтэй хамаарал бүхий этгээдүүд ийм хөнгөлөлттэй зээл авч болохгүй гээд хууль баталчихсан. Тийм учраас тэн дээр бүүр тодорхой санкцтай, агуулгатай хууль батлагдчихсан байдаг.

Ер нь нийт манай энэ хүүгийн зардал маань та сайн мэдэж байгаа. Макро эдийн засгийн тэнцвэр маань алдагдчихсан учраас, төлбөрийн баланс маань алдагдалтай учраас үйлдвэрлэгч улс биш болчихсон учраас импортын дандаа инфляц өртөөлөгдөөд. Ингээд импорт нь үнийн өсөлтийг, үнийн өсөлт нь зээлийн хүүг өндөр байлгаад, инфляц өндөр болохоор зээлийн хүүгийн чинь хэсэг нь инфляц байгаа шүү дээ. Инфляцын ханшаасаа өндөр болгож бодлогын хүүг гэж гарч ирээд байгаа юм. Энийгээ давсан өндөр хүүтэй болохоор…/минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт 1 минут.

Г.Занданшатар: Тэгэхээр ийм өндөр хүүтэй үндэсний үйлдвэрлэл сэргэх бололцоогүй. Үндэсний үйлдвэрлэл сэргэж дотоодын зах зээлээ хангахгүй болохоор импортод гарч байгаа валют хэвээрээ. Ийм чөтгөрийн тойрогт орчхоод байгааг таслан зогсоохын тулд арай стандартын бус чиглэлтэй энэ олон улсад нэн ялангуяа Азийн зах зээл, Азийн орнуудын төрийн зохицуулалт түлхүү ашиглагддаг хөнгөлөлттэй зээлийн механизмаар энэ нураагаад унагаачихсан үйлдвэрлэлийн салбараа эхний ээлжид хүнс, хөнгөн үйлдвэрийн салбараа дээш нь татах бодлого явуулж байгаа юм.

Хуучин бол манай экспортын 80 хувь нь хүнс, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн байсан юм байна лээ 91 онд. Одоо бол уул уурхайн бүтээгдэхүүнээс 90 хувийн хамааралтай. 2, 3-хан бүтээгдэхүүнээс энэ хоёрынх нь үнэ дэлхийн зах зээл дээр хэлбэлзэхээр дагаад бүх төсөв, инфляц, иргэдийн амьжиргаа бүгд доройтдог. Ийм чөтгөрийн тойрогт орчхоод байгааг л эрс шинэчилж засах ёстой учраас бид ирэх таван жилийн үндсэн чиглэлдээ энэ иргэдийн амьжиргааг татах, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт хийх цогц төлөвлөгөөг эрс шинэчлэл хийж оруулъя гэж байгаа юм. Ингэж байж бид энийг…/минут дуусав./

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Тэгэхээр таны ярианаас ойлгохдоо хөнгөлөлттэй зээлийн тогтолцоо ингээд явсаар байх юм байна. Та тэгээд эрчим хүчний салбарыг хөгжүүлэхдээ нийлүүлэлтээс эхлэхгүй эрэлтээс нь эхэлнэ гэж үзлээ дээ. Тэгээд яг

энэ дээр макро эдийн засгийн бодлогын хувьд Ардчилсан нам бол ямагт юунд ямар бодлого барихыг зорьж байсан бэ гэхлээр төсөв мөнгөний бодлогын хүрээнд ерөнхийдөө нийлүүлэлт талдаа илүү түлхүү дэмжих бодлогыг ямагт барьж ирсэн. Та бүхэн маань эрэлтийг дэмжих буюу эдийн засагт мөнгө нийлүүлэх, элдэв янзын халамж, тэр хөнгөлөлттэй зээл маягаар эдийн засаг руу мөнгө шахах тэр бодлогыг дэмжсэний үр гайгаар гэдэг юм уу, үр нөлөөгөөр өнөөдрийн нөхцөл байдалд хүрчхээд байна гэж харж байгаа. Тэгэхээр энэ дээрээ бас эргэж харна уу гэж хүсэх байна.

Тэгээд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн нь яаж ч нэмэгдсэн гэсэн Монголчууд бид яаж ийж байгаад хоол хүнсээ болгочихдог. Гэтэл бас урт хугацааны хөрөнгө оруулалтууд байна. Ялангуяа залуу гэр бүлүүдийн хувьд энэ орон сууц худалдаж авах хамгийн том хөрөнгө оруулалт байдаг. Гэтэл орон сууцын үнэ 3 жилийн өмнө 1м^2 шинэ орон сууцын үнэ 3 сая төгрөг байсан бол өнөөдөр 5 сая төгрөг болоод өсчихсөн байж байна. Ердийн нэг залуу гэр бүл 60м^2 орон сууц худалдаж авахад 300 сая төгрөг шаардагджээ. Гэтэл 6 хувийн ипотекийн зээлийн дээд хэмжээ 150 сая төгрөг хэвээр байгаа 30 хувийн урьдчилгаа төлөөд 6 хувийн зээлд хамрагдлаа гэхэд 1 сарын эргэн төлөлтийн хэмжээ 2.7 сая. 1 өрхийн дундаж орлого 3 сая төгрөг хүргэхгүй үгүйтэй байгаа шүү дээ. Тэгэхээр би та тоо ярьдаг хүн учраас тоо хэлээд байна л даа. Тэгэхээр дундаж залуу гэр бүл бол ерөөсөө орон сууц худалдаж авах тийм нөхцөл бололцоогүй болчихлоо. Тийм ч учраас залуучууд маань гадагшаа гарахыг илүүд үзэж байна. Тэгж байж ядаж орон байрныхаа асуудлыг шийдье гэсэн ийм бодлого. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Ардчилсан намын Засгийн газар ипотекийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлсэн, барилгын материалын үйлдвэрлэлийг бас нэмэгдүүлсэн ийм зүйлүүдийг хийсэн. Одоо таны Засгийн газрын хувьд ямар бодлого барих вэ?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Жаргалан гишүүнтэй яг агуулга нь адилхан боловч таны яриа яг 2 зөрчилтэй болчхоод байгаа юм. Би нийлүүлэлтээ дэмжье гээд байгаа байхгүй юу. Эрчим хүчний ч тэр. Одоо сэргээгдэх эрчим хүч гэхэд батарейтайгаа 10 цент хүрчхээд байна л даа. Зүгээр дангаараа 5, 6 цент. 3, 4 цент рүү хямдруулах ногоон эрчим хүчний ийм шинэ технологи нэвтрүүлэхээр энэ тодорхой төслүүд ирэх таван жилийн үндсэн чиглэлд тусгачихсан байгаа. Яг тэрэнтэй адилхан жишээлбэл барилгын салбарт би нийлүүлэлтийг дэмжих бодлогыг түрүүлж бодож байна. Ингэж байж барилгын үнийг бууруулахгүй бол ипотекийн зээл чинь эрэлтийг нь дэмжээд байгаа байхгүй юу. Та бүхний хэрэгжүүлж эхэлсэн ипотекийн зээл манайх өөртөө барилгын материал үйлдвэрлэдэггүй байхад улс ипотекийг эрэлтийг дэмжчихээр импортоо дэмжээд барилгын материал, ган, төмөр, цемент бүгд импортоор аваад ингээд валютын ханшийг чинь өсгөөд валютын ханш чинь эргээд инфляцыг өсгөөд иргэдийн амьжиргаанд хүндрэл учруулаад байгаа юм.

Ийм учраас эрэлт, нийлүүлэлт 2-ыг дэмжихгүй бол дан эрэлтийг дэмжээд байхаар орон сууцын үнэ тасралтгүй өсөөд таны хэлснээр 3 сая байсан бол ингээд даблдаад өсчихсөн 6 сая. Зөвхөн өнгөрсөн 2 жил гэхэд 24 хувиар өсчихлөө. Тийм учраас бид орон сууцжуулалтын банк байгуулж эрэлт, нийлүүлэлт хоёуланг нь дэмждэг “Affordable housing” буюу орлогод нийцсэн орон сууц барьдаг хот, хөдөөд.

Улаанбаатар хотод гэхэд 83 мянган өрх айл 3-5 сая төгрөгийн орлоготой. Тэрэнд нийцсэн, тэр орлогод нь нийцсэн орон сууцыг барьж байгуулдаг л хэрэгтэй тэгвэл. Зөвхөн эрэлт дэмжээд байхаар худалдан авах чадвартай энэ Туулын голоос урагшаа Хан-Уул дүүрэг чинь тэр чигээрээ хороолол болоод өндөр өртөгтэй орон сууц үнийг чинь өсгөөд байдаг. Яг бага орлоготой иргэдэд нийцсэн, орлогод нь нийцсэн орон сууцын бүтээмж байхгүй. Ийм учраас эрчим хүч ч тэр, орон сууц ч гэсэн тэр нийлүүлэлт талынхаа бодлогыг дэмжиж байж, нийлүүлэлт дотроо орцуудынхаа бодлогыг дэмжиж байж өөрөөр хэлбэл цементийн үйлдвэр, арматурын үйлдвэр, гангийн үйлдвэрээ дэмжиж байж хямд өртөгтэй орон сууц баригдах тэр хэмжээгээрээ иргэдээ орон сууцжуулах, Улаанбаатар утаагүй болох зөвхөн халаагууураар биш орон сууцад орж байж XXI дүгээр зуунд хүн шиг амьдрах…/минут дуусав./

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Ардчилсан нам засаг барьж байх үед шинэчлэлийн Засгийн газрын үед энэ барилгын материал үйлдвэрлэлийн чиглэл дээр маш олон ахиц дэвшилт гарсныг та хүлээн зөвшөөрч байгаа юм байна. Ардчилсан намын хувьд эдийн засаг дахь төрийн оролцоо нэмэгдэж буй явдалд ямагт шүүмжлэлтэй хандаж ирсэн. Аливаа эдийн засгийн харилцаа зах зээлийн зарчмаараа хөгжиж, эрүүл өрсөлдөөн явагдах учиртай. Тиймээс шинээр төрийн өмчит аж ахуйн нэгж байгуулахгүй байх, одоо байгаа төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээ аль болох хувьчлах бодлого баримтлахыг танай Засгийн газраас ч гэсэн бас шаардсаар ирсэн байгаа.

Гэтэл та орон сууцжуулалтын банк байгуулна гэж яриад байгаа юм. Монгол Улсын банк, санхүүгийн салбарт одоогоор 10 гаруй банк үйл ажиллагаа явуулж байна. Тэр дунд Төрийн банк гэж бас ашигт ажиллагааны хувьд бас учир дутагдалтай ямагт хоцордог төрийн өмчийн банк байгаа. Энэ банкийг ч гэсэндээ бас хувьчлах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байдаг.

Мөн түүнээс гадна ипотекийн санхүүжилтийн тогтолцоог олон улсын жишгийн дагуу ийм тогтолцооных нь арга хэлбэрээр хөгжүүлж ирсэн 10 гаруй жилийн туршлага байгаа. Тэгэхээр энэ орон сууцжуулалтын банк гэдэг зүйл чинь энэ тогтолцоог эвдээд тэгээд сүүлийн жилүүдэд хувийн арилжааны банкнууд ипотекийн зээлийг өөрсдийнхөө эх үүсвэрийг олон улсын зах зээлээс бас энэ ногоон эх үүсвэрийн зээлүүдийг татаж, татах замаар ипотекийн зээлийг өөрийн санхүүжилтээр олгодог болчхоод байгаа шүү дээ.

Тэгэхээр тэр бүх зүйлээ бас эвдэх ийм санаачилга орж ирж байна гэж харж байгаа. Тэгэхээр бид цаашид хоёрдогч зах зээлээ улам хөгжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт татах замаар энэ барилгын салбарыг, энэ ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна гэж харж байгаа. Тэгэхээр цаашдаа энэ Орон сууцжуулалтын банк гэдэг дээр маш эсрэг байр суурьтай байгаа гэдгээ бас хэлье. Тэгээд энэ тогтолцоогоо яаж илүү эвтэйхэн одоо байгаа зүйлээ илүү төгөлдөржүүлэх замаар авч явах вэ гэдэг дээр анхаарал хандуулаач гэж бас хүсэх байна.

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Ер нь өмч хувьчлал гэдгийг оновчгүй буруу зохион байгуулснаас шалтгаалаад нийгэмд хувьчлалын талаар их сүргүй ойлголттой болчихсон юм билээ. Тийм учраас Төрийн банкийг хувьчилна, хэн хуваж авах гэж байна гэдэг л ийм л ойлголттой хэлэлцүүлгүүд сая явж үзэхэд энэ зуны хугацаанд тийм ойлголттой байна. Тэгтэл энэ бол бид тийм учраас IPO гаргах буюу 22 компанийг судлаад 9 компанийн төрийн өмчийн компанийг Төрийн банкийг оролцуулаад олон нийтийн болох ийм чиглэл барьж байна. Илүү олон нийтийн хяналтад олон нийтийн public компани болох чиглэлийг барьж байна.

Тэгтэл тэр шаардлагыг хангахын тулд 3 жил ашигтай ажилласан байх ёстой. Олон улсын аудит хийгдсэн байх ёстой. Ийм тодорхой шалгууруудыг хангасан байж байж энэ төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулна. Харамсалтай нь ярьснаасаа эсрэг юм хийдэг их юм байна. Жишээлбэл, тухайн үед хэт их төрийн оролцоог дэмжсэн ийм 12-16 онд тэгээд Төрийн банкийг тэгвэл хувьчлахгүй яасан юм? Үр ашгийг нь сайжруулахгүй яасан юм? Энэ ер нь Эрдэнэ Монгол маань Тавантолгой байна. Энэ бүх бололцоо нь байсаар байсан. Харин энэ хэрэгжээгүй.

Одоо харин бид энийг илүү public компани болгож үр ашгийг нь дээшлүүлэх чиглэл, хандлага барьж байна. Орон сууцжуулалтын банк бол дэлхий нийтийн хандлага. Манайх шиг эсгий гэртэй хот дэлхийд байхгүй. Эсгий гэртээ хот биш Солонгосын, Германы энэ орон сууцжуулалтын банк, орон сууцжуулалтын хөтөлбөр, санхүүжилтийн хэлбэрүүд энэ нийлүүлэлтээ дэмжээд эрэлтийг бас дэмжсэн ийм хос дэмжүүлэлтийн бодлогоор иргэдээ орон сууцтай болгодог, хямд өртөгтэй орлогод нийцсэн орон сууцаар хангадаг бодлогыг, Америкт хүртэл дэлхийн бүх улсад Freddie Mac, Fannie Mae-ээс авхуулаад Сингапурт хүртэл бүх улсад ийм орон сууцжуулалтын механизмууд орон сууцжуулалтын санхүүжилтийн тусдаа механизм үйлчилж байгаа юм. Яагаад гэвэл энэ хүний суурь, үндсэн хэрэгцээ байхгүй юу. Хүний эрхийн орох…/минут дуусав./

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Яг сая таны дурдсан Америкийн Fannie Mae and Freddie Mac-ийн жишээгээр Монголын Ипотекийн Корпорац гэж байгуулаад тэгээд хоёрдогч зах зээлийг бас хөгжүүлэлтүүд эхлээд явж байсан. Тэгээд хамгийн гол нь бид нар танайх ингэсэн манайх тэгсэн гэж бас яримааргүй байна. Урагшаа гарч ярья гэсэн тийм бодол байгаа. Барилгын салбар дээр танд бас санаа хэлэхэд өнгөрсөн хугацаанд, өнгөрсөн 10 жилийн хугацаанд болохлоор ямар хандлага давамгайлж байна вэ гэхлээр улсын төсвөөс бас янз бүрийн гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр ийм барилга барьж байгаа явдал маш ихээр ихсэж байгаа. Ялангуяа бүр орон сууцын барилгууд.

Гэтэл манай дотоодын барилгын компаниуд бүрэн чадавхтай болсон шүү дээ барилга барих. Тэгэхээр энэ төсвийн хөрөнгө оруулалтаар юм уу эсвэл төр дээр байгаа зээлийн эх үүсвэрээр энэ барилга барих явдлыг бас зогсоох нь зөв гэсэн ийм байр суурьтай байгаа.

Дараачийн асуудалдаа оръё. Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн, цахилгааны үнэ өссөн талаар ярьж байгаа. Бас хамгийн эмзэг хэрэглээний үнэ өдөр ирэх тусам өсөж байгаа. Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ гэсэн

ангиллын зардлын үнэ өнгөрсөн 1 жилийн хугацаанд 18 хувиар өсжээ. 1 өрх дунджаар 1 сар 113 мянган төгрөгийн эм авдаг гэжээ. Утааны улирал эхэлсэн. Энэ зардал улам бүүр нэмэгдэж байгаа.

Нөгөө талаас энэ тогтмол эм авах хэрэгцээ шаардлагатай хүмүүс бол хамгийн эмзэг бөгөөд хамгийн орлого багатай хүмүүс байдаг. Тухайлбал, манай ахмадууд байна. Тэтгэврийн хөгшчүүд үнийн өсөлтөд хамгийн ихээр нэрвэгдэж байна. 689 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа хөгшид эм тангаа авна, хоол хүнсээ авна, орон сууцын төлбөрөө төлнө, цахилгаан, дулаанаа төлнө ер нь яаж амьдрах вэ? Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч бас энэ ангилалд багтаж байна. Тэгэхээр Засгийн газраас ахмадуудын нийгмийн асуудалд хэрхэн яаж анхаарч байгаа, цаашид тэтгэврийн реформ хийх бодол байна уу?

Н.Учрал: НЕБ-ын 48 дугаар сургуулийн 9[а] ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе.

Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Тэтгэврийн реформ хийх шаардлагатай. Ерөөсөө манай энэ реформуудын үндсэн шаардлага бол энэ авлига, хулгайтай л нөхцөлдөж байгаа юм. Яагаад тэтгэврийн реформ хийх шаардлагатай вэ гэхээр энэ Тэтгэврийн сан алдагдалтай болчихсон 2030 он гэхэд Тэтгэврийн нийгмийн даатгалын сангийн алдагдал бараг Оюу толгойн хэмжээнд хүрэх тооцоотой. Яагаад энэ тэтгэврийн зөрүү энэ бүх юм чинь инфляцынхаа дагуу төлж байгаа тэтгэвэр өсөөд байхад Нийгмийн даатгалын сан үржиж, хөгжиж байх ёстой сан хөгжөөгүй. Нийгмийн даатгалын санд үе үед нь хулгай нүүрлүүлчихсэн. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хямд хүүтэй байршуулдаг. Үржүүлж байх ёстой газар үрэн таран хийгдчихсэн хаячихсан учраас Нийгмийн даатгалын сан маань өрөө даахаа больчихсон. Ахмадуудын нас уртсаад байдаг, Монгол хүний насжилт уртсаад байдаг сайн үзүүлэлт байдаг. Тэрийг дагаад тэтгэврээ инфляцын хэмжээтэй уялдуулж нэмэгдүүлээд байдаг зардал тал нь өсөөд байдаг. Энэ талд нь дагаж өсөж байх ёстой Нийгмийн даатгалын сан хулгайд идэгдчихсэн үе үед. Энэнээс болоод Тэтгэврийн санд зайлшгүй реформ хийх болчхоод байгаа юм.

Одоо энэ дутсан санг яаж нөхөх вэ гэдэг хамгийн том асуудал. Ерөөсөө энэ банкин дээр ч байгаа, үе үед байгаа энэ системүүд дандаа энэ газар болгонд хулгайд нэрвэгдсэнээс болж л энэ сангууд маань, Нийгмийн даатгалын сан маань энэ бүгд маань алдагдлын уурхай болчхоод байна. Энийг эхэлж хаахын тулд заавал энэ шатыг дээрээс нь шүүрдэж энэ сахилга хариуцлага, авлигагүй дэг журамтай энэ системийг бий болгож байж, бүх энэ савны цоорхой ёроолуудыг хааж бөглөж байж энэ системүүд бүгд ажиллаж эхэлнэ. Энэ тэгэхээр 1 дүгээр зорилт энэ авлигал, хээл хахуулгүй байх системээ төгс төгөлдөржүүлэх л асуудал байгаа юм. Ингэж байж бид нарт энэ Эдийн засгийн эрх чөлөөний хууль, чөлөөт эдийн засгаа дэмжих хуулиудаа өргөн барьж бид бас ойрын хугацаанд багц хуулиудыг өргөн барихаар төлөвлөж байна. Энэ бол Эдийн засгийн эрх чөлөөний хуультай хамт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, татварын багц хууль, татварын реформ, нийгмийн даатгалын реформын…/минут дуусав./

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Ахмадуудын тэтгэвэр нэмэгдэхгүй байгаад байгаа шалтгаан нь болохлоор эрх баригчдын авлигал, хээл хахууль, хулгай гэж хэлэх шиг боллоо. Тэгээд авлигал, хээл хахууль, хулгайтайгаа хэдүүлээ тэмцмээр байна аа. Тэгээд энэ бол зөвхөн хоосон та хэдийн ийм Пи Ар үг баймааргүй байна. Тодорхой бодит үр дүн баймаар байна. Тэгэхийн тулд ингээд бодитой үр дүнгээ та нар маань бас богино хугацаанд харуулаач гэж хүсэх байна.

Хоёрдугаарт бас яг энэ бодлогын шийдлүүдээ цогц байдлаар Засгийн газраас яаралтай өргөн баримаар байна. Бас хангалттай хугацаа өнгөрч байна. Ер нь аливаа Засгийн газрын тэр бодлогын манлайлал, бодлогын шийдлүүд оруулж ирэх цаг хугацаа чинь эхний 100 хоногтой бас хийгддэг шүү дээ. Тэгэхээр би танд бас 100 хоног болох үед чинь бас тэрийг ярьж байсан. Тэгэхээр Нийгмийн даатгалын сангийн нийгмийн даатгалын тогтолцооны реформ, энэ татварын реформ үгүйлэгдэж байна. Татварын ийм багц хуулийн шинэчлэлийг Засгийн газар өргөн барих бүрэн эрхтэй. Энийг бид 24 оны 7 сарын 2-ноос хойш шаардаж байгаа. Харамсалтай нь орж ирэхгүй байгаад байгаа. Иргэдээс санал авч байна гээд л яваад байгаа. Өнгөрсөн 7 хоногт Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг дээр Татварын ерөнхий газрын тодорхой мэдээллүүдийг бас сонссон. Тэгэхээр татварын байгууллага дээр төвлөрч байгаа өр төлбөртэй аж ахуйн нэгжүүдийн тоо өнгөрсөн жил 50 мянга байсан бол энэ жил 70 мянга болчихжээ. Татварын өр төлбөрийн үлдэгдэлтэй, үлдэгдлийн хэмжээ өнгөрсөн жил 3 гаруй их наяд төгрөг байсан бол энэ жил 6.5 их наяд төгрөг болчхож.

Тэгэхээр аж ахуйн нэгжүүд чинь энэ татварын дарамт дор сөхөрч байна. Түрүүн бид нар зээлийн хүү ярилаа зээлийн хүү өндөр байна, татварын дарамт өндөр байна. Яаж энэ нөхцөлд бид иргэдийнхээ амьжиргааг тэтгэх юм бэ, яаж орлогыг нь нэмэгдүүлэх юм бэ? Тэгэхээр энэ татварын асуудал дээр та яг ямар тодорхой бодлого, шийдвэрийг богино хугацаанд яаж оруулж ирэх вэ? Энэ дээр бүр яг тодорхой шийдлүүд нэрлэнэ.

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Ер нь бид нар тасралтгүй л ажиллаад л байна л даа. Тэгэхдээ ажил хийлгэхгүй байна, амар заяа үзүүлэхгүй байна. Нэг бол огцруулна гэх юм. Нэг бол ингээд л улс төржөөд байх юм. Нэг бол ажил хаяад байх юм. Бензин шатахуун биднээс хамааралгүй өөрсдөө үйлдвэрлэдэггүй учраас дайн байлдаанаас болоод тасраад байх юм. Тэгэхдээ тэр бүх асуудлуудыг бид зохицуулаад, эрэмбэлээд, шийдээд явж байна.

Татварын реформыг энэ төсвийн хуульстай хамт эхлэлийг нь тавьж бид нэмэгдсэн өртгийн албан татвар бол татварын орлогоосоо гадна бүртгэлийн зорилготой учраас бүртгэлийг ил тод болгох зорилгоор НӨАТ-ыг 1 сарын 1-нээс эхэлж буцаан олголтыг 2 хувийг 5 хувь болгож нэмэгдүүлэх, тодорхой түвшинд 70, 80 хувьдаа хүрэхээр ийм хуулийн төслийг өргөн барьсан. Парламентын хэлэлцүүлгийн явцад энэ 10 сарын 1 болж хойшилсон байна лээ. Хойшилчихсон. Яах вэ энэнтэйгээ уялдаад бид татварын реформынхоо багцыг шинэчлээд ойрын хугацаанд өргөн барина. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийг ирэх 7 хоногт өргөн барихаар төлөвлөж байна. Энэ дотор багц хуулиуд өргөн баригдана. Тэгэхээр ипотекийн зээл ч бай, орон сууцжуулалтын банк ч бай энэ цогцоороо

ирэх таван жилийн үндсэн чиглэлд өнөөдөр хэрвээ батлагдвал энэ бүх “идеологи” нь ирэх жилүүдэд хэрэгжүүлэх бодлогын суурь баримт бичиг батлагдана.

Үүнтэй уялдуулаад бид төрөөс төрийн өмчийн компаниудын үр ашгийг сайжруулах асуудлыг 3 удаа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд түрүүчээсээ хариуцлагыг нь тооцохыг нь тооцоод, хувьчлах, татан буулгах, эрэмбэлээд тэгээд ирэх 7 хоногт Улсын Их Хуралд өргөн барихаар бид төлөвлөж ажиллаж байна.

Дараа нь дээр нь энэ Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуультай хамт татварын реформ, нийгмийн даатгалын цогц реформын хуулиудаа өргөн барина. Татварын дарамтыг ерөнхийдөө бидний тооцож байгаагаар 3-4 их наяд төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн. Ингэхдээ жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг илүү чөлөөлөх. Тэгэхдээ харамсалтай нь сүүлийн үед татвар төлөлтийг сааруулах зорилготой юм шиг татварын өршөөл, татварын реформ хийж байж дараа нь татварын өршөөл хийж байсан ийм циклтэй байгаа манай өмнөх 4 арваны тогтолцоон дээр ч гэсэн би ажиллаж байсан. Тэгтэл одоо…/минут дуусав./

Н.Учрал: Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Тэгэхээр та Занданшатар сайдаа ажил хийлгэхгүй байна, улс төржүүлээд байна, янз бүрийн зүйл парламент руу оруулж ирээд байна гэж ярьж байна, гадаад шок ч бас ярьж байна. Мэдээж дэлхийн аль ч улс оронд бүх улс төрч нар, бүх Засгийн газрууд иймэрхүү бэрхшээлүүдтэй байгаа. Тэгэхээр хүн ер нь улс төрд яах гэж орж ирдэг вэ? Энэ бэрхшээлүүдийг даван туулаад тодорхой бодит шийдлүүдээ өөрийнхөө легистийг үлдээх гэж орж ирдэг тийм ээ. Тэгэхээр элдэв янзын шалтаг, шалтгаан тоочихоо болиод яг энэ бодит ажил руугаа зоригтой бас орохыг бид нар шаардаад байгаа шүү дээ. Тийм л зүйл өнөөдөр бас яригдаж байгаа.

Өнөөдөр танд би 1 нэр томьёо бас хэлэхийг хүсэж байна. Өнөөдрийн бид нар хэлэлцүүлгийг “Амьжиргааны өртөг” гэсэн сэдвийн хүрээнд хийе гэж бас нам дээрээ ярьсан. Тэгээд амьжиргааны өртгийн хямралд Монгол Улс нэрвэгдэж байна уу? Энэ бол КОВИД-оос хойш бий болсон энэ амьжиргааны өртгийн хямрал буюу Англиар “cost of living crisis” гээд байгаа юм. Тэгэхээр бид нар яг ийм бодитой хямралтай нүүр тулаад байна гэдэг өнцгөөсөө та бас дараа дараачийн Засгийн газраас хэрэгжүүлэх бодлого, шийдвэрийнхээ арга хэмжээндээ бас хандаач гэдэг ийм байдлаар асууж байгаа.

Яагаад вэ гэхлээр иргэдийн амьдрал үнэхээр хүнд байна. Амьжиргааны өртөг нь дийлдэхээ байчихлаа. Тэгэхээр бид нар бодитой ийм зүйлүүдийг хийхгүй бол өнгөрсөн удаагийн хэлэлцүүлэг дээр ярьсан дундаж давхарга чинь улам бүүр багасна. Тэгээд Монгол Улс хэзээ тэгж чинээлэг Швейцар лугаа хөгжих юм улам бүүр алсраад байна шүү дээ. Тэгэхээр бид нар өөрсдийнхөө цаг хугацаан дээр өөрчлөлт хийх ёстой.

Төгсгөлийн асуулт. Та элдэв янзаар гуйвуулж дайвуулахгүйгээр яг л 1 л асуултад хариулт өгнө үү? Та өрхийнхөө амьжиргааны зардалд сард хэдэн төгрөг зарцуулдаг вэ? Улсын Их Хурлын даргаас Ерөнхий сайдын цалин илүү бага байгаа гэж бодож байгаа. Тэгээд Ерөнхий сайдын хувьд энэ мэдээлэл бас нээлттэй байх

боломжтой гэж харж байгаа. Тэгэхээр яг энэ амьжиргааны өртгийн хямрал танай өрхөд ямар арга хэлбэрээр нөлөөлж байна вэ?

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Ер нь энэ сүүлийн 10 жилд, ер нь бараг сүүлийн 30 жилд өрхийн зардал бол үндсэндээ орлогын дүнгээсээ өндөр байсан. Бодит орлогын дүнгээсээ. Ер нь цар тахлын үед хүний хэрэглээ хумигдсантай холбоотойгоор зардал нэлээн буурсан, орлого үл ялиг давсан тооцоолол гардаг. Өөрөөр хэлбэл орлого давж байж хүн хуримтлалтай байна. Хуримтлалтай байж байж дундаж давхарга амьдралын нөхцөлөө сайжруулах бололцоо бүрдэнэ. Тийм учраас амьдрах зардал бол орлогоосоо их байхыг хэлж байгаа юм. “Cost of living” хот хотоороо тэр хот илүү өндөр өртөгтэй хот гэдэг ч гэдэг юм уу…/минут дуусав./

Н.Учрал: 37 минут 30 секунд хэтэрсэн байна. Тэгээд Ерөнхий сайд хариулж бас чадаагүй асуултаа сөрөг хүчний бүлгийн гишүүд асуухад бас нэмээд хариулах нь зөв байх. Дэгийн хуулиараа хугацаа тогтоосон. Батбаярын Жаргалан гишүүнд баярлалаа.

Одоо Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж хариулт авах нийт хугацаа 37 минут 30 секундээс хэтрэхгүй байна. Гишүүдэд ирцээ бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асуух зөвшөөрөл олгоё.

Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Дэгээр нэг дор асуулт асууна. Би 3 асуулт асууна. Гэхдээ Их Хурлын дарга ер нь мэтгэлцээн гэдэг нэртэй мөртөө урьдчилж асуултаа өгөхөөр мэтгэлцээн биш болчхоод байгаа юм. Тэгэхээр цаашдаа бас энийг бас анхаармаар юм байна. Зарчмын юм хэлж байгаа юм.

1.Амьжиргааны зардлын өсөлт ба иргэдийн бодит орлогын энэ бууралтын тал дээр.

Энэ өрхийн бодит орлого бодит инфляцын өсөлтийг гүйцэхгүй байгаа. Хүнсний болон өргөн хэрэглээний барааны үнэ сүүлийн жилүүдэд тасралтгүй хаданд гарч байгаа. Иргэдийн амьжиргааны том маш том дарамтын энэ шалтгаан болж байгаа. Засгийн газар ойрын хугацаанд дараагийн 6 сарын дотор иргэдийн амьжиргааны зардлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр ер нь яг ямар бодитой алхмууд хийх вэ? Энэ төлөвлөгөөгөө та товч тодорхой хэлээч гэж.

2 дугаар асуулт энэ хавтгайрсан үр дүн муутай бодлогын талаарх.

Төрийн халамжийн хэмжээ жил ирэх тусам өсөж байгаа. Гэхдээ энэ амьжиргаа, иргэдийн амьжиргаанд сайжрах түлхэц авчирч чадахгүй байгаа. Хавтгайрсан халамжийн бодлого иргэдийн ажил хөдөлмөрт уриалах биш, урам зоригийг нь бадраах биш үндэс өөрөөр хэлбэл ач холбогдол муу байгаа гэдэг нь энэ дээрээс маш тодорхой харагдаж байгаа юм. Залуу үе ялангуяа Солонгос руу явдаг ч гэдэг юм уу ер нь л тийм дүрвэх, дайжих тал руугаа болчихлоо. Тэгэхээр Засгийн газар энэ халамжийг хавтгайруулах биш зорилтот бүлэгт нь хүргээд

хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар бодитойгоор ер нь яг ямар шинэчлэлийг бодлого биш шинэчлэлийг хийх вэ?

3 дугаарт энэ малчин, тариаланчдын амьжиргааны асуудлаар энэ олон аймагт ган, зудын эрсдэл байна. Гангийн эрсдэл байна. Энэ өвөл жишээлбэл малчид, тариаланчдын орлого бууraад тэдний өрхийн амьжиргаа хүндрээд байгаа. Энэ малчид, тариаланчдын өрийн ачаалал өсөөд залуу малчдын ирээдүй ер нь маш хүнд байгаа. Ер нь л орон нутгаас ер нь залуучууд дайжих хандлагатай болчихсон. Тэгээд энд гэр бүл төлөвлөлтийн бодлого гээд маш олон юм энэ цаана нь байгаа л даа.

Нөгөө талаасаа уур амьсгалын эрсдэлийг даван туулах чиглэлээр Засгийн газар ер нь яг ямар яаралтай бодлогуудыг хэрэгжүүлж байгаа вэ? Эдгээр 3 асуултад хариулт авъя.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Эрдэнэболд гишүүнтэй санал нэг байна. Энэ парламентын мэтгэлцээн бол Засгийн газраас оруулж ирсэн тодорхой шийдэл дээр ийм мэтгэлцээн хийж байвал илүү оновчтой, ажил хэрэгч, үр дүнтэй болно. Одоо болохоор ингээд асуултууд өгсөн нэртэй боловч асуултаасаа шал өөр өөр л асуултууд өнгөрсөн 3 юман дээр үндсэндээ нэг, үндсэндээ бараг өөр өөр асуултууд ирээд асуулт, хариултын танин мэдэхүйн шинж чанартай давамгайлаад байгаа юм.

Тийм учраас илүү парламентын шийдэл гарахад чиглэсэн ажил хэрэгч ийм шийдэл тойрч маргалдаж, мэтгэлцэж байвал парламентын мэтгэлцээн илүү үр дүнтэй болох болов уу гэж бодож байна. Тийм саналтай байна. Ер нь өнөөдрийн сэдэв бол “Амьжиргааны өртөг”. Тэгэхээр тантай нэгдүгээрт энэ хавтгайрсан халамжаар иргэдийн амьжиргааг шийдэж чадахгүй. Одоо бага орлоготой иргэдийн орлогын 78 хувийг нь тэтгэвэр, тэтгэмж бүрдүүлж байгаа.

Тэгэхээр зорилтот бүлэгтээ илүү чиглэсэн ийм халамжийн бодлого илүү оновчтой. Ийм учраас нийт иргэдийн бараг 90 хувь нь тэтгэвэр, тэтгэмж авдаг гэсэн ийм судалгаа байна. 90 хувьд нь ямар нэгэн байдлаар тэтгэвэр, тэтгэмж оногдож байна. Ийм учраас халамжийг оновчтой болгох, халамжийн реформ хийх чиглэлээр манай Аубакир сайд ажиллаж байгаа. Тэр талаар бас дэлгэрүүлж хариулж болно. Ер нь яах вэ инфляц бол, ерөөсөө амьжиргааны өртөг амьжиргаа бол инфляц, үнийн өсөлтөөр л хэмжигдэж байгаа амьжиргаа өртгийн өөрчлөлт нь. Энэ бол бид нар эрэлт, нийлүүлэлт хоёуланг нь анхаарахгүй бол дандаа нийлүүлэлтийн шинж чанартай инфляц биш, эрэлтийн ч шинж чанартай инфляц бий болоод байгаа.

Нийлүүлэлт талаас гэхэд энэ жилийн хувьд шатахуун, эрчим хүчний үнийн өсөлтүүд нөлөөлсөн бол Улсын Их Хурлаас батлагдсан энэ улаан буудайн импортыг тэглэсэн ч байдаг юм уу гурилын импортыг тэглэсэнтэй холбогдоод тариалалт багасаж, манай ургац 34.7 хувиар буурсан тариалалттайгаа. Энэнээс болоод энэ жил бид нар улаан буудайн импортоор авахаас өөр аргагүй болж байгаа. Төмс 54.8, хүнсний ногоо 15 хувиар буурсан. Энэ нийлүүлэлт бол буурч байгаа учраас импортыг өдөөж байгаа.

Н.Учрал: Өлзийхүүгийн Шижир гишүүн. Гишүүд 2 минутад асуултаа товч тодорхой асууна. Ерөнхий сайд бас 2 минутад хариулна.

Ө.Шижир: Өдрийн мэнд. Монголчууд өнөөдөр зээлээ зээлсний хооронд, өрнөөс өрний хооронд амьдарч байгаа. Барьцаалж болох бүх юмаа барьцаанд тавиад, тавьж болох бүх зүйлээ барьцаанд тавьж амьдарч байгаа. Нэг үгээр хэлбэл Монгол ардын зүйр үг байдаг “Өртэй хүн өөдөлдөггүй, өттэй мал таргалдаггүй” гэж. Монголчууд маш энгийн зүйл хүсэж байгаа. Олсон орлого нь амьжиргааны өртөгт нь, амьдрах зардалд нь хүрдэг байх ийм л зүйлийг хүсэж байгаа. Засгийн газраас, танаас тансаг амьдралыг хүсээгүй. Өнөөдөр 1.4 сая хүн хөдөлмөр эрхэлж байгаа хэдий ч улсын дундаж цалин 2.6 сая хийж байгаа. Нийт уул уурхайн салбарт 5 сая төгрөгөөс дээш төгрөгийн цалинтай ажиллаж байгаа 73100 хүнийг хасаад тооцох юм бол энэ тоо чүү ай 1.9 сая хүрнэ. 1.9 сая төгрөгөөр хүн өнөөдөр ахуй амьдралаа залгуулж байна гэсэн үг. Нийт хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн 57 хувь нь улсын дунджаас бага цалинтай ажиллаж байна. Амьжиргааны доод түвшин 2016 оноос хойш 10 жилийн хугацаанд 318700 төгрөгөөр өссөн бол 1 өрхийн сарын хэрэглээний зардал 2 сая төгрөгөөр нэмэгдсэн. Нэг үгээр хэлбэл өрөөр амьдарч байна.

Тийм учраас би танд 36 настай, 3 хүүхэдтэй, өөрөө төрийн албан хаагч хийдэг, эхнэр нь хувийн хэвшилд ажилладаг 2.6 сая төгрөгийн цалин дээр нэмэх нь эхнэр нь 2 сая төгрөг. Ингээд нийтдээ дур 4.6 сая төгрөгийн цалингийн орлоготой өрхөөр жишээ авч танаас асуулт асуулт асууя.

Энэ өрх ипотекийнх нь зээл дээр сард 700 мянган төгрөг, цалингийн зээл дээр сард 950 мянган төгрөг, аппликэйшний зээл дээр 150 мянган төгрөг төлөөд үлдсэн багахан мөнгөөрөө хоол хүнс буюу саяын 2 сая төгрөгөөр амьдарч байгаа. Ингээд өрхийн орлого нь зөвхөн анхдагч хэрэгцээгээ хангадаг хоёрдогч, гуравдагч хэрэгцээг хангаж чаддаггүй. Том хүүхдийнхээ хувцсыг багадсанд нь өгдөг. Багадсанд нь дахиад багад нь өгдөг ийм л амьдрал байна.

Өнөөдөр залуучууд ипотекийн зээлтэй, цалингийн зээлтэй, автомашины зээлтэй, сургалтын зээлтэй, хэрэглээний зээлтэй, гар утасны зээлтэй, банк бусын зээлтэй, аппликэйшний зээлтэй, нэмээд ломбардын зээлтэй. Ахмад малчид нь малчны зээлтэй, тэтгэврийн зээлтэй. Ёстой л нээрээ цалинтай тулдаа амьдарч байна л гэдэг нөхцөл байдалд амьдарч байна. Надад танаас ганцхан асуулт байна. Та зээлтэй юу ямар нэгэн?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь судалгаанаас үзэхэд нийт иргэдийн, нийт өрх айлуудын 63.8 хувь нь зээлтэй байгаа юм. Энэ бол өнгөрсөн оны мөн үетэй харьцуулах юм бол цалингийн зээл, хэрэглээний зээл багассан үзүүлэлт боловч иргэд орлого нь хүрэлцэхгүй байгаа учраас голцуу хэрэглээний зээл авч байгаа. Цалингийн зээл, тэтгэврийн зээл, саяын хэлсэн малчдын зээл голцуу бизнес хөгжилдөө гэхээсээ илүү амьжиргаагаа нөхөхдөө авч байгаа зээл харагдана. Тэрний 15 хувь нь гэхэд автомашины зээл, лизингийн зээлүүд, санхүүгийн лизингийн зээлүүд, автомашины зээл энэ тэр авч байгаа. Тэгэхээр энэ нийт агуулгаар нь харгалзаад үзвэл ер нь энэ амьжиргааны өртгийн үзүүлэлтийг олон

улсын стандартын дагуу тооцсон ч гэсэн тэр яах вэ зүгээр статистик дундаж 2 сая 989 мянга гэж байгаа л даа. Зардал нь бол 3 сая 9 мянга гэхээр 172 мянгаар дунджаараа зарлага орлогоосоо илүү байгаа юм.

Тийм учраас зарлага илүү байна гэдэг чинь хүмүүс зээл л, дунджаараа зээл рүү чиглэж байна гэсэн үг. Таны хэлж байгаа 56 хувь нь энэ дунджаас доогуур цалинтай байгаа 2 сая хэдэн 400 мянга гэдгээс чинь.

Тэгэхээр ер нь эмч, багш нарын цалин 1 дэх бодитой хийж байгаа шийдлүүд юу байна гэхээр эмч, багш нарын цалинг нэмэгдүүлсэн. Үнэхээр тэгэхдээ хавтгайруулж нэмэгдүүлээгүй. Цалинг хавтгайруулж нэмэгдүүлсэн гэж яриад. Бид суурь доод цалинг нэмж байгаа. Улаанбаатар хотын багш нарын ачаалал нийт сурагчдын 3-ны 2 нь 60 гаруй хувь нь Улаанбаатарт сурагчид байна. Тэгтэл нийт багш нарын 3-ны 1 нь Улаанбаатарт байна. Тэгтэл тэр залуу багш нар сая 200, сая 484 мянган төгрөгийн цалингаар гар дээрээ 1 сая 200 мянга, сая гаруй төгрөг аваад Улаанбаатар хотод амьдрахад бол хэцүү.

Хөдөө орон нутгийн багш нар 40 хувийн нэмэгдэлтэй байдаг учраас зардал харьцангуй бага байна. Тэгэхдээ хөдөөд багш нарыг дэмжих бодлого гэж тайлбар. Тийм учраас бид энд суурь бага цалинг дээшээ 2 сая 200 мянга хүртэл нэмэгдүүлэх бодлого, чиглэл барьсан сая бол. Эмч, нар багш нарын цалин нэмэгдэхэд гол дундаж давхарга болох…/минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт 1 минут тодруулна Шижир гишүүн.

Ө.Шижир: Яах вэ та миний ганц асуултад хариулсангүй. Гэхдээ Үндэсний статистикийн газраас 2016 оноос хойш хэрэглээний үнийн индексийн өсөлтийг дунджаар 8.66 гэж тооцсон юм байна. Гэтэл бодит байдал дээрээ 8.66 хувь бус зөвхөн хонины мах гэхэд 2016 оноос хойш 204 хувь буюу өмнөх 204 хувь. Энэ бол жилийн дунджаар шүү. Зөвхөн өмнөх оныхоос 14 хувь, үхрийн мах өмнөх оныхоос 14.7 хувь, адууны мах 13 хувь, төмс 16.2 хувь, манжин 14.6 хувь, элсэн чихэр 9.5, ургамлын тос 13.6 гэх мэт өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнүүд Үндэсний статистикийн хорооноос гаргаж байгаа жилийн дундаж хэрэглээний үнийн индексийн 8.6 хувиас өөр байгаа шүү гэдгийг би танд хэлэх гэсэн юм. Бодит амьдралд статистик гаргаж байгаа цаас 2 зөрж байгаа гэдгийг Монголчууд бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд та миний ганц асуусан асуултад хариулсангүй. Баярлалаа.

Н.Учрал: Цэндийн Баатархүү гишүүн. Ерөнхий сайд 1 нэмэлт минутаар хариулна.

Г.Занданшатар: Асуултад гүйцээж хариулж амжсангүй. Би өөрөө яг хувь хүний нэр дээр зээлгүй байна. Миний зарлага харьцангуй бага. Би ажил, гэр 2-ын хооронд явдаг учраас өөр бусад газраар ордоггүй. Өдрийн хоолны зардлаас бусад зардал гаргадаггүй учраас одоогоор. зээлгүй амьдарч байна. Тийм учраас өглөө гараад л орой ирдэг өөр газраар явдаггүй учраас ингээд л хүргэж өгөөд хүргээд авчихдаг учраас миний зардал харьцангуй гайгүй. Ордонд хямд хоол ордны хоол идчихэж байна. Ингээд л үндсэндээ миний зардал ингээд л өдрийн хоолны зардал гарч байгаа учраас.

Түрүүн Жаргалан гишүүний асуултад хариулж амжаагүй. Ингээд нийлүүлэн харьцуулахад зардлаа хэмнэж эдийн засагч хүн учраас энэ хүндрэлтэй эрин үед ингэж амьдарч байна. Зээл алга байна. Тэгэхдээ зээлгүй 32 хувьд хамаарч байгаа. Бусад асуудлаар амьжиргааны өртөг, амьжиргаа шийдэл гарцууд багш, эмч нарын цалинг нэмэгдүүл…/минут дуусав./

Н.Учрал: Ерөнхий сайдаас асуулт асуух, үг хэлэх хугацаа 2 минутаас хэтрэхгүй. 1 удаа 1 минутаас хэтрэхгүй хугацаагаар тодруулж болно. Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Өнгөрсөн 10 жилийн Монгол Улсын өнөөгийн байдлын үр дүнг илэрхийлэх хүнтэй хамт мэтгэлцэх гэж байна. Өнөөдөр Улаанбаатар хотын агаар орчны бохирдол, амьжиргааны энэ өртөг, ажил хийсэн ч ядуурдаг, ажил хийгээгүй ч ядуурдаг энэ Монгол Улсын сүүлийн 10 жилийн бодлого, шийдвэртэй салшгүй холбоотой хүн бол Монгол төрд байдаг бүхий л өндөр албан тушаалыг ээлжлэн сэлгэн хашсан хүн бол та юм гэж би хувьдаа бодож явдаг.

Та дандаа ирээдүй цаг дээр ярьж байна. Ер нь Монгол хөгжихгүй байгаа шалтгаан чинь дандаа ирээдүй цаг дээр яриад байх юм. Одоогоо оношилж, өнгөрснөө зөв дүгнэж, алдаагаа засахгүйгээр бид цаашаа явах боломжгүй. Үнэхээр өнөөдөр 2 талд улс төржих биш энэ Монгол Улсыг улс шиг болгоё 3.5 сая хүнийг цалингаараа амьдардаг улс болгохын төлөө бид нар бодлогоо уралдуулъя гэж бодож байна. Бодлогоо уралдуулъя гэж бодож байна. Монголын өнөөгийн байдал цоорхой хувинтай адилхан. Ямар ч зүйл хийгээд тэр хувь нь дүүрэхгүй байна. Тэр бидний алдаа. Монгол Улсын Ерөнхий сайд хариуцлагатай хүн. Нэг зүйлийг онцолж хэлж байна. Монголын сүүлийн 10 жил шат шатад хулгай гарсан юм байна. Хулгайгаар дүүрсэн юм байна, хулгай цэцэглэн хөгжсөн юм байна. Энэ хулгайн өртгийг иргэд нуруун дээрээ төлж байгаа юм байна. Өнөөдрийн амьжиргааны өртөг, инфляц, үнийн өсөлт бол энэ хулгайн шалтгаан, үр дагавар гэж. Тэгэхээр бид нар цалин нэмье, цалинг шат дараатай нэмье гэж яриад байдаг. Инфляцыг үйлдвэрлэж байгаа бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг нэмэгдүүлж байгаа үндсэн шалтгаан нь хулгай юм гэж бодож байна. Тийм учраас яг энэ цаг үед та…/минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт 1 минут Баатархүү гишүүн. Тодруулгадаа асууя. Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь би ирээдүй цаг дээр зөвхөн яриагүй өнгөрсөн, одоо, ирээдүй 3 цаг дээр ярьж байгаа гэж бодож байгаа. Яагаад гэхээр би төсвийн тодотгол хийсэн. Үнийн өсөлтийг бууруулахын тулд 2025 оны төсвийн тодотгол хийж, 2026 оны төсвийг илүү бодитой мөчлөг сөрсөн бодлого болгож энэ талаасаа эдийн засагт үнэ өсөх дарамтыг бууруулж, цалинг нэмэгдүүлж, суурь орчныг арилгаж засахад чиглэгдсэн ийм өөрчлөлтүүдийг хийж ирснээ ирээдүйд хийх энэ таван жилийн үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлагдаж байгаа учраас ийм 3 цаг дээр ярьж байна. Тийм учраас дандаа өнгөрсөн цаг дээр ярих нь хаашаа юм, дандаа ирээдүй цаг дээр ярих юм энэ гурваа холбож ер нь аливаа 3 үе дээрээ тогтож байх ёстой гэж би ойлгож байгаа юм.

Тийм учраас зөвхөн 10 жилд энэ эдийн засаг ингээд болохоо байчихсан биш энэ бол 30 жилийн алдаа. Өмч хувьчлалаас хасуулаад хүнсний үйлдвэрлэл тэгээд Дэлхийн худалдааны байгууллагад элссэн эдийн засгийн энэ алдаатай бодлогуудын чинь үр дүнд энэ үнэ өсдөг. Өөрсдөө үйлдвэрлэгч улс биш болсон, хараат болсон, хамааралтай болсон энэ бүх тоо, эдийн засгийн баримтууд чинь 30 жилийн алдаа. Зөвхөн 10 жилд бий болчихсон юм шиг. Энэ авлига, хулгай чинь өмч хувьчлалаас эхлээд л өнөөг хүртэл үргэлжилж байгаа энэ ардчилалтай хамт үр хөврөл нь гараад ирчихсэн ийм бүтээгдэхүүн. Тийм учраас танай, манай гэж бие бие рүүгээ чих биш хамтраад л энэ болж бүтэхгүй асуудлуудаа шийдээд, засаад, тэгээд цоорхойгоо бөглөөд, хамтраад урагшлах нь л илүү эрүүл шийдэл гарц. Тийм учраас бид нар бие биеийгээ буруутгахаас илүү зөв шийдэл гаргахын төлөө явах ёстой гэж бодож байна.

Тийм учраас бид эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих гэж байна. Хувийн хэвшлийг дэмжих татварын таатай орчныг бүрдүүлэх, ТӨК-удыг нээлттэй ХК болгож, олон нийтийн хяналтад шилжүүлэх, дэд бүтэц, орчин, хүчний төслүүдэд түлхүү анхаарах зэрэг арга хэмжээг нэмэгдүүлж энэний үр дүнд бүтээмж нэмэгдэж, энэ хэрээр Монгол хүний үнэлэмж өсөж, цалин орлого нэмэгдэнэ. Бүтээмж сайтай бол цалин, орлого нэмэгдэнэ.

Н.Учрал: Цэндийн Баатархүү гишүүн тодруулна.

Ц.Баатархүү: Бидний өнгөрсөн зам алдаатай байсан гэдэгтэй санал нийлж байна. Гэхдээ өнгөрсөн 10 жил алдааг засах чиглэлээр ажиллаагүй, алдааг улам цэцэглэн хөгжүүлсэн байна гэдгийг бид бүхэн бүгдээрээ хүлээн зөвшөөрч байна. Одоо алдааг засах 100 хоног өнгөрч байна танай Засгийн газрын хувьд.

ТӨК-ийг нээлттэй болгоё гэж ярьж байна. Одоо яаралтай энэ реформоо хийгээсэй гэж би хүсэж байна. Үнэхээр энэ амьжиргааны өртгийг нэмэгдүүлж байгаа, үнийн өсөлтийг бий болгож байгаа жишээлэх юм бол нийслэл Улаанбаатар хотын орон сууцыг авах, авахын тулд барилгын компани газрын зөвшөөрөл авахын тулд хүнд суртлын төлбөр төлдөг.

Жишээлэх юм бол дулааны эх үүсвэр авахын тулд хүнд суртлын төлбөр төлдөг. Цэвэр усны эрх авахын тулд хүнд суртлын төлбөр төлдөг, эргүүлээд Улсын комисст хүлээлгэж өгөхийн тулд авлигын хүнд суртлын төлбөрийг төлдөг өө. Энэ тогтолцооны авлигын өртгийг Улаанбаатарчууд, Монголчууд нуруун дээрээ үүрч байна. Тийм учраас таны ярьж байгаа хулгайтай тэмцэх энэ ал…/минут дуусав./

Н.Учрал: НЕБ-ын 93 дугаар сургуулийн 11[а] ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье. Тийм үү?

Даваагийн Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Нэлээн хэдэн сэдэв бэлдэж ирсэн. Цаг маш бага юм байна. Тэгээд товчилъё. Төсөв болон хувьчлалтай холбоотой асуудлуудаар санал хэлэх юм байгаа. Бас зарчмын хувьд асуух юм байгаа. Төсөв дээр Засгийн газар 120 их наяд төгрөгийн хөрөнгийг хөдөлгөж байгаа. Хөрөнгө

буюу бид нар актив хөрөнгийг хөдөлгөж байгаа. Гэтэл 33 их наядын бид нар улсын төсвөөс татвар нэрээр баталж өгөөд Засгийн газрыг ажилд нь оруулдаг, 90 их наядын цаана нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дээр эргэлдээд байна. Энэ эргэлдээд байгаа мөнгөнөөс буцаагаад улсын төсөвт нэмэр болж байгаа орлого бол маш муу байгаа. Энийг сайжруулж ажиллах шаардлагатай. Энэ дээр бас таны саналыг сонсъё.

Дараад нь урсгал зардлаа цаашид ер нь хөдөлгөхгүйгээр яг энэ чигт нь царцаагаад одоо байгаа энэ урсгал зардлынхаа хүрээнд цаашид Засгийн газрууд оруулж ирэх төсвөө баримталж ажиллавал их зүгээр байна.

Тэгээд гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж байгаа төсөл, хөтөлбөр дээрээ Монгол Улсынхаа эрх ашгийг сайн тавьж өгөхгүй бол Монгол Улс өөрөө алдагдалд орохуйц ийм гэрээ, контрактуудыг маш их хийж ирсэн алдаа, дутагдлууд байна. Дээрээс нь 3-д нь төр өмчүүдээсээ хувьчлах замаар цаг алдахгүйгээр салах ёстой болчхоод байна. Хамгийн тод жишээ Монгол Ардын намын цагаан байрны даргынх нь хаяа үеэл нь Төрийн банкны захирал хийж байгаа юм. Бид нар ийм нөхцөлд шударга ёс, авлигаасаа салах, хулгайгаасаа салах гэдэг асуудлуудыг ярих боломж байхгүй. Яг шударгаар нээлттэй сонгон шалгаруулалт зарлаад захирлуудыг нь сайхан томилоод нээлттэйгээр компаниудаа хувьчлаад явах юм бол банкнуудаас бид нар өч төчнөөн тэрбумаар нь орлого олж улсын төсөвтөө нэмэр болох боломжтой атал өнөөдөр энэ маш муу түвшинд явж байгааг та өөрөө харж байгаа. Энэ дээр та саналаа хэлээрэй.

2 дугаар асуудал малчидтай холбоотой. Сүү, мах 2 өнөөдөр үнэтэй байна. Тэрнээс бусад дайвар бүтээгдэхүүн, арьс шир ерөөсөө үнэ хүрэхгүй байна. Монголчууд энийг сүүлийн хэдэн жил ярьж байгаа. Малчид тэр дундаа. Энэ тал дээр ямар бодлого баримталж ажиллаж, ойрын хугацаанд энэ яавал үнэд хүрэх вэ гэдгийг та малчдад бас хэлж өгөөч? Яг малчнаас ирсэн асуулт нь Малчны тухай хуулийн 4.2.9 дээр заасан…/минут дуусав./

Н.Учрал: Цогтбаатар гишүүнд 1 минут өгье.

Да.Цогтбаатар: 4.2-ын өндөр настан тэтгэмжийн асуудлыг бас тодруулж өгөөрэй гэсэн. Тэгээд сүүлд нь бол нийгмийн асуудал буюу энэ Улаанбаатар хот чинь Туулын хурдны зам гээд 2 аравны, их наяд, 5 их наяд төгрөгөөр зам барих гээд байна. Үүгээр бид нар жишээлэхэд баруун аймаг руу гардаг, Баянхонгор, Өвөрхангай руу гардаг Лүнгийн замыг өргөтгөх боломжтой. Энэ Улаанбаатар хотоор явж байгаа төмөр замыг судлаад өгч байхад яагаад Нийслэлийн Засаг дарга ийм буруу шийдвэр гаргаад ажиллаад байгаа юм бэ? Энэ дээр таны байр суурь?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Түрүүчийн Баатархүү гишүүний асуулттай нийлүүлээд ер нь хариулахад бид бас энэ ТӨК-удын үр ашгийг сайжруулж байж. Энэ хамгийн гол үр ашгийг сайжруулах ёстой салбар бол төрийн өмчийн компаниудын асуудал байгаа юм. Тэгэхээр төрийн өмчийн компаниудыг хувьчлах тэр дотроо IPO гаргаж олон нийтийн компани болгоход тодорхой шалгууртай. Өөрөөр хэлбэл аудитаар, олон улсын аудитаар аудитлагдсан байх ёстой. Тэрэнд хугацаа орж байна. Дээр

нь 3 жил ашигтай байх ёстой. Тэгж байж олон нийт хувьцаанд гарч хувьцаанд арилжаалагдана. Ингэж байж Хөрөнгийн бирж амилна.

Ингээд үнэт цаасны 2 дахь зах зээл 1 дэх зах зээлд энэ макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахын тулд, хүүг бууруулахын тулд хувьцааны өгөөжийг нэмэгдүүлж ийм санхүүгийн зах зээлээ хөгжүүлэх шаардлагатай байгаа. Энэ талаар Жаргалан гишүүн ч гэсэн асуугаад байсан. Ингэж байж санхүүгийн бүтээгдэхүүний өртөг хямдарч, санхүүгийн зах зээл ч гэсэн хөгжих ёстой. Гэтэл энэ чинь 30 жилийн алдааг жишээлбэл 100 хоног дотор засчхаж болохгүй. Жишээлбэл, аудит хийхэд чинь зарим тохиолдолд 6 сар энэ тэр шаардагдаж байна. Томоохон компаниуд дээр. Аудитын процесс эхэлж байна. Ингээд энэ үр ашгийг сайжруулна.

Хоёрдугаарт тэр сүү, махнаас гадна арьс шир, ноос, ноолуур, дайвар бүтээгдэхүүнийг гаргах манай туйлын зорилго байгаа. Энэ ухдаг шар алтнаас ургадаг цагаан алт гэж энэ нөхөн төлждөг баялгаа экспортын бүтээгдэхүүн болгох нь манай эдийн засгийн энэ таван жилийн чиглэлийн үндсэн чиглэл. Ийм учраас энэ 183 сая хүнтэй 2 триллион долларын зах зээл Евро Азийн холбооны 6 улстай эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудал оруулж ирнэ. Энэний гол зорилго бол энэ 3 төрлийн 347 нэр төрлийн бүтээгдэхүүнийг татваргүй, хөнгөлөлттэй, тарифын болон тарифын бус барьергүйгээр экспортлоход чиглэгдэж байгаа юм. Энэний үр дүнд бидний хийсэн тооцооллоор саяын таны хэлсэн дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд 160 хувиар өсөх тооцоотой…/минут дуусав./

Н.Учрал: Ерөнхий сайд нэмэлт 1 минут.

Г.Занданшатар: Мах, махан бүтээгдэхүүн гэхэд 140 хувиар нухаш, зайдас гэдэг юм уу, хиам, каз гэдэг юм уу ийм бүтээгдэхүүнүүдийг боловсруулаад махныхаа экспортыг нэмэгдүүлэх, арьс ширний үйлдвэрлэлийг шинэ шатанд гаргаж гаргах бололцоотой. Энэ зах зээл гэхэд 12 тэрбум долларын арьс шир, ноос, ноолуур, мах, махан бүтээгдэхүүн импортолдог зах зээл. Энийг бид 10 хувьд нь нэвтрэхэд л 1.2 тэрбум долларын экспорт хийх ийм бололцоо бүрдэнэ гэж байгаа юм.

4.2.2.9 Малчны тухай хуулийн малчны нийгмийн даатгалыг 1 удаа л нөхөн төлөх тухай хууль батлагдсан. Тэгээд жил болгон л 1 удаа нөхөн төлдөг хууль батлагдаад байх юм энэ чинь байнгын хуультай ялгаагүй болчихно. Тэр хугацаандаа л нөхөн төлөх давуу эрхийг олгосон. Тэгэхдээ зах зээл дээрх оролцогчид татвар төлөгчид жигд, тэгш, шударга байх зарчмыг мөрдлөг болгохгүй бол цэргийн тэтгэвэр, малчдын тэтгэвэр ингээд тус тусад нь ялгаад л хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлээд байх тусмаа Нийгмийн даатгалын сан чинь улам дампуураад алдагдалд ороод нийтийнх нь эрх ашиг хохироод байгаа гэдгийг бас бодох ёстой.

Н.Учрал: Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд Ерөнхий сайдаа. Бид 2 ингээд минутаар шууд асуулт хариултуудаа өгөөд явчхаж болно тээ? Энэ инфляцын 2 хувийг үүсгэж байгаа эрчим хүчний салбарын талаар ярилцъя гэж би асуултаа өгсөн байгаа танд. Тэгээд энэ дулаантай холбоотой сонин юм яваад байгаа. Та мэдэж байгаа

байх. Эрдэнэс Тавантолгойгоос 300 тэрбум төгрөгийг гаргаад энэ шахмал түлш БНХАУ-аас бид нар авч байгаа 1.1 сая төгрөгийн өртөгтэй Эрээнд оруулж ирэх дүн нь 700 мянган төгрөг тэгээд хот руу оруулж ирэхээрээ 1.1 болчихдог, иргэдэд зарахдаа 200 мянган төгрөгөөр зарж байгаа шүү дээ бид нар. Тэгээд 750 цэгээр борлуулж байснаа одоо болохоор 350 цэг болгочихсон. Иргэд түлшээ авах гэж очерлоод ийм хүнд байдалтайгаа. Энийг ер нь хэн шийдсэн юм ийм шийдвэрийг?

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Манай Засгийн газрыг томилогдоод бүрдэх үед энэ тендер нь зарлагдаад бараг шалгарчихсан зогсоох боломжгүй гэж байсан. Өмнө нь ч гэсэн тэр Орчны бохирдлын хорооноос энэ Бортээг энэ тэртэй холбоотой шалгагдаад яригдаад байгаа асуудал чинь бас яг ийм хагас кокс нүүрс баахныг оруулж ирээд хадгалчихсан. Тэр нь бас энэнээсээ илүү үнэтэй байж байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ маргааш би явж газар дээр нь үзэж энэний яг хоруу чанар, үр ашиг, юмыг бас газар дээр нь үзэж танилцъя гэж төлөвлөж байна. Энэ бол тендер нь шалгагдаад, зарлагдаад компани шалгарчихсан нөхцөлд буцаах болдоггүй олон улсын шүүх юугаар явдаг ийм гэрээ, контрактууд ихэвчлэн хийгдчихсэн байх юм. Олон гэрээнүүд тэгж хийгдсэн байна.

Тийм учраас энэний үр ашгийг бид газар дээр нь үзэж тухайн үедээ Улаанбаатар хот утаагүй болчихно. 50 хувь буурчихна, энэ бол хамгийн шилдэг ойрын технологи гэсэн. Бид цахилгаан халаагуураа нэмэгдүүл тэр 5 мянгыгаа яаралтай хэрэгжүүлж, 5 мянган айлыг хамгийн их утаатай газруудад цахилгаан халаагуурт шилжүүл. Цаашлаад энэ дунд хугацааны шийдлүүдээ утааг бууруулах цогц бодлогыг цахилгаан халаагуур, газ, 5 ийм цогц бодлогын шийдлийг гаргаад тэгээд энийгээ хэрэгжүүл. Тэр шахмал түлшээ ч гэсэн, хагас коксоо ч гэсэн Монгол улсад үйлдвэрлэдэг бол, Баганууp болон Улаанбаатар хот дээр хэрэгжүүл гэсэн ийм чиглэл гаргаад ажиллаж байгаа дараа жилийн хувьд. Энэ жилийн бид нар зун өнгөрч байхад томилогдоод энэ асуудлыг аль болох үр бүтээлтэй байхыг л шахаж шаардаж байна. Тэгээд энэ бас эрчим хүчний хангамжтай бас холбогдох асуудал болно. Цахилгаан халаагуурын асуудал.

Н.Учрал: Энэ дэг нь 2 минут тэгээд 1 минутаар тодруулж болно гэсэн юм байна. Тэгэхээр Цэнгүүн гишүүнд 2 минутыг бүтэн өгчихье. Тэгээд Ерөнхий сайд 1 минутаар хариулна. Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Энэ тэгээд их сонирхолтой байгаад байгаа юм. Хэн шийдвэр гаргасан юм бэ л гээд. Монгол Улс чинь өөрөө ямар нүүрсний баялагтай улс билээ? Тийм байж байж ийм шийдвэрийг яг хэн нь гаргаад явчихсан юм? Та Засгийн газрын тэр нийслэл гэж байна тээ, нийслэл Нямбаатар дарга шийдсэн юм уу тээ? Би энийгээ Чойжилсүрэн сайд шийдсэн юм болов уу гээд асуух гээд байж байлаа л даа. Тэгээд яагаад энийг асууж байна гэхээр чинь сүүлийн 15 жил 5 их наядыг бид нар утаатай тэмцэхэд зарцуулсан байгаад байгаа юм. Тэгээд энэ 5 их наяд төгрөг өөрөө зүгээр салхинд хийсээд алга болсон. Хэн ч энэ дээр хариуцлага үүрч байгаагүй. Үндсэндээ энэ утааны тухай асуудлаа бид нар шийднэ гээд тэгэхээр ингээд орон сууц барина ингэнэ тэгнэ гээд бодит байдлуудаа ингээд байхгүй болгоод явчихдаг. ТӨК-уд нь энэ дээр ажиллаж байхад ТӨК-ийн менежментээ сайжруулна гэдэг.

Тэгээд та уул нь санаж байгаа бол анх томилогдохдоо ТӨК-удыг хувьчилна гэж байсан. Тэгээд би танаас асууж байсан яг 47 компанийг эрчим хүчний компанийг хувьчилж болж байна. Та хувьчлах уу гээд. Эхний 100 хоногтоо би 20 компанийг хувьчилчихна гэсэн. 8 сарын 1-ний байдлаар та 1 компанийг татан буулгаад 1 компани дээр 1-ийг нь нийлүүлсэн л ийм үр дүнтэй байж байна шүү дээ. Хэзээнээс та ажлаа хийх гэж байгаа юм бэ? Эрчим хүчний компаниуд дээр асар их менежментийн шинэчлэл дутагдаад тэнд бид нар энэ захиргаанууды нь солих шаардлага гарсан. 6 сарын 2-нд энэ ТЭЦ-III дээр гарсан дэлбэрэлтийг ярьж байгаа хүн алга байна. ТЭЦ-III дээр та БЭТ томилсон. Та яагаад ТЭЦ-III дээр БЭТ томилох шийдвэр гаргасан юм? Тухайн үед ТЭЦ-III чинь өөрөө 100 хувь ТӨК. Тэгэхээр ТӨК ТУЗ-аараа дамжуулаад гүйцэтгэх захирлаа солиод тэнд шийдвэрүүдээ гаргаад явах чадамжтай байх ёстой, төр өөрөө тийм чадамжтай байх ёстой. Тэгж байгаад гэнэт БЭТ томилоод л энэ асуудлыг шийдээд алга болчихсон юм шиг болгочхож байгаа юм? Тэгээд төр чинь таны удирдаж байгаа Засгийн газар чинь ажиллаж чадахгүй байгаа юм биш үү? Таны кабинет чинь таны үгэнд орохгүй байгаа юм биш үү? Би танаас 15 асуулттайгаар асуусан эрчим хүчний салбарт болж байгаа бүх бодлогуудыг асуусан.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: 1 минутад хариулах учраас товч хариулъя. Нэгдүгээрт, эрчим хүчний 2 компани татан буулгасан. Цаашдаа эрчим хүчний компаниудын дамжуулахыг хувьчилж болохгүй. Түгээх болон цахилгаан станцуудад олон нийтийн хяналттай болох public компани болох ажил хийгдэж байгаа. Тэр үед миний хэлж байгаа шалтгаан дээр энэ аудитлагдсан байх. IPO гаргахад шаардах шаардлагуудын процесс зуун задгай байгаа учраас эд нар хэрэгжихэд хугацаа авч байна.

БЭТ томилохын хувьд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу парламент бол төрийн өмчийн компаниудын хууль батлагдаад өгчихвөл тэр БЭТ томилох процесс чинь тэнд өөрөөр хуульчлагдсан байгаа юм. Энэ хууль хэрэгжсэн байх практикийг хэрэгжүүлэхгүй бол дэлбэрэлтээс шалтгаалаад онцгой дэглэм тэнд эрчим хүчний салбарт тогтоохгүй бол өвлийг өнтэй давах уу үгүй юү, Улаанбаатар хот хөлдөх үү үгүй юү гэдэг асуултын тэмдэг тавигдчихсан байсан. Ингэж онцгой дэглэм тогтоож ТЭЦ-III болон бусад эрчим хүчний салбарууд дээр өндөржүүлсэн бэлэн байдлаар ажилласны…/минут дуусав./

Н.Учрал: Баярлалаа. Минут дууссан. Жудгийн Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Ерөнхий сайд танаас дараах асуудалтай холбоотой асуулт асууя. Амьжиргааны өртөг. Мэдээж Монгол Улс амьжиргааны өртөг хэдийгээр өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулах юм бол бага боловчиг бодит орлого нь хэзээ ч түүнтэйгээ нийцдэггүй учраас амьжиргааны өртөг асар өндөртэй гэж тооцогдохоос өөр замгүй болчхож байгаа юм. Мэдээж ядуурлын түвшин 418 мянган төгрөг гэж байгаа юм. Тэгээд энэ 418 мянган мянган төгрөгөөс доош орлоготой өрхийн тоо маш өндөр иргэдийн тоо бас маш өндөр. Тэгэхээр ядуурлын түвшин 27 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, 913 мянган хүн ядуурлаас доогуур түвшинд амьдарч байна. Сүүлийн 10 жил ерөөсөө энэ бодит энэ ядуурлын түвшин нэмэгдсэн, буурсангүй. Огт буурсангүй. Гэтэл Вьетнам улс 1990 онд ядуурлын түвшин 70 хувьтай байсан юм байна. Монголд тэр үед 33 хувь байсан юм байна.

Гэтэл өнөөдөр Вьетнам улс ядуурлын түвшин 4 хувьтай болчихсон байна. Монгол нөгөө л 28,27, 28,27 огт буурахгүй байна. Тэгээд та эдийн засагч хүн мэдэж байгаа Энгелийн коэффициент гээд тээ? Нийт энэ айл өрхүүд иргэдийн зарлагын хүнсний зарлага нь хэд байна вэ? Нийт зардал дахь эзлэх хүнс нь, хүнсний зардал ер нь хэд байгаа юм бол оо? Энийг гаргадаг юм уу тэгээд эндээс маш их юм хамаарах юм байна лээ. Монголд асар өндөр байгаа гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ зардал өндөр байна гэдэг чинь хоол хүнснээс өөр зардал гаргах ямар ч боломжгүй. Юун театрт очиж кино үзэх, юун тэр зугаа цэнгэл байхгүй. Аргагүй шүү дээ 900 мянга бараг сая орчим хүн нь 418 мянган төгрөгөөс доош орлоготой амьдарч байхад ямар соёлын зардал гаргах юм бэ? Тэгэхээр энэ коэффициентыг дээш, энэ коэффициентыг зөв болгох тал дээр эсвэл энийг ер хэмждэг тийм зүйл байна уу энэ Монгол Улсын Засгийн газарт? Яаж Монгол улсыг…/минут дуусав./

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Монгол улсад амьжиргааны өртгийн өөрчлөлтийг хэрэглээний үнийн индекс буюу инфляцаар тооцдог. Энэ хэмжээсийг 10 мянган өрхийг түүврээр, санамсаргүй түүврээр сонгож авч байхад бүх нийгмийг төлөөлж чадахуйц 10 мянган өрхийн хэрэглээний сагсны, хэрэглээний багцыг судалж үзээд тэндээс 430 барааны гол хэрэглэдэг тэр Монгол айл өрхүүдийн хэрэглэдэг 430 бараа, үйлчилгээний үнийг Олон улсын валютын сангийн аргачлалын дагуу бусад улсуудын дэлхийн стандартын дагуу улсуудын дагуу 430 барааны үнийг 1 сагсанд хийж үүгээр инфляцыг тооцдог.

Тэгэхээр энэ дотор хүнсний бүтээгдэхүүнээс эхлээд эм, эмийн хэрэгсэл, тэгээд бараа, үйлчилгээний бүгдийнх нь үнэ орж байгаа. Хамгийн дийлэнх эх нь яг таны хэлсэн зөв. Нэн ялангуяа 2019 оноос хойш КОВИД-оос хойш хүнсний бүтээгдэхүүний үнэ 2 дахин нэмэгдсэн. Гурилын үнэ, талхны үнэ сая Жаргалан гишүүн хэлээд байсан 2700 “атар” талх 2700 болсон. Бусад талхнууд өөр 2700 төгрөг болсон бол тэр үед 400 төгрөг байсан бол 2700 болох жишээтэй. Гурилын үнэ бас бараг 2 дахин өссөн.

Ингээд тээвэр ложистикийн шинжтэй дэлхий дахины энэ хямралаас шалтгаалаад ер нь дэлхийн улсууд их инфляц бий болсон. Туркийн инфляц 33 хувь, нөгөө яриад байгаа Аргентины инфляц 38 хувьтай байх жишээтэй. Манай улсын хувьд 2 оронтой тоондоо барьж байна. Дэлхий нийтээрээ үнэ өссөн. Энэ дотроо үнийн өсөлтөд Монгол хүний хувьд мах, гурил 2 бол хамгийн суурь үнэ байгаад байгаа юм.

Өнөөдөр махны үнэ 20 мянга, үхрийн мах ястай мах 20 мянга, ясгүй мах 23 мянга орчим төгрөг байгаа. Энэ бол бид нар захыг нээснээрээ ченжгүйгээр малчид шууд 4 цэгт махыг шууд борлуулж малчдаас борлуулж эхэлсэн чинь үнэ мянга орчим төгрөгөөр буурч байгаа. Өвлийн идэш энэ тэр гээд. Махны үнэ байнга өсөж ирсэн юм байна лээ. Бас л 2 дахин бараг өссөн. Тэгэхээр энэ бид ажил авснаас хойш 6 сарын 30-наас энэ хооронд үнэ тогтвортой байгаа. Валютын…/минут дуусав./

Н.Учрал: Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Мэдээж бодит орлого нь амьжиргааны өртгөө яагаад ч гүйцэхээ больсон гэдэг нь тодорхой байгаа. 8-12 хувийн хооронд хэлбэлзэж байна гэж байгаа юм инфляцыг Үндэсний статистикийн хороо. Гэтэл хүнсний инфляц дангаараа 15-20 хувьтай гэж байгаа юм. Тэгэхээр ер нь бодит байдал дээр иргэдийн 70-80 хувь нь ядуу амьдарч байна гэж үзэж байгаа юм. Тэгэхээр таны өргөн барих гэж байгаа Татварын багц хуульд иргэдийн бодит орлогыг дэмжсэн ямар ч зүйл, заалт байхгүй байгаа.

Тэгэхээр хувь хүний орлогын албан татварыг 1 хувь болгох гэсэн энэ иргэдийн 100 мянган иргэдийн санаачилга, мөн гишүүдийн санаачлаад өргөн барихад бэлдчихсэн байгаа энэ хуулийн төслийг та дэмжих үү? Ингэж байж бодит орлого чинь бага ч атугай нэмэгдээд улмаар тэр өртгөө нөхөж чадахгүй хэдий ч бага ч атугай зардлаа хамрах хүрээнд очих юм бол тэгэхээр энэ дээр та яг ямар бодолтой байгаа юм бэ? Энэ татвар дээр ялангуяа бодит орлогыг нэмэгдүүлэх дээр иргэдийн?

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг 2 дахин нэмэгдүүлэх 5 хувьд хүргэх ийм төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Одоо 10 дугаар сарын 1 болоод хойшилчихсон байна лээ. Тэгэхдээ 10 дугаар, энэ бол бас бодит байдал дээр 5 хувь гэдэг үндсэндээ 50 хувиар буцаан олголтыг нэмэгдүүлж байгаа нь инфляцад бас нэмэгдсэн өртгийн албан татвар чинь өөрөө үнэд шингээд яваад байдаг учраас энэ бол тодорхой хэмжээний нэг талаасаа инфляцад нөгөө талаасаа иргэдийн орлогод бодитой нэмэр, хандив болно гэж тооцож байгаа.

Дундаж орлого 3 сая гэж байгаа бол жилдээ 4 ам бүлтэй өрх худалдан авалтын хэмжээгээрээ 3-4 сая төгрөг буцаагаад аваад байх, НӨАТ-ын буцаан олголт бас аваад байх энэ ингээд жишээлбэл хамгийн бодитой жишээ нь. Бусад хүн амын орлогын албан татвар 1 хувь, бага орлоготой иргэдээ илүү дэмжсэн ийм татварын реформын 3-4 их наядаар татварын дарамтыг бууруулахад чиглэсэн татварын багц хуулийн төслийг D-parliament дээр тавиад манай Сангийн яам, холбогдох газрууд…/минут дуусав./

Н.Учрал: Далайн Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Ерөнхий сайдад энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ илүү мэтгэлцэх гэхээсээ илүү иргэдэд тодорхой мэдээлэл хүргэх ийм зорилготой байгаа учраас би асуултаа тодорхой зөвхөн тоо баримт асуух маягаар тавья. Та бас тодорхой хариулахыг бодоорой.

Амьжиргааны өртөг гэдэг маань маш өргөн ойлголт. Нутаг дэвсгэрээсээ авхуулаад хот тосгон гээд газраасаа, байгаа газраасаа хамааралд амьжиргааны өртгүүд янз бүр байдаг. Тийм учраас би энэ амьжиргааны өртгийг зөвхөн дундаж орлоготой өрхийн хэмжээнд байгаагаар нь ингэж асуултуудаа тавья. Нэг ёсондоо дундаж орлоготой өрхийн амьжиргааны өртөг гэсэн үг.

Тэгэхээр 1 дүгээр асуулт нь дундаж орлоготой өрхийн амьжиргааны өртөг яг хэдэн төгрөг байгаа вэ? Өөрөөр хэлэх юм бол хэдэн төгрөгийг 1 сарын

хэрэгцээндээ зарцуулж байгаа бол өнөөдөр Монгол Улсад дундаж орлоготой өрх гэж тооцох вэ гэсэн ийм асуулт байна. Энэнтэйгээ зэрэгцүүлээд дахиад энэ хэрэглээний үнийн индекс гээд та бас түрүүн дурдсан, 430 барааны талаар ярьсан байгаа. Тэгэхээр хэрэглээний үнийн индекс маань 8.6 хувь өмнөх оныхоо одоо үеэсээ өссөн гэдэг дээр бид нар түрүүн дурдаад өнгөрсөн. Энэ дунд нь ингээд доторх бүтцийг нь харах юм бол эрчим хүчний бүтээгдэхүүнүүд, эрчим хүчний үйлчилгээнүүд хамгийн их өссөн байгаад байгаа юм.

2 дахь асуулт анхаарах ёстой асуулт нь юу вэ гэхээр үйлчилгээний салбарын зардал маш их өсчихсөн байгаад байгаа юм. Эргүүлээд ингээд нөгөө талд нь харахаар үйлчилгээний салбарт ажиллаж байгаа ажилчдын цалин нь нэмэгдээгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ зардал хаанаас гарч ирээд байгаа юм бэ? Яагаад хэрэглээний үнэд багтаж байгаа үйлчилгээний салбарын зардал өсөж байгаа вэ гэдэг дээр та хариулт өгнө үү? Энэ 2 асуулт байна.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ойлголоо. Батбаяр гишүүний асуултад хариулъя. Ер нь амьжиргааны доод түвшин 488-495 мянган төгрөг орчим байхад өрхийн орлого дундаж орлогод, дундаж гэхээр 2 сая 970 мянган төгрөг гэж Статистикийн газар тооцсон. Зарлага нь 3 сая 90 мянга гэж байгаа. Өөрөөр хэлбэл 123 мянган төгрөгөөр зарлага нь орлогоосоо дунджаар даваад байгаа ийм чиг хандлагатай байна. Ер нь дундаж орлоготой иргэн …/минут дуусав./

Н.Учрал: Ерөнхий сайдад нэмэлт минут.

Г.Занданшатар: Ийм учраас өнөөдөр дундаж өрөх сар бүр зээл авах шаардлагатай болж байна гэсэн үг. Үүнийг орлогын бүлгээр нь авч үзвэл нийт өрхийн 60 орчим хувь нь орлогоосоо давсан зарлагатай байна. Яг энэнтэйгээ багцаатайгаар 63.8 хувь нь зээлтэй байна. Ийм учраас бид ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлттэй макро түвшинд 6 хувь байж байж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж байж энэ дундаж давхаргаа өргөжүүлэх, хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалт хийх, хадгаламжтай болох, үнэт цаас, хувьцаа худалдаж авах боломжтой болох, бас хуримтлалтай болох, орлого нь зарлагаасаа илүү давж байж ийм нөхцөлийг л бүрдүүлэхэд чиглэгдсэн ийм зорилтыг ирэх таван жилийн үндсэн чиглэлд тавьсан байгаа. Өнгөрсөн хугацааны бодлогууд ч гэсэн дандаа зардлаа, инфляцыг бууруулахад л бид эрэлтийн болон нийлүүлэлтийн шинж чанартай инфляцыг хязгаарлах чиглэгдэж байна.

Үйлчилгээний салбар бүтээмж дандаа багатай байдаг салбар. Жишээлбэл, үсчний бүтээмж өдөрт хэдэн хүн засна нэмэгдэх бололцоогүй. Бусад салбар технологийн дэвшлээр…/минут дуусав./

Н.Учрал: Хуулийн цаг дууссан байна. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулиар 37 минут 30 секунд. Нийт цаг дууссан байна. Далайн Батбаяр гишүүнд 1 минут нэмж өгье.

Д.Батбаяр: Ингээд уян хатан удирдаж, хурлыг удирдаж байгаа Учрал даргадаа их баярлалаа. Тэгэхээр би яг залгуулаад асууя Ерөнхий сайдаа та сая хэллээ 3 сая 90 мянган төгрөгийн өртөгтэй зардалтай байгаа гэж хэлж байна.

Тэгвэл яг энэ дундаж орлоготой өрхөд яг энэ зарлагаа даагаад цаана нь өртөг нь, цаана нь орлого нь илүү гарч байгаа хуримтлалтай үлдэж байгаа дундаж орлоготой өрхийн хэдэн хувь байгаа вэ? Энэ дээр танд тоо байгаа юу? 1 дүгээр асуулт нь байна.

2 дугаарт нь хэрэв ингээд үлдэгдэлтэй, цаанаа хуримтлалтай үлдэж чадаж байгаа бол энийгээ зөвхөн банканд хадгалуулахаасаа илүүтэйгээр хөрөнгө оруулалт хийх боломжууд нь юу байгаад байгаа вэ? Таны ойлголтоор энэ passive income гэдэг юмны ойлголт ер нь зөв үү, буруу юу? Энийг дэмжих ёстой юу, үгүй юү? Энэ дээр та тодорхой хариулаад өгөхгүй юү?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Тийм. Ер нь Монгол улсын нийт хадгаламжийн хэмжээ 24.3 их наяд болсон. Бодит хүү 3.8 хувь байгаа инфляцад бас тооцоод. Тэгэхээр ер нь бодит өсөлт 4 хувь л гэж тооцож байгаа юм. Энэ жилийн хувьд. Бусад үед дандаа буурч байсан бодит орлого. Өөрөөр хэлбэл, инфляцаа орлого нь гүйцэхгүй байгаа. Тийм учраас энэ хөрөнгө оруулалт хийх, pssive income буюу хөрөнгө оруулалт хийх, хадгаламж, хүү, үнэт цаас олох гэх мэт нэмэлт орлого олох боломж чинь өөрөө илүү орлоготой, бодит орлоготой болж байж л энэ нөхцөл бүрдэнэ.

Ийм учраас үнийн өсөлтийг макро түвшиндээ хязгаарлаж байх нь л Засгийн газрын гол зорилго байна. Ингэж байж иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх нөхцөл болно. Үүний тулд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мөн ажлын байр бий болгох, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого энэ ирэх таван жилийн гол бодлого байгаа. Саяын хугацаанд ч гэсэн энэ чиглэлүүдийг барьж байна. Хамгийн гол нь ажил эрхлэлтээр шилжих ёстой. Энэ бэлэн мөнгөний нийлүүлэлтийг дэмжээд энэ…/минут дуусав./

Н.Учрал: Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлгийн гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурал дахь олонхын бүлгийн асуулт ирүүлсэн гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авна. Асуулт асууж, хариулт авах нийт хугацаа 15 минутаас хэтрэхгүй байна. Гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна. Индэрт урья. Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Хөвсгөл, Завхан, Увс, Баян-Өлгий аймгийн иргэдээс ирүүлсэн хүсэлт байгаа юм. Монгол Улсын Газрын тухай хуульд 2023 оны 12 сарын 7-нд өөрчлөлт оруулсан нэмэлт, өөрчлөлт. Энэ яасан гэхлээр зэрэг газар олгохтой холбоотой энэ харилцааг цахим хэлбэрт шилжүүлээд нэгдүгээрт, хялбарчлах, хоёрдугаарт иргэд энэ хүсэлтээ цахимаар гаргах ийм зохицуулалт хийж өгсөн.

Нөгөө талаар энэ цахим хэлбэрээр гаргах боломжийг олгосон мөртөө энэ зөвшөөрлийг олгох эрхийг орон нутагт байсныг нь төвлөрүүлчихсэн ийм байдал үүссэн байна. Өнөөдөр яг энэнтэй холбоотойгоор иргэд хэдийгээр хүсэлтээ гаргасан боловч хүсэлтийн дагуу дараалалд орсон байдлаар газрынхаа жишээ нь

зөвшөөрлийг авч чаддаггүй эзэмших эрхийн гэрчилгээгээ авч чаддаггүй ийм хүнд суртал үүсчихсэн байна гэж байгаа юм.

Тэгээд иргэдийн хувьд ахуй болон амьдралтайгаа холбоотой бас газар эзэмших харилцаа нь хүндэрсэн, зарим иргэдийн хувьд бас энийг бизнесийн харилцаанд орсон байдлаар ашиглах зорилттой байдаг. Тэгэхээр энэ дээр үнэхээрийн хүндрэл учирлаа. Цахим шилжилт нэг талдаа сайн юм шиг мөртөө нөгөө талдаа эрх мэдлийг төвлөрүүлснээс болоод захиргааны хүнд суртал үүсэж байна гэсэн ийм санал, гомдол ирүүллээ. Энийг Ерөнхий сайд таны Засгийн газар хэдийд яаж шийдэх вэ гэсэн ийм асуулт байна.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Зулпхар гишүүний санал маш чухал санал, асуудал байгаа юм. Газар амьдралын үндэс, улсын ч үндэс. Тийм учраас газрын харилцаа их тодорхой зохицуулах шаардлагатай. Ийм учраас хэт төвлөрүүлснээс болоод нэн ялангуяа аймаг, орон нутаг, сум орон нутгийн газар олголт иргэдийн газар эзэмших эрхэд хүндрэлүүд учирч байгаа. Ийм учраас бид 7 дугаар сарын 18-ны Засгийн газрын хуралдаанаар энэ газрын тухай хуульд өөрчлөлт оруулж нэгдүгээрт, хэт төвлөрлийг багасгах, иргэдэд арай хүндрэл чирэгдэл багатай хөдөө орон нутагт нэн ялангуяа газар олголтыг илүү хялбарчлах, оновчтой болгох.

Харин аймаг, Засгийн газрын түвшинд газрын нэгдсэн сангийн төлөвлөлтийн бодлогыг хаана газар тариалан, уул уурхай, мал аж ахуй бэлчээрийн газрынхаа нэгдсэн бодлогыг Засгийн газар дээр барьдаг. Түүнээс газар олголтыг Засгийн газрын хуралдаанаар шийдээд яваад байгаа байхгүй юу. Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар Барилга, хот байгуулалтын яамны харьяа байсан чинь Ерөнхий сайдын харьяанд ирчихсэн. Энийг эргээд төвлөрлийг сааруулах чиглэл, үүрэг өгсөн. Энэ асуудлаар өнгөрсөн долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар би тодорхой үүрэг чиглэл өгч, энэ газар олголтыг Засгийн газрын түвшинд шийддэг биш аймаг, орон нутгийн түвшинд, тэгэхдээ хяналттай, нээлттэй, ил тод байдлаар шийддэг. Зөвхөн цахимаас гадна бодитоор санал, өргөдлийг авч шийддэг нэн ялангуяа хөдөө, орон нутгийн хүндрэлтэй байдлыг харгалзаж үзэж шийдэх ийм тодорхой зохицуулалт хийх үүрэг даалгавар өгсөн. Энэ чиглэлээр манай Бат-Амгалан сайд, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга Батманлай нар бас ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа. Тэн дээр Зулпхар гишүүн бас энэ саналуудыг тодорхой тавиад хэрэгжүүлэхэд анхаарч ажиллаж болно.

Н.Учрал: Зулпхар гишүүн тодруулна.

С.Зулпхар: Ерөнхий сайд болон Засгийн газар үүн дээр их шуурхай ажиллаж байгаад бас талархалтай байна. Бид цахим шилжилтийг хийх ёстой. Нөгөө талдаа цахим шилжилт төрийн үйлчилгээг бас заримдаа авч байгаа иргэдийн хувьд бэрхшээл учруулдаг. Энэ өөрөө цахим соёлтой холбоотой, цахим хэрэглээтэй холбоотой. Тодорхой бүлгүүдийн хувьд бас хүндрэл учруулдаг. Энийг цаашдаа анхаарах нь гэж ойлголоо.

Хоёрдугаарт, ер нь бүх юм нь төвлөрч байгаа нь өөрөө нэг талдаа мэдээллийн системийн хувьд зөв боловч яг шийдвэр гаргах түвшинд анхан шатын

нэгжид шийдвэр гаргах эрхийг нь олгож байх нь зөв байна гэсэн бидэнд ийм сургамж болж байна. Энэ дээр та тууштай ажиллах юм байна гэж ойлголоо. Зөв үү?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь тэгэхдээ цахимжилтыг бас огт үгүйсгэж болохгүй. Цахим хүсэлт нэвтрүүлснээр иргэдийн, иргэдээс шаарддаг 18 төрлийн цаасан баримт бичиг материал цуглуулах хүндрэл арилж, улсын хэмжээнд 18169 иргэн цахимаар газар авах хүсэлтээ тавьж шийдвэрлүүлсэн байгаа. Ер нь тэгэхдээ одоогийн хуульд ч гэсэн Засаг дарга газар олголтын ерөнхий дарааллыг хөндөх эрхгүй ч гэсэн хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны түвшин доогуур зэрэг тусгай хэрэгцээт иргэдийг дэмжих, цахим үйлчилгээний хүртээмжийг хангах хууль, эрх зүйн болон зохицуулалтын 3 боломж байгаа.

1 дүгээрт, цахим хүсэлт гаргах боломж. 2 дугаарт нь цаас тусгайлан газар олгох эрх Засаг даргын түвшинд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, улс, нийслэлийн хөрөнгө оруулалт болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд газар эзэмших эрх олгоход дарааллын зохицуулалт хамаарахгүй гэж заасан. Энэ дээр Засаг даргын эрх байгаа. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар нэгдсэн бодлого, шийдвэрийн хүрээнд уг заалтыг үндэслээд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, амьжиргааны түвшин доогуур хүрэхийн гишүүдэд нэн тэр…/минут дуусав./

Н.Учрал: Тодруулж дуулсан. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууна.

Г.Лувсанжамц: Өдрийн амгаланг айлтгая. Юуны өмнө 9 сард цаг гаргаж уулзсанд баярлалаа. Тухайн үед танд утааг шийдэх боломж болон шийдэл тэгээд хэдий хэмжээний санхүүжилт хэрэгтэй, жил болгон байшин гэрийг дулаалах арга хэмжээг хэрэгжүүлснээр цаашдаа 2028 он гэхэд нийслэлийн агаарын бохирдол 50-аас дээш хувиар буурах боломжтой байна гэсэн шийдлийг танд танилцуулсан. Тэгээд энэнийхээ хүрээнд танд өнөөдөр 2 зүйл дээр асуулга явуулсан. Эхнийх нь 2017 онд баталсан Засгийн газрын 98 дугаар тогтоол агаарын бохирдлыг шийднэ гээд 8 жилийн хөтөлбөр боловсруулсан.

Хоёрдугаарх нь хаврын чуулганаар миний бие ахалж байгаад ажлын хэсгээрээ Их Хурлын тогтоол батлуулсан. 2025 оны Улсын Их Хурлын 57 дугаар тогтоол байгаа. Энэ 2 зүйл дээр хэрэгжилтийн талаар танаас асууя гэж бодож байна.

98 дугаар тогтоолын хувьд 4.1.2 дээр нийслэлийн гэр хорооллын тэлэлтийг зогсоож, яндангийн тоог нэмэгдүүлэхгүй.

4.1.6.Цахилгаан халаагуур ашиглах техникийн боломжийг бүрдүүлэх гэж тусгасан боловч гэж тусгасан боловч өнөөдөр цахилгаан халаагуурт шилжээд утааг бууруулж байгаа өрхүүдийн цахилгаан нь хангалтгүй байна, чанар нь хүрэлцэхгүй байна гэсэн асуудлууд их байна.

4.2.6 дээр гэр, байшингийн дулаалгыг сайжруулж дулааны алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ гэсэн Засгийн газрын зүгээс бодитой төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй гэж ойлгож байна. Миний хувьд Улаанбаатар энийг сүүлийн 3 сарын хугацаанд төвийн 6 дүүргүүдээр тойроод явж байна. Маргаашаас СХД-ээр яваад дулаалах зөв мэдлэг, мэдээллийг мэргэжлийн байгууллагууд олон улсын холбооны байгууллагуудаас хүргүүлье гэсэн байдлаар та бүхний ажлыг дэмжээд явж байна.

Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, дээрээс нь агаарын бохирдлыг бууруулах дотоодын үйлдвэрлэлд татварын хөнгөлөлт үзүүлэх Хот байгуулалтын яамнаас Сангийн сайдад бичиг хүргүүлсэн байгаа гэж ойлгосон. Энэ шийдэл хэзээ гарахаар байгаа бол?

4.5.5 дээр агаар орчны бохирдлын улмаас үүсэх өвчлөлийг бууруулна гэсэн зорилтыг тавьсан.

5.1 дээр агаарын бохирдлыг 80-аас дээш хувиар бууруулна гэсэн 8 жилийн хөтөлбөр дээр зорилгын шалгуур үзүүлэлтийг тавьсан байгаа. Өнөөдөр…/минут дуусав./

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ер нь энэ ногоон санхүүжилтийг дэмжих, ногоон шилжилтийг дэмжих, нэн ялангуяа манайх шиг энэ агаарын бохирдол ихтэй улс, хотын хувьд, Улаанбаатар хотын хувьд энэ цогц бодлого хэрэгтэй. Ийм учраас зөвхөн санхүүжилтээс гадна санхүүжилтийн эрх зүйн орчноос гадна бид энэ орон сууцжуулах урт хугацааны, дунд хугацааны түлш болон дулаалгын цогц шийдэл хийх, богино хугацаанд энэ түлш ойрын хугацаанд агаарын бохирдлыг бууруулах ийм шилжилт шинэчлэлүүд шаардлагатай байгаа. Тэгэхээр Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи баримт бичгийг шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, бусад байгууллагууд орчихсон байгуулан ажиллаж байгаа. Одоогийн ангилал шалгуурыг Зүүн өмнөд Ази болон Европын холбооны таксономитой харьцуулсан судалгаа хийж ажиллаж байна.

Ийм учраас бас таныг Сингапуртай энэ талаар бид гэрээ байгуулж, карбон кредитийн гэрээ байгуулж ажиллаж байгаа. Энэ бол ногоон шилжилтэд ногоон санхүүжилтийг олж авахад энэ дулаалга ч тэр, ногоон орон сууц ер нь товчхондоо Улаанбаатарын агаарын бохирдлыг бууруулах, утааг бууруулах энэ карбон гаралтыг бууруулах, яндангийн тоог бууруулах ийм цогц шийдэл хэрэгтэй. Энэ чиглэлээр банк бус санхүүгийн байгууллагууд байгуулагдаад бас карбон кредитийн ажил хийж байгаа. Энийг бид орон сууцжуулалтын банктай холбож шийдэхээр төлөвлөж ажиллаж байна.

Энэ дээр бас татварын хөнгөлөлт энэ ногоон барилга ба дулаалгыг дэмжсэн энийгээ хийж байгаа өрх айлуудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлдэг ийм хуулийн төслийг Хувь хүний орлогын албан татварын хуулийн төсөлд энэ заалтыг оруулсан. Ер нь ногоон барилгын стандартад нийцсэн орон сууц худалдан авах, барих энэ үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт үзүүлэх хөнгөлөлт үзүүлэхээр энэ

манай татварын реформын ажлын хэсэгт байгаа. Гэр хорооллын айл өрх дулааны алдагдлыг бууруулах…/минут дуусав./

Н.Учрал: Нэмэлт тодруулга 1 минут Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Ажлын хэсэг ажиллаж байгаа юм байна гэж ойлголоо. Карбон кредитээ хэрэгжүүлнэ гэдгийг дэмжиж байна. Гэхдээ энийг хэрэгжүүлэхийн тулд бид нар хэмжих, тайлагнах, баталгаажуулах буюу Эм Ар Ви тогтолцоо нь байх ёстой. 57 дугаар тогтоол дээр үүнийг хэрэгжүүлье гээд үүрэг өгсөн байгаа. Сингапур дээр бид нар хэдийгээр хэлэлцээр хийж байгаа боловч энэ Эм Ар Ви, үндэсний Эм Ар Ви нь байхгүй байх юм бол карбон кредитийг хэрэгжүүлэх боломжгүй байх. Тэгэхлээр энийг хэрхэн ажиллаж байгаа юм оо? Сангийн яаман дээр энэ дээр гаргалгаа байгаа юм болов уу? Байхгүй бол энэ дээр нь бас дэмжиж ажиллахад бэлэн байна. Татварын хууль дээр бас байшин, гэрээ дулаалсан өрхүүдэд татварын буцаан олголтыг олгоно гэсэн заалт туссан байгаад баяртай байна. Тэгээд энэ чуулганаар багтаад энийг батлах боломжтой байгаа болов уу?

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Лувсанжамц гишүүнтэй санал нэг байна. Маш зөв. Гэхдээ энэ бас уур амьсгалын өөрчлөлт болон карбон зах зээлийн дэлхий нийтийн чиг хандлагатай уялдуулаад явбал санхүүжилтийн болон ногоон шилжилтийн бодлого цогцоороо шийдэгдэх дэмжлэг туслалцаа авах, ирэх жил болох дэлхийн цөлжилтийн эсрэг COP17 зохион байгуулах ч гэсэн энийг нэг хэсэг нь болгож ажиллах зорилгоор энэ ажлууд явж байгаа юм.

Тэгэхдээ энэ Сангийн яам биш Эдийн засаг, хөгжлийн яам дээр уур амьсгалын өөрчлөлт ба карбон зах зээлийн хүрээнд Монгол Улсад агаарын чанарыг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлсэн. Ялангуяа энд гэр хорооллын дулаалгын асуудал ч гэсэн тэргүүлэх ач холбогдолтой орж байгаа. Ер нь БНСУ-тай, Сингапуртай, Швейцартай Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дагуу хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж, хэрэгжилтийг хангах хамтарсан хороо байгуулахаар төлөвлөсөн. Энэ нь карбон зах зээлийн бүртгэлийн механизмыг бий болгох суурь болно. Энэ бүртгэлийн механизм нь ер нь хэмжинэ, тайлагнана бол ерөөсөө смарт буюу бүх төлөвлөлтийн суурь зарчмууд шүү дээ. Мэжурибл Майнинг…/минут дуусав./

Н.Учрал: Улсын Их Хурлын гишүүн Отгоны Саранчулуун.

О.Саранчулуун: Сайн байна уу? Манай улс ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх талаар хууль тогтоомжтой. Үүн дээр Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлд илүү олон хувилбарыг тусгасан байгаа. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал гэж явж байгаад хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхлыг хориглоно гэж ингэж заасан байгаа. Гэсэн хэдий ч хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй нийт хүмүүсийн дөнгөж 10 хувь нь өнөөдөр хөдөлмөр эрхэлж байгаа. Засгийн газрын төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэсэн ийм төлөвлөгөө оруулсан байгаа. Энэ дээр ямар арга хэмжээг төлөвлөж байна вэ гэдэг нэгдүгээр асуудал байгаа.

2 дугаарт нь Засгийн газрын төлөвлөгөөний 2.1.1 дээр гэр бүл, хүн амын нийц онцлогт нийцсэн бодлого дотор хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангана гэсэн заалт байгаа. Яг энэ заалтын хүрээнд одоо манай Засгийн газарт ямар төлөвлөгөөг боловсруулсан бэ? Яагаад гэвэл би энийг 2026 оны төлөвлөгөөнөөс хараагүй. Мөн 24 оны ажлын тайлан дээр яг энэ дээр тухайлсан ажлуудыг олж хараагүй байна.

3 дугаар асуулт нь Ерөнхий сайд та хөгжлийн бэрхшээлтэй хүнийг, тэргэнцэртэй нэг хүнийг дагуулаад хотын хамгийн ээлтэй ямар төрийн үйлчилгээгээр орох вэ? Мөн ямар хувийн хэвшлийн үйлчилгээгээр дагуулж орж өдрийн хоолонд орж юм ярьж суух вэ гэсэн ийм 3 дахь асуулт байна.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Саранчулуун гишүүний асуултад ярья. Ер нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 48 холбооноос хамтраад надад хүсэлт тавьсан. 12 сарын 3 бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр гэдгийг та мэдэж байгаа байх. Тэрний өмнө бид бас энэ талаар яриа хэлэлцүүлгүүд ер нь шууд холбогдож холбогдох асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа. Гол нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар төвлөрч байгаа. Энэ боловсролын энэ талаар манай Аубакир сайд ч гэсэн бид 2 ярилцаад энэтэй холбогдоод шууд Засгийн газартай хамтарч ажиллая гэсэн санал тавьсан байгаа.

Ер нь Боловсролын ерөнхий хуульд бол жишээлбэл боловсрол дээр ялгаварлахгүй, тэгш, хүртээмжтэй, гадуурхгүй, нээлттэй байх зарчмыг баримталж, бүх иргэнд боловсрол эзэмших эрхийг тэгш хүртээмжтэй болгоно гэж заасан. Энэ дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт 86 хувьд хүрсэн. Санхүүжилт бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, малчин өрхийн хүүхэд зэрэг ялгаатай хэрэгцээтэй сурагчид ноогдох хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлж санхүүжүүлж байна одоо. Ганцаарчилсан сургалт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамран сургах тойрог харгалзахгүйгээр боловсролын үйлчилгээ үзүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Энэ дээр бас хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нийт хүүхдүүдэд тэгш боломж олгож байгаа зүйл энэ medlee.mn цахим сургуулийг байгуулсан Засгийн газраас. Энэ цахим сургууль бол ахлах ангийн сонгон сурах, судлах хичээлийн багшийн хүрэлцээгүй байдлыг арилгах, хөдөө орон нутагт болон хилийн чанад дахь Монгол хүүхдүүд, тэр дотроо бас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хэл заслын сургалт зэрэгт хамрагдах тэгш боломжийг олгож байгаа.

Боловсрол нөхөн олгох сургалтад 4241 сурагч хамрагдаж байна гэж тоо баримт өгсөн байна. Үүний 392 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Цаашдын төлөвлөгөө бол…/минут дуусав./

Н.Учрал: Нийт хугацаа дууссан байна. 15 минутаас хэтрэхгүй байна гэсэн дэгийн хуультай. Саранчулуун гишүүнд баярлалаа.

Гишүүд ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо үргэлжлээд Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүд асуулт асууж, хариулт авна. Өмнө нь бас урьдчилан нэр ирүүлсэн байгаа. Нийт хугацаа 30 минутаас хэтрэхгүй байна. Ирцэд бүртгүүлсэн дарааллын дагуу асуулт асууна. Пүрэвжавын Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, нийт гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд Улсын Их Хурал дахь ХҮН намын зөвлөлөөс бас тодорхой 2 асуудлаар урьдчилсан хүргүүлсний дагуу би бас өнөөдөр тодорхой асуултуудыг бас асууя гээд бэлдсэн байгаа.

1 дүгээрт, Монгол Улсын 2026-30 оны хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болох энэ хөгжлийн чухал баримт бичгийг Улсын Их Хурлаар батлахаар ингээд хэлэлцээд явж байна. Энэ маань манай Монгол Улсын гадаад худалдааны, хамгийн том гадаад худалдааны эргэлт уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гол түнш болсон БНХАУ-ын энэ 15 дугаар таван жилийн төлөвлөгөө өнгөрсөн 10 сард батлагдсан бас энэнтэй бас тодорхой асуудлууд нь экспортын чиглэл дээр бас уялдсан болов уу гэж бодож 2 энэ дээр бас эхнийхээ асуултуудыг асууя.

1 дүгээрт, Хятадын энэ таван жилийн төлөвлөгөөнд БНХАУ нүүрсний хэрэглээг бууруулах бодлого хэрэгжүүлэхээр тусгасан. Тэгэхээр Монгол Улс нүүрсний экспортын энэ эрэлтэд бас дунд, урт хугацаанд бас сөргөөр нөлөөлөхөөр байна гэж харагдаж байгаа Монгол улсын. Тэгэхээр уг нөлөөллийг энэ таван жилийн төлөвлөгөөнд ер нь яаж тусгасан бэ? Ер нь Засгийн газар энэ дээр бас ямархуу бодлого, чиглэл барьж ажиллаж байгаа вэ гэдэг эхний асуултаа асууя..

Н.Учрал: Ганзориг гишүүн энэ дэг нь 30 минутаас хэтрэхгүй байна гэсэн цөөнхийн гишүүдэд хуваарилчихсан юм байна. Тэгээд 2-хон гишүүний нэр ирсэн учраас энийг асуугаад л тодруулаад л нэмэлт 1 минуттай юм байна шүү дээ. Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Ганзориг гишүүний асуултад хариулъя. Ер нь бид энэ үндсэн чиглэлийг боловсруулахдаа Монгол Улсын нүүрсний экспортын гол зах зээл болох БНХАУ-ын зах зээлийн нөхцөл байдал, таамаглалыг суурь тооцоондоо тусгасан. Дунд хугацааны эрэлтийн таамаглал бол манай холбогдох яаманд судлаачдын таамаглалаар БНХАУ-ын нүүрсний хэрэглээ 2030 он хүртэл одоогийнхоо өсөлтийг хадгална. Түүнээс хойш аажмаар буурах хандлагатай байгаа. Иймд Монгол Улсын 2026-2030 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд гадаад эрэлтийг энэ дээр тооцоод хангалттай үнэлж тооцсон. Энийг яг практик алхам болгож бид БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Чянтай сая уулзахдаа 2 улсын төрийн тэргүүн нарын түвшинд хүрсэн гадаад худалдааг 20 тэрбум долларт хүргэх энэ зорилгоор нүүрсний экспортыг 100 сая тоннд хүргэж хадгалах гэсэн энэ зорилтоо ярилцаж, зарчмын хувьд тохиролцож ажиллаж байна.

Ер нь сүүлийн 10 жилд Хятад улсын нүүрсний импорт 147 хувиар өссөн. 48 сая тонноос 122.3 сая тонн болж нэмэгдсэн. Энэ Хятад улсад нийтлэг тавигдаж байгаа, уул уурхайд тавигдаж байгаа дотоод хяналт, шалгалт чангарсан тул энэ олборлолт буурсан байдаг.

Цаашдаа коксжих нүүрсний экспорт бид нийт хэрэглээнийхээ 15 орчмыг Хятад улс таван жилийн төлөвлөгөөнийхөө үндсэн чиглэлийг баталсан. 15 дугаар таван жилийн төлөвлөгөө бол энэ ирэх 3 сард батлагдана. Тэгээд энийг бас бүс нутгийн интегралчлал, эдийн засгийн интегралчлалтай уялдуулъя, энэ хил боомт, хамтын ажиллагааны хүрээнд уялдуулъя гэдэг саналыг бид БНХАУ-ын Засгийн газарт тавьж ажиллаж байна.

Мэдээж бүс нутгийн интегралчлал, дэд бүтэц, бүх хөгжил бол бүс нутгийн интегралчлалд нэгдэж байж энэтэй харилцан уялдаж байж үр дүнтэй, бодитой хэрэгжинэ. Ийм зорилгоор энийгээ уялдуулах саналыг тавьж манай Шинэ итгэл, эрс-Шинэчлэл гэдэг таван жилийн үндсэн чиглэлийг нэр дурдаж байгаад уялдуулах талаар бас…/минут дуусав./

Н.Учрал: Ганзориг гишүүн.

П.Ганзориг: Үүнтэйгээ холбоотойгоор Монгол Улс экспортынхоо бас бүтцээ төрөлжүүлэх ялангуяа уул уурхай хэт хамаарлыг бууруулах чиглэлээр хөдөө аж ахуйн салбарт жишээлбэл нэлээдгүй хэмжээний хөнгөлөлттэй зээл, татаас, дэмжлэг өгч ажиллаж байгаа. Энэ маань бас яг бодитой үр дүнгээ өгч байна уу үгүй юү гэдэг нь ялангуяа ажлын байрыг нэмэгдүүлж байна уу, экспортын орлогыг өсгөж байна уу гээд энэ бас тодорхойгүй маш нарийн үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай байгаа.

Тэгэхээр ер нь энэ түүхийн бүтээгдэхүүнийг боловсруулаад нэмүү өртөг шингээгээд экспортлох талаар ямар чиглэлийн үйлдвэрүүдийг тухайлбал хээзээ оруулаад ямар хэмжээний бүтээгдэхүүнийг экспортолно гэж тооцож байгаа вэ? Энэ дээр бас тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

Н.Учрал: Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Манай уламжлалт экспортын бүтээгдэхүүнүүдээ сэргээж хөгжүүлэх зорилтын хүрээнд ноос, ноолуур, арьс шир, мах, махан бүтээгдэхүүн бид бас өрсөлдөх чадвартай, дэлхийд өрсөлдөх чадвартай, органик ийм шинэ төрлийн зах зээл болгож хөгжүүлэх зорилт явж байгаа. Яг энэ 3 бүтээгдэхүүнийг экспортолъё л гэдэг зорилгоор энэ 3-тай хамааралтай 347 нэр төрлийн бүтээгдэхүүнийг Евро Азийн 183 сая хүнтэй 2 триллион долларын зах зээлд экспортлох зорилгоор энэ гэрээг манай талын хүсэлтээр тавьж шийдвэрлэсэн. Зарчмын хувьд шийдэл нь гараад явж байна.

Энэ гэрээ хүчин төгөлдөр болоод мөрдөгдөөд ирэхэд манай дайвар бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос, ноолуурын үйлдвэрлэл 100-аас дээш хувиар өснө гэсэн ийм симуляц таамаглалтай. Өөрөөр хэлбэл энэ зах зээлийн тодорхой хэсэгт манайх өрсөлдөх чадвар, органик чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх замаар бид Евро Азийн эдийн засгийн холбооны худалдааны төрөл зээлээр уул уурхайн…/минут дуусав./

Н.Учрал: Дэгийнхээ хуулиар хуралдаанд нэрсээ ирүүлсэн гишүүд 2 минут асуугаад 1 минут тодруулна. Өмнө нь болохоор бүлгийн даргаа цөөнхийн бүлгийн даргыг төлөөлж Жаргалан гишүүн 75 минут мэтгэлцсэн юм байна шүү дээ. Их

Хурлынхан тайлбарлаарай энэ Нараа дарга. Анх бас 15 минут шууд ярилцаж байсан даа.

Харин тийм хурдан Тамгынхан Ерөнхий нарийн бичгийн даргыг томилохгүй бол. Дэг асуумаар байдаг.

Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Энэ экспортын төрөлжилттэй холбоотой манай Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний бас асар их нөөцтэй. Тэгээд энэ Хятадын 15 дугаар таван жилийн төлөвлөгөө энэ коммунист намынхаа ерөнхийдөө хурлаар үндсэн чиглэлээ бол баталсан. Энэ дээрээ бол ногоон эрчим хүч, дижитал эдийн засаг, өндөр технологи, ложистикийн салбарууд гээд энэ салбаруудаа нэлээд хэмжээний хөрөнгө оруулалтууд хийж энэ бодлого чиглэлээ ийш нь чиглүүлж ажиллана гэж заасан.

Тэгэхээр манай Монгол Улсын хувьд эрчим хүчээр дотоодынхоо хэрэгцээг хангаад цаашлаад энэ эрчим хүчнийхээ, ялангуяа сэргээгдэх эрчим хүчнийхээ нөөцийг ашиглаж, экспортын шинэ бүтэц салбар үүсгэж ажиллах ийм бодлого, чиглэл дээр Засгийн газар ямархуу бодлого төсөөлөлтэй байгаа вэ? Хэзээнээс ер нь энэ ногоон эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний экспортыг ямар байдлаар хийнэ гэж бодож байгаа вэ?

Н.Учрал: Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Монгол Улс БНХАУ-ын ногоон дижитал шилжилт хөгжлийн бодлогын хүрээнд уялдуулаад уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр 3 салбарт онцгой ач холбогдол өгч ажиллаж байна.

1 дүгээрт, энэ ногоон эрчим хүч. Бид энэ Монгол улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд эрчим хүчний экспортын хэмжээг 10 Гегабайтад хүргэхээр төлөвлөсөн. Санхүүжилтийг нь нүүрстөрөгчийн кредит карбон кредит сая Сингапуртай гэрээ байгуулсан. Одоо Швейцартай байгуулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд болон ногоон эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэх замаар энэ чиглэлээр манай Шадар сайд бас нэлээн идэвхтэй ажиллаж байгаа.

Дижитал эдийн засаг, логистикийн хүрээнд бид бас хиймэл оюун ухаан, дата төв, дижитал эдийн засгийн чиглэлээр хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Монголын давуу талыг ашиглаж эрчим хүчний үйлдвэрлэл сайжирчих юм бол түүнтэй нийцсэн дата төв, дата центрүүдийг барьж байгуулах энэ чиглэлээр хамтран ажиллах бололцоо гарах юм байна лээ.

2 дахь үндсэн чиглэл нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын баталгаажуулалтыг хийж хэрэгжүүлснээр энэ чиглэлийн экспортоо нэмэгдүүлэхэд анхаарч байна. Одоо махны экспорт гэхэд үндсэндээ нэлээн эрс нэмэгдсэн. 170 сая долларт хүрээд байна. Энэ жил 280 сая доллар хүргэхээр төлөвлөөд махны экспорт нэмэгдэж байна. Ноос, ноолууран бүтээгдэхүүн, самнасан ноолуур нэмүү өртөг шингээгээд самнасан ноолуурын экспорт 247 сая долларт хүрсэн. Махны экспорт нэмэгдэж байна. Энэ маань яваандаа уул уурхайн бүтээгдэхүүнтэйгээ хамт төрөлжиж экспортоо болон төрөлжүүлэх энэ гол бидний

эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн ирэх таван жилд тавьж байгаа зорилгын чиглэлүүдийг нь эрчим хүч экспортлогч, хүнс экспортлогч улс болгох зорилгод нийцэх юм.

Н.Учрал: Энэ чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиа баримтална. Энэ чинь Их Хурлын асуулгын нийт хугацаа 2 цагаас хэтрэхгүй. Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа цөөнхийн бүлэгт 75, олонхын бүлэгт 15, цөөнхийн гишүүд 30 минут гэж заасан. Цөөнхийн бүлэгт оногдсон хугацааны 2-ны 1 хүртэлх хугацааг бүлгийн дарга, бусдыг нь гишүүд, дээрээс нь 112.2 буюу бүлгийн цуварсан асуултын тоог 9-өөс хэтрүүлэхгүй гээд Жаргалан гишүүн сая 8 асуулт асуулаа. Үлдсэн тэр цөөн бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс нэрсээ ирүүлсэн байдлаараа 30 минутад багтаагаад гишүүд нь асуух ёстой. Ганзориг гишүүн л нэрээ ирүүлсэн байгаа юм. Хуульдаа ингээд заачихсан учраас би сая танд бас нэмээд өгчихлөө.

Тэгэхээр нэмэлт асуултуудаа та Ерөнхий сайдаас тухайлан асуугаад тодруулаад явахыг хүсье. Ганзориг гишүүн хуулийг бас ойлгож байгаа байх гэж бодож байна. Тэгээд манай Ерөнхий сайд манай ХҮН намын зөвлөлийн дарга Ганзориг гишүүн нар одоо Ерөнхий сайдыг дагаад Ганзориг гишүүн өөрөөр нь ор. Үлдсэн 8 асуултаа асууна. Орой эсвэл уулзаарай. Ингээд нэмэлт тодруулаад явна. Хэдүүлээ бие биеэ танихгүй хүмүүс шиг байхгүй. Зарим асуултуудаа өрөөнд нь ороод асууж болж байна, утас шөрмөсөөр залгаад асууж болж байна. Энэ чинь олон хэлбэрүүд байна шүү дээ. Ингээд ер нь өнөөдөр Ерөнхий нарийн бичиг энэ тэрээ томилоод энэ дэгээ шийдээд явахгүй бол бас их төвөгтэй болж эхэлж байна шүү.

Ингээд гишүүдэд ирцэд бүртгэгдсэн дарааллын дагуу асуулт асуух зөвшөөрөл өглөө. Индэрт гишүүд асуултаа Ерөнхий сайдаас авсан. Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүд асуулт асууж, хариултыг авч дууслаа.

Улсын Их Хурлын асуулгын цаг дууслаа. Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танд талархаж байгаагаа илэрхийлье. Амжилт хүсье.

Одоо үргэлжлээд хэлэлцэх асуудлууд үргэлжилнэ.

16.00 цаг

Үргэлжлээд энэ Таван жилийн үндсэн чиглэл дээр ажлын хэсгийн бэлтгэсэн та зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураана.

Сая гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Тэгэхээр ирцээ бүрдүүлмээр байна.

Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Санал хураалт явуулна.

Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 210 санал бэлтгэгдсэн байна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт

харьяалагдаагүй тус бүр 2 хүртэлх гишүүн үг хэлж болно. Мөн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан хууль санаачлагч санал хэлж болно. Гишүүдийг танхимд урья. Санал хураалтад бэлтгэе.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн зарчмын зөрүүтэй саналуудыг танилцуулъя.

1.Төслийн 2 дахь заалтын “төлөвлөгөөнд болон” гэснийг “төлөвлөгөөний төсөлд,” гэж, “төсөвт” гэснийг “төсвийн төсөлд” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Пүрэвдорж, Р.Сэддорж, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Р.Батболд, Н.Батсүмбэр, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц М.Мандхай Б.Мөнхсоёл, Ц.Мөнхтуяа, З.Мэндсайхан, Ч.Номин, Н.Номтойбаяр, П.Сайнзориг, О.Саранчулуун, Б.Уянга, Г.Уянгахишиг, Б.Хэрлэн, С.Цэнгүүн, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат. Цаашид ажлын хэсэг гэх.

Бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

1 дүгээр санал. Төслийн 2 дахь заалтын “төлөвлөгөөнд болон” гэснийг “төлөвлөгөөний төсөлд,” гэж, “төсөвт” гэснийг “төсвийн төсөлд” гэж тус тус өөрчлөх. Санал хураалт.

45 гишүүн дэмжиж, 51.7 хувиар дэмжигдлээ.

Төслийн 1 дэх заалтын “үнэлгээний үзүүлэлт” гэсний дараа “, зорилтот түвшин” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 49 нь дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

3.“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэл” батлагдахтай холбогдуулан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах аргачлалыг хуулиар тогтоох, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулах, төлөвлөх, батлах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах цаглавар, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхтэй холбоотой хуулиудын уялдааг хангаж, шаардлагатай хуулийн төслийг боловсруулан 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Улсын Их Хурлын тогтоолоор Засгийн газарт даалгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 47 нь дэмжиж, 54 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр хавсралтын “Өмнөтгөл” хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл /цаашид “Үндсэн чиглэл” гэх/-д үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчдын болон тэдгээрийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн түвшинд тулгамдаж байгаа асуудлыг тогтоож, уг асуудлуудыг шийдвэрлэх арга зам, шийдвэрлэснээр бий болох үр дүн, хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон болно. Шалгуур үзүүлэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой

хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулсан бөгөөд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тус үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь нарийвчлан заасан.

Үндсэн чиглэл нь Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, улс, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн төсөв, цаашлаад байгууллагын стратеги болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг баримт бичгийн суурь болно. Үндсэн чиглэлд тодорхойлсон үр дүнг бодлого, төлөвлөлтийн эдгээр баримт бичигт тусгаж, зорилтот үр дүнг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Үндсэн чиглэл нь “Шинэ итгэл – Эрс шинэтгэл”-д зорьсон “Хүний хөгжил”, “Нийгмийн хөгжил, үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Эдийн засаг, дэд бүтцийн хөгжил”, “Байгаль орчин, ногоон эдийн засаг”, “Төрийн бүтээмж, засаглал”, “Бүсийн хөгжил”, “Үндэсний өрсөлдөх чадвар”, “Шинжлэх ухаан, технологи, хиймэл оюун” гэсэн бодлогын 8 чиглэлээс бүрдэх бөгөөд энэ хүрээнд үндэсний 10 үр дүнд хүрэхээр төлөвлөв.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 49 нь дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.2 дахь заалтыг “Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нийгмийн даатгалын уялдааг сайжруулж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын эзлэх хувийг 20 хувиар нэмэгдүүлнэ.” гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 50 нь дэмжиж, 57.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Боловсролын чанар болон хүртээмжийн ялгааг арилгаж, эрүүл мэндийн тогтолцооны гүйцэтгэлийн хүрээг тогтоож, хүн-төвтэй, хүртээмжтэй, чанартай, санхүүгийн эрсдэлгүй тусламж, үйлчилгээг иргэн бүрд тэгш хүргэж, дундаж наслалтыг 2 насаар нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцсэн хүний нөөцийг бэлтгэн, хүний хөгжлийн үзүүлэлтийг 0.85 оноонд хүргэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 50 нь дэмжиж, 57.5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт “эв нэгдлийг” гэснийг “эв нэгдэл” гэж өөрчилж, “, эх оронч үзлийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 51 нь дэмжиж, 58.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь заалтын “байдлыг бэхжүүлж” гэснийг “байдлыг дэмжиж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 49 нь дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 1 дүгээр хавсралтын 5 дахь заалтын гарчгийн “Засаглал, дижитал шилжилт” гэснийг “Төрийн бүтээмж, засаглал” гэж, 2 дугаар хавсралтын бүлгийн гарчгийн “ЗӨВ ЗАСАГЛАЛ, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ” гэснийг “ТӨРИЙН БҮТЭЭМЖ, ЗАСАГЛАЛ” гэж; төслийн 3 дугаар хавсралтын “ЗАСАГЛАЛ, ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ” гэснийг “ТӨРИЙН БҮТЭЭМЖ, ЗАСАГЛАЛ” гэж; төслийн 4 дүгээр хавсралтын 4.1, 4.2 дахь хүснэгтийн “БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ” гэснийг “БҮСИЙН ХӨГЖИЛ” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Гишүүдийн 50 нь дэмжиж, 57.5 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 2.1.2.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “2.1.2.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.6.7” гэж, “Салбар” баганад “72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” гэж, “Үр дүн” баганад “Ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох” гэж, “Арга зам” баганад “Анхдагч хуулийн төсөл шинээр боловсруулах, батлуулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “2.1.2.4” гэж, “Салбар” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Үр дүн” баганад “Ахмад настныг дахин хөдөлмөр эрхлэхийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ахмад настны (55-70 хүртэлх хөдөлмөр эрхлэлтийн түвшин)” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 38.4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 39.0, 2027: 39.6, 2028: 40.2, 2029: 40.8, 2030: 41.4” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Ажиллах хүчний судалгаа, Үндэсний статистикийн хороо, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батчимэг. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал. Санал хураалт. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал шүү.

39 нь дэмжиж, 48 нь татгалзлаа. Санал дэмжигдсэнгүй.

11.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 1.1.3.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “1.1.3.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.1.34” гэж, “Салбар” баганад “71804 Мэргэжлийн боловсрол” гэж, “Үр дүн” баганад “Мэргэжлийн багшийн хангалт, чанарыг сайжруулна” гэж, “Арга зам” баганад “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар”

баганад “1.1.3.4” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно” гэж, “ТХЗ уялдаа” баганад “4.с.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Индекс” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 2,332.4 (мян.төг) гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 2025 оны түвшнээс дээгүүр, 2027: 2026 оны түвшнээс дээгүүр, 2028: 2027 оны түвшнээс дээгүүр, 2029: 2028 оны түвшнээс дээгүүр, 2030: 2029 оны түвшнээс дээгүүр” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт.

40 гишүүн дэмжиж, 47 гишүүн дэмжсэнгүй. Санал дэмжигдсэнгүй.

12.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 4.1.2.3 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.1.2.3” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “Алсын хараа 2.7” гэж, “Салбар” баганад “72212 Гэр бүлийн хөгжил, хамгаалал” гэж, “Үр дүн” баганад “Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.” гэж, “Арга зам” баганад “Угийн бичгээ хөтлөх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.1.2.3” гэж, “Салбар” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Үр дүн” баганад “Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Угийн бичгээ хөтөлдөг гэр бүл” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Тооцох+3%, 2027: Тооцох+5%, 2028: Тооцох+8%, 2029: Тооцох+10%, 2030: Тооцох+15%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал, Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал. Санал хураалт.

54 гишүүн татгалзаж, 33 гишүүн дэмжиж, 62.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

13.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 35 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “35” гэж, “Төсөл арга хэмжээний нэр” баганад “Боловсролын салбарын багш ажилтныг орон сууцжуулах төсөл” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их

Хурлын гишүүн Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт.

27 гишүүн зөвшөөрч, 60 гишүүн татгалзсан. 69 хувиар санал дэмжигдсэнгүй. 14.

15.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 37 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “37” гэж, “Төсөл арга хэмжээний нэр” баганад “Боловсролын сургалтын байгууллагын сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн үйлдвэр” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт.

32 гишүүн зөвшөөрч, 55 гишүүн татгалзлаа. 63.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

14 алгасаад уншчихсан байна.

Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 36 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “36” гэж, “Төсөл арга хэмжээний нэр” баганад “Багшийн хөгжлийн үндэсний төвийн барилга /Улаанбаатар хот/” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал, Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал. Санал хураалт.

29 гишүүн зөвшөөрч, 58 гишүүн татгалзсан. 66.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

16.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 38 дахь мөр нэмэх:

“Дугаар” баганад “38” гэж, “Төсөл арга хэмжээний нэр” баганад “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын үдийн хоолны хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнсний үйлдвэр” гэж, “Тайлбар” баганад “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах” гэж, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй, Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт.

29 гишүүн зөвшөөрч, 58 гишүүн татгалзсан. 66.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналуудаар санал хураая.

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1.в дэх заалтыг үндэслэн төслийн 4 дүгээр хавсралтын 4.3 дахь хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”, 4.4 дэх хэсэгт заасан “Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Ажлын хэсгээс Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Энэ үндсэндээ гол бас өчигдөр Эдийн засгийн байнгын хороон дээр бид бүхний бас үл ойлголцол үүсгээд ингээд ажлын хэсгийн саналууд унасан гол шалтгаан маань энд байгаа. Энэ өөрөө юу гэхээр зарчим. Бид нар ажлын хэсгийн зүгээс ерөөсөө хуулиа баримталъя, зарчмаа баримталъя. Яг одоо баримтлагдаж байгаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, түүнээс даган гарсан холбогдох журмууд Төсвийн тухай хуулиуд дээр аливаа улсын төсвийн хөрөнгө оруулалт маань ямар ч тохиолдол ТЭЗҮ болоод холбогдох судалгаанууд зайлшгүй хийгдсэн байх ёстой, эдийн засгийн үр ашигтай нь батлагдсан байх ёстой. Ингээд тодорхой энэ хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нь тодорхойлоод, эрсдэлийн үнэлгээг нь хийгээд ингээд юу гэдэг юм эх үүсвэрүүдийг нь тодорхойлогдсон байх ёстой байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бол хуулийн зүйл, заалт тодорхой энийг дагаж гарсан журмынх нь зохицуулалтууд одоо мөрдөгдөж байгаа асуудал байгаа.

Тэгэхээр ажлын хэсэг бол бид нарын хувьд үндсэндээ энэ хуулиа л дагая. Энэ зарчмынхаа дагуу Засгийн газраас оруулж ирсэн тодорхой энэ ТЭЗҮ болоод энэ журмын нийцэл хангаагүй асуудлуудыг хасъя гэдэг саналыг тавьсан байгаад байгаа. Тэгэхээр би бас гишүүдэд ч гэсэн тодорхой хэмжээний үл ойлголцол бол үүссэн байж магадгүй шүү. Хууль дээр тодорхой ийм заалт байгаа. Мөн дээрээс нь холбогдох журмууд дээр нь ийм байгаад байгаа. Яг ийм төслийн иж бүрдлийн мэдээлэл нь чанарын шаардлага хангахгүй ийм асуудал байх юм бол тухайн тэр яаманд нь төсвийн ерөнхийлөн захирагчид нь буцаах энэ бол зохицуулалтууд байгаа юм. Тэгэхээр бид нар дараа дараадаа аливаа том төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлье гэвэл аль болохоор юу гэдэг юм богино хугацаанд ТЭЗҮ нь, асуудлуудыг нь бүрэн дүүрэн шийдвэрлэсэн байх ийм шаардлагатай зохицуулалт байгаа шүү.

Дээрээс нь би Засгийн газрын хувьд тодорхой бас ганц нэг томоохон төслүүдийн асуудлыг бас ярьж байх шиг байна. Эгийн гол гэдэг юм уу энэ төслүүд Оросуудтай ярьж байсан ч гэдэг юм уу. Яг үндсэндээ одоо аваад үзэхээр эдгээр маань тодорхой хэмжээнд ТЭЗҮ болоод төслийн иж бүрдлийн материал бэлэн байдал хангаагүй асуудлууд байгаа. Тэгэхээр бид нар энэ асуудлуудыг одоо бол энэ үзэл баримтлал, үндсэн чиглэл батлагдсаны дараа Улсын Их Хурлаас үүнийг баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тогтоолыг батална. Тэгээд энэ тогтоол дээр тухайн тэр санхүүжилтийн эх үүсвэр нь шийдвэрлэсэн, ТЭЗҮ болоод

төслийн бэлэн байдлыг нь бүрэн дүүрэн хангасан асуудлуудыг энэ хөрөнгө оруулалтын хөтөлбөр, жагсаалтууд тэр явцын дунд ингээд шийдвэрлээд нэмэлт, өөрчлөлт оруулаад яваад байж болно гэдэг энэ заалтыг нь хийж өгч байгаа. Угаасаа хуулиар хориглосон зүйл, заалт байхгүй.

Тэгэхээр нэг талдаа өнөөдөр юу гэдэг юм батлагдаж байгаа энэ хавсралтад орсон бэлэн зураг төсөв, санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн төслүүд энэ чигээрээ 5 жил яваад өөр юм нэмж орохгүй гэсэн тийм үндэслэл байхгүй шүү. Хууль дээр, тогтоол дээр хэзээ ч бид нар нэмэлт, өөрчлөлт оруулж болдог. Гол нь бид нар зарчмаа л баримтлах ёстой. Зарчмын хувьд ямар нэг байдлаар юу гэдэг юм тусгах боломжгүй, одоо магадгүй юу гэдэг юм хуулийн шаардлага хангахгүй, суурь судалгаа, мэдээлэл байхгүй асуудлуудыг энэ үндсэн бодлого, чиглэл дээрээ оруулах боломж, бололцоо байхгүй байгаад байгаа юм.

Нөгөө талдаа гишүүдийн хувьд маань ч гэсэн бас жоохон үл ойлголцол үүсээд байгаа асуудал маань үндсэндээ энэ амин чухал энэ хөгжлийнхөө бодлого дээрээ, үзэл баримтлал дээрээ бид нар энэ төсөв шиг хандаж байгаа асуудал байна. Бид нар энийгээ тодорхой хэмжээнд хуулийн өөрчлөлтийн хүрээнд засварлах зайлшгүй шаардлагатай байгаа. Ингээд Улсын Их Хурлаас бас яг батлах тэр тогтоол дээр ирэх хаврын чуулганаар багтаж хууль хоорондын нийцлүүдийг хангах, Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, мөн бусад энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудын цаглавар болоод энэ хоорондын зөрүүтэй асуудлуудыг цэгцлэх үүрэг даалгаврууд бид нар бас өгч байгаа.

Тэгэхээр одоо бол цааш цаашдаа бид нар бас илүү энэ хөрсөд дээрээ бууж, илүү ТЭЗҮ болоод энэ асуудлуудаа бэлэн байлгах тал дээр Засгийн газраас илүү санаачилгатай ажиллах шаардлагатай байна л гэж үзэж байгаа юм. Тэгэхээр энэ саналыг та бүхэн маань дэмжихгүйгээр унагаагаад ингээд яваарай. Тэгэхгүй бол одоо өргөн баригдсан Засгийн газрын 55 их наяд дээр нэмэх нь дахиад 20 их наядын төслүүд төсөв шиг орж ирэх гээд байгаа асуудал байгаа юм. Энийг дараа Засгийн газар өөрөө шийдэх ёстой гэж харж байгаа.

Н.Учрал: Хууль санаачлагч Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Эрхэм гишүүд ээ, энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль нэлээн бас хатуу зохицуулалттай, нэлээн санкц өндөр. Энэ бодлого, төлөвлөлтийн дагуу улс төрийн намууд хөгжлийн бодлого, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулаагүй бол сонгуульд орохоос нь татах хүртэл ийм санкцтай нэлээн хатуу ийм бодлогын тогтвортой байдлаа хангах гэж гаргасан ийм хууль, эрх зүйн орчин байгаа.

Сая Байнгын хороо болон гишүүдээс энэ 8 гишүүн гэхэд л 7.4 их наядын хөрөнгө оруулалтыг өөрийн тойрог дээр тавьчихсан. Тэгэхээр энэ үндсэн гол хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээний хөгжлийн бодлого хангах гэсэн зорилтоосоо хазайгаад явчихлаа. Ямар нэгэн техник, эдийн засгийн үндэслэлгүй, техник технологийн түвшнийг үнэлсэн, салбарын хөгжлийн үзүүлэлтийн нөлөөллийн тооцоо байхгүй. Шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэрийн санал нь тодорхой бус, эрсдэлийн ямар нэгэн шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй. Ийм байгаа тул бид энэ сая ажлын хэсэгтэй

зөвшилцөөд энэ 4.3, 4.4 дүгээр жагсаалтыг хасаад, хуулийнхаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиа боловсронгуй болгоод ирэх хавар шинээр шаардлагатай техник эдийн засаг, үндэслэл нь баталгаажсан, эх үүсвэр нь баталгаажсан төслүүдээ оруулж ирье гэж ингээд зөвшилцөж сая тохирлоо. Тэгэхээр сая Тэмүүлэн гишүүний, ажлын хэсгийн даргын саналын дагуу дэмжихгүйгээр шийдвэрлэж өгнө үү. Тэгсэн нөхцөлд бусад хойд талын саналууд хэлэлцэхгүй болно гэсэн үг.

Н.Учрал: Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал. Түрүүн уншсан. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

83 гишүүн татгалзсан. 96.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал.

Төслийн 4 дүгээр хавсралтын 4.3 дахь хэсэгт заасан санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай.

Шаардлагагүй болчихсон уу? Хэддүгээр санал хүртэл? 29 хүртэл хураах шаардлагагүй болчхож байна гэж ойлгож байна. Их Хурлын Тамгын газар лавлагаа өгөөрэй. Хэн хариуцаж байна? Ажлын хэсгийн ахлагч та тайлбарлаадах уу? Хэддүгээр заалт хүртэл. Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Энэ саяын санал маань үндсэндээ хуулийнхаа шаардлагыг болоод төслийн ТЭЗҮ, санхүүжилтийн шаардлагуудаа хангаагүй төслүүдийг бид нар хасаж байгаа учраас ар талын 2-28 хүртэлх бусад Байнгын хороод болоод гишүүдээс гаргасан хөрөнгө оруулалт нэмэхтэй холбоотой асуудлууд санал хураагдах шаардлагагүй болж байгаа. Тэгээд төслийнхөө иж бүрдэл бэлэн байдлаа хангаад Засгийн газартаа хүсэлтээ өгөөд тэндээ шийдэгдэх эрх нь ингээд нээгдээд л явна гэсэн үг. Одоо бид нар зарчим болоод, хуулиа бариад ингээд явахгүй бол үндсэндээ хууль маань гууль болох гээд байгаа л ийм л нөхцөл байдал үүсээд байгаа юм. Цаашдаа хөрөнгө оруулалтууд гэдэг зүйл заавал ч үгүй ТЭЗҮ, заавал ч үгүй хуулийнхаа иж бүрдлийг хангасан байх, эх үүсвэрээ бүрдүүлсэн байх ийм шаардлага л байгаа гэсэн үг.

Н.Учрал: Манай Тэмүүлэн гишүүнтэй ажлын хэсэг хариуцлагатай сайн ажилласан байна.

29.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал.

Төслийн 2 дугаар хавсралтын 1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Хувь хүний хөгжлийг дэмжих” гэснийг “Багшийн чанар, хангалтыг сайжруулж, сургалтын хөтөлбөрийг шинэчилж, хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан орчинд суралцах тэгш боломжоор хангах” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

30.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, 1.1.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, 2.1.2.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад

“Боловсролын яам” гэж, 2.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Сангийн яам” гэж тус тус нэмэх, 4.1 дэх дэд заалтын “Үндсэн хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам” гэснийг “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэснийг “Эдийн засаг, хөгжлийн яам, Боловсролын яам” гэж өөрчлөх, 4.1.3.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам” гэж, 4.1.4.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 4.2.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 4.4.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Зам, тээврийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 4.4.1.4 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 4.4.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж, 4.4.3.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 4.4.3.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 4.2.3.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам” гэж, 4.2.5.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам гэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 4.2.5.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж тус тус нэмэх, 4.1.1.2 дахь дэд заалтын “Бодлогын Үндэслэл” баганад “АХ-2.2” гэснийг “АХ-2.2.16” гэж өөрчлөх, “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 5.4.2.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж, 5.7.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Шадар сайдын Ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн)” гэж, 6.2.2.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 6.3.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам” гэж, 7.2.4.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж, 7.8.1.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам” гэж, 8.1.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж, 8.1.2.5 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, 8.1.2.7 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Эдийн засаг, хөгжлийн яам” гэж, 9.1.1.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 9.1.6.1 дэх дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Шадар сайдын Ажлын алба (Гадаадын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа эрхэлсэн)” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

85 гишүүн татгалзаж, санал дэмжигдсэнгүй.

29 дэх заалт дээр 5 гишүүн дэмжиж, 5.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

31.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Эцэг, эхийн оролцоог дэмжих” гэснийг “Монгол хүн болох, монгол ёс заншил, түүх соёлоос суралцахад эцэг, эхийн оролцоог дэмжих” гэж өөрчилж, төслийн 3 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтад дараах шалгуур үзүүлэлт нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 3 дахь мөрөнд “Багш мэргэжлээр төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллах хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад

“2026: Тооцох 5%, 2027: Тооцох+10%, 2028: Тооцох+15%, 2029: Тооцох+20%, 2030: он Тооцох+30%” гэж, “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээлэл, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж,

- “Шалгуур үзүүлэлт” баганын 4 дэх мөрөнд “Багшийн ажиллах орчны стандартын шаардлагыг хангасан сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин: 2024, Түвшин: Тооцох, 2026: Тооцох5%, 2027 он Тооцох10%, 2028: Тооцох15, 2029: Тооцох20, 2030: Тооцох30%” гэж, “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик, тоон мэдээ, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

1 гишүүн дэмжиж, 1.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

32.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж, 2.1.2.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

1 гишүүн дэмжиж, 1.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

33.Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтын 1-ийн 2 дахь “Шалгуур үзүүлэлт” мөрийг хасаж дараах байдлаар өөрчлөх:

“Шалгуур үзүүлэлт” баганын 1 дэх мөрийг “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн бүлэг дүүргэлтийг 35-аас доош байх бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь” гэж өөрчлөн найруулж, “Суурь түвшин” баганад “Түвшин: “76.5” гэснийг “39.7” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: “78” гэснийг “43.8” гэж, “2027: 80” гэснийг “48.8” гэж, 2028: “82” гэснийг “56.8” гэж, 2029: “84” гэснийг “61.8” гэж, 2030 онд: “88” гэснийг “70” гэж,

“Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлт, сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /аймаг/” гэснийг “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн бүлэг дүүргэлтийг 35-аас доош байх бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /орон нутаг/” гэж, “Суурь түвшин” баганад “Түвшин: “97” гэснийг түвшинг “82.2” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 98” гэснийг “84.7” гэж, “2027: 98.5” гэснийг “87.7” гэж, “2028: 99” гэснийг “92.7” гэж, “2029 он: 99.5” гэснийг “99.7” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

2 гишүүн дэмжиж, 2.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

34.Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганад дараах 5 мөр нэмэх:

- “Шалгуур үзүүлэлт” баганын 3 дахь мөрөнд “Багш мэргэжлээр төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллах хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” “Зорилтот түвшин” баганад “2026:

Тооцох5, 2027: Тооцох10, 2028: Тооцох15, 2029 он Тооцох20, 2030 он Тооцох %” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Боловсролын яам, Мэдээлэл цуглуулах орон зай: Салбарын тайлан, Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам, Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж;

166.Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах.Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт.

167.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах” гэснийг “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэснийг “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж өөрчилж; 3 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно” гэж, “ТХЗ уялдаа” баганад “4.с.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Индекс” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 2,332.4 (мян.төг)” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 2025 оны түвшнээс дээгүүр, 2027: 2026 оны түвшнээс дээгүүр, 2028: 2027 оны түвшнээс дээгүүр, 2029: 2028 оны түвшнээс дээгүүр, 2030: 2029 оны түвшнээс дээгүүр” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Статистик тоон мэдээлэл, салбарын тайлан”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Боловсролын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа.

166 дугаар санал 56.1 хувиар дэмжигдсэн.

167 дугаар санал санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа. Санал хураалт.

63.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

168.Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.1 дэх дэд заалтын “Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /нийслэл/” мөрний “Суурь түвшин” баганад Түвшин: “76.5” гэснийг “Т/Бодитоор тооцох/” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: “78” гэснийг “Тооцох+2%” гэж, 2027: “80” гэснийг “Тооцох+4%” гэж, 2028: “82” гэснийг “Тооцох+6%” гэж, 2029: “84” гэснийг “Тооцох+8%” гэж, 2030: “88” гэснийг “Тооцох+10%” гэж, мөн дэд заалтын “Стандартын шаардлага хангасан бүлэг дүүргэлттэй сургуулийн бүлгийн нийт бүлэгт эзлэх хувь /аймаг/” мөрний “Суурь түвшин” баганад Түвшин: “97” гэснийг “Тооцох” /Бодитоор тооцох/” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: “98” гэснийг “Тооцох+2%” гэж, 2027: “99” гэснийг “Тооцох+4%” гэж, 2028: “99” гэснийг “Тооцох+6%” гэж, 2029: “99.5” гэснийг “Тооцох+8%” гэж, 2030: “99.9” гэснийг “Тооцох+10%” гэж тус тус өөрчлөх. Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах. Санал гаргасан.

Санал хураалт. Галбадрах гишүүний санал дэмжигдсэн буюу Эдийн засгийн байнгын хорооны санал дэмжигдсэнгүй. 75.6 хувиар.

169.Төслийн 3 дугаар хавсралтын 1.2. Сая дэмжигдсэн шүү дээ Галаа багш. Аа за. Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Энэ санал ажлын хэсгээс гаргасан 33 дугаар саналтай давхацсан байсан. Тэнд тоо тавьчихсан байсан байна лээ. Тэгээд энэ, тийм учраас би одоо энэ энэ саналыг одоо дахиж санал хурааж өгөхийг хүсэж байна. Татаж байна. Саналаа татаж байна. Татахын тулд дахиж санал хураалгах билүү үгүй юү?

Н.Учрал: Галбадрах гишүүний 168 дугаар саналыг татлаа.

169.Төслийн 3 дугаар хавсралтын 1.2.1.4 дэх дэд заалтад доор дурдсан агуулгатай шалгуур үзүүлэлтүүд нэмэх:

“Шалгуур үзүүлэлт” баганад “Эрүүл мэндийн салбарт зарцуулж буй зардлын ДНБ-нд эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 3.2” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 3.5, 2027: 5, 2028: 5.5, 2029: 6, 2030: 6” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн статистик, эрүүл мэндийн хөгжлийн төв, Үндэсний тооцоо”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Захиргааны статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам, Сангийн яам” гэж, мөн “Шалгуур үзүүлэлт” баганад “Засгийн газрын нийт төсөвт эрүүл мэндийн эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 8.3” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 10, 2027: 11, 2028: 11.5, 2029: 12, 2030: 12” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн статистик, эрүүл мэндийн хөгжлийн төв, Үндэсний тооцоо”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Захиргааны статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам, Сангийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан. Санал хураалт.

Дэмжээгүй саналыг дэмжлээ. Дэмжсэн нь 12, татгалзсан 70.

85.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

170.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 1.2.1.7 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “1.2.1.7” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-2.2.5” гэж, “Салбар” баганад “71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ” гэж, “Үр дүн” баганад “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгийг тогтмолжуулна.” гэж, “Арга зам” баганад “Үзлэг, оношилгоо, шинжилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам” гэж; 3 дугаар хавсралтын “ХҮНИЙ ХӨГЖИЛ” бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “1.2.1.7” гэж, “Салбар” баганад “Эрүүл мэндийн яам” гэж, “Үр дүн” баганад “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгийг тогтмолжуулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон хүн ам” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Тооцох+3%, 2027: Тооцох+5%, 2028: Тооцох+8%, 2029: Тооцох+10%, 2030: Тооцох+15%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрүүл мэндийн яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Эрүүл мэндийн яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл. Санал хураалт.

Эдийн. Засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжсэнгүй. Санал босож байна.

92.7 хувиар татгалзсан байна. Мөнхсоёл гишүүний санал босож байна гэсэн үг.

171.Төслийн 2 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Багшийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах” гэснийг “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтоож, бусад нийгмийн баталгааг сайжруулах” гэж өөрчилж, “Хамтран хариуцагч” баганад “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам” гэж; 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2 дахь мөрөнд “Багшийн үндсэн цалинг улсын дундаж нэрлэсэн цалингаас дээгүүр тогтооно” гэж, “ТХЗ уялдаа” баганад “4.с.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Индекс” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин 2,332.4 (мян.төг) гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 2025 оны түвшнээс дээгүүр, 2027: 2026 оны түвшнээс дээгүүр, 2028: 2027 оны түвшнээс дээгүүр, 2029: 2028 оны түвшнээс дээгүүр, 2030: 2029 оны түвшнээс дээгүүр” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Үндэсний статистикийн хороо, Боловсролын яам” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Статистик, тоон мэдээлэл, салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Боловсролын яам” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа гишүүний санал босож байна. 68.7 хувиар Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжсэнгүй.

172.Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь” гэсэн мөрний “Зорилтот түвшин” баганад 2027: “36” гэснийг “32” гэж, 2028: “51” гэснийг “40” гэж, 2029: “71” гэснийг “50” гэж, 2030: “96” гэснийг “65” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Галбадрах. Санал хураалт .

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 13 гишүүн дэмжиж, 15.7 хувь дэмжигдсэнгүй.

173.Төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 1.3 дахь дэд заалт нэмэх:

“1.3.Улсын хөгжлийн тэргүүлэх салбар болсон боловсролын салбарын санхүүжилтийг хүртээмжтэй, тогтвортой өсгөх зорилгоор жил бүр тухайн жилийн Төсвийн тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр тооцоолсон дотоодын нийт бүтээгдэхүүний зургаагаас доошгүй хувийг, эсхүл улсын төсвийн нийт зардлын хориос доошгүй хувийг боловсролын салбарт зарцуулахаар төлөвлөж хэрэгжүүлнэ.”.

Ийм санал байж болохгүй шүү. Тэгээд энэ бол Мөнхтуяа гишүүний олон санал болсон хэдий ч энэ бол бас Төсвийн хуулийн зөрчил болохоор байна. Энэ дээр Тэмүүлэн гишүүн тайлбар хийх үү? Ажлын хэсэг Тэмүүлэн гишүүн тайлбар хийе.

Г.Тэмүүлэн: Энэ бас юу гэдэг юм яг Засгийн газраас орж ирсэн төсөл дээр байгаагүй. Энэ асуудлаар ДНБ 6-аас доошгүй хувийг улсын төсвийн нийт зардлын 20-оос доошгүй хувийг боловсролын салбарт гээд байгаа. Тэгэхээр бид нар ирэх таван жилийн хугацаанд ийм шилжилтийг нэг талдаа бас хийж болохгүй гэдгийг би бас хэлэх байх нь. Тэгэхээр болж өгвөл энэ саналаа татаад мэдээж бид нар боловсролын салбараа дэмжинэ. Гэхдээ боломж, бололцоогүй зүйлийг хийх, тооцоо судалгаагүй хийх бас боломж, бололцоогүй байгаа л гэдгийг би бас хэлэх байна.

Тэгэхээр одоо бол ажлын хэсгийн саналууд дууссан. Дандаа хувь гишүүдийн саналууд байгаа. Энэ болгон дээр бид нар хариуцлагатай хандаад дандаа ингээд Эдийн засгийн байнгын хорооныхоо саналыг ногоон болгоод дэмжээд явах шаардлагатай байна л гэж хэлэх байна.

Н.Учрал: Манай Мөнхтуяа гишүүн ер нь багш нарын асуудлыг ер нь таван жилийн чиглэл дээр ч тэр, төсвийн хүрээ, төсвийн төсөл, бүх хэлэлцүүлгийн түвшинд багш нарын асуудал дээр ажил хэрэгч ханддаг шүү. Мөнхтуяа гишүүн санал дээрээ тайлбар хийнэ. Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Ер нь энэ багш нарын цалинг ДНБ-ийхээ 7 хувь, 6 хувь Төсвийн нийт зардлын 20 хувь руу хүргэх ажлаа бид нар бас хиймээр байна. Ер нь олон улсын гэрээ, конвенцод нэгдчихсэн шүү дээ боловсролын салбартаа ингэж зарцуулна гээд. Тэгээд одоо болохгүй л гээд байвал болохгүй, болгоё гэвэл болно л гэж бодож байна. Тэгэхдээ яах вэ энэ удаа би энэ саналаа татъя аа.

Н.Учрал: 173 дугаар саналыг Мөнхтуяа гишүүн татлаа.

174.Төслийн 1 дүгээр хавсралтад доор дурдсан агуулгатай 2.3 дахь дэд заалт нэмэх:

“2.3.Дундаж давхаргыг дэмжиж, өрхийн бодит орлогыг хамгаалж, нийгмийн хамгааллын оновчтой тогтолцоогоор өрхийн орлогод үүсэх эрсдэлийг бууруулан, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлын түвшнийг 15.0 хувьд хүргэнэ.”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл. Санал хураалт.

Мөнхсоёл гишүүний гаргасан саналыг 28 гишүүн дэмжиж, 33.7 хувь дэмжсэн байна. Ингээд Мөнхсоёл гишүүний санал босож байна гэсэн үг.

175.Төслийн 2 дугаар хавсралтын 3.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт

Мандухай гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг 17 гишүүн дэмжиж, 20.5 хувь нь дэмжлээ. Ингээд Мандхай гишүүний санал одоо босож байна гэсэн үг.

1.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 4.2.5.5 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.2.5.5” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн” баганад “Мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлт буурч, иргэдийн хор уршгийн талаарх мэдлэг, боловсрол нэмэгдэж, урьдчилан сэргийлэх зан үйл төлөвшиж, хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц багасна” гэж, “Арга зам” баганад “Илрүүлэх, шинжилгээний чадавхыг сайжруулж, лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, хилийн боомтын хяналт шалгалтыг бэхжүүлж, илрүүлэх төхөөрөмж суурилуулах, хууль бус эргэлтийн мэдээллийн системийг сайжруулж, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай болгох, иргэдийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх сурталчилгаа зохион байгуулах, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх.” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын яам, Боловсролын яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “4.2.5.5” гэж, “Салбар” баганад “Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж, “Үр дүн” баганад “Мансууруулах бодисын хэрэглээ болон хууль бус эргэлт буурч, иргэдийн хор уршгийн талаарх мэдлэг, боловсрол нэмэгдэж, урьдчилан сэргийлэх зан үйл төлөвшиж, хэрэглэгчдийн тоо мэдэгдэхүйц багасна” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Тус гэмт хэрэгт холбогдож буй хүний тоо” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: Тооцох” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: Тооцох-10%, 2027: Тооцох-20%, 2028: Тооцох-30%, 2029: Тооцох-40%, 2030: Тооцох-50%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Хууль зүй, дотоод хэргийн яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа. Санал хураалт.

Одонтуяа гишүүний зарчмын зөрүүтэй саналыг 24 гишүүн зөвшөөрч, 28.6 хувь нь Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжсэн тул Одонтуяа гишүүний санал босож байна.

176.Төслийн 2 дугаар хавсралтын 4.4.3 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэсний дараа “, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт.

Мандхай гишүүний зарчмын зөрүүтэй саналыг Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй саналыг 19 хувь, 16 гишүүн дэмжиж, Мандхай гишүүний санал босож байна.

177.Төслийн 2 дугаар хавсралтын 5.1.2.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Нийлүүлэлтийн сүлжээг өргөтгөх” гэсний дараа “, хүний нөөцийг бэлтгэх (анхан, дунд, дээд шатанд), ажлын байрыг баталгаажуулах” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 15 гишүүн дэмжиж, 17 хувь нь, 15 гишүүн буюу 17.9 хувь нь дэмжсэн байна. Ингээд Мандхай гишүүний санал босож байна.

178.Төслийн 2 дугаар хавсралтын 5.3.1.2 дахь дэд заалтын “Хамтран хариуцагч” баганад “Шадар сайдын ажлын алба (Бүсчилсэн хөгжил, онцгой

байдлын асуудал эрхэлсэн)” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 14 гишүүн дэмжиж, 16.7 хувь нь дэмжсэн байна. Мандхай гишүүний санал босож байна гэсэн үг.

179.Төслийн 2 дугаар хавсралтын 5.3.1.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Селекц, үржил, генетикийн хяналтыг сайжруулах биотехнологийн ололтыг нэвтрүүлэх” гэснийг “Бэлчээр тэжээлийн нэг болон олон наст ургамлын үрийн генфондыг бий болгох, үр үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэжээлийн таримлын технологийг нэвтрүүлж, малын тэжээлийн баазыг бэхжүүлэх, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэгж бүтээгдэхүүнд зарцуулах тэжээлийн зардлыг бууруулахад чиглэсэн дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, нутагшуулах” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 13 гишүүн буюу 15.5 хувь нь дэмжсэн байна. Мандхай гишүүний санал мөн босож байна гэсэн үг.

180.Төслийн 2 дугаар хавсралтын 5.3.1.3 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх” гэсний дараа “, хөрсний үржил шимийг сайжруулах, ган, чийгт тэсвэртэй үр сортыг бий болгож, тариалах” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүй болгоё. Улсын Их Хурлын гишүүн Мандхай.

М.Мандхай: Энэ 180 дугаар санал ажлын хэсгийн бас саналд орсон байгаа тул энийг татаж өгнө үү гэж хүсэж байна.

Н.Учрал: 180 дугаар саналыг Улсын Их Хурлын гишүүн Мандхай татаж авч байна. 180 дугаар саналыг татлаа.

181.Төслийн 2 дугаар хавсралтын 5.4.1.1, 5.4.1.2 дахь дэд заалтуудын “Хамтран хариуцагч” баганад “Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 13 гишүүн 15.5 хувь нь дэмжсэн байна. Мандхай гишүүний санал мөн босож байна.

182.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 5.6.1.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “5.6.1.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2” гэж, “Салбар” баганад “70901 Дулаан, цахилгаан эрчим хүч” гэж, “Үр дүн” баганад “Цахилгаан эрчим хүчний зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулна.” гэж, “Арга зам” баганад “Цахилгаан эрчим хүчний бөөний өрсөлдөөнт зах зээл рүү үе шаттай шилжих.” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар”

баганад “5.6.1.4” гэж, “Салбар” баганад “70901 Дулаан, цахилгаан эрчим хүч” гэж, “Үр дүн” баганад “Цахилгаан эрчим хүчний зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Цахилгаан эрчим хүчний нийлүүлэлтэд өрсөлдөөнт зах зээлийн эзлэх хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2025, Түвшин: 0%” гэж, “Зорилтот түвшин” баганад “2027: 0.1%, 2028: 1%, 2029: 5%, 2030 он: 10%” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Эрчим хүчний яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Захиргааны статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Эрчим хүчний яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг, Золжаргал, Цэнгүүн. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 13 гишүүн дэмжиж, 15.5 хувиар дэмжсэн тул санал дэмжигдсэнгүй. Санал босож байна.

183. Төслийн 2 дугаар хавсралтын 6.3.1.1 дэх дэд заалтын “Арга зам” баганад “Олон талын оролцоонд суурилсан ой хамгааллыг дэмжих” гэсний дараа “, дөрөйтсон бэлчээрийг ойжуулах ойн бэлчээр үүсгэн, уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 16 гишүүн дэмжсэн. 19 хувиар дэмжсэн тул санал босож байна.

Манай яамныхан энэ ажлын хэсгийнхэн энэ зүгээр үү юу болоод байна? Одоо нэгтгээд уншихаар уншигдахгүй юм л болох вий дээ. Харин тийм одоо бас ийм олон тал талаас санал гаргачихаар нэгтгээд 1 бичиг баримт болохоор уншихаар ойлгогддоггүй талтай шүү дээ. Тийм. Тэрийгээ манай ажлын хэсгийнхэн бас хэлж яриад Энхбаяр сайд тайлбар тавиад явахгүй бол. Агуулга нь уг нь зөв л юм байна гэж бодоод л явж байна. Тэгэхдээ гол нь уншигдах уу үгүй юу?

184.Төслийн 2 дугаар хавсралтын 6.3.1.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Усны нөөцийн зохистой ашиглалтыг дэмжих” гэсний дараа “, нэн ховор болон ховордсон загасыг унаган орчинд нь нөхөн сэргээх, үржүүлэх” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэсний дараа “, Боловсролын яам” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандухай. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 15 гишүүн дэмжиж, 17.9 хувиар санал зөвшөөрсөн тул санал мөн босож байна.

186.Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 6.3.1.6 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “6.3.1.6” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-6.3” гэж, “Салбар” баганад “71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент” гэж, “Үр дүн” баганад “Экосистемийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөв цөөрөм, усан сан, нуур байгуулна.” гэж, “Арга зам” баганад “333 нуур- нэг сум, нэг нуур- усны нөөцийн хуримтлал бий болгож уур амьсгалын өөрчлөлтөөс сэргийлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Байгаль

орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Усны газар” гэж; 3 дугаар хавсралт, арван юу гэж байгаа юм энэ?

...Хавсралт “Дугаар” баганад “6.3.1.6” гэж, “Салбар” баганад “71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент” гэж, “Үр дүн” баганад “Экосистемийн тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөв цөөрөм, усан сан, нуур байгуулна.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Шинээр байгуулсан хөв цөөрөм, усан сан, нуур” гэж, “ТХЗ-ын уялдаа” баганад “13.1” гэж, “Хэмжих нэгж” баганад “Тоо” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2025, Түвшин: 4” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 54, 2027: 104, 2028: 154, 2029: 204, 2030: 259” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам”, “Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын статистик”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Жил тутам”, “Хариуцах байгууллага: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхбаясгалан. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 25 гишүүн зөвшөөрч, 29.8 хувиар зөвшөөрөгдсөн буюу дэмжээгүй санал чуулганы хуралдаанаас босож байна гэсэн үг.

185.Төслийн 2 дугаар хавсралтын 6.3.1.5 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх” гэсний дараа “(Мал бордох аж ахуй, малчдын бууцаар органик бордоо үйлдвэрлэх цех, үйлдвэрүүдийг орон нутагт байгуулах, үйлдвэрлэсэн бордоогоор нь бэлчээр болон тариалангийн талбайн хөрсөө бордох, үржил шим, бүтээмжийг нэмэгдүүлэх)” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 21 гишүүн зөвшөөрсөн байна. 63 гишүүн татгалзсан. 75 хувь нь татгалзсан тул санал босож байна гэсэн үг.

Манай намын бүлгүүд гишүүдийн ирцэд анхааръя. Дамдинням сайд аа дараа нь Стратегийн бүтээгдэхүүний хууль хэлэлцэнэ шүү дээ. Ирцээ бүрдүүл. Ирцээ бүрдүүлье. Дараа нь эцсийн хэлэлцүүлэг биз дээ?

187.Төслийн 2 дугаар хавсралтын 4.2.4.2 дахь дэд заалтын “Арга зам” баганад “Авьяасыг тасралтгүй хөгжүүлэх” гэсний дараа “хичээлийн дараах хөтөлбөр хэрэгжүүлэх” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пунсалмаа. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 69 гишүүн татгалзаж, 82.1 хувь нь татгалзсан тул босож байна.

188. Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 8.2 дахь дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “8.2” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-5.2, 8.2” гэж, “Салбар” баганад “Бүх салбар” гэж, “Үр дүн” баганад “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Хууль, эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх”

гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж; 3 дугаар хавсралтын бодлогын чиглэлийн “Дугаар” баганад “8.2” гэж, “Салбар” баганад “Бүх салбар” гэж, “Үр дүн” баганад “Улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хот, тосгоны эрх зүйн байдлыг зохицуулсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлт” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026: 100, 2027: 100, 2028: 100, 2029: 100, 2030: 100” гэж, “Мэдээллийн үзүүлэлтүүд” баганад “Мэдээллийн эх сурвалж: Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийн тайлан”, **“**Мэдээлэл цуглуулах арга зүй: Салбарын тайлан”, “Мэдээлэл цуглуулах давтамж: Хагас жил тутам”, “Хариуцах байгууллага: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 24 гишүүн зөвшөөрч, 28.6 хувиар зөвшөөрсөн тул санал дэмжигдсэнгүй. Санал босож байна.

189.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 7 дахь дэд заалтын “Төсөвт өртөг /сая төгрөгөөр/” баганад “468,000.0” гэсний харгалзах мөрний “2026” баганад гэснийг “93,600.0” гэж, “2027” баганад “93,600.0” гэснийг “81,895.0” гэж, “2030” баганад “210,610.0” гэснийг “128,715.0” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах. Санал хураалт.

Байнгын хорооны дэмжээгүй саналыг 11 гишүүн зөвшөөрч, 13.1 хувь нь зөвшөөрсөн тул санал босож байна.

190.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 7 дахь дэд заалтын “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатарт 41” гэснийг “Улаанбаатарт 31” гэж, мөн хавсралтын “4.2.Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-ийн 7 дахь дэд заалтын “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатарт 41” гэснийг “Улаанбаатарт 31” гэж, шалгуур үзүүлэлт баганын 1 дэх мөрний “2030” баганад “80” гэснийг “100” гэж, шалгуур үзүүлэлт баганын 2 дахь мөрний “2026” баганад “0” гэснийг “10” гэж, “2027” баганад “0” гэснийг “35” гэж, “2028” баганад “1” гэснийг “60” гэж, “2029” баганад “1” гэснийг “80” гэж, “2030” баганад “1” гэснийг “100” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан. Улсын Их Хурлын гишүүн Галбадрах. Санал хураалт.

Эдийн засгийн. Байнгын хорооны дэмжээгүй саналыг 15 гишүүн зөвшөөрч, 17.9 хувиар зөвшөөрөгдсөн тул санал босож байна.

191.Төслийн 4 дүгээр хавсралтын. Айн. Тэмүүлэн гишүүн. 100-н. Галбадрах гишүүний микрофоныг өгье.

Ж.Галбадрах: Түрүүн дэмжигдсэн байсан, боссон 172 дугаар санал одоо өмнө нь ажлын хэсгийн саналтай бас давхардсан байсан учраас энийгээ би татаж байна саналаа. 172-ыг.

Н.Учрал: 172 дугаар саналыг санал гаргасан Их Хурлын гишүүн Галбадрах татлаа. Санал татагдлаа.

Тэмүүлэн гишүүн 190-ээс хойш санал хураах уу?

Г.Тэмүүлэн: Энэ 192-оос хойших саналууд энэ дандаа яах вэ санхүүжилт, төсөвт өртөгтэй жишээлээд хэлэхэд 192 дээр жишээ нь сум хоорондын замууд байгаад байгаа. Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаан хайрхан, Баруунтуруун гээд 164.5км, 343.6 тэрбумын өртөгтэй гээд. Тэгэхээр үндсэндээ бид нар энэ үндсэн чиглэл гэдэг энэ зүйл маань өөрөө хөгжлийн бодлого байгаа. Тэгээд энийг бид нар нэг талдаа төсвийн бодлого шиг, эсвэл төсөв санхүүжилтийн асуудлыг эх үүсвэрийг шийдэх байдлаар, төсөв байдлаар ойлгож болохооргүй байна. Тэгэхээр бид нар нэг талдаа энэ асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам нь өөрсдөө эрэмбэлээд ямар төсвийг, ямар хөрөнгө оруулалтыг, ямар хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг оруулж ирэх нь өөрсдөө шийдэх нь зөв.

Тэгэхээр би бол хэлэх нь сүүлийн 4 саналыг гаргасан гишүүд маань өөрсдөө саналуудаа татах нь зүйтэй гэж бас харж байгаа. Нэг талдаа энэ хөгжлийн төлөвлөгөө биш хөөсөрсөн одоо төсвийн мөрөөдлийн жагсаалт болчих вий дээ гэсэн ийм болгоомжлол байна.

Нөгөө талдаа бид нар хэрэв боомтын зам гэдэг юм уу, эсвэл тэр тухайн тэр юу гэдэг юм бүс нутгийн хөгжил дэмжих зам байсан бол бас ойлгож болно шүү дээ. Гэтэл магадгүй сум хоорондын зам маягтай иймэрхүү асуудлуудыг, дээрээс нь ТЭЗҮ байхгүй бол, хуулийн шаардлага хангаагүй бол бид нар авах боломж, бололцоо байхгүй. Тэгэхээр санал гаргасан гишүүд нь өөрсдөө тайлбараа хэлээд саналуудаа татвал уул нь сайн байна гэдгийг бас хэлэх байна.

Н.Учрал: 191 дүгээр саналыг Улсын Их Хурлын гишүүн Золжаргал гаргасан. 192 дугаар саналыг Улсын Их Хурлын гишүүн Заяабал гаргасан. 193-ыг Улсын Их Хурлын гишүүн Бадамсүрэн гаргасан. 194-ийг Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг, Сэддорж нар гаргасан. Энэ 4 саналыг энийг Байнгын хороо руу чиглэл өгөөд буцаачих уу? Тэгээд Байнгын хороон дээр татах бол. Бадмаа гишүүн саналаа, Заяабал гишүүн, Золжаргал гишүүн. 191 дүгээр саналыг хураалгая даа тэгээд.

191.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 50 дахь мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 50 дахь мөр тус тус нэмэх:

- 4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “50” гэж, “Бүс, аймаг” баганад “Говийн бүс: Өмнөговь” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, “Үр дүн” баганад “5.1.1” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2029” гэж, “Төсөвт өртөг баганад “75,645.7” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад гэж, “2026-2030” баганад гэж, “2026” баганад “5 сая” гэж, “2027” баганад “40 сая” гэж, “2028” баганад “26,845.0” гэж, “2029” баганад “3,782.3” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Шууд хөрөнгө оруулалт” гэж, “Хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж;

- 4.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийн “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “50” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2029” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Барилга угсралтын ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь“ гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, “2026” баганад “7” гэж, “2027” баганад “53” гэж, “2028” баганад “95” гэж, “2029” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Гишүүд анхааралтай. Санал хураалт.

Уянгахишиг гишүүн микрофон өгье.

Г.Уянгахишиг: Сая яг дарж амжилгүй хугацаа нь дуусчихлаа. Уг нь зөвшөөрөхийг дарсан юм. Тийм, тайлбар хүлээж байгаад ногооныг уг нь дарах гээд дарсан чинь яг “0” дээр давхацчихлаа. Тэгэхээр горимын санал гаргаж болох уу? Саналыг хүчингүй болгоод дахиад санал хураалгах.

Н.Учрал: Төхөөрөмж ажиллаагүй гэж ойлголоо. Төхөөрөмж ажиллаагүй тохиолдолд л ингэж горимын санал хураана шүү дээ. Төхөөрөмж ажиллаагүй байна. Уянгахишиг гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Саналыг хүчингүй болгох горимын санал. Горимын санал.

Золжаргал гишүүний гаргасан 191 дүгээр саналаар дахин санал хураалт явуулъя гэдэг горимын санал дэмжигдсэн тул дахин санал хураалтыг явуулъя.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Золжаргал. Санал хураалт.

Гишүүдийн 43 гишүүн дэмжиж, 51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 43 гишүүн дэмжлээ. 51.2 хувиар санал дэмжигдлээ.

192.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 84 дэх мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 84 дэх мөр тус тус нэмэх:

- 4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ” хэсгийн “Дугаар” баганад “84” гэж, “Бүс, аймаг” баганад “Баруун бүс, Увс” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн 164.5км хатуу хучилттай авто зам” гэж, “Үр дүн” баганад “5.7.1.1” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Төсөвт өртөг /сая.төг/” баганад “343,642.7” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад гэж, “2026-2030” баганад “343,642.7” гэж, “2026” баганад “10,000.0” гэж, “2027” баганад “110,000.0” гэж, “2028” баганад “110,000.0” гэж, “2029” баганад “70,000.0” гэж, “2030” баганад “43,642.7” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Улсын төсөв” гэж, “Хариуцагч” баганад “Зам, тээврийн яам” гэж;

- 4.2 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтийн “БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ” хэсгийн “Дугаар” баганад “84” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн 164.5 км хатуу хучилттай авто зам” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь“ гэж, “Суурь түвшин” баганад “0” гэж, “2026” баганад “2.9” гэж, “2027” баганад “35.9” гэж, “2028” баганад “67.9” гэж, “2029” баганад “88.3” гэж, “2030” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Зам, тээврийн яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүд Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 45 гишүүн дэмжиж, 53.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Бадамсүрэн гишүүний.

193.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 88 дахь мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 88 дахь мөр тус тус нэмэх:

4.1 дэх хэсгийн жагсаалтын “ЗАСАГЛАЛ” хэсгийн “Дугаар” баганад.

Би тат гээгүй шүү. Бадамсүрэн гишүүн.

М.Бадамсүрэн: 193 дугаар саналаа татах саналтай байна. Хүлээж авна уу.

Н.Учрал: Бадамсүрэн гишүүн 193 дугаар саналаа татаж авлаа. 193 дугаар саналыг татагдсанд тооцлоо.

194 энэ саналыг санал хураасны дараа санал хураалт үргэлжилнэ. Өнөөдөр энэ хуулийг, таван жилийн чиглэл Их Хурлын тогтоолыг 50+1-ээр эцэслэн батална. Хуультай шүү. Гишүүдийг урья. 65 хүрнэ. Заавал хүрэх ёстой.Тэгэхгүй бол Их Хурал өөрөө хууль зөрчих байдалд орж байгаа шүү. Энэ Засгийн газрын ажил биш одоо Их Хурлын ажил болсон шүү. Манайхан, гишүүд ээ гишүүдийгээ уриарай.

194.Төслийн 4 дүгээр хавсралтын 4.1 дэх хэсэгт заасан “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт”-д доор дурдсан агуулгатай 51 дэх мөр, мөн 4.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын 2026-2030 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”-д 51 дэх мөр тус тус нэмэх:

- 4.1 дэх хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “51” гэж, “Бүс, аймаг” баганад “Улаанбаатар, төв” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл” гэж, “Үр дүн” баганад “5.6.1.1, 6.2.2.2” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Төсөвт өртөг баганад “3,560,000.0” гэж, “Санхүүжилтийн гүйцэтгэл” баганад гэж, “2026-2030” баганад “3,560,000.0”, “2026” баганад “0” гэж, “2027” баганад “356,000.0” гэж, “2028” баганад “1,424,000.0” гэж, “2029” баганад “1,424,000.0” гэж, “2030” баганад “356,000.0” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэр” баганад “Гадаад зээл” гэж, “Хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж;

- 4.2 дахь хэсэгт заасан жагсаалтын “ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛ” хэсгийн “Дугаар” баганад “51” гэж, “Төсөл, арга хэмжээний нэр” баганад “Улаанбаатар хот орчмын цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн төсөл” гэж, “Санхүүжилтийн хугацаа хэрэгжих он” баганад “2026-2030” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Ажлын явц” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь“ гэж, “Суурь түвшин” баганад гэж, “2026” баганад гэж, “2027” баганад “10” гэж, “2028” баганад “50” гэж, “2029” баганад “90” гэж, “2030” баганад “100” гэж, “Хариуцагч” баганад “Эрчим хүчний яам” гэж. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг, Сэддорж.

2 гишүүн санал гаргасан. Хоёулаа татах ёстой юм. Тэгэхээр санал хураалт явуулна. Санал хураалт явуулна шүү.

Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг, Сэддорж нарын гаргасан зарчмын зөрүүтэй санал. Санал хураалт.

Засгийн газраас Таван жилийн үндсэн чиглэлийг Их Хуралд өргөн мэдүүлсэн. Тэгээд анх өргөн мэдүүлэхдээ энэ үндэсний үр дүн, салбарын үр дүн, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн гээд индикаторуудыг тавиад явсан байсан. Саналын явцад сая өнөөдөр бараг 200 санал хураалаа. Нийлүүлээд нэгтгээд харахаар юу болсон байгааг таашгүй байна. Тэгэхдээ Тэмүүлэн гишүүнтэй ажлын хэсэг сайн ажилласан. Талархаж байна. Ер нь Занданшатарын Засгийн газар байгуулагдсан цаг үеэс хойш Засгийн газар энэ таван жилийн үндсэн чиглэлийг энэ шинжлэх ухааны салбарынхан, эрдэмтэн судлаачид, бүх талын үүрэг оролцоог хангавал сайн ажилласан шүү.

Тэгэхээр бас төрийн албан хаагчдадаа талархах хэрэгтэй. Манай Эдийн засаг, хөгжлийн яам бүрэн бүрэлдэхүүнээрээ таван жилийн чиглэлд ажиллалаа. Ингээд ажлын хэсэгт ажилласан Эдийн засаг, хөгжлийн яам, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Сүрэнхорол, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мөнхтөр, Бизнес орчны бодлогын газрын дарга Балчинлувсан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн дарга Мөнх-Эрдэнэ, ажлын хэсэгт ажилласан хүн бүрд талархал илэрхийлье. Баярлалаа.

Тодотгох залруулж бас хэлэх асуудлууд байна. Зарчмын зөрүүтэй саналын 39 дүгээрт хураагдсан 1.2.1.1 дэх заалтын 7 дахь шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин баганын мэдээллийг дутуу уншсан тул 2026 онд 125.4 гэж, 2027 онд 119 гэж, 2028 онд 112.7 гэж, 2029 онд 106.3 гэж, 2030 он 100 гэж тус тус нэмэх

2.Зарчмын зөрүүтэй саналын 136 дугаарт хураагдсан 9.1 дэх заалтын нэмэгдүүлэх гэж уншсан. Энэ бол “нэмэгдүүлэх” биш “цөөрүүлэх” гэж уншигдах байсныг залруулж байна.

Сүүлийн 194 дүгээр санал Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг 35 гишүүн зөвшөөрсөн. 41.7 хувь нь зөвшөөрсөн. Тэгэхээр энэ санал ингээд босож байх шиг байна.

Мөн энэ Тэмүүлэн гишүүнийг ахалсан ажлын хэсэгт ажилласан бүх гишүүдэд талархаж байна. Дээрээс нь Их Хурлын Байнгын хороо, референтүүдэд талархал илэрхийлье. Энэ олон хүний хичээл зүтгэл шүү. Олон хүний хичээл зүтгэлээр гарч байгаа ажил. Тэрнээс биш тойргийн асуудлаас тусгах гэж энэ жилийн төлөвлөгөө ч бай, таван жилийн чиглэл дээр ч ажиллах зохимжгүй. Цаашдаа бид нар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулиа илүү тодорхой болгож, энэ Засгийн газраас өргөн мэдүүлсэн таван жилийн чиглэл, жилийн төлөвлөгөөг концепцын хувьд өөрчилдөг байдлыг таслан зогсоох ёстой. Тийм учраас Их Хурал Хөгжлийн бодлогын хуульдаа өөрчлөлт оруулж ингэж концепцоор нь өөрчилдөг, янз бүрийн тойргийн сонирхлыг тусгадаг, дараа нь хэрэгжих боломжгүй, хэмжиж болохгүй олон зорилтууд тавьдаг байдлыг халах ёстой гэдгийг бас хэлмээр байна.

Энд хамтран зүтгэсэн хүн болгонд баярлалаа. Эдийн засгийн байнгын хороо Сэддорж даргатай Байнгын хороо зөвлөхүүд, референтүүд бүгдэд талархал илэрхийлье. Одоо эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

21.14 цаг

Бид нарт 3 цаг байна шүү 12 цаг болтол. Гишүүд ээ танхимдаа сууна шүү одоо. Гишүүд танхимдаа. Манай намын бүлгийнхэн танхимдаа сууя. Манай энэ Пүрэвдорж дарга байна, бас Ардчилсан намын гишүүд байна. Доржханд дарга байна. ХҮН намынхан бараг 90 хувьтай байна гэсэн гэж хэлсэн. 100 хувь байгаа. Батбаатар дарга хаачсан? Батбаатар дарга 100 хувь байна. Гишүүд, манай гишүүд суугаарай. Манай намын бүлгийн гишүүд сууя.

Үргэлжлүүлээд 2 асуудал байна. Тэр хооронд Эдийн засгийн байнгын, одоо санал хураалт. Одоо 2 санал хураалт явуулаад үргэлжлээд Эдийн засгийн байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг рүүгээ ороод буцаж орж ирээд чуулганаар эцэслэн батална. Ингээд бүгдээрээ таван жилийн чиглэлээ шинэ сар гарахын өмнө дуусгая.

Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал

Түрүүн өдөр Ардчилсан намын бүлэг 2 цагийн завсарлага авсан. Ардчилсан намын бүлэг 2 цагийн завсарлага 2 цаг 23 минутад дууссан. Завсарлах хугацаа дуусаад одоо 8 цаг 20 минут болж байна. Завсарлагааны хугацаа дууссан. Ингээд завсарлагааны хугацаа дууссан.

Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх асуудлуудыг асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Одоо Байнгын хорооны саналаар нууц санал хураалт явуулна.

Ардчилсан намын 2 цагийн завсарлага дууссан. Завсарлагааны хугацааг сунгах уу?

Завсарлагааны хугацаа дууслаа. Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Их Хурлын гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж дууссан.

Нэр дэвшигчийг танхимд урья. Одоо Байнгын хорооны саналаар нууц санал хураалт явуулна. Эхлээд чөлөөлөх санал хураалтыг явуулна.

Мандхай гишүүн суугаарай суугаарай. Хүмүүс дуудаарай. Гишүүд суудалдаа сууя. Бүлгийн дэд дарга нар ирцээ бүрдүүлье. Ирцээ бүрдүүлье. Нэр дэвшигч танхимд хүрэлцэн ирсэн байна. Хөөе Номинчимэг гишүүн хаана байна? Ирцээ бүрдүүл ээ. Үгүй үгүй энэ чинь таны л дарга байсан хүнийг томилох гээд байна шүү дээ. Тэмүүжин гишүүнийхээ ангийн охиныг томилох гэж бас их л юм болж байна даа. Би одоо ирц бүртгэлийн санал хураалт нэг явуулъя. Үүдэнд гарсан хүн байна уу? Цаашдаа дэгээ сахиулаад Үндсэн хуулийн ямар нэгэн зөрчил гаргахгүйгээр хариуцлагатай ажиллая. Тийм учраас хариуцлагатай хүнийг бас энэ урьж авчирч байна. Тийм учраас эхнээсээ жоохон хариуцлагатай байя. Энэ чинь телевиз, радиогоор, хэвлэл мэдээллээр харж байна шүү дээ. Хүүхдүүд шиг юм болж байна шүү дээ. Бүртгэл, санал хураалтад бэлтгэх үү эхлээд, дараа нь бүртгэл явуулъя. Санал хураалтад бэлтгэе. Батнайрамдал гишүүн хаана байна, Батнайрамдал гишүүн хаана байна?

Бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт. Наранбаяр сайд орж ирж байна.

Одоо Байнгын хорооны саналаар нууц санал хураалт явуулна. Эхлээд чөлөөлөх санал хураалтыг явуулна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Барсүрэнгийн Баасандоржийг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураалтыг явуулна. Санал хураалт.

Чөлөөлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Барсүрэнгийн Баасандорж өнгөрсөн хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Их Хурлын Байнгын хорооны ахлах

зөвлөх гээд хариуцлагатай олон албыг хашиж ирсэн. Төрийн бас бэлтгэгдсэн албан хаагч. Барсүрэнгийн Баасандоржид цаашдынх нь ажил үйлсэд амжилт хүсье.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 49 гишүүн дэмжиж, 61.3 хувийн саналаар чөлөөлөх саналыг гишүүдийн олонх дэмжсэн байна.

Одоо томилох санал хураалтыг явуулна. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Лувсандоржийн Өлзийсайханыг томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нуущаар санал хураана. Гишүүд анхааралтай. Нууцаар санал хураана. Лувсандоржийн Өлзийсайханыг томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Лувсандоржийн Өлзийсайханыг томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор нууц санал хураах гэж байна. Эхлээд санал хураалтад бэлтгэе.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Лувсандоржийн Өлзийсайханыг томилох саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилъё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулахад Их Хурлын гишүүдийн 49 гишүүн буюу 61.3 хувь нь дэмжсэн байна.

Томилох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилогдсон Лувсандоржийн Өлзийсайхан танд ажлын амжилт хүсье.

Тогтоолын төслүүдийн эцсийн найруулгыг та бүхэнд сонсгоё. Монгол Улсын Их Хурлын тогтоол “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Барсүрэнгийн Баасандоржийг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүн байна уу?

“Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох” тогтоол, Монгол Улсын Их Хурлын тогтоол.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

“Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай”, “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье. Өлзийсайхан даргад баярлалаа. Ажлын амжилт хүсье.

Гишүүд өнөөдөр таван жилийн үндсэн чиглэлийг эцэслэн батлах ёстой. Дараагийн асуудалдаа оръё.

21.33 цаг

Тогтоолд нэмэлт, оруулах тухай Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Мягмарсүрэнгийн Бадамсүрэн танилцуулна. Индэрт урья.

М.Бадамсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Манай улсын газар тариалан, мал аж ахуй, хүнсний салбарын үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлт болон олон улсад үүссэн нөхцөл байдал, эдийн засгийн таагүй нөлөөнд мэдрэг байсаар байгаа бөгөөд цаашид үүсэж болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үзэж, цаг үеийн шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр гаалийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийг өргөн мэдүүлсээр ирсэн.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн чуулганаар мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор импортлох мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилыг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсан.

Дээрх хуулийн хэрэгжилтийн хүрээнд гурилын нийлүүлэлт нэмэгдэж, үнэ тогтворжсон эерэг үр дүн гарсан боловч энэ нь улаан буудайн гурил

үйлдвэрлэгчийн үйл ажиллагаанд нөлөөлөөд зогсохгүй манай улсын эдийн засгийн тулгуур салбаруудын нэг болох хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд нөлөөлж, цаашдаа салбарын хэмжээнд үйлдвэрлэлийн тасалдал үүсгэх эрсдэлтэй байдлыг үүсгэсэн.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн чуулганы хуралдаанаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсан болно.

Харин 2025 онд байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан баруун бүсийн хэмжээнд хур тунадас бага, гантай байснаас улбаалан байгалийн хадлан өвс, тэжээлийн гарц муу, улаан буудайн тариалалт, ургац хураалт өмнөх жилээс харьцангуй бага байгаа зэрэг тариалангийн үйлдвэрлэлийн бодит нөхцөл байдалд тулгуурлан улаан буудайн гурил, мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийн хангамж, нийлүүлэлт тухайн бүс нутагт доголдох нөхцөл байдал үүсээд байна.

Иймээс Баруун бүсийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл нарын 64 гишүүнээс Баян-Өлгий аймгийн Цагаан нуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор улаан буудайн гурил, малын тэжээл, тэжээлийн нэмэлтийг импортлох боломжоор хангаж, гаалийн албан татвараас чөлөөлж иргэдэд бодитой дэмжлэг болохыг хүссэн санал, хүсэлтийг ирүүлсэн байна.

Хөдөө аж ахуйн салбарт үүссэн бодит нөхцөл байдлыг харгалзан үзэж, алслагдсан бүсийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нэг болох улаан буудайн гурилын хангамж, нөөц тасалдахгүй байх, байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалсан малын тэжээлийн хомсдол үүсэж болзошгүй хүндрэлийг даван туулахад тухай бүр Засгийн газрын хүрээнд шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын 1999 оны “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай” 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах зорилгоор “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг боловсруулаад байна.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Баярлалаа.

Н.Учрал: Төслийн талаарх Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабал танилцуулна. Индэрт урья.

Б.Заяабал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр ирүүлснийг Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар

шийдвэрлэж Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Хууль санаачлагч цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулах, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болон мал, амьтны тэжээлийн хангамж, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх, мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах зорилгоор улаан буудайн гурил болон малын тэжээл, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь хэмжээг тогтоох зайлшгүй шаардлагын үүднээс “Импортын барааны гаалийн албан татварын хувь хэмжээг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Тогтоолын төслийг Байнгын хорооны хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Заяабал сүүлийн жилүүдэд баруун бүсийн аймгуудад ган, зудын хүндрэлтэй нөхцөл байдал байнга тулгарч байгаа тул улаан буудайн гурил болон малын тэжээл, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй бөгөөд гадаргуугийн ус хуримтлуулах газар тариалангийн усжуулалтын системийг үр ашигтай ашиглах боломж, шийдлийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Золжаргал тогтоолын төслийг дэмжиж байгаагаа дурдаад малын тэжээл, нэмэлт бүтээгдэхүүнийг импортын татварын хөнгөлөлтийг баруун бүсээр хязгаарлахгүйгээр нэгдсэн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл ган, зудын эрсдэлийн асуудлыг түр хугацаанд шийдэх биш тогтвортой бодлогын шинэчлэлийн хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналыг тус тус хэлсэн болно.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Батжаргалын Заяабал гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Даваасүрэнгийн Есөн-

Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Хурцаагийн Цэрэнханд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хороодын санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

Мөнхбат гишүүнээр тасаллаа. Энэ хооронд Сэддорж дарга Эдийн засгийн байнгын хороо Сүхбаатар танхимд Тэмүүлэн гишүүн ажлын хэсгийн ахлагчийн хамтаар хуралдаад эцсийн хэлэлцүүлэг явуулж байгаад чуулганы нэгдсэн хуралдаанаар өнөөдөр эцсийн хэлэлцүүлгийг хийж дуусгая. Энэ хооронд Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байна. Энэ хуулийн санал хураалт дараагийн хуулийн санал хураалт таван жилийг зэрэгцүүлээд санал хураалтаа явуулчихъя нэгдсэн байдлаар. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгэхээр нэг зүйлийг бас анхааруулахад энэ зарим гишүүд энэ өргөн барьсан энэ хуулийнхаа асуудлыг Засгийн газраар тодорхой асуудал, өөрөөр хэлбэл Засгийн газрын хурлаар орсон шийдвэрээ энэ асуудалд хэлэлцэгдэж явлаа гэдэг ийм мэдээлэл гаргаснаар болж бас зарим бизнес эрхэлж байгаа хүмүүс тодорхой хэмжээний бизнесийн алдагдалд орсон ийм зүйл байгаа.

Ер нь хууль батлах, тогтоол батлах процесс удаан хугацаанд явдаг. Засгийн газраар оронгуут тэрийгээ зарласнаас болоод энэ олон хүмүүс гурил, тэжээлээ баруун бүсэд зарж борлуулж тэгээд энэ татвар нь чөлөөлөгдчихсөн учраас дахин шинээр татах ийм зүйлүүдийг хийсэн, хийх гэж энэ мэдээллээс болж хийсэн. Гэвч харамсалтай нь энэ Засгийн газраас дэмжигдсэнээс хойш маш их удаан хугацаанд Их Хурлаар орж ирж байна. Их Хурлаар энэ асуудал хэлэлцэгдээд бас 2 долоо хоног болно. Үүний дараагаар Ерөнхийлөгч хориг тавихгүй бол энэ Төрийн мэдээлэл дээр энэ хууль гарснаар хууль хэрэгжиж эхэлнэ. Тийм учраас энэ зарим залуу гишүүд бас тодорхой хэмжээгээр энэ хуулийн процессыг бас мэдэхгүйгээр мэдээлэл хийснээс болж зарим бизнес эрхэлж байгаа хүмүүс бас хохирох ийм зүйлүүд гарсан гэдгийг хэлье.

Тийм учраас мэдээж энэ төслөө санаачлаад энийгээ батлуулах гээд энэ ард иргэдийнхээ ялангуяа баруун бүсийн ард иргэдийн хямдхан гурил хэрэглэх тэр зүйлийн төлөө зүтгэж байгаа нь маш сайн хэрэг. Тэгэхдээ энэ хууль батлах энэ процессыг бас зөв бодож, ярьж, ойлгуулж, ард иргэдээ ойлгуулж, хугацаа энэ тэрийг нь сайн ярьж хэлж байх ёстой шүү гэдгийг бас сануулж хэлье. Баярлалаа.

Н.Учрал: Пүрэвдорж гишүүн санал хэллээ. Жангабыл гишүүн.

Х.Жангабыл: Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд оройн мэндийг хүргэе. Өнөөдөр бид баруун аймгуудтай хил залгаа боомтуудаар импортоор орж ирдэг улаан буудайн гурил, мал, амьтны тэжээлийг гаалийн татвараас чөлөөлөх талаар хэлэлцэж, иргэдэд бодит дэмжлэг үзүүлэх гарцыг ярилцаж байна. Саяхан миний бие Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайдтай хамт баруун

аймгуудад ажиллах томилолтод хамтран оролцож Баян-Өлгий аймагт 5 хоног ажиллан тойргийн ард иргэдтэй уулзаж уулзалт хийсэн. Байдал үнэхээр ноцтой байна. Баруун бүсийн ихэнх нутгаар өнгөрсөн зун гандуу байсны улмаас гамшгийн өндөр эрсдэл бий болсон. 2025-2026 оны зудын эрсдэлийн үнэлгээгээр Баян-Өлгий аймагт зуд болох маш их эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан байна. Дээрээс нь гурил, будаа, малын тэжээл, бензин шатахуун, өргөн хэрэглээний барааны үнэ богино хугацаанд асар их үнэ өсөж, иргэд малчдын амьжиргаанд шууд дарамт үзүүлж байна.

Тэгэхээр надад хэд хэдэн асуулт байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад 1 дүгээрт яг энэ асуудлаар 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр миний бие болон 65 гишүүн гарын үсэг зурсан албан бичгийг танай яаманд хүргүүлж, баруун аймгуудтай хил залгаа боомтуудаар импортоор орох улаан буудайн гурил, малын тэжээлийг гаалийн татвар болон нэмэгдсэн хөрөнгийн албан татвараас чөлөөлөх санал тавьсан. Гэтэл өнөөдөр хүртэл 2 сарын хугацаа өнгөрсөн ч бодит шийдвэр гараагүй байна. Сая Пүрэвдорж гишүүн бас ярьж байна. Яагаад энэ асуудал ийнхүү удааширсан бэ? 1 дэх асуулт.

2 дахь нь энэ хэлэлцэж буй Улсын Их Хурлын тогтоол гаалийн татварын хувь, хэмжээг бүсийн онцлогоор ялгавартай тогтоох эрхийг Засгийн газарт олгоно. Энэ их сайшаалтай хэрэг. Татвар буусан ч гэсэн улаан буудайн гурилын импортын мэдэгдэл болон 25 мянган тонн улаан буудайн гурил импортлох квотыг олгохгүй байгаа нь баруун бүсийн аймгуудад тодорхой хүндрэл үүсгэж байна. Тэгэхээр Бадамсүрэн сайдаа баруун аймгууддаа хил залгаа боомтуудаар улаан буудайн гурилын импортын мэдэгдэл болон 25 мянган тонн гурил импортлох квот олох уу? Бид татвараа буулгасан ч гэсэн импортлох квотоо олохгүй бол татвар буулгах ямар ч хэрэг гарахгүй юм.

3 дугаарт жил бүр бид малчдын өвөлжилтийн асуудалд гал унтраах байдлаар хандаж, түр зуурын арга хэмжээ яг өнөөдрийнх шиг авч байна. Харин асуудлыг үндсээр нь шийдэх шаардлага байна. Тухайлбал, Баян-Өлгий аймгийн хувьд авч үзвэл бэлчээрийн даацын үнэлгээгээр 68 хувь нь бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн дүнтэй гарлаа. Гарсан байна олон дахин шүү. Энэ бэлчээрийн даац ийм өндөр хэтэрсэн нөхцөлд 1 дүгээрт, малын тоог бууруулах хэрэгтэй. 2 дугаарт, тэжээл тариалах аж ахуйг эрхлэх аж ахуйн нэгжүүд болон иргэдийг дэмжих ёстой. Гэвч иргэд, аж ахуйн нэгжүүд тэжээл тариалах хүсэлт гаргахад тарих газар олдохгүй тариа тари,х газар олголт олон…/минут дуусав./

Н.Учрал: Бадамсүрэн гишүүн асуултад хариулъя. Дахиад 1 минут авах уу? Жангабыл гишүүнд нэмэлт 1 минут.

Х.Жангабыл: Тийм газар олголт олон шат дамжлагатай, асар их хүндрэлтэй. Засгийн газар газар олгоно гэсэн боловч бодит байдал дээр шийдэл гарахгүй байна. Тэгэхээр 3 дахь асуулт ийм нөхцөлд танай яам бэлчээрийн даац, тэжээлийн үйлдвэрлэл, газар олголтын асуудлыг цогцоор нь шийдэх ямар бодлого барьж байгаа юм бэ? Энэ асуудлыг шийдвэл жил болгон бид ингээд гал унтраах асуудлыг авч хэлэлцэхгүй юм. Тэгээд шинээр сонгогдсон Бадамсүрэн сайддаа бас ажлын амжилт хүсье.

Н.Учрал: Бадамсүрэн гишүүн хариулъя.

М.Бадамсүрэн: Жангабыл гишүүн энэ баруун бүсийн хүн амын гурил, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, өвөлжилтийн нөхцөл байдал, малчдад тулгамдаж байгаа асуудлын талаар зөвхөн өнөөдөр үг хэлэхээс гадна санаачилга гаргаж бас ажил хэрэгчээр хандаж, 64 гишүүний хамт энэ тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хурлаас шийдвэр гаргуулахаар хандсан нь өнөөдөр ингээд санал хураалтаар дэмжигдвэл ингээд бодит ажил хэрэг болох гэж байна.

Тэгээд импортын мэдэгдлийн тухайд энэ тогтоолын төслийг өнөөдөр хэлэлцэн баталбал цаашаа энэ маш шуурхай хурдтай ингээд явах боломжтой. Өөрөөр хэлбэл, баруун бүсийн нэр заасан 5 боомтоор импортын татварыг тэглэх эрхийг Засгийн газарт олгож байгаа. Энэ утгаараа ингээд энэ шуурхай явах гол шийдвэр нь ингээд гарах юм.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хувьд зөв. Ер нь зуны бэлтгэл хангана гэж байхгүй, өвөлжилтийн бэлтгэл хангадаг. Тийм учраас энэ хүрээндээ 1 дүгээрт, мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулах энэ гол бодлого нь экспортыг дэмжих, экспортод малын мах, малын гаралтай бүтээгдэхүүн их л гарч байвал малчдын орлого нэмэгдэнэ. Малчид бидэнд хамгийн гол нь малын маань махыг үнэ цэнтэй болгож өгөөч гэдэг ийм саналыг тавьж байгаа. Сүүлийн 1, 2 жилд махны экспорт бас эрс нэмэгдэж байгаа ийм эерэг үзүүлэлттэй байгаа. Цаашдаа ч гэсэн энэ бодлогыг үргэлжлүүлнэ.

Дээр нь тэжээл тариалах асуудлууд тулгамдсан асуудал болж байгаа. Ер нь цаашдаа хадлангийн бүс нутаг үндсэндээ ихээхэн хомсдож байгаа. Тийм учраас тэжээл тариалах асуудлыг бодлогоор дэмжиж, манай яамны зүгээс энэ тэжээлийн тариалахад зориулж иргэдэд хоршоо нөхөрлөлд газрыг хамгийн боломжит нөхцөлөөр тодорхой болзолтойгоор олгох асуудлыг хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар бид нар боловсруулна гэж төлөвлөж байгаа гэдгийг бас танд хэлье. Баярлалаа.

Н.Учрал: Жангабыл гишүүн тодруулна.

Х.Жангабыл: Саяын квот олголт 25 мянган тонн, дээрээс нь импортын мэдэгдэл олгох асуудлыг бид хэчнээн ч гаалийн талбайг буулгасан ч гэсэн импортын мэдэгдэл өгөхгүйгээр, гурил орохгүйгээр энийг буулгаад ямар ч үр дүн байхгүй л дээ. Тэгэхээр энэ асуудлыг шийдэж өгөх үү, шийдэх үү гэсэн асуулт асуултад хариулт авъя.

Н.Учрал: Бадамсүрэн сайд.

М.Бадамсүрэн: Энэ асуудлыг шуурхай шийдвэрлэнэ гэдийг гишүүнд хариулъя. Анхаарал хандуулж баруун бүсийн алслагдмал бүсийн иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд хэдий зүүн бүсээ сонгочихсон ч гэсэн адилхан алслагдмал бүсээс сонгогдсоны хувьд онцгой анхаарч ажиллана гэдгийг танд бас хэлье. Шуурхай ажиллана. Баярлалаа.

Н.Учрал: Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Тогтоолын төслийг дэмжиж байгаа. Хэл, хил, мал 3-тайгаа байхад хэн баян Монгол баян гэж бас манай нэрт яруу найрагч хэлсэн байдаг. Яах аргагүй бас Монголчууд биднийг бас хоолтой, ундтай байлгаж, Монгол улсынхаа бас хязгаар нутгийг бас эзэнтэй байлгаж, Монгол өв соёлоо тээж байгаа иргэдийн гол амин зуулга бол мал байгаа малчдын маань. Тийм болохоор Монгол улсын бас Үндсэн хуульд мал сүрэг төрийн хамгаалалтад байна гэж заасан байдаг. Энэ зун энэ баруун аймгууд Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай Завхан аймгууд нэлээн гандуу зунтай болсон. Гантай учраас өвс хадлан, тэжээлээ бэлдэж чадаагүй. Түүнээсээ болоод бас энэ өвөл нэлээн тийм хүндэвтэр өвөл ер нь бас зуд болох өндөр эрсдэлтэй байгаа. Энэ асуудалд бас Засгийн газраас, Улсын Их Хурлаас бас онцгой анхаарч, уг нь засгийн газраа тогтоолоо 10 сарын 8-нд баталсан. Харамсалтай нь бид нар бас улс төржиж, талцаж хуваагдаж янз бүр болсоор байгаад өвөл болсон хойно Улсын Их Хурлаар энэ тогтоол маань хэлэлцэгдэх гэж байна.

Энэ алслагдсан аймгуудад үнэхээр бүх л төрлийн бараа, бүтээгдэхүүн өндөр үнэтэй. Тээврийн зардал өндөр үнэтэй учраас гурил нь үнэтэй, будаа нь үнэтэй, тэгээд бензин шатахуун үнэтэй, өвс, тэжээл үнэтэй. Малчид маань хэдэн малаа бас онд оруулах гэж энэ зунжин, намаржин Дорнодоос, Дорнодын Халх голоос Баян-Өлгий рүү, Увс руу, Ховд руу өнжсөн өвсийг тээвэрлэсэн, тээсэн. Өнөөдөр Улаанбаатар хотод 1 боодол өвс нь 15 мянга орчим төгрөгийн үнэтэй байгаа бол баруун бүсийн аймгуудад 25 мянга, 30 мянга болсон байгаа. Ийм л нөхцөл байдалд малчид маань алслагдсан бүс нутгийн ард иргэд маань бас амьдарч байгаа.

Тийм болохоор бас яаралтай энэ тогтоолыг бас баталж, энэ Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховдын Ярантад, Увсын Боршоо, Завханы Арцсуурь, Говь-Алтайн Бургастай гэсэн боомтуудаар импортоор өвс, тэжээл, ялангуяа гурил тэжээл орж ирэх бас бололцоо боломжийг бас яаралтай бүрдүүлээд өгчих юм бол энэ бас малчдад бас жоохон ч гэсэн дэм болох болов уу гэж үзэж энэ тогтоолын төслийг Засгийн газраас Их Хуралд оруулсан. Их Хурал бас нэн яаралтай горимоор хурдан хугацаанд шийдээд явах байх.

Цаашдаа бас төрийн бодлого тодорхой байдаг ,тогтвортой байдаг баймаар байгаад байгаа юм. Урьд нь баруун бүсийн боомтуудаар гурил, тэжээл татваргүй ордог байсан. Энийг татвартай болгосон, дахиад татваргүй болгосон, дахиад татвартай болгосон. Ингээд л үндсэндээ ингээд л тийм тогтворгүйгээс болоод байгаа юм. Тэртээ тэргүй л алслагдсан аймгууд нь үнэн л юм чинь. Алслагдсан аймгуудын боомтуудаар орж байгаа бензин шатахуун, гурил, будаа энэ бүхэн татваргүй байгаа нь тогтвортой л баймаар байгаа юм л даа. Олон жил ярьж байгаад заримдаа татваргүй болгочихдог, заримдаа татвартай болгочихдог. Энийг цаашдаа ингэж татвартай болгох асуудал байхгүй байх ёстой шүү. Энийг энийг бас Улсын Их Хурлын гишүүд, хууль тогтоогч нар бид бүхэн бас цаашид анхаарах ёстой. Ийм тогтворгүй бодлоготой байдгаас болж үнэхээр бас ард иргэд, бизнес эрхлэгчид, ялангуяа тэнд бас алслагдсан бүсийн ард иргэд ялангуяа их бас зутарч байгаа ба,с энд бас өртөж байгаа үнийн өсөлтөд. Тэгээд энэ дээр л цаашдаа бас Их Хурлын гишүүд бас анхаарч, төр зохицуулалтаа хийнэ. Үнийг нь зохицуулалт хийнэ. Ингэхдээ энэ алслагдсан бүс нутагт ажиллаж, амьдарч байгаа ард иргэдийнхээ энэ төвийн бүсэд амьдарч байгаа ард иргэдтэй бас адилхан үнэтэй зарлага нь адилхан байх, орлого нь адилхан байх энэ бодлогоо л бас цаашид бас

анхаарах ёстой. Энийгээ бас гишүүд бид бүгд цаашид бас анхааръя л гэдгээ бас хэлье.

Н.Учрал: Бямбацогт гишүүн санал хэллээ. Мөнхбат гишүүн? Мөнхбат гишүүн байхгүй байна.

Тогтоолын төслийн талаар Байнгын хороодоос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр суууриа илэрхийлж үг хэлнэ.

Зулпхар гишүүнээр тасаллаа. Жангабыл гишүүн? Жангабыл гишүүн саналаа хэлсэн. Зулпхар гишүүн алга байна. Нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэх 2 гишүүн нэрээ татлаа. Гишүүд үг хэлж дууслаа.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураах ёстой. Саналуудыг нэгтгээд хураая. Дараагийн асуудалд оръё.

Одоо Эдийн засгийн байнгын хороо таван жилийн үндсэн чиглэлийн эцсийн хэлэлцүүлгийг хийж байна. Дараагийн асуудалд оръё.

21.57 цаг

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль. Анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн.

Н.Бамсүмбэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 39.10-д заасныг баримтлан Стратегийн ач холбогдол бүхий

бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт өгсөн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул хуралдаан даргалагч хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 70.6 хувийн саналаар дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Н.Учрал: Ажлын хэсгийн гишүүдийн нэрс. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням, Монголбанкны Санхүүгийн зах зээлийн газрын захирал Энхжин, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Чулууны Хишигдалай, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ганбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тос бүтээгдэхүүний хэлтсийн дарга Чулуунбат, Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Даваабаяр.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Анар гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн? Алга байна. Ж.Ганбаатар гишүүн? Алга байна. Баасанжаргал гишүүн? Алга байна Сэддорж гишүүн? Алга байна. Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байна. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Манай улс 100 хувь гадаадаас хараат байгаа. 100 хувь импортоор газрын тосны бүтээгдэхүүнийг хангаж байгаа. 95 хувь нь ОХУ-аас, 5 орчим хувь нь Хятадаас. Шатахуун тасалдах юм бол нийгэмд ямар аюул нүүрлэж байгаа вэ гэдгийг бид биеэрээ саяхан хүртэл бас мэдэрсэн. Одоо ч гэсэн зарим газар, нэн ялангуяа хөдөө орон нутагт бензин шатахуун, түлш тасалдсан байдалтай байгаа. Тэгээд энэ нөхцөл байдал юуны улмаас үүдэж бий болов гэдэг маш том асуултын тэмдэг. Өмнө 2021 оны 10 сард ОХУ-ын” Роснефть” компани 92 бензинийг нийлүүлэлтийг бууруулсан. Үүнтэй холбоотойгоор манай Монгол Улсад нэлээд хомсдол үүсэж байсан. 23 оны 9 сард мөн ОХУ Засгийн газраасаа тогтоол гаргаж, шатахууны экспортыг бас түр хугацаанд хориглосон байдаг. Энэ бол манай улсад бас сөргөөр нөлөөлж байсан түүхтэй.

Улмаар Засгийн газар хооронд ер нь манай хөрш улсад ямар хүнд нөхцөл байдал байгаа билээ? Тэгээд энэ геополитикийн нөхцөл байдлаа үл харгалзан хөрш улс Монгол Улсыг шатахуунаар тасалдуулахгүй байх ийм гэрээг уг нь байгуулсан. Гэхдээ яг энэ шатахуунтай түлш нийлүүлэх гэрээг байгуулахдаа хос гэрээ шүү гэдгийг анхааруулан байж, манай улсын хувьд 1 гэрээг нь соёрхон баталж, 1 гэрээг нь соёрхон батлаагүй. Төр ингээд барьчихсан байгаад байгаа. Бүтэн жилийн хугацаанд бид барьсан.

Тэр нь юу юм бэ гэхлээр агаарын хөлгийн түлш нийлүүлэх гэрээ. Тухайн үедээ чуулганаар бид нар бас хэлэлцэж байхад санаж байна л даа. 1 дүгээрт тухайн гэрээнд орчуулгын алдаанууд гарсан байх. Бас зайлшгүй харж үзэх тодорхой асуудлууд бас гарсан байх. Гэсэн хэдий ч талдаа дийлэнхдээ улс төржиж энэхүү гэрээг бид нар соёрхон батлаагүй. ОХУ хэдийгээр хосолмол гэрээ байгуулсан шүү гэдгийг анхааруулж аль аль нь хүчин төгөлдөр байж байж бид нар энэ гэрээгээ мөрдөнө өө гэдгийг наанаа хэлсэн ч гэсэн цаанаа биднийг бас түлшээр тасалдуулахгүй байх ийм зарчмыг баримталж байгаа.

Гэхдээ тэгсэн ч гэсэн байнга сануулж байгаа хосолмол гэрээ шүү. Та нар 1 гэрээгээ батлаагүй байгаа шүү, хэлсэн амандаа хүрээрэй гэдэг ийм асуудлыг дэвшүүлээд байгаа. Манай чуулган, намрын чуулган 12 сарын 31-нд 75 хоногт хүрнэ. Ганцхан сарын хугацаа үлдсэн Дамдинням сайд аа энэ цаг хугацаагаа ашиглаад соёрхон батлах ёстой энэ хос гэрээний 1 болох агаарын хөлгийн түлшний энэ гэрээг соёрхон батлах асуудлыг оруулж ирэхгүй бол хэчнээн дотоодын аж ахуйн нэгж, байгууллагууддаа давуу байдал үүсгэж зээл өгье, та нар эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүл, нөөц саваа барь, та нар энэ зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр ав гэж бид нар өнөөдөр энэ шийдвэрийг гаргасан ч гэсэн айлын талаас нийлүүлэлтээ хийж чадахааргүй болох юм бол яах вэ гэдэг маш том эрсдэл байгаа шүү. Ийм учраас энэ гэрээгээ хурдан шуурхай оруулж ирээч ээ. Одоо яг юу дутуу байна вэ? 1 сарын дотор амжих уу үгүй юү? Одоо ирэх биш энэ Улсын Их Хурлын гишүүд улс төржиж болох асуудал байна, болохгүй асуудал бас байна гэдгийг ойлгосон болов уу гэж би бас найдаж байна. Ийм учраас яг энэ цаг үе дээрээ гэрээгээ маш шуурхай оруулж ирж соёрхон батлуулах тал дээр нь анхаармаар байна.

Н.Учрал: Ариунзаяа гишүүний асуултад Дамдинням сайд хариулна.

Г.Дамдинням: Гишүүдийн оройн мэнд хүргэе. Тийм манай Ариунзаяа гишүүн яг л зовлонг нь мэдэж байгаа учраас яг л болж байгаа асуудлыг цаад утгаар нь яг харж асууж байна. Шатахууны тасалдал 1 дүгээрт ер нь үе үеийн л зовлон байсан юм байна лээ. Ерөөсөө тасралтгүй. 21, 23, 25 гээд л ингээд явж байна. Энэ удаагийнх бид нар зохицуулалт хийгээд ямар ч байсан юм ард нь гаргах гээд хичээж байна. Орон нутгийнхаа хангалтыг ойрын үед энэ төвөөс хангаад байгаа. Баруун аймгууддаа тээврээр явуулдаг энэ нөхцөл байдалтай төвөөс хангаж байгаа энэ нөхцөл байдлаас шалтгаалаад бас жоохон зарим сумдад хоцрогдож байгаа асуудлууд байна. Говийн бүс нутгууд руу явуулж байгаа зарим аймгуудын Засаг дарга нарын бас болох, болохгүй үйл ажиллагаанаас болоод бас тээврийн үйл ажиллагаа тасалж байгаа ч асуудлууд байна. Тэгээд зохицуулаад ингээд явуулж байна.

Өнгөрсөн жил ОХУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр баталсан энэ гэрээ бол маш чухал 2 гэрээ байсан юм байгаа юм. Орж ирсэн 2 гэрээ. Хосоороо орж ирсэн 2 гэрээ. Манай улс 35 жилийн хугацаанд ардчилсан тогтолцоонд шилжсэнээсээ хойш энэ шатахууныг тасалдахгүй нийлүүлэх тухай гэрээ ерөөсөө байхгүй байсан юм билээ. Тэгээд энэ гэрээгээ хийхдээ онгоцны түлш нийлүүлэх тухай гэрээг цуг хоёулангаар нь хийнэ гэж орж ирсэн. Энэ гэрээ 4 дүгээр сард орж ирээд нэлээн улс төр болоод ингээд бүтэлгүйтсэн.

Энэ гэрээн дээр 8 асуудал байсан. 8 асуудал нь бас үнэхээр эргэж харахгүй бол болохгүй ийм нөхцөл байдалтай асуудлууд байсныг 6 сарын дундуур ажил авснаас хойш тасралтгүй энэний араас яваад манай Газрын тосны газрынхан, манай Газрын тосны агентлагийнхан гээд бүгдээрээ нийлээд энэ 8 асуудлаар ОХУ-тай тасралтгүй хэлэлцээр хийж байна. Хийгээд ингээд үндсэндээ нийт 8 асуудлаас 7-г нь Монголын саналаар шийдвэрлэхээр томьёолцгоосон.

Энэ дотор арбитрын асуудал байдаг юм. Хөшигийн хөндийн нисэх буудлын асуудал байдаг юм, их олон асуудлууд бий. Татвар тогтворжуулахтай холбоотой асуудлууд байсан. Энэ асуудлууд дээр ОХУ-ын тал маань сая Занданшатар Ерөнхий сайдын айлчлалын үеэр миний бие Цивилев сайдтай уулзаж, ОХУ-ын Эрчим хүчний сайдтай ярилцаж нэлээн тохиролцоонд хүрээд 1 асуудлыг Их Хурлаар оруулъя гэж үлдээсэн. Тэр бол удахгүй орж ирнэ. Манай яамны зүгээс болон Монгол Улсын зүгээс гэсэн үг үндсэндээ. Бид эцсийн томьёоллоо бэлдээд ОХУ-д явуулчихсан байгаа. Одоо ОХУ-аас тэр эцсийн томьёолол дээр зөвшөөрч байна гэсэн хариу ирэх юм бол бид Их Хуралд оруулахад бэлэн байгаа. Өөрөөр хэлбэл, бид Засгийн газрын зүгээс хийх ажлаа бүрэн хийчихсэн.Одоо хариу ирэхээр нь оруулж ирнэ.

Н.Учрал: Чинбатын Анар гишүүн? Анар гишүүн байхгүй байна.

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжих санал хураалтыг явуулах ёстой. Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байна. Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байгаатай холбогдуулаад санал хураалтыг Эдийн засгийн байнгын хорооны хуралдааны дараа таван жилийн чиглэлтэй нэгтгээд хэлэлцье. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, мөн Стратегийн бүтээгдэхүүн, ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль, таван жилийн чиглэлийг нэгтгээд санал хураалтыг явуулъя. Эдийн засгийн байнгын хороо юу болж байна?

Эдийн засгийн байнгын хороо хуралдаж дуусаж байна.

Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасан байна. Энэхүү горимын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Эцсийн хэлэлцүүлэг рүү шилжүүлье гэсэн саналын томьёоллоор санал хураахад 5 гишүүн буюу 6.2 хувь дэмжсэн байна. 93.8 хувь татгалзсан тул санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гаргасан горимын санал дэмжигдээгүй тул Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлье.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулахад бэлтгэж байна.

Хуралдааныг үргэлжлүүлье.

22.29 цаг

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Сэддорж танилцуулна. Индэрт урья.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42, 61 дүгээр зүйлд заасныг баримтлан 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг төсөлд бүрэн тусгалаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зарчмын зөрүүтэй 2 саналын томьёоллоор, нийцүүлэн жигдрүүлэх зарчмын зөрүүтэй 2 саналын томьёоллоор санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлгийн үеэр санал хураалгахаар үлдээсэн гүйцээн боловсруулах санал, нийцүүлэн жигдрүүлэх зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг, зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Сэддорж даргад баярлалаа. Ажлын хэсгийн гишүүд анхны хэлэлцүүлэг дээр ажиллаж байгаа ажлын хэсгийн гишүүд хэвээр байна. Засгийн газрын гишүүд, Эдийн засаг, хөгжлийн яамныхан Чандмань даргыг мартчихсан байна шүү. Баярлалаа. Ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээрээ байна.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

Асуулт асуух гишүүн байхгүй байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д зааснаар хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу хураасан санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 2.1.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.” гэснийг “Хөдөлмөрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх” гэснийг “Хөдөлмөр, нийгмийн гурван талт түншлэлийг бэхжүүлэх хүрээнд хамтын гэрээ хэлэлцээрийн чанарыг сайжруулах, тоог нэмэгдүүлэх” гэж; 3 дугаар хавсралтын 2.1.3.2 дахь дэд заалтын “Үр дүн” баганад “Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргааныг бууруулна.” гэснийг “Хөдөлмөрийн маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлнэ.” гэж. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал гишүүдийн 45 нь буюу 54.9 хувь нь дэмжсэн байна. Санал дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар хавсралтад доор дурдсан агуулгатай 7.6.1.4 дэх дэд заалт нэмэх:

2 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Бодлогын үндэслэл” баганад “АХ-4.2.44, 4.2.47, 4.5.8” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Арга зам” баганад “Баталгаат шуудан, цахим систем ашиглах, санал авах байрны

тоог нэмэгдүүлэх” гэж, “Үндсэн хариуцагч” баганад “Гадаад харилцааны яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар” гэж, “Хамтран хариуцагч” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж; 3 дугаар хавсралтын “Дугаар” баганад “7.6.1.4” гэж, “Салбар” баганад “70304 Гадаад улсад байгаа Монгол иргэдэд туслах” гэж, “Үр дүн” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэд төрийн сонгуульд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж, “Шалгуур үзүүлэлт” баганад “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийн сонгуульд оролцсон хувь” гэж, “Хэмжих нэгж” баганад “Хувь” гэж, “Суурь түвшин” баганад “Он: 2024, Түвшин: 7.1” гэж, “Зорилтот түвшин” баганад “2026:, 2027: 10, 2028: 15, 2029:, 2030:” гэж, “Мэдээллийн эх сурвалж” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж, “Мэдээлэл цуглуулах арга зүй” баганад “Салбарын тайлан” гэж, “Мэдээлэл цуглуулах давтамж” баганад “Жил тутам” гэж, “Хариуцах байгууллага” баганад “Сонгуулийн ерөнхий хороо” гэж. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал гишүүдийн 47 буюу 57.3 хувь дэмжлээ. Санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заалтыг үндэслэн хураасан санал.

1.Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.1.1 дэх дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2026 онд “2025 оны түвшнээс дээгүүр” гэснийг “2,800,000 төгрөгөөс доошгүй (түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ.) гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

Гишүүдийн 45 буюу 54.9 хувь нь дэмжлээ. Санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2.2 дахь дэд заалтын “Шалгуур үзүүлэлт” баганын 2026 онд “2025 оны түвшнээс дээгүүр” гэснийг “2,800,000 төгрөгөөс доошгүй (түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ.) гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Энэ зарчмын зөрүүтэй санал дээр Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн, дэмжээгүй дээр энэний дараа үг хэлнэ тээ.

2,800,000 төгрөгөөс доошгүй (түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ.) гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Та үг хэлэх үү? Зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулаад дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж болно. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үг хэлнэ. Саналын томьёололтой холбогдуулж.

Х.Тэмүүжин: Саналын томьёололтой холбоотой биш ээ. Танайхан ард түмнээ хулхидна, парламент дээр байгаа цөөнхийн бүлгээ хулхидна, дандаа худлаа ярина. Уул нь өнөөдөр Ерөнхий нарийн бичгийн даргын томилгоог хэлэлцэхгүй гэж ярьсан. Таван жилийн үндсэн чиглэлээ хэлэлцээд санал хураалтуудаа дуусгаад явъя гэж хэлсэн. Шөнө, оройгоор албан тушаалыг нь дандаа луйвар хийнэ хөшигний ард. Хулгай хийдэг, худлаа ярьдаг чинь үнэхээр хэтэрчихлээ. 49-хөн гишүүнээр томилогдож байгаа Ерөнхий нарийн бичгийн дарга

чинь Улсын Их Хурлын дэгийн зөвлөх хийж чадах юм уу? Уул нь би зарчимтай яриа хэлцэл хийлээ гэж ойлгосон. Гэтэл та нар 49-н хүнээрээ дэмжээд томилчихлоо. Түүгээрээ намдаа зөвлөхөө хийлгээрэй. Энэ Улсын Их Хурал дээр бол биш байна. Уул нь парламент соёл байх ёстой шүү дээ. Олонх, цөөнхийн энэ хуралдааныг яаж явуулах тухай хуулийн зөвлөгөө өгөх гэж байгаа дэгийн зөвлөх шүү дээ. Та хэдийн байгаа царайгаар одоо юу гэж харагдаж байна гэхлээр та хэд Үндсэн хуулийн цэцээр тоглосон юм байна. Улс төрийн захиа, даалгавраа тэрүүгээр хийлгэсэн юм байна. Одоо хариуд нь шагналаа өгч байгаа юм байна. 28 оны сонгуулиар аягүй бол танай намаас нэр дэвшинэ. Ийм л дүр зураг харагдаж байна шүү дээ.

Их Хурлын дарга болоод энэ индэр дээр суугаад төвийг сахина гэж хэлчхээд цөөнхдөө зүгээр л бид хуралдаад дотроо юмаа яриадахъя гэхэд хуралдах боломж өгөхгүй өнөөдөржингөө чуулганаа хийгээд тэгээд ар хударгаар нь хийж байгаа юм чинь энэ шүү дээ. Албан тушаалаа ямар хурдан шийддэг юм бэ, Бялуу шагналаа ямар хурдан түгээдэг юм бэ. Арай хэтэрлээ шүү дээ. Ардчилсан нам юу гуйсан юм. Одоо мөргөж сөгдөж гуйх юм уу хаашаа юм. Бүлгээрээ нэг хэлэлцээдэхье л гэсэн шүү дээ. Улсын Их Хурлын бүтцийн чинь байгууллага шүү дээ. Гэтэл юу болгов оо харанхуй шөнөөр, оройгоор. Саяхан бид анхдугаар Үндсэн хуулиа батлаад бүгд найрамдах төрийн сонголт хийсэн өдрөө тэмдэглэлээ. Ардын нам тэнд өөр үзэл бодолтой байсан бүх хүмүүсээ буудаж алчхаад Коминтерны Үндсэн хуулийг баталсан. Өнөөдөр арга барил чинь ерөөсөө солигдоогүй байна шүү дээ. Бусдынхаа үг хэлэхийг, байр сууриа илэрхийлэхийг, хоорондоо ярилцахыг яг буудаж байгаатай адилхан хуураад алга болгочхоод ар хударгаар нь яг л 101 жилийн өмнө хийсэн ажлаа дахиад хийж байна шүү дээ. Ямар арчаагүй юм бэ. Тэр үед хүний амиар зольж байсан байх. Өнөөдөр зүгээр парламентын хэвийн үйл ажиллагаагаар зольж байна шүү дээ. Улсын Их Хурлын Даргын дэргэдэх зөвлөлөөр ч ярилцахгүй, намын бүлгээр нь ч хэлэлцүүлэхгүй зүгээр л кнопдоод л бүгдийг шийднэ гэж бодож байгаа. Ийм увиа…/минут дуусав.

Н.Учрал: Тэмүүжин гишүүн би таныг хүндэтгэлээ. Энэ зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулсан үг биш байсан. Тийм. Гэхдээ өдөр 1 цаг 23 минутад, 12 цаг 23 минутад 2 цагийн завсарлага өгсөн. Ингээд үүнээс хойш таван жилийн үндсэн чиглэлийг хэлэлцэж явж байгаад орой Эдийн засгийн байнгын хороо эцсийн хэлэлцүүлгийг хийх гээд Байнгын хороо руу орсон. Тэгэхээр завсарлага авсан асуудлыг дуусах, эсвэл сунгах асуудлыг шийдэх ёстой юм нэгэнт алх цохичихсон учраас. Тэгээд би Ардчилсан намын бүлгээс энэ 2 цагийн завсарлагаа үргэлжлүүлэх үү энэ дээр байр сууриа хэл гэсэн. Та байгаагүй. Ингээд завсарлага дуусаад цохиод ингээд л явсан.

Тэрнээс биш энд ямар нэгэн, тэр чинь нэгэнт цохичихсон учраас би үргэлжлүүлэх үү эсэх асуудлыг эндээс шийдэх ёстой шүү дээ. Тийм. Тэгэхдээ та энэ асуудал дээр ингэж бас 300 мянган гаруй гишүүд, дэмжигчидтэй улс төрийн намыг ингэж үүх түүхээр нь доромжилж болохгүй л дээ. Та бас ярих юм байна, ярихгүй юм байна. Та чинь бид нарт Төрийн онол, Эрх зүйн онол заагаад байж байхдаа арай өөр хүн байсан шүү дээ. Та энэ үдэш, орой орж ирж ингэж 300 мянган гишүүд, дэмжигчидтэй нам доромжилж болохгүй шүү дээ. Би энд ерөөсөө нам яриагүй шүү дээ. Би энд эрх баригч намын даргын ямар ч байр суурь баримтлаагүй шүү. Би Их Хурлын дэгийн хуулиа л барьсан. Таныг би байна уу та саналаа хэл гэсэн. Та хэлээгүй. Тэгээд байхгүй байсан. Тэгээд би өөр яах юм,

эсвэл орхиж болох юм, би таныг байхгүй энэ чинь таван жилийн чиглэл одоо хүртэл хэлэлцээд байж байна шүү дээ та. Тэгээд тэр чинь Эдийн засаг орохоор энэ завсарлагаагаа зогсооё гээд ингээд цохих гэсэн чинь та байхгүй байсан. Зарим гишүүд байсан. Ингээд л явсан.

Тэрнээс биш энэ чинь ямар улс төрч хүн ингээд л авчраад томилох гээд байгаа юм байхгүй. Та мэдэж байгаа шүү дээ. Тийм, тэгээд та өөрөө, одоо би анхныхаа хэлсэн үгэнд байгаа шүү. Би спикерийн хувьд тэгш боломжоор хангана, би хариуцлагатай байна гэж би танд хэлсэн. Тийм учраас би тантай соёлтой, хуулийнхаа хүрээнд л би тантай ярьж байна. Түрүүн завсарлагыг яах вэ асуугаад явахад энд байгаагүй өөр бүлэг төлөөлөх хэн байна гэсэн байхгүй, тэгээд завсардаад дуусчихсан,. Тэгээд л орж ирсэн. Тэгээд байгаа гишүүдийнхээ хооронд ингээд шийдэгдээд явсан.

Тэгэхээр та бас энэ шинэ даргаар томилогдож байгаа хүнийг надаас илүү сайн мэднэ. Тийм учраас та бүхэн бас хоорондоо ярилцах хэрэгтэй. Харин тийм. Тэгэхээр би харин таныг би хүндэтгэж байна. Ойлгож байна тийм. Ардчилсан намын бүлгийнхнийг би хүндэтгэж байна. Би ярьсан, хэлсэндээ зарчимтай байна. Тийм учраас өнөөдөр ингэж бас та болохгүй шүү дээ энэ чинь. Энэ чинь 101 жил гэж ингэж болохгүй шүү дээ. Би энэ индэр дээр би улс төрийн намын дарга хийгээгүй байгаа шүү дээ огт. Үгүй үгүй тийм. Тэгэхдээ би би энэ Ардын намын дарга хийхгүй байгаа шүү дээ. Хийхгүй байгаа шүү дээ. Тэгэхдээ би танаар бас намаа ингэж хэлүүлэхгүй шүү дээ. Тийм биз дээ? Би энд намын дарга огт хийгээгүй шүү дээ. Би таныг хүндэтгээд хуулиа ярьж байгаа шүү дээ.

Одоо бүгдээрээ саналаа хураая. Төслийн 2 дугаар санал...түүнээс цааш улсын дундаж цалингаас доошгүй түвшинд хүргэнэ.) гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

Нийт гишүүдийн 45 гишүүн буюу 54.9 хувь нь зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн байна.

Төслийн 3 дугаар хавсралтын 1.1.2 дахь дэд заалтын шалгуур үзүүлэлт багана гэсэн энэ санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Одоо зарчмын зөрүүтэй санал нь дуусчихлаа шүү дээ Мөнхтуяа гишүүн. Одоо дараа нь ямар асуудал байна тэр дээр үг хэлж болно. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа. Зарчмын зөрүүтэй саналыг 4 санал байсан тээ. Болсон байна. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Одоо “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор, Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Нийт гишүүдийн 46 гишүүн буюу 56.1 хувь “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Их Хурлын тогтоолын төслийг дэмжлээ.

Болдын Жавхлан гишүүн, Рэгдэл гишүүн нар дэмжсэн байна. Протоколд дэмжсэнээр үлдээе.

Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүдэд талархал илэрхийлье. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг бас батлахад идэвхтэй оролцож, мэдлэг, ур чадвараа дайчилсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн, төрийн албан хаагч нарт, Их Хурлын Тамгын газар Байнгын хорооныхонд талархлаа илэрхийлье. Одоо тогтоолд, түрүүний асуудал.

23.16 цаг

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулах ёстой.

Түрүүн гишүүд үгээ хэлсэн. Дэмжсэн, дэмжээгүй саналуудыг хэлсэн. Ингээд үргэлжлүүлээд хэлэлцэнэ. Асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан, дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

Тогтоолын төслийг нийт гишүүдийн 44 буюу 53.7 хувь дэмжлээ. Тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг дэмжлээ.

Гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

Ингээд өнөөдөр Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хуулийн хугацаанд Их Хурал баталж дууслаа. Идэвх, зүтгэл гаргаж оролцсон Их Хурлын гишүүддээ талархал илэрхийлье.

Өнөөдрийн Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганаа өндөрлөснийг мэдэгдье. Сайхан амраарай.

23.18 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ *Д.ОТГОНДЭЛГЭР*